





# БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ

буюу  
ГЭГЭЭРЭЛД ХҮРЭХ ЗАМ








## Номыг бүтээгчид:

Аким Г.	Лувсанжамц Д.
Алтангэрэл П.	Мөнхбаяр Ч.
Амаржаргал Б.	Мөнхтуяа Б.
Амарсанаа Л.	Мягмар А.
Бадрал П.	Мягмарсүрэн Ж.
Батбаяр Б.	Намираа Б.
Батбаяр Д.	Нанзаддорж Н.
Бацэнгэл Д.	Ойгонжаргал Б.
Батчулуун Б.	Отгонжаргал П.
Баярхүү Т.	Оюунчимэг Д.
Баярмаа Б.	Оюундулам Ш.
Болдбаатар Б.	Равдан Г.
Бямбажав Х.	Содбаатар С.
Ганзориг Р.	Тайванжаргал Э.
Гомбосүрэн Ц.	Төрмөнх Д.
Дамбажав Х.	Цэнддоо Б.
Жамц Н.	Цэрэнпунцаг Ц.

*Бурханы уг сургаалыг үе үеийнхэн орчуулж, дамжуулсаар иржээ. Бидний эл бүтээл анхных биш шигээ сүүлчийнх лав биш. “Үгийг яаж ч дамжуулсан дутуу дулим болдог нь харамсалтай. Гэвч үгийг дуулахгүй өнгөрвөл түүнээс ч харамсалтай” гэж мэргэд сургажээ. Үе үеийн орчуулан хөрвүүлэгчдийн нэгэн адил энэ л үгийг санан санан зүрхиээж бас зоригжсиж уг ажлыг хийлээ.*








Богд Зонхов




БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ

**ЭХЛЭН ГЭГЭРЭГЧДЭД**

ЛАМРИМ  
ЛАМРИМ





DDC  
294.34  
3-688

## Бодь мөрийн зэрэг

Зохиогчийн эрх © “Гэгээрэлд хүрэх зам” сан  
Улаанбаатар. 2006 он

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олишуулахыг хориглоно.


Хавтасны зураг: БОГД ЗОНХОВ


Хавтасны дизайныг Ч.Мөнхбаяр  
Хэвлэлийн эхийг Б.Баярмаа

Цаасны хэмжээ 130x190

ISBN 978-99929-861-3-1




*Printed in Taiwan*










## Гарчиг

Өмнөх үг	VII
Үдиртгал	XI
Бурханы шавь монголчууддаа	XVI
Оршил	1
1. Адиша	5
2. Номлолын суу билэг	19
3. Номлол заах болон түүнд суралцах журам	33
4. Багшийг шүтэх ёс	51
5. Бясалгальн дараалал	83
6. Бясалгальн тухай буруу ойлголтыг няцаах	103
7. Завшаан, боломж бүхий хүн заяа	115
8. Хүний гурван хэв шинж	131
9. Үхлийн тухай эргэцүүлэх	149
10. Хойд насны амьдралыг эргэцүүлэх	175
11. Гурван эрдэнээс аврал эрэх	199
12. Аврал эрэх журам	219
13. Үйлийн үрийн үндсэн шинж	243
14. Үйлийн үрийн төрөл зүйл	251
15. Буяны зам мөрд орох	293
16. Эхлэн гэгээрэгчийн санаа бодол	311









## ӨМНӨХ ҮГ

Будда Шагжамуни “Миний сургаал ном умар зүгээс цаашлан умар зүг рүү түгнэ” хэмээн эш үзүүлсний биелэл болж, буддын шашин Энэтхэгээс Төвд рүү, Төвдөөсөө Монгол руу гэхчлэн тутжээ. Гэхдээ амар хялбар зам туулсангүй. Хойд Энэтхэгт анх үүсээд зүг зүгт түгсэн буддын олон урсгал Төвдийн өндөрлөгт дэлгэрэхдээ бөө мөргөл, анимизм, янз бүрийн шүтлэгтэй холилдон ихээхэн мухар сүсгийн төрхийг олсон байна. Бурханд хүрэх арга замыг эзэмшсэн гэх феодалын давхрага тогтоож, элдэв тарни, уншлагын хүчээр эдгээгч, аврагч гэх маягийн зальтан олширч, тэр гэхийн тэмдэгтүй болжээ. Чухам энэ үед буюу XIV зуунд Төвдийн Хөх нуурт Богд Зонхов мэндлэв. Тэрээр Будда болон түүний залгамжлагчдын сургаал номыг уг эхээс нь эхлэн судлаад үндсэн агуулгыг нь багтаасан *Ламрим Чэн Мо* хэмээх Алхам алхмаар гэгээрэлд хүрэх шат дамжлагын тухай бүтээлээ туурвижээ. 1402 онд зохиосон энэ бүтээл гэгээрэх замыг дагагсдыг эхлэн гэгээрэгч, улам гэгээрэгч, төгс гэгээрэгч хэмээн гурав ангилан тус тусын судлах, бясалгах хүрээг зааж өгчээ.







Монголчуудын *Бодь мөрийн зэрэг* хэмээн монголчлон нэрлэж ирсэн дээрх бүтээл турван хэсгээс бүрдэнэ гэсэн үг юм.

Буддын шашны *Их хөлгөний суртаал*-ыг Төвдөөр дамжуулан залсан монголчууд *Бодь мөрийн зэрэг* судрыг олонтаа орчуулсан юм. Анхдугаар богд Занабазарын эцэг Түшээт хан Гомбодоржийг насан өөд болоход хойтын буянд нь зориулан Алтангэрэл увш эл буянтай үйлийн анхны шанг татжээ. Дараа нь Зая Бандид Намхайжамц *Бодь мөрийн зэрэг*-ийг дахин шинэчилж орчуулан, тод үсэгт буулгасан байна. Энэ мэтчлэнгээр бидний эл номын гол баримтлах эх болсон “Хүрээ барын хэвлэл”-ийг хүртэл нэг бус удаа шинэчлэн найруулагдсан бололтой. Гэхдээ анхлан буддын шашны хөлгөн судар *Ганжуур*, *Данжуур*-ыг орчуулах үед тогтоосон буддизмын нэр томъёоны толь болох *Мэргэд гарахын орон*-ы тогтоосон зарчмаас нэг их холдоогүй байна.

Гэгээрэх замын тухай судрыг орчин цагийн монгол үсгээр олон түмэнд хүргэсэн нь ч бас нэг бусаа. Энд Гандантэгчэнлийн хийдийн санваартан лам Т.Булганы 2004 онд эрхлэн хэвлүүлсэн *Зонхава Лувсандагва. Их Бодь мөрийн зэрэг*, мөн Г.Пүрэвбатын 2002, 2003 онуудад эрхлэн хэвлүүлсэн *Богд Зонхаба. Бодь мөрийн зэрэг* бүтээлүүдийг хэлж байна. Эхнийх нь төвд эхтэй дахин тулгаж зарим хэллэг, найруулгыг засан өөрчилсөн бол дараагийнх нь хүрээ барын хэвлэлийн эхийг шуудаар кирилл үсгэнд буулгажээ. Иймээс эдгээр бүтээлүүд нь монголын хуучин бичгийн уламжлалт найруулга, нэр томьёог үндсэнд нь хадгалсан байдаг.

Хэл яриа нь цаг үргэлж өөрчлөгдөн хөгжиж байдаг тул өнгөрсөн гурав, дөрвөн зуун жилийн хугацаанд олон нэр томьёоны утга өөрчлөгджээ. Өнөө бидний ярьж, бичиж буй орчин цагийн монгол хэл кирилл үсэгтэй бичиг дээр суурилан XX зууны дундуур бүрэлдэн






тогтсон билээ. Иймэрхүү үзэгдлээс хамаараад улс үндэстэн бүрт өөрийн хуучин үг хэллэгээс шинэ рүү нь орчуулах хэрэгцээ байнга гарч ирдэг. *Бодь мөрийн зэрэг-ээс* арай өмнө монгол хэлээр бүтээгдсэн *Монголын нууц товчоо*-г бил Ц.Дамдинсүрэнгийн орчуулгаар уншиж байж ойлгодог зэрэг нь ийм учиртай. Наад зах нь “бодь” гэдэг үг өнөө цагт ноомой, байгаа байхгүй нь мэдэгдэхгүй номхон гэсэн санааг заах ба “Манай хүн ч ёстой бодь амьтан даа” гэвэл цаана нь хачин ноомой нэгэн байна гэж ойлгогдоно. Харин эл үгийг хэдэн зууны өмнө “гэгээрэл” гэдэг утгатай хэрэглэж байжээ. Тэгхээр “Бодь гөрөөс” хэмээх бэлгэдэл амьтан нь, хүнээс үргэдэггүй номхон гөрөөс биш Буддагийн номыг анх сонсон гэгээрсэн амьтны нэг аж. “Онол” гэдэг үгийг одоогийнхоос эсрэг утгаар нь “практик” хэмээх санаагаар хэрэглэдэг байсан гэхчлэн иймэрхүү жишээ маш олон. Хэл ярианы хөгжил, нэр томъёо ухагдахуны өөрчлөлтөөс үүдэлтэй иймэрхүү бэрхшээлээс болоод кирилл үсгээр ч бай, уйгаржин бичгээр ч бай яах аргагүй л монголоор бичигдсэн байх боловч ухаж ойлгоход нэн бэрхшээлтэй хуучны ном судрууд бий болжээ. Үүнд *Бодь мөрийн зэрэг* ч хамаатай.

Ингээд бил орчин цагийн хүний хэл яриа, ойлголтод хамгийн ойр, дэлхийн жишиг орчуулгын нэг болсон “*The Great treatise on the stages of the path to Enlightenment; Lam rim chen mo. Tsong-kha-pa*. Snow Lion Publications. New York. 2004”-ыг жишиг болгож, жирийн уншигчид, сүсэгтэн олонд ойлгомжтой, энгүүн хэл найруулга бүхий *Бодь мөрийн зэрэг-ийг* шинээр хэвлүүлэх зорилго тавьсан юм. Ингэхдээ жинхэнэ төвд эх *Ламрим чэнмог* хүрээ барын *Бодь мөрийн зэрэг*, дээр өгүүлсэн англи орчуулга, кириллүсэгтбуулгасан эхүүдтэй тулганжишиж шинэчиллээ. Энд *Бодь мөрийн зэрэг-ийн* орос орчуулга “Чже Цонкапа. Большое руководство к этапам Пути





*пробуждения.* Изд. Нартанг. Санкт Петербург.1998” номыг бас дурьдууштай. “*Нимэд Жэ Цонхави Ламрим чэва шүгсө. Дарамсала 2000*” гэсэн номоор төвд эхээ баримжаалав. Төвд, монгол, англи, орос хэлний хүлээн зөвшөөрөгдсөн орчуулагчид, санваартан, шашин болон буддын гүн ухаан, философи судлаачид, сэтгүүлч, зохиолч 30 гаруй хүний хоёр жилийн нөр хөдөлмөрөөр энэ ном бүтлээ.


Богд Зонховоос хойш 100 гаруй жилийн дараа германы шашны шинэчлэгч Мартин Лютер *Библи* судрыг тэр үеийн ардын хэлээр орчуулан хатуу чиг баримжаатай санваартнуудаас ихээхэн банга донго сонссон байна. Гэвч шашин нь жирийн хүний сэтгэл зүрхэнд хүрэхийн хэрээр амьдрах хүч өгч, хуучинсаг сүм хийдийн хүлээнээс чөлөөлөн ер бусын эрчим хайлажээ. Чухам энэ эрчим нь Европийн аж Үйлдвэрийн хувьсгалын хөдөлгөгч хүч болсон гэдэг.


Урьдын сайн үлийн үр, ашдын ерөлөөр эх орон нэгтэй болж төрсөн монгол ах дүүстээ Буддагийн ариун сургаалыг шинэлэг байдлаар түгээх бидний хүсэл эрмэлзэл хүн ардын маань сэтгэл зүрхэнд гэгээрлийн зул асаагаасай хэмээн залбирч байна.

Бодь мөрийн зэрэг номыг монголчилж ирсэн үеийн орчуулагчдад буян санаж, сайны ерөөл өргөж байна. Мөн судрыг уламжлалт орчуулга, үг хэллэгийг хадгалах байдлаар буулган шинэ үсгээр хэвлүүлж байсан Гандантэгчэнлийн хийдийн санваартан лам Т.Булган гуай, уран барималч лам Г.Пүрэвбат гуай нарын бүтээлийг уг эх, эртний орчуулга хийгээд гадаад эхтэй тулган нягтлах үүднээс олонтаа нээн үзэж гарч байсныг талархан дурсаж, тэдний сайн үйл бүтээх, бусдыгаа гэгээрүүлэх хүслэнг магтан ерөөж байна.

## *Номыг бүтээгчид*

X







## УДИРТГАЛ

ХХ зууны ээдрээтэй он жилүүдэд шашингүйн суртлын дор үзэл санаа нь төлөвшөн манай үеийнхний нэлээдэд буддын шашны ертөнцийг үзэх үзлийн талаар багагүй төөрөгдөл байх тул зарим зүйлийг урьдчилан тайлбарлах хэрэгцээ гардаг. Хэрвээ та буддын ном сургаалын талаар сайн ойлголттой бол бидний энэхүү нуршааг хүлцэн учлаад өнгөрүүллээрэй.

Бидний төөрөгдөл нь шинжлэх ухааны шашингүйн үзэл гэдэг бурхангүйн суртлаар хүмүүжсэнд ч гол нь байгаа юм биш. Хамгийн гол нь шашин гэхээр Христийн суртлыг ойлгож, тэрний ийм тийм юм нь буруу хэмээн сонсч өссөнд байна. Шашин гэхээр хорвоог анхлан бүтээгч Ертөнцийн эзэн байдаг, түүний хүсэл зоргоор хүний хувь тавилан хөтлөгдөг, эзэнтэй нэг сайн холбоо тогтоогоод авбал өмнөх нутгэл хилэнцээс үл хамааран бүх юм болоод явчихдаг юм шиг ойлгож ирсэнд хамаг төөрөгдөл байжээ. Буддагийн сургаал ёсоор энэ хорвоо эхэлсэн бүтээгдсэн цаг, зохион бүтээгч эзэнтэй хэмээн үзэх нь хамгийн гун гүнзгий төөрөгдлийн эх юм байна.







Ертөнц тоолшгүй галвын тэртээгээс үйлийн үр бүрэлдэн боловсрох байдлаар хувьсан оршиж ирсэн ба цаашдаа одоо бидний хийж буй үйлийн үр хэрхэн боловсрохоос хамааран үргэлжлэх бөгөөд эцэс төгсгөлийг ч төсөөлөх аргагүй юм байна.

Завшаан, боломж бүхий хүн заяг олсон энэ насын одоо эдлэн буй жаргал зовлон нь таны энэ насын болон түүнээс өмнөх үед хийсэн үйлүүдийн чинь сайн ба муу үр боловсрохоос хамаатай аж. Будда Шагжамуни “*Таны эдэлж буй үйлийн үрийг би өөрчилж чадахгүй, учир нь ийм маягаар үр дүн нь гарах тийм үйлийг та өөрөө нэгэнт хийчихсэн. Харин муу үйлийг үргэлжлүүлэн хийгээд үрийг нь цаашид амсахаас өөрийгөө хэрхэн авран хамгаалахыг зааж, гэгээрүүлж өгье*” хэмээн хэлж байна. Өнөөдрийн байдлыг идшидээр өөрчилж болохгүй чгэсэнэнэ мөчөөс хойш үлдсэн амьдрал, дараа дараагийн төрөл тутмыг сайжруулан дээшлүүлэх зам байна гэсэн үг. Ингэхийн тулд гэгээрэх ёстой. Гэгээрнэ гэдэг хялбаршуулан хэлэхэд Буддагийн сургаалыг дагах замаар сэтгэлээ зөв болгохоос эхэлнэ, сэтгэл зөвдөөд ирэхээр үйл зөвдөөд явчихна. Үйл зөвдөж байгаа юм чинь араас нь зөв үр бүрэлдэх нь зайлшгүй. Зөв үйлийн үрийг эдлэх нь зол жаргал мөн гэсэн энгүүн томъёолол болно. Ирээдүйгээ урьдчилан харах боломж бидэнд байхгүй. Харин ирээдүйгээ урьдчилан засах боломж хүн бүхэнд олддог юм байна. Ирээдүй өнөөдрөөс эхэлнэ хэмээн манайхан дуулдаг биз дээ.

Будда Шагжамунигийн “*Хамаг амьтан жаргалан хийгээд жаргалын шалтгаанаас үл хагацах болтугай. Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийн шалтгаанаас хагацах болтугай*” хэмээсэн ерөөлд энэ сургаал цогцлон шингэжээ. Энэ бол хамаг амьтан жаргаг, жаргахдаа хийж байгаа бүхий л үйл нь дандаа зөв үйл байг, тэр зөв үйлүүд нь цаашид үргэлжлүүлэн жаргах







шалтгаан болон бүрэлдэг гэсэн үг. Энэ бол хамаг амьтан зовлонгүй амьдраг, зовлонгүй амьдрахдаа хожим хойно зовлонгийн шалтгаан болох буруу зөрүүгээс ямагт хол байг гэсэн цогц санаа билээ. Ингэж гэгээрэн амьдарч чадвал Бурхан болох боломж бүх хүнд байдал аж.

Таны уншин танилцах энэ номд “Тоо томшгүй Будда”, “Хумхын тоос шиг олон будда” гэхчлэнгийн хэллэг бий. Энэ хорвоод тоо томшгүй олон будда байдал ба та яваандаа тэдний нэг болж болох үндэс байдал гэсэн санаа шүү. Буддын сургаал ёсоор Бурхан нь даган мөрдөх үлгэр дуурайл, зам мөрөөр нь хөтлүүлэн явсаар өөртэй нь адилхан зиндаанд хүргэх хөтөч юм. Тийм болохоор буддизмд өртөнцийн эзэн, бүтээгч гэхчлэнгийн ойлголтыг учир шалтгааны үүднээс эрс няцаадаг. Бурхан гэдэг үг “багш”, “зам заагч”, “гэгээрэлд хөтлөгч” гэдэг утгатай, тиймээс “Бурхан багш” гэсэн хос үгээр олонтаа хэрэглэгддэг.

Тоо томшгүй буддагийн нэгэн Будда Шагжамуны буюу Бурхан багш нь бидэнтэй адилхан хүний орчлонд төрж, амьдраад гэгээрэн будда болжээ. Ингээд өөрийнхөө гэгээрсэн тэр замналаар орчлонгийн хамаг амьтныг хөтлөн өөдлүүлэх хүслээр сургаал номлолоо заажээ. Тэр замаар нь явахыг хүссэн мөчөөсөө эхлэн хэн боловч Буддагийн хөвүүн болж авралд нь багтах бөгөөд багшийн мөрөөр замнан гэгээрсээр Шагжамунитай адилхан будда болж болох юм байна. Ингэхээр Бурхан багшийн сургаал нь хүнээс ангид орших дээд хүчний тухай сургаал бус. Харин хүнд өөрт байх боломжийн тухай, түүнээ хэрхэн зөв ашиглах, өөрөө өөрийгөө яаж төгс төгөлдөр болгон гэгээрүүлсээр бурханы зиндаанд хүргэх тухай агуу их итгэл найдвар хайлрлаж, ирээдүйг гэрэл гэгээтэй харагдуулсан сургаал юм.

Ингээд номыг орчин цагийн монгол хэл аялгуунд тааруулан буулгасантай холбогдуулан зарим нэг





тайлбар нэмж байна. Буддагийн нэрийг бичих бурд “Ялж төгс нөгчсөн, түүнчлэн ажирсан” гэх өргөмжийг заавал дурьдсаар иржээ. “Ялж төгс нөгчсөн” гэдэг нь муу хүсэл шунал, сэтгэлийн гэмээс салсан, “түүнчлэн ажирсан” гэдэг нь орчлонгийн жам ёсыг ухааран зохицон амьдарсан гэх утгыг заадаг аж. Уншигч та эл номд Буддагийн нэр гарах тоолонд энэ тодотголыг хамтад нь сэтгэлдээ санаж байгаарай.


Утга санаа нь цагийн эрхээр өөр болсон хэллэгүүдийг ерөнхийд нь шинэ агуулгад нь нийцүүлэн орчуулсан. Заримыг үлдээсэн тул зохих тайлбар хийж байна. Тухайлбал, “Буддагийн зарлиг” гэдэгт Бурхан багшийн өөрийн аман айлдварууд, “лагшин” гэдэгт түүний бие шогцыг, “таалал” гэдэгт үзэл санаа, оюун билгийг нь тус тус багтаан ойлгоорой.

Мөн муу бүхний үндэс болсон “нисванис” гэдэг ойлголтыг “сэтгэлийн гэм” хэмээн томъёоллоо. Ингэхдээ эхний хэдэн удаад **сэтгэлийн гэм (нисванис)** хэмээн ойлгомжтой байдлаар давхар бичлээ. Сэтгэлийн ийм муу гэм буюу нисванис 84 000 байдаг нь муу үйлд хөтлөх аюултай, сэтгэлийг буруутгах осолтой наян дөрвөн мянган үндэс, шалтгаан байдаг гэсэн санаа.

Там, бирд, муу занаян тухай хэсгүүдийг та физик газар зүйн утга, өнөөгийн шинжлэх ухааны хэмжээсүүдээр сонжихоосоо илүү энэ хорвоо гэдэг нь таны төсөөллөөс үүдэлтэй тухай бурханы сургаалыг санан санан, тэндхийн халуун хүйтний болон бусад зовлонг нь бидний айх эмээх мэдрэмжид тулгуурлан ойлгуулж буйг санавал үр дүн нь улам сайн байх болов уу.

Буддын шашны тулгуур ойлголтын нэг “буян”-ыг бид заримдаа нэг талаас нь хүнд шууд өглөг өргөх, бусдад туслахыг хэлсэн зүйл хэмээн санадаг. Энэ бол зөв. Гэхдээ өөрийгөө гэгээрүүлэхийн төлөө, өөртөө







зөв дадал бий болгохын төлөө, өөрийн эрүүл энхийн төлөө хийж байгаа бүхэн чинь бас буян юм шүү гэдгийг нэмж хэлмээр байна. Учир нь та өөрийгөө хичнээн сайжруулж зөв зам руу хөтөлнө, тэр хэрээрээ бусдад тус болох эрмэлзлэл, чадамжтай болно гэсэн уг шүү дээ. “Нүгэл” гэдгийг яг үүний эсрэгээр ойлгоход болно. Өөрийхөө энэ биеийн төлөө санаа тавихгүй, хойт төрлөө бодохгүй байх нь нүгэл гэхчлэнгээр. Учир нь та эрдэмгүй, гэгээрэлгүй, биеэ хайхардаггүйгээсээ өвчин эмгэгт баригдсан, эсвэл муу явдалтан болбол хүн тусалж чадахгүйгээс гадна олон олон бурууг хийж, бусдыг хорлох үндэс бүрэлдэнэ шүү дээ.

Номыг эхлэн уншихын өмнө танд баяр хүргэх хэрэгтэй боллоо. Будда болон гэгээрэх үндсийг заахдаа нэгдүгээрт, хүн болж төрсөн байх, хоёрдугаарт, буддын шашиндэлгэрсэн газар оронд төрсөн байх, гуравдугаарт, гэгээрэх хүсэл төрсөн байх, дөрөвдүгээрт, сэтгэлээ боловсруулахаас эхлэн буддын ном сургаалд суралцан бясалгах замд орох хэмээсэн байдаг. Та эрдэнэт хүний биеийг олоод, бурханы сургаалтай газарт төрөөд, энэхүү номыг өмнөд дэлгээд байгаа болохоор Буддад дөтлөх замынхаа дөрөвний гурвуыг нэгэнт туулжээ. Ийм байхад баярлахаас өөр яах билээ.

Гэгээрсэн сэтгэлтэй байж гэгээрсэн хүн болно, гэгээрсэн хүмүүсээс бүрдсэн нийгэм гэгээрсэн үндэстэн болно.







## БУРХАНЫ ШАВЬ МОНГОЛЧУУДДАА

Цаст Төвдийн эрдэмт мэргэдийн оройн чимэг, турван ертөнцийн амьтан бүгдийг гэгээрүүлэгч багш хэмээгдэх Богд Зонхов XIV зуунд мэндэлж гэгээн сургаалаа түгээж эхэлжээ. Богд Зонхов 18 боть бүтээл түүрвил үлдээсэн юм. Эдгээрийн дотор судар ба тарнийн ёсонд суралцах дарааллыг үзүүлсэн хоёр бүтээл байдаг. Судрын ёсонд суралцах зам мөрийг заасан *Бодь морийн* зэрэг бүтээл нь эрт дээр цагаас монгол хэлнээ орчуулагджээ. Харин уг зохиолыг орчин цагийн монгол хэлэнд шинэчлэн хөрвүүлж, сүсэгтэн олонд буддын шашны гэгээрэл түгээх үйлсийг “Жавзандамба төв”-өөс эрхлэн эхлүүлсэн нь баяр хүргэх төдийгүй сайшаан дэмжууштэй буянт сайн мөрийн явдал мөнөөсөө мөн.

Бурхан Будда *Шри Ланкад* *айлдсан судар*-таа “Тэнгэрийнхөлгөн, Эсэрвагийнхөлгөн, бас Брадигагийн хөлгөн, Төгс гэгээрэгч хийгээд Шарвагагийн хөлгөний судрыг би *айлдсан*” хэмээжээ.

Мөн хутагт Арьяадэвийн *айлдсан Дөрвөн* зуут сударт:







Шагжа, Махавира, Браhma нарын  
Сэтгэлээр, үзэгдлээр, хэлээр үйлдэх  
Шашин номын турван ёс байдаг бөгөөд  
Сэрээж гэгээрүүлдэг нь буддын шашин юм гэжээ.

Ийнхүү сургасанчлан энэ дэлхийд өөр өөр цаг үед, ондоо ондоо газарт янз бүрийн шашин дэлгэрчээ. Эдний нэг нь биеэр хатуужихыг чухалчилж байхад нөгөө нь үг хэлээрээ сайн сайхныг үйлдэхийг номлож, гурав дахь нь сэтгэлийн ухаарлыг голлоно. Буддын шашин нь сэтгэлдээ зөв дадал хэвшүүлэхийг чухалчилж, юмс үзэгдлийг учир шалтгаанд нь тулгуурлан танин мэдсэн билг оюуныг сүсэг, энэрэлтэй хослуулан байж бие, хэл, сэтгэл гурвыг амирлуулан амар амгаланд хөтөлдөг.




Буддизм нь харьцангуй ба үнэмлэхүй үнэн, аргабилиг, шалтгаан-үр дагавар тэргүүтэй гүн үзэл хийгээд агуу үйл хэргийг алдаа мадаггүй, төгс төгөлдөр илэрхийлсэн гайхамшигт шашин билээ. Иймээс буддизмыг ухааран ойлгохын хэрээр итгэл үнэмшил төрдөг. Өнөө цагийн хөгжил дэвшилийн агуулга, шинжлэх ухаан, технологийн өсөлтийн эрэмбэ, жам ёсны хөгжлийн үйл явцуудтай харшлахгүйгээр хүний сэтгэл зүрхийг эзэмдэн гэгээрүүлэх чадал, боломж зөвхөн буддын шашинд байдаг юм шүү. Гэгээрэгч Будда Шагжамуни “Миний шашин хойт зүгээс хойшлон дэлгэрнэ” хэмээн бошиг үзүүлсний бэлгээр Буддагийн ариун сургаал Энэтхэгээс арагшлан Төвдөд, Төвдээс хойшлон Их Монголын гал голомтод дэлгэрсэн түүхтэй. Үеэс үед, үрээс үрд дамжуулан шашнаа залгамжуулж, цаг төрийн хатуу буулга, цааз хуулийн илдэн дороос үнэн сүсэг, итгэл бишрэлээ авч үлдсэн монголчуудад Буддагийн ариун сургаалаар гэгээрэх хувь ерөөл, шимтэн судалж, ухаажин гэгээрэх хэрэгцээ маш их байгаа. Ингэхдээ дуулж мэдэх, ухаарч таних, бясалган






гэгээрэхийг хослуулах нь үлэмж чухал аа. *Бодь морийн* зэрэг хэмээх энэхүү гэгээрлийн сурх бичгийг буддын шашинтаны сэтгэлээр уншин мэдэж, ухааран танъж, улмаар гэгээрэн боловсроой. Буддагийн гэгээн дууриалаар хүний энэхэн насандaa гэгээрэн жаргаж, цаашдын төрөл тутамдаа дээшлэн, цэнгэлийн манлайд хүрэхийн ерөөл өргөж дэвшүүлье.

*Шагжийн гэлэн Далай лам. 2006.08.27*





## ОРШИЛ

Багш Манзушид мөргөмү.


Тоо томшгүй сайн чанар цогцлон бүрдсэн сайхан төрхтөн  
Тоогүй олон амьтны хүслийг гүйцээх сайн номлолтон  
Буй бүхний утга учрыг ухаарч таньсан гэгээн оюунтан  
Будда хэмээх, Шагжагийн овгийн сор хөвүүнээ мөргөмү.

Эгэлгүй дээд энэ багшийн түмэн шавийн манлай  
Эрхэм Буддагийн үйлс бүхнийг залгуулж хөтлөгч  
Эргэн хувилах тоолшгүй төрөлдөө гэгээрэлд замчлагч  
Энгүй дээд Майдар, Манзури нартаяа бас л мөргөмү.

Ухажад бэрхтэй Гэгээрлийн эх болсон судрын  
Утгыг бүрнээ тайллагч бөгөөд замбутивийн чимэг  
Ахуй гурван ертөнцөд алдар нэр нь түгсэн  
Асанга, Нагаржуна багшийн өлмийд сөгдөн мэхиймү.

Энэхүү хоёр шинэтгэгчийн үүд юуг нь нээсэн  
Эгэлгүй агуу үйлс, гүн үзэл санааны утгыг  
Эндэл үгүй таньж, төгс бүрэн номлосон  
Эрхэм багш Адишад үлээмж мэхийн мөргөмү.





Дээдийн номлолт эрхэм зарлигийг харах нүд болж  
Дээшлэх заяатныг нирваанд хүргэх олом, гарам болж  
Асрал хайраараа авьяас эрдмээ хөтлөн сургасан  
Ачит багшийнхаа буяныг санаж мэхийн мөргөмү.

Өдгөө цагийн бясалгагч нар судлах нь багаджээ  
Өнөө судлаач нь бясалгах хэрэгтээ маруухан ажээ  
Асар олон нь эрхэм зарлигийг өрөөсгөл харжээ  
Аман айлдварыг шүүн тунгаах чадлаа гээжээ.

Энгүй Буддаг номлох сургаал заавар цөөрөөд  
Эрхэм мэргэдийн бясалгах уламжлал тасарсныг  
залгуулж

Эгэлгүй хоёр шинэтгэгчийн замналыг дэлгэрүүлэх  
болсон


Энэ завшаандаа миний сэтгэл баясахыг хэлэх үү.


Буруу үзэлд автан мунхагийн харанхуйд унаагүй  
болж гэм

Буй юмны сайн мууг ялгаж харахаа болиогүй болж гэм  
Бушуу наашаа анзаарч энэ номлолыг сонсогтун!  
Буяны замаар орон амьдын хэргийг бүтээгтүн!

Энэхүү гарын авлага нь (1) Ялгуулсан Буддагийн  
эрхэм зарлигийн бүх товч агуулга, (2) шинэтгэгч  
Нагаржуна, Асанга нарын үүсгэсэн уламжлал, (3)  
бүхнийг танин мэдэх төвшинд хүрэх оюунлаг ёс жаяг,  
(4) гэгээрэх гурван төвшинд суралцах дарааллын бүрэн  
хөтөлбөрийг багтаасан. Мөн хувь ерөөлтэй хэн бүхнийг  
төгс гэгээрлийн замаар шат дараатай хөтлөн гэгээрэлд  
хүргэх бүх заавар журмыг энд тайлбарлан таниулах  
юм.

Цуут Налиндарын мэргэд сургахдаа багшийн  
өгүүлэхүй нь ариун, шавийн сэтгэл нь ариун,  
номлол нь ариун байх ёстой, энэхүү гурван ариуныг  
хослуулан номлох нь зүйтэй хэмээсэн билээ. Хожим










Бикрамалашила хийдэд буддын шашин дэлгэрэхэд тэндхийн мэргэд номлол туурвигч нь агуу, номлол нь агуу байх, түүнийг номлож, суралцах зарчим нь ариун байхыг үндсэн нөхцөл гэж үзжээ. Энэ хоёр гайхамшигт аргачлалаас Бикрамалашилын аргачлалыг энэ гарын авлагад баримтлах болно.

Гэгээрэлд хүрэх сургаалын дарааллыг дөрвөн хэсгээр тайлбарлана:

1. Энэ номлолын язгуур нь ариун болохыг таниулахын тулд зохиогч нь агуу гэдгийг үзүүлэх (1 дүгээр бүлэг)
2. Энэ гарын авлагад бишрэл төрүүлэхийн тулд номлолын суу билгийг үзүүлэх (2 дугаар бүлэг)
3. Хоёр агуу чанар бүрдсэн номлолыг сонсох, номлох зарчим (3 дугаар бүлэг)
4. Жинхэнэ гарын авлагаар шавийг сургах дараалал (4 дүгээр бүлгээс хойш)







I


## АДИША


---

---

I. Энэ номлолын язгуур нь ариун болохыг таниулахын тулд зохиогч нь агуу гэдгийг үзүүлэх

- A. Адишагийн сурвалжит язгуур
- B. Адиша эрхэм чанар эзэмшил түүх
  - 1. Гэгээн мэдлэг олох онол эзэмшил түүх
  - 2. Онолын мэдлэгээ хэрэгжүүлж эрхэм чанар эзэмшил түүх
    - a. Адиша ёс зүйн зааврыг дагаж мөрдсөн түүх
      - 1) Аминчлан гэгээрэх сахил сахисан нь
      - 2) Бодисадвагийн сахил сахисан нь
      - 3) Очирт хөлгөний тангараг сахисан нь
    - b. Адиша төвлөрлийн зааврыг дагаж мөрдсөн түүх
      - 1) Ердийн товлөрөлд суралцсан нь
      - 2) Ер бусын төвлөрөлд суралцсан нь









в. Адиша билэг оюуны зааврыг дагаж мөрдсөн түүх

- 1) Ердийн билэг оюунд суралцсан нь
- 2) Бэлгэ билгүүнд суралцсан нь

В. Эрхэм чанар эзэмшээд шашинд хувь нэмэр  
оруулсан нь

- 1) Энэтхэгт бүтээсэн үйлс
- 2) Төвдөд бүтээсэн үйлс





## I. Энэ номлолын язгуур нь ариун болохыг таниулахын тулд зохиогч нь агуу гэдгийг үзүүлэх

Энэхүү гарын авлагыг хутагт Майдарын *Илт ухаафахын чимэг* номын өрөнхий арга барилд үндэслэн бүтээсэн юм. Ялангуяа *Гэгээрлийн замыг гэфэлтүүлэгч* номыг тулгуур болгосон билээ. Тиймээс *Гэгээрлийн замыг гэфэлтүүлэгч* номын зохиогчийг уг гарын авлагыг зохиосон гэж үзсэн ч болох юм.

Тэр хүн бол олны нэрлэж заншсанаар Адиша буюу их багш Дипанкара Шрижяна билээ.

### A. Адишагийн сурвалжит язгуур


Их орчуулагч Нагцо бээр *Наян бадагт магтаал-даа* Адишагийн сурвалжит угсаа язгуурыг нь ийн өгүүлжээ:


Үзэсгэлэнт Дорнын Зохар газарт  
Үлэмж гоёмсог Викранампур хотод  
Үзээд ханашгүй харш байдгийг  
Үй олон “Алтан далбаат” хэмээнэ.

Эрх дарх, эрдэнэсийн сангараа  
Энэ дэлхийд цуу нь түгсэн  
Эрхэмсэг Нангидын хаан ч гэсэн  
Энэ ордны тансагт атаархам.

Ордны эзэн, гүрний хаан  
Олондоо хүндтэй Гивабал байлаа.  
Оройд заяатай Балма Одсэржан бүсгүй  
Онцгой түүний хатан нь байлаа.

Бас тэгээд хааны гэр бүл  
Бадманямбуу, Давинямбуу, Балжиннямбуу  
Бие биейнхээ зулайг гишгэсэн  
Билэгт гурван хүйтэй байлаа.





Хунтайж Бадманямбуу бээр  
Хувь сайт таван хатан, есөн хүүтэй.  
Хутаг эрдэмт Содномбал гэгддэг  
Хувьт Данашири ч түүний агь аа.

Гэрээс гарсан тойн  
Гэгээн санваарт Бирузандра бол  
Одтой хаан Гивабалын  
Отгон хүү Балжиннямбуу нь билээ.

Харин хаантны дунд хөвгүүн  
Хамгаас хувьт Давинямбуу нь  
Хамаг амьтныг өдгөө гэгээрүүлэгч  
Хайрын дээд багш минь билээ  
хэмээн өгүүлсэн байdag.

## **Б. Адиша эрхэм чанар эзэмшил түүх**

Энэ нь хоёр хэсэгтэй:


1. Гэгээн мэдлэг олох онол эзэмшил түүх
2. Онолын мэдлэгээ хэрэгжүүлж эрхэм чанар  
эзэмшил түүх


### **1. Гэгээн мэдлэг олох онол эзэмшил түүх**

Энэ тухай Нагцо *Наян бадагт тагтаал*-даа ийн  
өгүүлдэг:

Билгийн номыг Буддагаас өөрөөс нь  
Биеэр нь сонсох хувьтны (шарвага) хөлгөнд  
Бишрэн суралцсан таны хатуужлыг  
Биеэр хэн ч үлгэрлэж чадахгүй ээ  
хэмээн өгүүлжээ.

Адиша хорин нэг хүртлээ буддын болон буддын бус  
ерөнхий эрдэмд боловсорчээ. Найруулга зүй, учир  
шалтгаан, урлах ухаан, анагаах ухаан дөрвийг судлан







төгс эзэмшсэн байна. Тэр дундаа арван таван насандaa Дхармакиртигийн *Үчир шалтгааны дусал* номыг ганц удаа сонсоод алдар цуутай, буддын бус нэгэн гүн ухаантантай мэтгэлцэн дийлсэн. Ингэж Адишагийн нэр олны танил болсон хэмээн Долунба дурсчээ.

Ингээд хожим Хар Уулын хийдийн гарамгай ёогч, баходам Хэважра бурханыг төсөөлөлдөө ургуулсан, Очирт дагинас бошиг үзүүлсэн Рахулагупта багшаас тарнийн бүрэн төгс эрх буюу авшиг хүртжээ. Ингээд Ишсанвидорж хэмээх сахилын нэртэй болсон байна. Хорин есөн нас хүртлээ оюун ухааны шидийг эзэмшсэн олон багшийн дэргэд Очирт хөлгөнд суралцаж, тарнийн бүх эх бүтээл болон гарын авлагад нэвтэрсэн аж. Нэгэнтээ тэрээр “Би л ганцаараа нууц тарнийг нэвтэрхий мэддэг боллоо” хэмээн бодож гэнэ. Гэтэл дагинас урьд өмнө сонсож, судлаагүй тантрын олон ботийг зүүдэнд нь үзүүлэн омгийг нь дарсан гэдэг.

Улмаар багш болон ядам бурхад сэргүнд нь ч, зүүдэнд нь ч хувраг болвол шашин, амьтанд маш их тустай хэмээн байн байн сануулах болсон гэдэг. Ингээд гэгээрлийн Бэлтгэл төвшний хоёрдугаар шатанд хүрсэн нэгэнтэй багш шавь барилдан хувраг болжээ. Багш нь Махасангхикийн аймгийн ёс зүйг чандлан баримтлагч Шиларакшита юм. Энэ тухай Нагцо *Наян бадагт тагтаал*-даа “Танд сахил хүртээсэн багш бол гэгээрлийн хоёрдугаар төвшинд хүрсэн, алдар цуутай нэгэн” гэжээ. Ийнхүү Адиша Бал Мармэ Зод Иш гэдэг сахилын нэр хүртсэн аж.

Тэрээр гучин нэг хүртлээ буддын гүн ухааны дээд, доод бүх урсгал чиглэлийг судалжээ. Тэр дундаа





Отантапури хэмээх газар *Их дэлгэрэнгүй тайлбарыг* Дхармаакшита багшаар арван хоёр жил заалгасан юм. Тэгснээр буддын ёс зүйн үндсэн дөрвөн чиглэлийн эх зохиолуудыг гарамгай мэддэг болов. Мөн чиглэл бүрийн хориглосон, хориглоогүй наад захын зүйлийг ч эндүүрэхээргүй ойлгожээ.

Адиша өөрийн болон бусад чиглэлийн гүн ухааны далайг гаталж, эх бүтээлүүдийн бүх утга агуулгыг алдаа мадаггүй оюундаа шингээсэн билээ.

## **2. Онолын мэдлэгээ хэрэгжүүлж эрхэм чанар эзэмшийн түүх**

Ер нь Буддагийн аман айлдвар бүхэлдээ гурван ай сав болж хуваагддаг. Тиймээс хэрэгжүүлэх сургаал нь эрхэм гурван зааварт багтах учиртай. Ёс зүйн заавар нь бясалгал, билэг оюуны заавар зэрэг бусад бүх эрхэм чанарынхаа суурь нь хэмээн эрхэм зарлиг болоод түүний утга санааны тайлбаруудад олонтаа дурьдсан байдаг.

Иймээс нэн түрүүнд ёс зүйн зааврыг дагаж мөрдөн эзэмших учиртай.


### **a. Адиша ёс зүйн зааврыг дагаж мөрдсөн түүх**


Энэ нь гурван хэсэгтэй:

1. Аминчлан гэгээрэх сахил сахисан нь
2. Бодисадвагийн сахил сахисан нь
3. Очирт хөлгөний тангарааг сахисан нь

#### **1) Аминчлан гэгээрэх сахил сахисан нь**

Энэ тухай Нагцо *Наян бадагт тагтаал-д* өгүүлэхдээ:





Та шарвагагийн хөлгөнд суралцахдаа  
Савгандaa эмзэглэх сарлаг шиг ёс зүйг сахисан.  
Ариун санваарт, жавхаалаг, журамт гэлэн,  
Ёс зүйг чандлан баримтлагч танд сөгдье.  
гэсэн байдаг.

Зэрлэг сарлаг савганых нь ганц нэгхэн хялгас модонд тоороход түүнийгээ таслаж чадахгүй эмзэглэсэндээ хөдлөхгүй байсаар гөрөөчний гарти амиа алддаг. Үүнтэй адил Адиша гэлэн сахилын өчүүхэн зүйл бүрийг ч ширхэгчлэн сахидаг байжээ. Тиймээс сахилын үндсэн шаардлагыг хэрхэн биелүүлсэн нь ойлгомжтой. Ийнхүү тэрээр ёс зүйн зааврын нарийн ширийн зүйлсийг амь шиггээ сахин хамгаалж, ёс зүйг чандлан баримтлагч болсон байна.


## 2) Бодисадвагийн сахил сахисан нь


Энэ тухай Нагцо *Наян бадагт магтаал-д* ийн дурдьжээ:

Төгс чанарын холгөнд ороод та  
Үлэмжк сэтгэл тань асар ариусан  
Гэгээрэх тэмүүлэлдээ бусдыгаа орхиогүй  
Оюун төгөлдөр, энэрэнгүй сэтгэлд тань мөргөе.

Хайр ба энэрэх сэтгэлд үндэслэн гэгээрэх тэмүүлэл (бодь сэтгэл) хөгжүүлдэг олон гарын авлагад суралцсан болохыг энд өгүүлжээ. Ялангуяа багш Серлинбаг шүтэн Майдар, Манзушири хоёроос Асанга, Шантидэва нарт уламжлагдан ирсэн гэгээн гарын авлагуудыг өнө удаан судалсан ажээ.

*Наян бадагт магтаал-д* өгүүлэхдээ:





Өөрийхөө зорилгыг зөнд нь хаяд  
Өрөөлийн хэргийг бүтээдэг миний багш.  
гэсэн байдаг.

Энд өгүүлснээр Адиша өөрөөсөө илүү бусдыг хайлрах гэгээрэх тэмүүлэл (бодь сэтгэл) сэтгэлдээ төрүүлсэн байна. Тэрхүү гэгээрэх чин хүсэл нь түүнийг гэгээрэх тэмүүллийн үйлсэд урин дуудаж, бодисадвагийн агуу их үйл хэрэгт суралцах сахил хүртжээ. Ингээд тэрээр бодисадва нарт зориулан тогтоосон хууль цаазаас огтхон ч гажилгүй заавар журмаа чандлан сахисан билээ.


### 3) Очирт хөлгөний тангараг сахисан нь


Энэ тухай Нагцо *Наян бадагт тагтаал*-даа:

Эрхэм та Очирт хөлгөнд ороод  
Өөрийгөө бурханд төсөөлөх ба Очирт оюунт  
Ёгийг бүрэн эзэмшигч, авадхутипа,  
Нууцын ахуй ёсыг баримтлагч түүнд мөргөмү  
хэмээн айлдажээ.

Нагцо энэ бадагтаа Адиша эхлэлийн шат буюу өөрийгөө бурханы төлөвт ургуулах бясалгал ба төгсгөлийн шат буюу очирт оюуныг эзэмшисэн учир эрх дархтай ёгч хэмээн ерөнхийд нь харуулжээ. Ялангуяа тэрээр тантрын хууль цаазыг зөрчилгүй, тангаргаа ёсчлон сахисан бөгөөд *Наян бадагт тагтаал*-д:

Тэрээр санамж, сэрэмжээ хадгалаан  
Сэтгэлдээ ёс бусыг агуулаагүй бөгөөд  
Сэрэмж, мэрийлттэй байж, хоосон дур үзүүлээгүй тул  
Үндсэн алдааны гэм буруу гаргаагүй билээ  
Гэж өгүүлжээ.





Ийнхүү Адиша гурван сахилын ёс зүйн заавар журмаар андгай тавихдаа хоосон дүр үзүүлэлгүй тавьсан андгайгаа баримталж, тогтоосон хориг цаазыг нь зөрчилгүй сахисан байна. Хааяа өчүүхэн төдий алдаа гаргавал тэр даруйд нь тухай тухайн залруулах зан үйлээр нь сайтар ариусгадаг байжээ. Иймэрхүү түүх намтар эрхэм зарлигийг ухаарсан мэргэдийг баясгадаг билээ. Тиймээс суут гэгээнтнүүдээс үлгэр дууриал аваарай.

**б. Адиша төвлөрлийн зааврыг дагаж мөрдсөн түүх**

**1) Ердийн төвлөрөх бясалгалд суралцсан нь**

Тэрээр тайван төлвийг эзэмшийн ачаар сэтгэлээ бүрэн захирч сурчээ.

**2) Ер бусын төвлөрөх бясалгалд суралцсан нь**

Адиша тантрын ёсны хатамж суух үйлийг зургаа болон гурван жилээр хэрэгжүүлэн гүйцэлдүүлж эхлэлийн шатанд маш баттай хүрчээ. Энэ үедээ Оддиянагийн дагинаасын уянгат дууг сонссоноор барахгүй түүнийг ой тойндоо тогтоож авсан гэдэг.


**в. Адиша билэг оюуны зааврыг дагаж мөрдсөн түүх**


**1) Ердийн билэг оюунд суралцсан нь**

Тайван төлөв ба үлэмж үзэл хосолсон үлэмж үзлийн бясалгалын төвлөрөл эзэмшийн байна.

**2) Бэлгэ билгүүнд суралцсан нь**

Тэрээр төгсгөлийн шатны онцгой төвлөрөх бясалгал эзэмшийн бөгөөд энэ тухай нь *Наян бадагт тагтаал-д* огүүлэхдээ:





Нууц тарнийн эх бүтээлд зааснаар бол  
Та Бэлтгэл төвшинд хүрсэн нь тодорхой  
хэмээсэн билээ.

## **В. Эрхэм чанар эзэмшээд шашинд хувь нэмэр оруулсан нь**


### **1. Энэтхэгт бүтээсэн үйлс**


Адиша бээр Бодигая дахь гэгээрлийн сүмд буддын бус гүн ухааны сургаалыг гурван удаа буддын үзэл баримтлалаар няцааж, Буддагийн номлолыг хамгаалжээ. Мөн тэрээр буддын гүн ухааны дээд, доод чиглэлүүдийн зарим нэг ойлгомжгүй, буруу ойлгогдсон, эргэлзээтэй зүйлсийг тодорхой болгож буддын шашныг дэвжээсэн юм. Тиймээс буддын бүх ургсал чиглэлүүд түүнийг өргөмжлөн хүндэлдэг. Энэ тухай *Наян бадагт магтаал-д*:

Эрхэм гэгээрлийн ариун сүмд  
Эндүүтэй номлолын худлыг залруулж  
Тэнгэрээс арслан хүрхрэх мэтээр  
Тэрсүүдийн баримтлалыг няцаасан билээ.

Отантапури хийдэд шавилан суугч  
Гурван зуун тавин хувраг,  
Ондоо бас Викрамшила сүмээс  
Оролцож асан зуу орчим хувраг  
Бүгд нийлээд дөрвөн аймаг савд  
Бүхий л итгэлээрээ хуваагдаж байсан ч  
Бүгдээс дээшилж гэгээрсэн та минь  
Бүүрэлхэж хэнийг нь ч адлаагүй билээ.

Магадха нутгийн хaa сайгүй  
Манай багшийг шүтдэг байсан  
Дагаж бишрэгч дөрвөн сахилтан  
Дандаа таныг биширдэг байсан.






Ахуй орчлонг гэгээрлээр гийгүүлж өөд татан  
Амьд бүхний шүтээн болсон таны номлолыг  
Арван найман номын аймгийн хуврагууд ирээд  
Алдалгүй сонсч гүнээ бишрэн дагаж байсан  
хэмээн магтан дуулжээ.


## 2. Төвдөд бүтээсэн үйлс

Эзэн ноёны өвөг дээдэс үе дамжин Жазон Сэнгэ, Нагцо Цүлтэм Жалба хэмээх хоёр хэлмэрчийг ар араас нь Энэтхэг рүү явуулж Адишаг ихэд хичээнгүйлэн ахин дахин урьсан юм. Ингээд тэрээр Жанчүвод хааны үед Дээд Арид иржээ. Тэгэхэд түүнээс буддын шашныг цэгцэлж өгөхийг хүссэн аж. Тийнхүү Адиша судар, тантрын бүх утга агуулгыг хураангуйлан, дагаж мөрдөх дараалалтай нь нэгтгэсэн Гэгээрлийн замыг өөрслүүлэгч гарын авлагаа туурвих болон бусад үйлсээр буддын шашныг хөгжүүлжээ.

Тэрээр Арид гурван жил, Нитанд есөн жил, төв Төвд, Зан зэрэг бусад газарт таван жил болсон юм. Ингэхдээ хувь ерөлтэй бүхэнд судар, тантрын эх зохиол, заавар журам бүрийг ойлгуулан сэнхруулсэн. Шашны мартагдсан зарим уламжлалыг дахин амилуулж, амь төдий болсныг нь сэргээсэн юм. Бас буруу ойлгож будилсныг нь засаж залруулан эрдэнэ мэт үнэт шашныг гажуудлаас гаргасан билээ.

Ер нь цастьн оронд буддын шашин анх Шантракшита, Падмасамбхава нарын уламжлалаар бий болсон. Харин хоосон чанарын утга агуулгыг ойлгоогүйн улмаас арга барилыг хэт дорд үзэн, бүх төсөөллийг үгүйсгэгч чань буддизмын хятад тэргүүнүүд шашныг завхруулжээ. Үүнийг их багши Камалашила гайхалтай няцааж, Буддагийн үзэл санааг





хамгаалсан нь хожим хойчдоо их тустай үйл болсон юм.


Хожуу дэлгэрэлтийн үед тантрын аймгийн утгыг буруу ойлгосон зарим нэгэн өөрийгөө бандида, ёгч хэмээн нэрлэх болжээ. Тэд буддын шашны үндэс болсон ариун ёс зүйд ихээхэн балаг тарьсан. Гэхдээ Адиша энэ бүхнийг таслан зогсоож, буруу ойлголтуудыг засч залруулсан билээ. Ингэснээр буддын шашныг зөв дэлгэрүүлж, цастин орны хүн бүхэнд өөрийн биеэр ач тусаа хүртээсэн юм.


Буддагийн үзэл санааг тайлбарласан бүтээл туурвиход гурван нөхцөл төгс бүрдсэн байх ёстой.

1. Ядам бурхадтай учирч зөвшөөрөл авсан байх.  
2. Тэдгээрийг хэрэгжүүлэх заавар журам нь Ялгуулсан Буддагаас тасралгүй уламжлагдан ирсэн байх.  
3. Таван зүйлийн ухааныг эзэмшилж байх эдгээр юм. Энэ гурван нөхцлийн нэг нь байхад гарын авлага зохиож болдог. Харин гурвуул бүрдвэл төгс төгөлдөр болох нь гарцаагүй бөгөөд Адишагийн хувьд бүгд цогц бүрджээ.

1. Ядам бурхад ивээллээ хайрласан тухай *Наян бадагт магтаал-д* ийн өгүүлжээ:

Бахдам Хэважра,  
Дамциггоди жалба,  
Баатарлаг Арыябал,  
Дарь эх тэргүүтэнтэй  
Нүүр учран зөвшөөрөл авч  
Зүүдэндээ ч, сэруүндээ ч  
Гүн үзэл ба агуу үйл хэргийн  
Гэгээн номлол үргэлж хүртсэн.





2. Багшийн уламжлалын тухайд бол нийтлэг ба Их хөлгөний хоёр уламжлал авчээ. Их хөлгөний тухайд гэвэл Төгс чанарын болоод Нууц тарнийн хөлгөний уламжлал өвлөсөн юм. Төгс чанарын хөлгөний уламжлал нь үзэл санааны болон үйл хэргийн хоёр зүйл уламжлалтай. Түүнээс үйл хэргийн уламжлал нь Майдар, Манзушири хоёроос өвлөгдсөн бөгөөд нийтдээ Төгс чанарын хөлгөний гурван уламжлалтай. Түүнчлэн Адишагийн нууц тарнийн уламжлал нь таван аргачлалаас бүрддэг. Мөн үзэл баримтлалын зарчим, адислал, заавар журмын хэд хэдэн уламжлалтай. Энэ бүхнийг Адиша олон уламжлалаас өвлөн авчээ. Эдгээр уламжлал, аргачлал зэргийг өвлүүлсэн багш нарынх нь тухай *Наян бадагт магтаал-д*:


Үргэлж шүтсэн багш нь гэвэл  
Оюун ухааны шидийг эзэмшишэн  
Шандива, Серлинба болон  
Бхадрабодхи, Занашри тэргүүтэн.


Тэр дундаа Нагаржунагаас уламжлагдан  
Нэгээс нөгөөд тасралтгүй өвлөгдсөн  
Гүн үзэл ба агуу үйл хэргийн гарын авлагыг  
Адиша багш та минь өвлөн авсан билээ.  
Хэмээн дурьдсан байdag.

Оюун ухааны шидийг эзэмшишэн арван хоёр багш нь нэгэнт тодорхой бөгөөд түүнээс ч олон багштай байсан гэдэг.

3. Түүнийг таван зүйл эрдэм мэдлэгийг төгс эзэмшишэн тухай дээр өгүүлсэн билээ.

Тиймээс энэ их багш Буддагийн үзэл санааг сайтар тайлбарлан таниулж чадсан юм.







Их багш санаанд багтамгүй олон шавьтай бөгөөд тэд нар нь Энэтхэг, Кашмир, Оддияна, Балба болон Төвдөд бий. Тэдний шилдэг нь Адишатай эрдэм мэдлэгээр эн тэнцүү Энэтхэгийн их бандида Бодова, Дарма-агара-мади, Умсэнгэ нар юм. Зарим нэг нь Шинэн санваг нэмээд тав ч гэж тоолдог. Төвдийн Аригаас орчуулагч Ринчинсамбуу, Нагцо мөн эзэн ноён Жанчивод нар, Зан нутгийн Гаргэва, Гойхүгва, Лхазай нар, Лхоабраг нутгийн Чагватичаг, Гиважон нар бас Хам нутгийн Налжорва чинбу, Гонбава, Шийравдорж, Чагдор Донба нарыг дурьдаж болно. Мөн төв Төвдийн Хүдэн зундуй жүндүн, Ог лэгви шийрав, Бромдонба Жалбижуний нар бий.

Эдний дундаас Гэтэлгэгч Дарь эх бошиг үзүүлсэн, их багшийн гэгээрүүлэх үйлсийг дэлгэрүүлэх уламжлалыг өвлөж авсан Бромдонба Жалбижуний хамгийн шилдэг нь юм.

Зохиогчийн суу билгийг товчхон дурьдвал ийм бөгөөд Адишагийн намтраас илүү дэлгэрэнгүй олж үзээрэй.







II

## НОМЛОЛЫН СУУ БИЛЭГ

II. Энэ гарын авлагад бишрэл төрүүлэхийн тулд номлолын суу билгийг үзүүлэх

- A. Номпол бүхэнтэй зөрчилдөлгүй ухааруулах суу билэг
- Б. Эрхэм зарлигийг бүхэлд нь гарын авлага болгох суу билэг
- В. Буддагийн үзэл санааг төвөггүй ойлгуулах суу билэг
- Г. Үлэмж гэмт үйлээс аяндаа холдуулах суу билэг





## II. Энэ гарын авлагад бишрэл төрүүлэхийн тулд номлолын суу билгийг үзүүлэх


Эдүгээ туурвин буй номлолд *Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч*-ийг үндсэн гарын авлага болгон ашигласан. Адиша бодын зохиосон олон эх бүтээл байдаг ч түүний *Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч* бол үндсэн суурь болохоор төгс төгөлдөр бүтээл юм. Түүнд судар, тарни хоёрын гол агуулга хураангуй байдлаар багтсан учир агуулга нь их өргөн дэлгэр билээ. Мөн сэтгэлээ номхотгох шат дарааллыг голлон гаргасны дээр амьдралд хэрэгжүүлэхэд нэн дөхөмтэй. Түүнээс гадна ном ёсонд мэргэшсэн хоёр их шинэтгэгчийн гарын авлагаар чимсэн болохоор бусад ном ёсноос үлэмж илүү билээ.


### A. Номлол бүхэнтэй зөрчилдөлгүй ухааруулах суу билэг

Авалокитаврата *Oюун ухааны зулын их тайлбар* номдоо номлол хэмээх ойлголтыг ингэж тодорхойлсон байдаг:

“Номлол” гэдэг бол урвашгүй амгалангийн рашаан хүртэхийг хүсэгч тэнгэр болон хүний бүрэн ухаарах, цээрлэх, шууд хэрэгжүүлэх, өөриймшүүлэх учиртай сургаалыг алдаагүй илэрхийлсэн Буддагийн эрхэм зарлиг юм.

Өөрөөр хэлбэл Буддагийн гайхамшигт аман айлдвартыг тэр чигт нь номлол гэж ойлгож болно. Номлол бүхэнтэй зөрчилдөлгүй ухааруулна гэдгийг энд өгүүлэх бүх заавар журам нь нэгэн бодгалийг төгс гэгээрүүлэх зам мөр болдог гэж ойлгоорой. Түүнчлэн номлолын аль





нь гол, аль нь туслах чанартай болохыг ч эндээс мэдэж авна.

Бодисадва нарын эцсийн зорилго нь энэ ертөнцийн амьтанд туслахад оршдог. Бодисадва нар гурван төшинд хуваагдах шавь нарыг чиглүүлэн залахын тулд тэдгээр номлолын заавар журмыг өөрөө даган мөрдөх ёстай. Энэ тухай Нагаржуна *Гэгээрэх тэмүүллийн тайлбар* зохиолдоо:

Өөрөө гарцаагүй ухаарсан зүйлээ  
Өрөөл бусдад ойлгуулах хүслээр  
Огт алдаа эндэгдэл гаргахгүйгээр  
Ухаантнууд шавь нартаа сургадаг.


гэсэн бол Дхармакирти *Үчир шалтгааны учир зүйн тайлбар* номдоо:


Үүсэл гарлын учир шалтгаан далд нарийн тул  
Үнэн учрыг тайлбарлан таниулах нь маш бэрх  
гэхчлэнгээр тайлбарласан байдаг.

Энд өөрөө бүрэн дүүрэн ойлгоогүй зүйлээ бусдад заан сургаж чадахгүй хэмээн өгүүлсэн байна. Хамгийн гол нь бодисадва нар гурван төвшний хүний суралцах зам мөрийг өөрөө мэддэг болсноор ертөнцийн үйл хэргийг бүтээх учиртай.

Майдарын *Илт ухаарахын чимэг*-т “Бусдад туслагчид бүх зам мөрийг бүхэлд нь ухаарсны үндсэн дээр ертөнцийн үйл хэрэгт үйлчилдэг” гэсэн байдаг. Мөн *Гэгээрэгсдийн эх* хэмээх сударт ийн өгүүлжээ:

Бодисадва нар шарвага, брадига, төгс гэгээрэгсдийн зам мөрийг өөриймшүүлэх бөгөөд тэр бүх зам мөрийг мэддэг байх ёстай. Тэр тусмаа эдгээр мөрийг төгс






төгөлдөр болгохын тулд бүх зам мөрийн ажил үйлийг гүйцэлдүүлнэ.


Тиймээс Их хөлгөнтөн учраас Бага хөлгөний аймаг савд хамаарах заавар журамд суралцахгүй гэдэг нь номлолыг зөрчиж буйн шинж юм.

Их хөлгөний зам мөр нь нийтлэг ба онцгой хоёр төрөл байдаг. Гэтэл нийтлэг зам мөр нь Бага хөлгөний аймаг саваас гарсан болохоор орхиж хаанаас байх вэ. Энэ тохиолдолд зөвхөн өөрийн амгалан жаргаланг зорилго болгох мэтийн Бага хөлгөний зарим нэг онцлогоос бусдыг нь Их хөлгөнтөн хэрэгжүүлэх ёстой. Бодисадвагийн дэлгэрэнгүй аймаг сав нь номлолоос илүүтэй гурван хөлгөний учир шалтгааныг тайлбарлаад байдгийн учир нь энэ.

Түүнээс гадна үнэхээр бүрэн төгс гэгээрнэ гэдэг ганц нэг гэм нүглээс салж, зарим нэг эрхэм чанар эзэмших төдийхөн биш, харин хамаг гэм нүглээс ангижирч, бүх эрхэм чанарыг төгс цогцлуулна гэсэн үг. Төгс гэгээрэлд хүргэх Их хөлгөний сургаал нь гэм нүглээс гүйцэд салгаж, бүх эрхэм чанарыг төлөвшүүлдэг. Бусад бүх хөлгөний гэмийг цээрлэх, сайныг өөриймшүүлэх эрдэм мэдлэгт хамаарах юм бүхэн Их хөлгөний зам мөрд багтдаг. Тийм учраас эрхэм зарлигийн нэгээхэн хэсэг нь төгс гэгээрлийн төвшинд хүргэх Их хөлгөний зам мөрд багтдаг юм. Ямарваа гэм нүглээс салгадаггүй, аливаа эрхэм чанар хөгжүүлдэггүй Буддагийн аман айлдвар гэж үгүй болохоор тэр бүхнийг Их хөлгөнтөн эзэмшихгүй байна гэж хаанаас байх билээ.

**Эргэлзээ:** Төгс чанарын дээд хөлгөнд суралцахад





Бага хөлгөний аймаг саваас айлдсан зам мөр хэрэгтэй юм байна. Гэтэл Очирт хөлгөнд ороход зам мөр нь зохицохгүй учир Төгс чанарын хөлгөн нийтлэг суурь болж чадахгүй.

*Тайлал:* Ингэж хандах нь туйлын зохисгүй. Төгс чанарын сургаалын гол утга учир нь гэгээрэх тэмүүлэл хөгжүүлэх санаа болон өгөөмөр чанар тэргүүтэй зургаан төгс чанарыг өөртөө шингээсэнд байдаг. Харин аль ч тохиолдолд энэ хоёрт тулгуурлах учиртай хэмээн *Бахдам очирын орғил-д:*

Утсан улаан амиа аргацаахын төлөө  
Гэгээрэх тэмүүллээ гээж огт болохгүй.


гээд мөн:


Зургаан төгс чанарын үйл хэргийг  
Зуурдхан ч болов орхиж болохгүй.  
гэж тэнд дурьджээ.

Энэ мэтийг тантрын олон эх бүтээлд дурьдсан байдаг билээ.

Ижилгүй дээд тантрын хот мандлын олон бясалгалд ороход ч гэсэн нийтлэг ба онцгой хоёр сахилыг хоёуланг авах хэрэгтэй гэж заасан байдал. Эхнийх буюу нийтлэг нь бодисадвагийн сахил юм. Сахил сахихдаа гурван ёс зүй зэрэг бодисадвагийн заавар журмыг андгай ёсоороо хэрэгжүүлдэг. Гэгээрэх тэмүүлэл төрүүлсэн хойноо андгай тавьсан заавар журмынхаа дагуу суралцахаас өөр зам мөр Төгс чанарын хөлгөнд байхгүй.

Амитаба бурханд тангараг тавихад өгүүлдэг шиг нууц тарниийн сахил хүртэхдээ ч андгай өгөх хэрэгтэй.





Доржханд, Самбууди, Баҳдам очирын оргил зэрэг тантрын ёсонд энэ тухай ингэж өгүүлсэн байдаг:

Баримталбал зохих бүх гэгээн номлол нь  
Гадаад, нууц болон гурван хөлгөн билээ.


Эдгээр хөлгөнүүдийн хориглосон, хориглоогүй харилцан адилгүй зарим нэг зүйлийг олж мэдчихээд халуун, хүйтэнтэй адилхан бүхэлдээ эсрэг тэсрэг мэт үздэг. Энэ тун бүдүүн тойм ойлголт болох нь тодорхой. Зарим нэг онцгойлон заасан зөвшөөрөх, хориглох талыг нь эс тооцвол эрхэм зарлигтай бүрэн дүүрэн нийцнэ. Иймээс гурван хөлгөн буюу таван зам мөрөөр дээш ахих тусам доод, доод шатныхаа эрхэм чанарын язгуурыг гүйцэд эзэмших хэрэгтэй.


Төгс чанарын зам мөрийн тухай *Гэгээрэгсдийн эх судар*-т:

Өнгөрсөн, одоо, ирээдүйн бүх гэгээрэгсэд  
Төгс чанарын зам мөрөөс өөрийг туулахгүй  
гэдгийг заасан байдаг.

Төгс чанар бол гэгээрсэн төлөвт хүрэх зам мөрийн амин сүнс болохоор орхиж явч болохгүй. Энэ тухай Очирт хөлгөнд олонтаа анхаараулдаг учраас төгс чанар нь судар, тарни хоёулангийнх нь нийтлэг зам мөр юм. Үүн дээр нууц тарнийн онцгой зам мөр буюу авшиг, тангараг, сахил, хоёр шатны ёог, зохих дүрэм горимыг нэмчихвэл гэгээрсэн төлөвт түргэн хүрнэ. Харин төгс чанарын нийтлэг зам мөрийг орхивол ихээхэн алдаа болно.

Үүнийг мэдэхгүй бол номлолын зарим хэстгийг ойлгосон мэт санагдан бусдыг нь гээнэ. Ялангуяа






дээд хөлгөнд ийм маягаар сүсэглэсэн болчихвол яваандаа Бага хөлгөний аймаг сав болон Төгс чанарын хөлгөнийг ч хэрэгсэхгүй. Түүнчлэн нууц тарнийн доод гурван тантрыг хэрэгсэлгүй орхидог нь үүнтэй их холбоотой. Ингээд номпол хэрэгсээгүй үйлийн үрээр томоохон хилэнц хураах ба гүйцэд боловсрох үр дагавар нь маш хүнд байх болно. Үүний эх сурвалжийг хожим тайлбарлана.


Тиймээс мэргэд багш нарыг түшиглэн эрхэм зарлиг бүхэлдээ нэгэн бодгалийг төгс гэгээрүүлэх нөхцөл болдог арга замыг ухаж ойлго. Нэгэнт сонгон авснаа хэрэгжүүлж эхлэ. Хараахан бодит ажил хэрэг болгож чадахгүй зүйлээ хэрэгжүүлэх чадал хүрэхгүй гэдгээр шалтаглан орхиж болохгүй. Харин “Хэзээ нэг би эднийг бодит ажил хэрэг болгох бол?! Хэзээ нэгтээ хэрэгжүүлэх л болно” хэмээн бодож бай. Тэгээд буян хуримтлуулж, хилэнцээ ариусгаж, түүнийг хүсэн залбирч нөхцлийг нь бүрдүүл. Тэгвэл төдөлгүй оюун ухааны чадал улам бүр өсөн нэмэгдэж, номлолыг бүхэлд нь бодитоор хэрэгжүүлэх чадвартай болно.

Эрхэм багш Донбаринбүчигийн “*Миний багши эн тэнциүү зам төрөөр хөтлөхөө тэднэ*” гэдэг угэнд ухаж ойлгох зүйл их бий.

Тиймээс энэ *Бодь төрийн зэрэг* нь судар, тантрын үндсэн агуулгыг нэгэн бодгалийг төгс гэгээрлийн төвшинд хүргэх зам мөр болгож нэгтгэн хөтлөж учир хамаг номлолтой зөрчилдөхгүй ойлгуулах суу билэг төгөлдөр юм.

## **Б. Эрхэм зарлигийг бүхэлд нь гарын авлага болгох суу билэг**





Гагцхүү Будда л ямар ч алдаа эндэгдэлгүй авч, гээх учиртай бүхнийг тайлбарлан таниулагч билээ. Буддагийн эрхэм зарлиг бол нирвааныг хүссэн хэн бүхнийг хэтийн болоод ойрын сайн сайхан, жаргалд хүргэх цорын ганц арга зам юм. Энэ тухай *Дээд уламжлал*-д өгүүлэхдээ:

Ялгуулсан Буддагаас илүү суу билэгтэн энэ ертөнцөд  
байхгүй

Оршихуйн мөн чанарыг буй чигт нь ойлгосон бүхнийг  
мэдэгч өөр үгүй.

Тиймээс Буддагийн айлдсан аль ч аймаг савыг бүү  
хольж хутга


Буддагийн арга барилыг зөрчвэл гэгээн номлолыг  
доройтууна.


Хэмээн заасан юм аа.

Тиймээс Буддагийн эрхэм зарлиг буюу гайхамшигт судар, тарнийн аль аль нь дээд гарын авлага мөн. Гэтэл хожуу үеийн шавь нар нь Буддагийн эрхэм зарлигийг бүрэн мэдэхгүй, дээдсээс уламжлагдах гарын авлага өвлөн аваагүй хэрнээ зарлигийг зоргоороо тайлбарлаж, үзэл санааг нь гүйвуулах болжээ. Иймд Нагаржуна, Асанга хоёр эрхэм зарлигийн тайлбар, гарын авлагуудыг зохиоход хүрчээ.

Зөв гарын авлага мөн аваас агуу эх зохиолуудыг ойлгуулах ёстой. Гэтэл тухайн гарын авлагыг даган суралцсан хэдий ч Буддагийн аман айлдвэр ба үзэл санааны тайлбарын утгыг ойлгуулж чадахгүй эсвэл түүнтэй зохилдохгүй зам зааж байвал орхих нь зүйтэй.

Мөн зарим нэг нь бүх аман айлдвэр бол дагаж мөрдөх гарын авлага биш зөвхөн номлолын ерөнхий утга, дагаж мөрдөх гарын авлагын утга санааг






тайлбарласан тусдаа сургаал байдаг мэтээр ойлгох нь бий. Гэгээн номлолыг онолын болон хэрэгжүүлэх хоёр тусдаа зүйл мэтээр үзэх явдал гардаг. Иймэрхүү бодол санаа нь ариун судар, тарни ба үзэл санааны алдаагүй тайлбарт итгэн сүсэглэхэд саад болно. Ингэж “Гол утга санааг агуулдаггүй, өнгөц мэдлэг төдий зүйл” гэж тоомжиргүй хандвал номлолыг зөрчсон үйлийн үр эдлэнэ.


Тиймээс нирвааныг хүсэгчдийн дагаж мөрдөх гарын авлага бол аман айлдвартууд юм. Гэвч бидний ухаан мөхөс тул эх зохиолыг уншаад гол санааг нь ойлгохгүй учир шууд гарын авлага болгон мөрдөх чадал хүрэхгүй. Харин “Гарын авлагыг баримтлан аман айлдвартыг ухааръя” гэдэг зарчим баримтлах хэрэгтэй. “Эх зохиолууд өнгөц мэдлэг төдий зүйл учир чухал биш, гарын авлага бол дотоод нарийн учрыг нь илэрхийлдэг тул илүү дээр” гэж бүү бод. Их ёогч Жанчувринчэн хэлэхдээ:

Гарын авлага ухаарна гэдэг алгын чинээ ном ойлгосноор дуусахгүй. Харин эрхэм зарлиг дотроос түүнийг олж ойлгох гэж ухаарвал зохино хэмээн заажээ.

Мөн Адишагийн шавь Гомбаринчэн зөвхөн Адишагийн гарын авлагараар бясалган нэг суудал дээр бие, хэл, сэтгэл гурвын гэмийг “үнсэн товрог” болгоод сая л бүх эх зохиол бол гарын авлага гэдгийг ойлгосон гэдэг. Та ч мөн түүнтэй адил ойлгох хэрэгтэй.

Мөн Донба Ринбучи, удаан номлол судалсан хэрнээ хэрэгжүүлэх зарчим нь тусдаа гэж ойлгож





байгаа бол эндуурэл гэжээ. Дээр өгүүлснээр, удаан хугацаанд номлол судлаад ч түүнийг дагаж мөрдөх журмыг ойлголгүй, номлолоо хэрэгжүүлмээр байна гэж өөр юм хайж яваа нэгэн бол өмнө дурьдсаныг ойлгоогүйн уршиг юм.


Васубандху *Абхидхармакоша* бүтээлдээ буддын шашныг ингэж тайлбарласан байдаг:


Буддын ариун номлол мөн чанарын хувьд  
Онолын ба хэрэгжүүлэх хоёр зүйл байдаг.

Иймээс онолын ба хэрэгжүүлэх хоёр сургаалаас өөр зүйл байхгүй. Онолын сургаал нь номлолыг эзэмшиж, хэрэгжүүлэх зарчмыг илэрхийлдэг бол хэрэгжүүлэх сургаал нь илэрхийлэгдсэн зарчмыг тэр чигт нь эзэмшүүлдэг. Энэ хоёр сургаал нь шалтгаан, түүнээс үүдэх үр дагаврын зарчмаар хэрэгждэг. Жишээ авьяя. Морь уралдуулахын тулд эхлээд уралдах газраа товлож, тэндээ л уралдуулдаг. Харин нэг газар товложихоод өөр газар уралдаан зохиовол хачин юм болно биз дээ. Үүнтэй адил сурч, судалснаасаа өөр зүйл хэрэгжүүлж болох уу? Энэ тухай Камалашила *Бясалгалын эцсийн шат* бүтээлийн сүүлийн хэсэгтээ:

Сурч, судлах билэг оюунаар бий болгосон ойлголтоо бясалгалын билэг оюунаар өөриймшүүлдэг. Өөр арга байхгүй. Товлосон газраа морь уралдуулахтай л адил хэмээснийг дурдья.

Харин энэхүү гарын авлага нь багш шавийн барилдлагаас эхлээд тайван төлөв ба үлэмж үзлийг хүртэлх зам мөр, эрхэм зарлиг ба түүний үзэл санааны тайлбар сэлт, мөн бүх шат дарааллын утга учрыг






хураангуйлан багтаасан. Түүний зэрэгцээ тэр бүхнийг тогтоон бясалгаж өөриймшүүлэх, ажиглан бясалгаж өөриймшүүлэн задлан шинжилж сурх дарааллыг ч бас нэгтгэсэн юм. Тиймээс эрхэм зарлигийн бүх заавар журмыг өөртөө агуулж байгаа билээ.


Гэхдээ дарааллыг гүйцэд баримтлалгүй, задлан шинжлэх зарим нэг хэсгийг нь тойм төдий үзвэл агуу эх зохиолууд гарын авлага болохгүй, өнгөцхөн мэдлэгтэй л үлдэнэ. Агуу эх зохиолуудын утгыг ихэвчлэн задлан шинжилж байж өөриймшүүлдэг. Гэтэл энэ аргыг хэрэгсэлгүй орхивол эх зохиолуудыг шилдэг гарын авлага хэмээн үзэх итгэл үнэмшил хаанаас төрөх билээ! Хэрэв эх зохиолууд шилдэг гарын авлага биш юм бол тэр бүхнийг өгүүлсэн Будда хэн болох вэ?

Судрын ёсны гүнзгий, өргөн цар хүрээтэй үзэл санааны тайлбар зэргийг гарын авлага болгон мөрдөх ойлголттой болох хэрэгтэй. Тэгвэл тантрын ёсны гүн үзэл санааг тайлбарласан зохиол, ёс жаягийг хялбархан дагаж мөрдөж чадна. Улмаар түүнийг шилдэг гарын авлага хэмээн үзэх итгэл үнэмшил төрдөг. Мөн эх зохиолуудыг жинхэнэ гарын авлага биш гэж хоёрдугаарт тавьдаг буруу бодол үгүй болно.

## **В. Буддагийн үзэл санааг төвөгтүй ойлгуулах суу билэг**

Эрхэм зарлиг, түүний үзэл санааг тайлбарласан хөлгөн судрууд нь шилдэг гарын авлага мөн. Гэвч төгс судлаагүй эхлэн суралцагчид заавар журмыг сайтар мөрдөхгүй бол үзэл санааны утга учрыг ойлгохгүй. Ойлголоо ч маш их цаг хугацаа, бэрхшээл туулах






болно. Харин багшийн гарын авлагыг дагавал утга учрыг нь хялбархан ойлгодог.


Чухамдаа энэ *Бодъ төрийн зэрэг* нь аман айлдвэр болон бусад хөлгөн судрын далд утгыг амар хялбар ухаарагчад туслана. Энэ талаар тухайн үед нь дэлгэрэнгүй өгүүлэх болно.

**Г. Үлэмж гэмт үйлээс аяндаа холдуулах суу билэг Цагаан лянхуа болон Үнэнийг өгүүлэгчийн бүлэгт Буддагийн аман айлдвэр нь шууд болон дам аль ч утгаараа бүхэлдээ зөвхөн гэгээрэх арга замыг заасан гэж өгүүлсэн байдаг. Харин үүнийг ойлгохгүй, нэг хэсгийг нь гэгээрэх арга, нөгөө хэсгийг нь гэгээрэлд садаа болдог мэтээр бодох нь бий. Түүнчлэн сайн муу, хэрэгтэй хэрэггүй, Их Бага хөлгөн гэж ялгавартай ханддаг. Мөн “Бодисадва үүнийг сурх ёстой, түүнийг сурх ёстгүй” гэх зэрэгээр орхидог. Ингэвэл номлолыг зөрчине. Энэ тухай *Тийн хүлэгчийг хураангуйлсан судар*-т өгүүлэхдээ:**

Манзушири минь, номлолыг зөрчсон үйлийн уршиг маш нарийн болой. Буддагийн номлосон зарлигийн нэг хэсгийг нь сайн, нөгөөг нь муу гэж ойлговол номлолыг зөрчиж буй хэрэг. Номлолыг зөрчсөн хэн ч хууль цаазаас гажна. Энэ нь Буддаг үл тоомсорлож, хуврагийг доромжилсонтой адил.

Энэ нь зөв, тэр нь буруу гэвэл бас л номлолыг зөрчине. Бодисадва нарт зориулж хэлсэн, шарвагад зориулж хэлсэн гэвэл номлолоос гажсан хэрэг мөн. Мөн брадига нарт зориулж хэлсэн гэвэл номлолоос гажсан явдал мөн. Энэ бол бодисадва нарын сургаал






биш гэвэл бас л номлолоос гажиж байгаа хэрэг.




Номлолыг зөрчих нь маш их уршигтай. Энэ талаар  
*Бясалгалин хаан* сударт өгүүлэхдээ:


Суврага бүхнийг нурааж хэмхэчвээс  
Суух, унах там тодорхой  
Судрын аймгийн сахилаас гажих нь  
Суврага нураагчаас түмэнтээ гэмтэй.

Гангын элс шиг архадыг хөнөөвөл  
Гарцаагүй унах там тодорхой  
Эрдэмт судрын санваарыг гажаах нь  
Элс шиг архадыг хөнөөснөөс ч гэмтэй  
гэхчлэнгээр сээрэмжлүүлсэн билээ.

Ер нь номлолыг янз бүрээр зөрчдөг. Гэвч дээр дурьдсан хэлбэр түгээмэл учир сээрэмжлэх нь зүйтэй. Өмнө өгүүлсэн номлолыг зөрчих үйл, түүний уршигийн тухай ялихгүй ойлголттой болох төдийд алдаанаас зайлсхийж, гэм уршигаас аяндаа холдоно. Буруу ойлголтоос ангижрахын тулд *Үнэнийг өгүүлэгчийн бүлэг* болон *Цагаан лянхуа-г* олонтаа уншигтун. Номлол зөрчигдөх бусад хэлбэрийн талаар *Тийн хүлэгчийг хураангуйлсан судар-аас* мэдэж аваарай.









III

## НОМЛОЛ ЗААХ БОЛОН ТҮҮНД СУРАЛЦАХ ЖУРАМ

III. Хоёр агуу чанар бүрдсэн номлолыг сонсох,  
номлох зарчим

- A. Суралцах журам
  - 1. Номлол сонсохын ач холбогдлыг эргэцүүлэх
  - 2. Номлол болон багшийг хүндэтгэх
  - 3. Суралцах журам
- B. Номлол заах журам
  - 1. Номлол заахын ач тусыг эргэцүүлэх
  - 2. Будда болон номлолыг хүндэтгэх
  - 3. Номлол заах санаа болон дүр байдал
  - 4. Хэнд заах, заахгүйн ялгаа
- B. Төгсгөлд нь ерөнхийлөн өгүүлбэл





## A. Суралцах журам

Суралцах журам нь гурван хэсэгтэй:

1. Номлол сонсохын ач холбогдлыг эргэцүүлэх
2. Номлол болон багшийг хүндэтгэх
3. Суралцах журам

### 1. Номлол сонсохын ач холбогдлыг эргэцүүлэх

Сонсохын цоморлиг сударт өгүүлэхдээ:

Дуулж мэдвэл ахуй ёсыг танина  
Дуулж мэдвэл алив нүтглээс сална  
Дуулж мэдвэл ашигтгүй үйлийг тэвчинэ  
Дуулж мэдвэл арилсан нирваанд хүрнэ.

ГЭЭД:


Өрхийг бүтээсэн харанхуй гэрт  
Өмнө тавьсан өнгөт эрдэнийг  
Харах нүд байлаа ч гэсэн  
Хаанаас үзэж чадах билээ.


Саруул ухаан, эрүүл бие  
Сайхан завшаанд олдсон байлаа ч  
Сануулж дуулгасан сургаалгүй бол  
Сайн мууг ялгахгүйн зовлонтой.

Өрх татахад гэр гэрэлтэж  
Өмнөх эрдэнэс нүдэнд тодрох шиг  
Сонсож дуулсны ид эрдэм  
Сохор өртөнцөд хараа оруулна.

Түүнчлэн Төрөл дамжсан үадиг-т:

Дуулж мэдэхэд сүсэг төрнө  
Дутуугаа нөхөх урам төрнө  
Тоост хорвоогийн мунхагаас сална  
Тохой биеэ ч гэгээрлээс солино.





Мэдэж дуулсны гэрэлт бамбарыг  
Мэхтэн гохтууд ч булааж чадахгүй  
Мэнэрч шүлэнгэтэх хорвоогийн хилэнцийг  
Мэдүүлж чамайт аврах нь л үнээн.

Буян, хишиг дундрахын цагт ч  
Буруулж урвахгүй сайн янаг  
Далдны өвчнийг дарах мөртлөө  
Дарвигнах гашуунгүй гайхамшигт эм


Суут гэгээдийн нудэнд өртөж  
Суугаа хуврагуудаас ч тодорч харагдана  
Ихэс дээдсийн таалалд өртөж  
Эгнэсэн сайчуудаас ч ялгарч танигдана.


Гээд мөн:

Дуулж мэдсэн хойноо хэргийг нь гаргавал  
Дундуур төрлийн хэлхээнээс ангижирна.  
гэхчлэнгээр өгүүлсэн байdag.

Тиймээс суралцахын ач холбогдолд чин сэтгэлээсээ итгэх хэрэгтэй.

Түүнчлэн *Бодисадвагийн төвшин*-д доор дурьдсан таван санаагаар сонсохын ач холбогдлыг илэрхийлжээ. Будда мэндлэх нь өдрийн од шиг ховор, түүний номлол ч ховор учир эрдэнэ гэж бодох(1). Номлол сонсох тусам мэдлэгийн хүрээ өргөжиж байдаг учир билэг оюуныг нээгч нүд гэж бодох(2). Билэг оюуны мэлмийг гийж бодит ахуй хийгээд юмс үзэгдлийн мөн чанарыг ухаардаг тул гэгээ гэж бодох(3). Эцэстээ нирваан ба агуу гэгээрлийн үр боловсрох учир агуу ач тустай гэж бодох(4). Тэгээд дээрх хоёрын үндэс болсон тайван төлөв, үлэмж үзлийн амгаланг эдлүүлэх учир эргэлзээгүй гэж бодох(5). Энэ дагуу сэтгэж, судалж суралцахын ач холбогдлыг тунгаа.





## 2. Номлол болон багшийг хүндэтгэх

Кишиигафбха судар-т ийн өгүүлдэг:

Дээдийн номыг анхааран сонс  
Дэглэх, сонжих эргэлзээгээ орхи  
Дэргэд чинь номлох ерөөлтэй багшaa  
Дээд Буддатай адилаар тахигтун.


Энд өгүүлснээр багшийг Будда хэмээн үзэж, арслант ширээнд залах зэргээр бусад өргөл хүндэтгэлийг үзүүлж, хүндэтгэлгүй хандахыг цээрлэх хэрэгтэй.


Мөн *Бодисадвагийн төвшин*-д ямар нэг буруу санаагүй, багшийн тухайд таван буруу бодол агуулалгүй сонс гэсэн дагуу суралцах хэрэгтэй. (1) Цаг тухайд нь сонсох, (2) тахин өргөмжилж, (3) хүндэлж, (4) уцаарлахгүй, (5) хэлснийг нь биелүүлж, (6) сул талыг нь өөчлөх ийм зургаан бодолгүй бол ихэрхүү зан гаргахгүй суралцах гэнэ. Номлол болон багшид биширч, тэр хоёрт тоомжиргүй хандсан бодолгүй байхыг хайхрамжгүй зан гаргалгүй суралцах гэдэг. Багшийн тухайд таван буруу бодол агуулалгүй суралщаын тулд (1) ёс суртахуунгүй, (2) гарал угсаа доогуур, (3) зүс царай муу, (4) ярих чадваргүй, (5) ширүүн үг хэлтэй гэж бодож болохгүй.

Мөн *Төрөл туулсан үадиг*-т:

Адаг хавыцаа даруухан сууж  
Ааш зангиин дөлгөөнийг сахиж  
Ашид баясгалант харцыг цогцлоож  
Рашаан хүртэх шиг номыг сонс oo.

Үлэмж сүжиглэх үнэнхүү сэтгэлээр  
Үзтэл танигдах бишрэлийг үүсгэн  
Үхлээс гэтэлгэх эм хүртэх шиг





Үймэрсэн сэтгэлээ төвлөрүүлэн  
Үнэн сүсгээр номыг сонс oo.  
хэмээсэн байна.

### 3. Суралцах журам

Энэ нь хоёр хэсэгтэй:

1. Шавийн гурван алдааг цээрлэх
2. Зургаан төрлийн төсөөлөл хөгжүүлэх

#### a. Шавийн гурван алдааг цээрлэх


Хөмөрсөн (1), дээшээ харсан ч бохир (2), бохирдоогүй ч ёроол нь цоорхой (3) саванд тэнгэрээс хур буувч дотор нь тогтохгүй. Тогтсон ч бохирдож ундны хэрэгцээг хангахгүй, бохирдоогүй ч дотор нь тогтохгүй савирч дуусна. Түүнтэй адил номын хүрээнд байсан ч анхааралтай сонсохгүй (1), анхааралтай сонссон ч буруу ойлгох, санаа бодол нь ондоо (2), эсвэл дээрх алдааг гаргахгүй ч сонссон үг ба утгыг нь тогтоохгүй мартах (3) зэрэг сул тал гаргавал номлол сонссоны хэрэг төдийлөн гарахгүй тул цээрлэх хэрэгтэй.


Сударт дээрх гурван дутагдлаас ангид байхын тулд “Сайтар сонс, анхааралтай бай, тогтоо” гэдэг гурван санааг хэлсэн байдаг. Мөн *Бодисадвагийн төвшин*-д бүгдийг мэдэх хүслээр анхаарлаа төвлөрүүлэн, гүн хүндэтгэлтэй, хамаг оюун бодлоороо сонс гэжээ.

#### б. Зургаан төрлийн төсөөлөл хөгжүүлэх

1. *Өөрийгөө өвчтөн хэмээн төсөөлөх.* Шантидэва *Бодисадвагийн замнал*-даа:

Энгүүн нэг шуухнаа тусахад  
Эмчийн зөвлөснөөр эдгээх байтал






Хүсэх, шунах олон гэмүүдэд  
Хүндээр нэрвэгдсэнээ яалтай билээ.  
хэмээн дурьджээ.


Бид өнө эртнээс эмчлэхэд бэрх, ужиг зовлон үүсгэгч өвчин болох хүсэл шунал мэт сэтгэлийн гэмтэй явж ирсэн тул цаг үргэлж өвдөж байсан гэдгээ ухаарах ёстой. Гамаба “Үнэндээ өвдөөгүй ч өвчтэй гэж бодвол бясалгал буруу болно. Гэтэл бид сэтгэлийн гурван хорын архаг өвчинд баригдаж, маш их тарчилж буйгаа даанч ухаардагтгүй” гэсэн байдал.

*2. Багшийг эмч хэмээн төсөөлөх.* Жишээ нь хий, шар мэтийн хүнд өвчин тусвал сайн эмч хайдаг. Хайсан эмчээ олвол бөөн баяр хөөр болж, хэлснийг нь бишрэнгүй сонсож хүндэлдэг. Үүн шиг номлол заах багш хай, олсон хойноо тээршаалгүй чимэг гэж тооцон хэлснийг нь хүндэтгэн биелүүлэх хэрэгтэй. Эрдэнэт эрхэм чанарын хураангуй-д энэ тухай:

Багшилж замчлах бодисадваг хайн олоод  
Бардам омгоо баттай итгэлээр дарж аваад  
Ужиг өвчнөө отчийг шүтэн эмчлүүлэх адил  
Ухаарал итгэлээр ачит багшаа дээдлэн шүт.  
хэмээсэн байна.

*3. Дагаж төрдөх гарын авлагыг эм хэмээн төсөөлөх.* Өвчтөн эмчийн өгсөн эмийн жорыг ихэд эрхэмлэн үздэг. Түүн шиг багшийн өгсөн гарын авлага, сургаал маш тустай болохыг ухамсарла. Машид хичээнгүйлэн дээдлэхийн зэрэгцээ түүнийг нь мартаж, орхигдуулж огтхон ч болохгүй.







4. Хичээнгүйлэн дагавал өвчин эдгэнэ хэмээн төсөөлөх. Өвчтөн эмчийн өгсөн эмийг уухгүй бол өвчин нь эдгэхгүй гэж ухамсарлан ойлгож уудаг. Үүнтэй адил багшийн зааврыг дагахгүй бол хүсэл шунал мэтээ дарж чадахгүй болохыг ухаарч, хичээнгүйлэн дагах хэрэгтэй. Дагаж мөрдөхгүй бол өч төчнөөн номлол сонсоод ч хэрэг болохгүй.

Хулгана яр гарахад хөл, гар тасарч унадаг. Энэ үед ганц нэг тун эм уугаад ямар ч нэмэр болохгүй. Гэтэл бид тогтоох аргагүй цаг хугацааны эхнээс л сэтгэлийн гэм (нисванис)-ээс үүссэн архаг өвчинөөр өвдсөн учир ганц нэгээр тоологдох гарын авлага дагаад тусаар бага. Зам мөрийн үе шат бүхэнд бүрэн гүйцэд суралцахын тулд билэг оюунаар тухай бүрд нь гярхай шинжлэн судалж, голын урсгал мэт тасралтуй хичээх нь чухал. Их багш Чандрагомин *Налинчалын лагтаал*-даа:

Тухайлсан сэтгэлийн гэм нүгэл  
Тунаж цаана нь шүглэсэн хойно  
Тулах, хугарах, яртах эмгэгийг  
Тун эмээр анагааж бараахгүй.  
хэмээн сургасан юм.

Учир иймээс өөрийгөө өвчтөн гэж бодох нь маш их ач тустай. Ийм бодолтой байхад дээрх бусад төсөөлөл бий болно. Харин үүнийг чихнийхээ хажуугаар өнгөрөөвөл сэтгэлийн гэм (нисванис)-ээс салгах учиртай сургаалын хэрэг гарахгүй, сонссон болоод л өнгөрнө. Эмчид үзүүлчихээд, хэлсэн эмийг нь уухын оронд эмийнх нь жорыг уншаад байгаа өвчтөнтэй адил болох тул өвчинөөс салахгүй. Энэ тухай *Бясалгалин хаан* сударт:





Олон жилийн хууч өвчинөөс  
Огтхон ч салаагүй хөөрхий амьтас  
Он удсан сэтгэлийн гэмээс салах гэж  
Оточ, маарамбыг зорих бөлгөө.

“Энэ ч, тэр ч туслана даа” хэмээн  
Элдэв долоон маарамбыг дуусгаад  
Эцэст нь уулзсан оточ түүнд  
Эм танг нь тааруулж өгнө өө.

Хосгүй оточтой учирсан атлаа  
Ховорхон эмийг залсан атлаа  
Эмчилж, хэрэглэж эдгээгүй бол  
Эмэнд ч, отчид ч буруу нь юусан.

Яг л үүн шиг номлол сонсчихоод  
Яруу алдар, утгыг таньчихаад  
Явах замналаа л болгохгүй юм бол  
Яасан ч хорвоогийн зовлонгоос салахгүй ээ.


Гээд цааш нь:


Сайн номыг би номлолоо ч  
Сайтар чи дагахгүй л юм бол  
Савтай эм өвөртөлж явснаар  
Салга өвчинөөсөө салахгүйтэй адил.  
гэсэн байдаг билээ.

Мөн Шантидэва *Бодисадвагийн замнал*-даа:

Эмийн жор уншиж, сонсоод  
Эдгэрдэг өвчин байхгүйн адилаар  
Эрхэм сургаалыг хоосон цэцлээд  
Эрэмбэ зиндаа өгсдөг учиргүй ээ.  
гэх зэргээр өгүүлсэн билээ.

Тиймээс л “Өвчин эдгэнэ гэдэг төсөөлөл төрүүлэхийг





хичээ” гээд байгаа юм. Харин “хичээнгүйлэн дагана” гэдэг нь багшийн хэлсэн авч гээх бүхнийг амьдралд хэрэгжүүлнэ гэсэн үг. Хэрэгжүүлэхийн тулд мэддэг байх хэрэгтэй. Мэдэхийн тулд сонсох ёстой. Сонсож байж ухаарах учиртай. Сонссон зүйлээ хэр чадлаараа хэрэгжүүлж байж сонссоны хэрэг гарна. Энэ тухай *Сонсохын цоломрлиг*-т:

Ерөөс сонссон нь муンдахгүй атлаа  
Ёс журмаас гажуу явбал  
Ёс суртаалыг гажаасанд унаж  
Ерөөсөө сонссоны хэрэг гарахгүй ээ.

Ерөөсөө сонссон нь алдаг оног ч  
Ёс суртаал сахиж чадваас  
Ёс суртаалыг өргөсний сайшаалаар  
Ерийн сонсонууд ч эрдэм болно оо.


Ерөөс сонссон нь ч алдаг оног  
Ёс суртаал ч бүдэг бадаг  
Юм юм гутамшигт унавал  
Янз төлөв доройтож муудна.


Ерөөсөө сонссон нь үлэмж их  
Ёс суртаал үнэхээр дээд  
Аль аль нь нийцэж байвал  
Ааш төлөв сайхан болно.

Гээд үргэлжлүүлэн:

Сайхан зарлигийн утгыг тайлж  
Санаа сэтгэлээ өгөхүйг ухаарлаа ч  
Сатаарч, уймарч хойрго хандвал  
Санаж сэргний хэрэг гарахгүй ээ.

Ачит багшийн номлолд баясч  
Аль бүхнээр сахилд хичээж





Адыг хазаарлаж, гэгээрлээр баясваас  
Алив ухаарал туйлдаа хүрнэ.  
хэмээн яруу өгүүлдэг.

Мөн *Үлээж сэтгэлийн шаардлага* сударт:

Үхэхийн цагтаа тэнэгүүд тарчилж  
Үзтэл хийгээгүй бүхэндээ гаслана  
Үүнийгээ санаагүй насаа барсан нь  
Үгээр хоосон номчирхсны балаг л даа.

Гээд цааш нь:

Амьдрал бус жүжгийг хараад  
Аль нэг явдлыг шагшигч нэгэн шиг  
Алмай хоосон цэцэрхээд л явбал  
Адилхан амсана шүү, тэнэгүүдийн зовлонг.


Мөн түүнчлэн:


Амтат журжийн гадуур хальсанд  
Амт шимт нь байдаггүй юм хойно  
Аргасан хальсыг нь зажилсан амьтан  
Анхилуун, тамсагийг нь мэдэхийн аргагүй.

Уралцаж, номчирхвол хальс хазах мэт  
Утгыг танивал жимсийг хүртэх мэт  
Удтал төөрсон номчирхлоо буцаа  
Утгыг эрж, сэрэмжээ хичээ  
гэх зэргээр айлдсан билээ.

5. *Буддаг төгс гэгээрэгч хэмээн төсөөлөх.* Номлол айлдагч Буддагийн эрдэм чадлыг санаж бодон төгс гэгээрэгч хэмээн биширнэ.

6. *Буддын шаин өнө удаан оршиг хэмээн төсөөлөх.*  
“Энэхүү номлолыг судалж буйгаас үүдэн Буддагийн





айлдсан номлол энэ ертөнцөд өнө удаан орших болтугай!” гэж бодно.

Бас номлол номлож, судлахдаа ном, сэтгэл хоёр ангид байвал ач тус нь гарахгүй. Тиймээс өөрийнхөө сэтгэлтэй ижилсүүлэх үүднээс л судлах хэрэгтэй. Улгэрлэвэл, нүүрээ цэвэрхэн эсэхийг мэдэхийн тулд толинд харж, хирээ арилгадаг. Үүнтэй адил өөрийн зан байдлын дутагдлыг номлол судлан, номын толинд харна. Улмаар “Миний байгаа байдал энэ” гэж сэтгэл зовнино. Тэгээд дутагдлаа засаж, эрхэм чанар эзэмшихийн тулд номлолыг дагаж, суралцах хэрэгтэй. *Төрөл туулсан цадиг*-т Судасигийн хүү бодисадва Сутасомагаас номлол заалтая хэмээн хүсэхдээ доорх угийг хэлдэг:


Ариун номын толинд хартал  
Алмай муухай төрхөө үзлээ  
Алмай мунхаг төрхөө таньмагц  
Ашигд гэгээрэхийн хүслэн төрлөө.


Ингээд бодисадва уг хөвүүнийг номлолд суралцах жишигт хүрснийг нь анзаарч ном заасан гэдэг.

Товчондоо, гэгээрэх тэмүүлэл төрүүлэхдээ доорх зүйлийг бодно:

Би амьтан бүхэнд туслахын толөө гэгээрлийн төвшинд хүрье. Тэр төвшинд хүрэхийн тулд түүний үндсийг нь эзэмших ёстой. Эзэмшихийн тулд мэдэх хэрэгтэй. Мэдэхийн тулд ном судлах шаардлагатай учраас номлол сонсоё.

Сонсохын ач холбогдлыг санан урам зоригтой байж, шавийн гурван алдаанаас цээрлэн номлол сонсохтун.





## Б. Номлол заах журам

Энэ нь дөрвөн хэсэгтэй:

1. Номлол заахын ач тусыг эргэцүүлэх
2. Будда болон номлолыг хүндэтгэх
3. Номлол заах санаа болон дур байдал
4. Хэнд заах, хэнд заахгүйн ялгаа


### 1. Номлол заахын ач тусыг эргэцүүлэх


Ашиг хонжоо, алдар нэр, эд хөрөнгө харалгүй номлол заах нь маш ач тустай үйл юм. Энэ тухай *Үзэлж сэтгэлийн сануулга* ном-д өгүүлэхдээ:

Майдар аа, эд хөрөнгө, нэр хүнд горьдоогүй номын өглөгийн ач тус нь дараах хорин зүйл буюу: (1) Ой санамж сайжрах, (2) ухаан саруулсах, (3) ухаарч ойлгох, (4) тууштай болох, (5) билэг оюунтай болох, (6) бэлгэ билгүүнтэй болох, (7) хүсэл шунал багасах, (8) уур уцаар багасах, (9) төөрөгдөлгүй болох, (10) муу сэтгэлд автагдахгүй, (11) ялж төгс гэгээрэгсийн таалалд нийцэх, (12) хүнээс бусад нь хамгаалах, (13) тэнгэр сахиус ивээх, (14) хөндлөнгийн хүний хорлолд өртөхгүй, (15) элгэн садангүүд орхихгүй, (16) бусад хүн үгэнд нь итгэх, (17) айх аюулгүй болох, (18) сэтгэлийн амгалан ундрах, (19) мэргэд магтан сайшах, (20) номын өглөг нь хожим дурсагдах эдгээр болно.

Судар номд олонтаа өгүүлдэг эдгээр ач тусанд үнэн голоосоо итгэх хэрэгтэй.

Дээр гарсан “тууштай болох” гэдэг санааг





Шантидэвагийн *Хураангуй* заавар журам-ын орчуулгад “шинээр сүсэг төрөх” гэж буулгажээ. Харин зарим хуучин орчуулгад “идэвх зүтгэлтэй” гэж байдаг.


## 2. Будда болон номлолыг хүндэтгэх


Ялж төгс гэгээрсэн Будда *Билгийн чандад хүрэхүй* номоо айлдахдаа өөрөө суудал засан бэлтгэж байсан юм. Номлолыг гэгээрэгсэд ч дээдлэн хүндэлдэг учир түүнд гүн хүндэтгэлтэй ханд. Багшийн эрхэм чанар болон түүний сургаал номынх нь ач тусыг санан дурсаж сүсэглэх хэрэгтэй.

## 3. Номлол заах санаа болон дүр байдал

*Сагартатийн асуултад хафиулсан* сударт дурьдснаар номлол заахдаа сэтгэлдээ таван санаа агуулна. Өөрийгөө эмч, номлолыг эм, номлол сонсогчийг өвчтөн, Буддаг төгс гэгээрэгч гэж үзэх ба “Буддын шашин өнө удаан орших болтугай” гэсэн бодолтой бай. Мөн номын нөхдөө хайрлах нь зүйтэй. Харин бусад нь надаас илүү гарчихвий гэсэн атаархал, хойш тавин залхуурах, ахин дахин номпохоос зүрхшээх, өөрийгөө магтаж өрөөлийг муулах, номоо харамлах, хоол хувцас мэтийн эд таваар горьдох зэргийг цээрлэвэл зохино. “Өөрийгөө болон бусдыг гэгээрэлд хүргэхийн төлөө номлол заасан буян маань жаргалын эх булаг” гэж бодож бай.

*Номлол заах дүр байдал.* Эхлээд усанд орж, цэвэрхэн хувцас өмсөнө. Тэгээд сэтгэлд тааламжтай, цэвэрхэн орчинд номлолын суудлаа засна. *Сагартатийн асуултанд хафиулсан* сударт муу сэтгэлийг ниргэх тарнийг дуулдахаар уншвал





эргэн тойрны зуун багцад зайд шулам болоод шулмын аймгийнхан ойртохгүй, ойртсон ч саад хийж чадахгүй гэж заасан тул эл тарнийг уншаарай. Ингээд баясгалантай төрхөөр, угтыг нь гаргахуйц жишээ авч, гаргалгаа нотолгоо хийж, эх бүтээлүүдээс иш татан заах нь зүйтэй. *Дээдийн номлол цагаан лянхуа*-д энэ тухай:

Номлол хичээлийг атаагүй заа  
Ноттой үлгэр олонтой заа  
Шантарч залхалгүй шургуу заа  
Шавилагчийн алмайд няцалгүй заа.


Мэргэдийн цээрийг сахиж заа  
Мэдлэгт дурлагчийг баясуулан заа.  
  
Үргэлж, завсаргүй номлолоо бясалгаж  
Үлгэр жишигээгэр мянгантаа нотолж  
Үй олонд баясгалан түгээвч  
Үнэндээ багш бол юу ч гүйхгүй.


Ужиг өвчтэй ч эм гүйхгүй  
Унтмаар байсан ч хэвтэр гүйхгүй  
Умдаасч өлслөө ч идэш гүйхгүй  
Улаан нүүцгэрсэн ч хувцас гүйхгүй  
Үлдаж тамирдсан ч унаа гүйхгүй  
Учир нь, багш шунах ёсгүй.

Багш мэргэд гэгээрэлдээ дурлаж  
Бас олныг гэгээрүүлэхэд шимтэж  
Амьд бүгдийг дээшлүүлэх үйлээрээ  
Аз жаргалаа ундраадаг номтой  
Хэмээн айлдсан юм.

#### 4. Хэнд заах, хэнд заахгүйн ялгаа

Эс зүйн сударф-т “Хүсээгүй бол бүү заа” хэмээн хэнд заах, хэнд заахгүйн ялгааг гаргасан байдал. Энэ ёсоор





хүсээгүй нөхцөлд номлох хэрэггүй. Мөн хүссэн байлаа ч номлол сонсоод хэрэгжүүлж чадах эсэхийг нь шинж. Харин номлолыг хэрэгжүүлж чадахаар нэгэн байвал өөрөө хүсээгүй байсан ч зааж болно.

Энэ тухай *Бясалгалын хаан* сударт:


Дээдийн номыг чамаас сонсох гэж  
Дэргэд чинь шавилах хүн ирвэл  
Дэвэрч хөөрөн номчирхохын оронд  
“Дэндүү чамламаар мэдсэн” гээрэй.


Сайхан багшийн ач буянаар  
Сайтар чи гэгээрсэн ч байлаа  
“Тан шиг дээдэст мөхөс над шиг нь  
Таарахгүй хонгөднө” гээд үзээрэй.

Оройн дээд номлогоосоо урьтаж  
Оюуны савыг нь шинжээд үзээрэй  
Ариун савтай, гэгээрэх хүнийг бол  
Асуухаас нь өмнө номлоод эхлээрэй  
гэж өгүүлсэн байна.

Үүнээс гадна *Ёс зүйн судар*-т ийн өгүүлсэн байдаг:

Суугаа хүнд зогсоогоор номлол бүү заа. Хэвтээ хүнд суугаагаар номлол бүү заа. Өөрөөсөө өндөрт сууж буй хүнд доороос нь номлол бүү заа. Зөв буруу нь үүнээс хамаарна. Өмнөө яваа хүний араас нь номлол бүү заа. Замаар яваа хүнд замын хажуугаас номлол бүү заа. Толгойгоо битүүлсэн, биеэ битүү ороосон болон элгээ тэвэрсэн, гарцаа салаавчилж дэрлэсэн зэрэг нөхцөлд номлол зааж болохгүй. Орой дээрээ үсээ овоолсон, малгай эсвэл титэмтэй, элдэв эрхи зүүсэн, чалма ороосон хүнд номлол зааж болохгүй. Заан,





морь унасан, сүйх эсвэл дамнуурганц ямбалсан, мөн гуталтай хүнд номлол бүү заа. Бас гартаа таяг, шүхэр болон илд мэтийн зэвсэг барьсан ба хуяг дуулга агссан хүнд номлол зааж болохгүй.


Харин дээр дурьдсанаас бусад бүх нөхцөлд номлол зааж болно. Энэ бол эрүүл хүнд зориулагдсан заавар юм.


## **В. Төгсгөлд нь ерөнхийлөн өгүүлбэл**

Номлох, сонсохоос бий болсон бүх буянаа хэтийн болон ойрын зорилгоо биелүүлэхэд зориулан залбирна.

Номлол заах, сонсох журам нь зөв бол тухайн үйл ажил хэдий цөөхөн хором байлаа ч өмнө дурьдсан ач тус гарцаагүй ирнэ. Номлол болон багшид сүсэглээгүйгээс үүдсэн урьд насны үйлийн хор уршиг нь номлол заах, сонсох журмыг дагавал арилна. Мөн дахин шинээр тийм үйлийн үр хуримтлагдахгүй. Номлол заах, сонсох журмыг дагавал зааж, сургасан гарын авлага нь өөрт хэрэг болно гэж урьдын ихэс дээдэс номлол заах журамд ихээхэн хүч тавьж иржээ. Ялангуяа *Бодь мөрийн зэрэг-ийн уламжлалыг өвлөсөн* багш нар энэ тал дээр ихэд анхаардаг байсан юм.


Энэ бол дагавал зохих гарын авлага мөн. Хэрвээ үүнийг ойлгохгүй, үүгээр сэтгэл нь огтхон ч өөрчлөгдөхгүй бол өөр ямар ч гүнзгий, дэлгэрэнгүй номлол заалгасан, бурханаа буг болгоно гэдэг шиг гэгээрлийн үндэс болсон номлолоо сэтгэлийн гэм (нисванис)-ийн өрөөсөн дугуй болгох явдал элбэг тохиолдоно. Тиймээс “шинийн нэгнийг эндүүрээгүй бол арван тавныг хүртэл төөрөлдөхгүй” гэдэг шиг номлол сонсож, судалсанаа мөрдлөг болгох энэ ёсыг









ухаантнууд баримталдаг. Номлох, сонсох боломж гарах бүрт ядахдаа хүсэл эрмэлзэлтэй бай. Номлол заах удиртгал болгон үүнийг өгүүллээ.

Олон үг нуршихгүйн үүднээс чухал чухал зүйлийг нь хураангуйлан өгүүлэв. Бусад эх бүтээлүүдээс энэ талаар дэлгэрүүлэн үзээрэй. Номлол заах удиртгальг өгүүлж дууслаа.








IV


## БАГШИЙГ ШҮТЭХ ЁС

### IV. Жинхэнэ гарын авлагаар шавийг сургах дараалал

А. Багш шавийн барилдлага бол гэгээрлийн үндэс

1. Ойлголт өгөхийн тулд дэлгэрэнгүй өгүүлэх
  - a. Шүтвэл зохих багшийн шинж чанар
  - b. Багшийг шүтэх шавийн шинж чанар
  - c. Шавь нь багшийг шүтэх ёс
    - 1) Багшийг шүтэх санаа бодол
      - a) Багшийг шүтэх ерөнхий хандлага
      - b) Гол үндэс болох сүсгийг бататгах
      - c) Багшийн ачийг дурсан санаж бишрэх
    - 2) Багшийг шүтэх үйл ажил
  - g. Багшийг шүтэхийн ач тус
  - d. Багшийг эс шүтэхийн гэм зэм
  - e. Дүгнэлт





#### IV. Жинхэнэ гарын авлагаар шавийг сургах дараалал

Энэ нь хоёр хэсэгтэй:

1. Багшийг шүтэх ёс (4-6 дугаар бүлэг)
2. Багшийг ёсчлон шүтсэн шавь хэрхэн суралцах тухай (7 дугаар бүлгээс хойш)

##### A. Багшийн барилдлага бол гэгээрлийн үндэс

Багшийг хэрхэн шүтэх тухай хоёр хэсгээр тодорхой тайлбарлана:

1. Ойлголт өгөхийн тулд дэлгэрэнгүй өгүүлэх (4 дүгээр бүлэг)
2. Бясалгах журам (5-6 дугаар бүлэг)

##### 1. Ойлголт өгөхийн тулд дэлгэрэнгүй өгүүлэх


Адишагийн *Гол агуулгын дээж-д*:


Их хөлгөний бүлд багтсан хүн  
Эрхэм багшид өөрийгөө даатгадаг  
Хэмээсэн.

Мөн Долбагийн эмхэтгэсэн *Бодовагийн сургаал* зохиолд:

Гэгээрлийн багшид үнэнч байх нь бүх гарын авлагын гол утга учир юм.  
Гэсэн байдаг.

Шавь ямар нэг эрхэм чанарыг эзэмших, алдаа дутагдлаас салахаас эхлээд аливаа сайн сайханд хүрэх нь гагцхүү гэгээрлийн багшаас хамаардаг. Тиймээс юуны түрүүнд багшийг шүтэх ёстой. *Бодисадвагийн эрдэм тэдлэгийн чуулбар-т* ийн өгүүлжээ:





Товчоор хэлбэл, бодисадвагийн үйл хэрэгт суралцах, түүнийг төгс эзэмших, улмаар төгс чанарын туйлд хүрэх. Мөн зам мөрөөр төвшин ахиж, тэвчээр, бясалгалын төвлөрөл, шууд танин мэдэхүйг эзэмших, үзсэнээ хэрэгжүүлэх, энэ бүхнийг эцсийн зорилгод чиглүүлэх болон гэгээрлийн төвшний эрхэм чанарыг эзэмших хийгээд бүрэн гэгээрэх нь зөвхөн багшаас шалтгаалдаг. Багш бол энэ бүгдийн үндэс, тэрээр дээрх чанаруудыг соёолуулна. Багш бол тэр бүхний эх булаг, дээрх чанарууд түүнээс л ундарна. Багш тэдгээр чанаруудыг хөгжүүлнэ, улам арвижуулна. Багш бол энэ бүхний тулгуур нь, нөхцөл нь билээ.


Мөн Бодова энэ тухай хэлэхдээ:


Төгс нирваанд хүрэхэд багшаас илүү хэрэгтэй зүйл үгүй. Эгэл жирийн амьдралд ч багшгүй бүтэх юм байдаггүй. Гэтэл муу төрлөөс дөнгөж ирчихээд огт мэдэхгүй замаар багшгүй явж болох уу даа?  
Хэмээсэн юм.

### a. Шүтвэл зохих багшийн шинж чанар

Ер нь эрхэм зарлиг болон түүний тайлбарт хөлгөн бүр өөр өөрийнхөөрөө багшийн шинж чанарыг тодорхойлсон байдаг. Харин энд гурван төвшний хүнийг Их хөлгөний зам мөрөөр хөтөлж төгс гэгээрлийн төвшинд хүргэх багшийн тухай ярих болно. Энэ талаар *Судар аймгийн чимэгт-т өгүүлэхдээ*:

Номхорсон, амгалан, амарлингүй  
Эрдэм чадлаар үлэмж, хичээнгүй, арвин мэдлэгтэй  
Оршихуйн мөн чанарыг ухаарсан, уран илтгэдэг  
Энэрэнгүй, ажилдаа дур сонирхолтой багшийг шүт.





Ийм арван сайн чанар шингээсэн багшийг шүтэх ёстой хэмээн хутагт Майдар өгүүлжээ.

Мөн өөрийн сэтгэлийг номхотгоогүй бол бусдын сэтгэлийг номхруулж чадахгүй гэж хэлсэн учир бусдын сэтгэлийг номхруулах багш эхлээд өөрийн сэтгэлийг номхруулсан байх учиртай. Харин хэрхэн номхруулдаг вэ? Зөвхөн өөрт аль хялбарыг нь дагаж, бусад эрхэм чанаруудыг оромдоод орхичихсон хүн бусдад тус нэмэр болохгүй. Харин Буддагийн сургаалыг бүхэлд нь даган өөрийгөө номхотгох хэрэгтэй. Тэр сургаал нь эрдэнэ мэт гурван заавар журамд багтана. Түүнийг номхруулах тэргүүтэй гурван заавар журам гэх нь ч бий. *Сэтгэлийг номхотгоно* гэдэг нь ёс зүйн заавар журам дагана гэсэн уг. Энэ тухай *Аминчлан гэгээрэхүй номд*:


Аргамжаа, чөдөргүй ардаг догшин  
Аргамаг, эмнэг сэтгэлийн хүлэгт  
Амгай, хазаар, ташуур тааруулж  
Аль хүссэнээрээ залах нь гэгээрэл  
хэмээсэн байдаг билээ.


Мөн *Айлдварын утгыг тодруулах бүлэг*-т ийн дурьджээ:

Ёс суртахуун бол номхроогүй шавийн хазаар билээ.

Эмнэг сургагчид сайн хазаар чухал байдаг. Түүнтэй адил сэтгэл буруу мэдрэхүйд татагдаж, догшин морь шиг буруу тийшээ зүтгэхийг нь хазаарлан зогсоон ёстой. Зөв чигт хандуулдаг ёс зүйн заавар журмыг хичээнгүйлэн дагавал сэтгэл хэмээх догшин морь номхорно.

*Амгалан* гэдэг нь санамж, сэрэмждээ тулгуурлан зөвийг дагаж, буруугаас зайлсхийж, дотоод сэтгэлийн





амгаланг олдог сэтгэл төвлөрлийн заавар журмыг эзэмшихийг хэлнэ.

*Алафлингүй* гэдэг нь сэтгэлээ жолоодсон амгаланд түшиглэн, үнэмлэхүй үнэнийг задлан шинжилдэг билэг оюуны заавар журам юм. Гэхдээ гурван заавар журмаар өөрийн сэтгэлийг номхотгох нь хангалтгүй. Багш хүн онолын эрдэмтэй байх учиртай. Гурван аймаг савын мэдлэгтэй байхыг *аравин тэдлэгтэй* гэдэг. Донбова “Багш нь Их хөлгөнийг олонтаа судалсан, өргөн мэдлэгтэй байх ёстой, гэхдээ хүн бүрийн хэр хэмжээнд тохирсон, хэн бүхэнд хэрэг болох гарын авлага өгч чаддаг байх учиртай” гэсэн байдал.


*Оршихуйн мөн чанарыг ухаарах* гэдэгт юмс үзэгдлийн Би - угүй мөн чанарыг ойлгосон билэг оюуны охь болсон онцгой чадвар болох үнэнийг шууд танин мэдэхүйг эрхэмлэн үздэг. Ийм чадваргүй ч гэсэн онол болон учир шалтгааны үүднээс ойлгон тайлбарладаг байх ёстой.

Харин багш хүн эдгээр чадвар, мэдлэгээр шавиасаа доогуур эсвэл адилхан байж таarahгүй, үлэмж илүү байх учиртай. *Гэгээрлийн багшийн тухай цотолригт* энэ талаар ийн өгүүлсэн байдал:

Өөрөөсөө доорхыг дуурайваас уруудах  
Өөр шигтэйгээ зэрэгцэл ахижгүй мухардах  
Өндөрт байгааг дагавал улам дээшлэх  
Өмнөө түрүүлэгчийг ямагт дагагтун.

Амгалант сэтгэл, ёс суртаалтанг  
Амьтанд үлгэрлэгч гэгээн оюунтанг  
Ашид дагах үлгэрээ болговоос  
Аяндаа чи үлэмж сайн болноо.






Пүчүнба нэгэнтээ “Суут дээдсийн намтрыг сонсоод өөртөө илүү их зорилго тавьсан” гэжээ. Мөн Тааши “Би Радэнгийн хийдийн ахмад үеийнхнийг өөрийн үлгэр дууриалаа болгосон” хэмэн хэлсэн байдал. Энэ дагуу өөрөөс эрхэм чанараар илүү нэгнийг үлгэр дууриал болгох нь чухал. Дээр дурьдсан номхорсон, амгалан, амирлангуй, арвин мэдлэгтэй, эрдэм чадлаар үлэмж илүү, оршихуйн мөн чанарыг ухаарсан зургаан чанар нь багш хүн өөрийгөө хөгжүүлэхэд хамаарна. Харин шавийн ой тойнд буухаар уран өгүүлдэг, энэрэнгүй, ажилдаа дур сонирхолтой, хичээнгүй дөрвөн чанар нь шавийг сургахад шаардагдана.


Энэ тухай Будда ийн хэлсэн юм:

Будда хилэнцийг усаар угаадаггүй  
Бусдын зовлонг гараар арилгадаггүй  
Өөрийн эрдэм чадлыг өрөөлд юулдэггүй  
Үнэн жам ёсыг таниулан гэгээрүүлдэг.

Гэгээрэгсэд бусдад эргэлзээгүй үнэний зам мөрийг зааж, араасаа дагуулдаг болохоос “хилэнцийг усаар угаах” мэтээр тусалдаггүй ажээ.

Багшийн үлдсэн дөрвөн чанарын нэг *уран өгүүлэх* нь номлолын утгыг ямар дарааллаар зааж шавийн ухаанд шингээхээ мэднэ гэсэн үг. Харин *энэрэнгүй* нь номлол зааж буй зорилго нь ариун буюу ямар нэг ашиг хонжоо, нэр хүнд горьдохгүй энэрэл, хайранд хөтлөгдөн заахыг хэлж байгаа юм. Бодова нэгэнтээ Жанавад “Лимогийн хүү минь, өдий болтол би номлол заахдаа надад хэрэг болно доо гэж бодож байгаагүй. Зовлонгүй амьтан байхгүй гэдэг үнэн шүү” гэсэн гэдэг. Багш хүн ийм л байх хэрэгтэй.






*Хичээнгүй* гэдэг нь бусад туслах унтрашгүй эрмэлзэлтэй байхыг хэлж байгаа юм. *Ажилдаа дүр сонирхолтой* гэдэг бол ахин дахин заасан ч ядардаггүй, зааж сургах бэрхшээлээс халшрахгүй байна гэсэн үг.


Бодова нэгэнтээ:

Гурван заавар журам дээр үнэний ухаарал, энэрэл хоёр нэмэгдэж байж хамгийн гол таван чанар болдог. Шанзуун багш маань тийм ч их мэдлэгтэй биш, тэвчээр багатайн дээр бусдын ачийг бодно гэж байхгүй. Гэвч дээрх таван гол чанар түүнд байсан болохоор ойр тойрондоо хэрэг болдог байлаа. Бас Няндон багшид уран илтгэх чадвар огт байхгүй. Ямар нэг зүйл заахад нь бид “энэ бүхнээс ганц нь ч толгойд үлдсэнгүй” гэцгээдэг байсан ч гол таван чанар түүнд байсан тул дэргэд нь байсан бүхэнд тус болсон юм хэмээсэн.

Харин гурван заавар журмыг эзэмшигэгүй, биелүүлдэггүй хэрнээ тэр тухай сайхан ярьдаг, эрхэм чанарыг шагшин магтаж амиа аргацаадаг хүн багш байж таарахгүй. Үнэндээ өөрт нь юу ч байхгүй болохоор түүний яриа хий хоосон юм. Зандан модыг магтаж хоолоо олдог хүнээс бусад хүмүүс “Чамд зандан байна уу” гэж зандан асууж сураглавал “Байхгүй” л гэж хэлнэ. Өөртөө эрхэм чанар төлөвшүүлээгүй хэрнээ дэний баахан ярьдаг багш ийм хүнтэй яг адилхан. *Бясалгалин хаан* сударт энэ тухай өгүүлэхдээ:

Айсуй тэр цагийн хуврагууд  
Сахил, суртлаа гадаа орхино  
Сайтар мэдэгчийн дүрийг өмсөнө  
Санваар, гэгээрлийг цэцэрхэл болгоно  
Санадаг, хийдэг нь хол зөрнө.  
гэж хэлсэн байдал.





Сэтгэл төвлөрөл, билэг оюун, нирваан гурав ч үүнтэй адилхан болох тухай *Бясалгалын хаан* сударт ингэж хэлжээ:

Агар зандангийн үнэр тансагийг  
Анхилах шахтал ярьдаг хүнээс  
Анхилуун нь чамд шингэсэн үү гэвэл  
Амьдрах арга минь энэ дээ л гэдэг

Өөрт байхгүй агарын үнэрийг  
Өроол бусдад сайрхагчтай адил.  
Суртал сахиж, ёогтоо нэвтрэхгүй  
Сураг ярьж дүвчигнэгч ч олширино.

Судрын энэ үг сэтгэл төвлөрөл, билэг оюун, нирваан гурвууланд нь хамаатай.


Гэгээрлийн багш бол ашдын үйл хэргийн хөтөч юм. Тиймээс багшид өөрийгөө даатгахыг хүсэгчид энэ бүхнийг сайтар ухамсарлаж, дээрх шинж чанар бүрэлдсэн нэгнийг цуцалтгүй хай. Мөн бусдад замчлахыг хүсэгчид ч тэр бүхнийг ухаарч эдгээр шинж чанарыг өөртөө бүрдүүлэхийг хичээ.


*Асуулт:* Цагийн эрхээр дээрх бүх эрхэм чанарыг шингэсэн багш олоход хэцүү болжээ. Тийм багш олдохгүй бол яах вэ?

*Хариулт:* Энэ асуултад *Субахугийн асуултанд хариулсан* судар ийм хариу өгч байна:

Өрөөсон дугуйтай хасаг тэрэг  
Морь хөллөөд ч ахихгүйн адил  
Өөд хөтлөх багшгүй бол  
Бясалгал гэгээрэлд ахих аргагүй.

Үзэсгэлэнт дээрээ ухаантай бол  
Үлэмж цэмцгэр нямбай бол





Үнэн номлолыг хүртсэн бол  
Үзтэл түүнээ дээдэлсэн бол

Гэгээрэх замдаа итгэлтэй бол  
Гэмгүй дөлгөөн ч зоригтой бол  
Хэл яриа цэцэн бол  
Хэнээс илүү энэрэлтэй бол

Өлсож цангахад энэлдэггүй бол  
Өвчин шанаалалд сөхөрдэггүй бол  
Өроолийн тусыг мартдаггүй бол  
Өгөөмөр ариун сэтгэлтэй бол

Буруу номд ороогүй бол  
Гурван эрдэнэд сүсэгтэй бол  
Ноттой хэлэхэд тэр нэгэн  
Номын нөхөр лав мөөн.


Дээр өгүүлсэн эрхэм чанартныг  
Дэлхийн будангуйгаас олох амаргүй ээ  
Дээд чанаруудын хагастай нь нэгэн  
Дэргэд учирвал хувь ерөөл өө.


Барагтай таарахгүй эрхэм чанарууд  
Багахан байлаа ч бүү алгас  
Баганхи тал нь ч, наймны нэг нь ч  
Байдаг л юм бол нууц тарниар нөхөрлө өө.

Энэ бол бүрэн төгс шинж чанарын ядаж наймны нэгийг  
нь эзэмшсэн байх ёстой гэсэн үг. Долбагийн эмхэтгэсэн  
*Бодовагийн сургаал-д* “Багш ч гэсэн ийм л байх  
ёстой” гэж Адиша хэлсэн хэмээн тэмдэглэжээ. Энд  
тодорхойлсон бүх шинж чанаруудыг төгс бүрдүүлэх  
хэцүү, хялбар алин боловч багш хүн ядаж наймны  
нэгийг нь эзэмшсэн байх хэрэгтэй.

## 6. Багшийг шүтгэх шавийн шинж чанар

*Арьядэвагийн Дөрвөн зуут-д:*






Шударга, ухаалаг, дур сонирхолтой бол  
Гэгээрэл дүүрэх сав болно  
Багш, шавь алин нь ч биесүүдээ  
Баалах, өөлөх ч бас л цээртэй.


Хутагт Арьядэва ийм гурван чанартай хүнийг номлол сонсож болох шавь хэмээн тодорхойлжээ. Дээрх гурван чанар бүрдсэн хүн багшийн эрхэм чанарыг сайн зүйл гэж хүлээж авахаас бус алдаа гэж үздэггүй. Мөн тэр хүн шавийн эрхэм чанарыг ч зүй ёсоор хүлээн зөвшөөрнө. Харин шавийн шинж чанар бүрдээгүй хүн номлол заах багш нь хэдий өө сэвгүй байлаа ч өөрийн буруугаас гэмтэн мэт үзэх эсвэл бүх алдаа дутагдлыг нь зөв зүйтэй мэт ойлгох явдал бий гэж Чандракирти тайлбартай өгүүлсэн байдаг. Тэгэхээр бүх шинж чанар бүрдсэн багш таарсан ч түүнийг олж танина гэдэг хэцүү, үүнээс үүдээд шавь өөртөө дээрх чанаруудыг шингээсэн байх ёстой.

Нэг талыг барьж туйлшрахгүй байхыг *шударга* гэнэ. Хэрэв туйлширвал түүндээ хөтлөгдөн зөв зүйтэй талыг олж харахгүй, багш сайн зааж сургасан ч утгыг нь ухаарахгүй. Бхававевика өөрийн *Төв үзлийн төн чанар* бүтээлдээ:

Туйлширвал сэтгэлийн гэмд автагдаж  
Амгаланг огт ойлгож чадахгүй  
гэсэн байдаг.

Өөрийн үзэл бодолдоо хэт баригдаж, бусад сургаал номлолыг үзэн ядахыг *туйлирах* гэдэг. Ийм хандлагаа өөрт чинь байгаа эсэхийг ажиглаад өөрчлөх нь зүйтэй. Энэ тухай *Бодисадвагийн гэгээрэлд хүрэх сударт:*





Хувийн үзэл бодлоосоо салж, номлогч, багш нарынхаа сургаал зохиолд уусан орж, сүсэглэх хэмээсэн.

*Асуулт:* Ингээд л боллоо гэж үү?

*Хариулт:* Түйлширдаггүй байж болно, гэхдээ зөв сургаал номлолыг буруугаас нь гарцаагүй ялгах оюуны чадваргүй бол шавь болж чадахгүй учир тэр хоёрыг ялгаж чадахуйц ухаалаг байх ёстой. Хэрэв ухаалаг бол хэрэггүйг нь орхиж, хэрэгтэйг нь дагадаг.

*Асуулт:* Энэ хоёр чанар байхад л хангалттай юу?

*Хариулт:* Хэдийгээр дээрх чанаруудыг агуулж байлаа ч сургаалт үлгэр сонсож байгаа мэт зүгээр сууснаар номлол сонсох шавь болж чадахгүй. Маш их идэвх зүтгэл гаргах ёстой.


Чандракирти өөрийн тайлбартаа эдгээр чанарууд дээр номлол болон багшийг хүндэтгэх, сэтгэлээ зориулах хоёрыг нэмээд шавийн таван чанар гэж тодорхойлжээ.


Мөн эдгээр таван чанарыг хураавал дөрөв болно:

- (1) номлолд дур сонирхолтой
- (2) сонсоход сэтгэлээ зориулах
- (3) номлол болон багшийг хүндэтгэх
- (4) буруу сургаалыг орхин зөвийг нь дагах

Энэ дөрвийг саруул ухаанаар зохицуулж, төв шударга зангаар зөрчлийг давдаг.

Багшид өөрийгөө даатгах шавийн дээрх шинж чанар өөрт гүйцэд бүрдсэн эсэхийг шинжигтүн! Бүгд бүрдсэн бол баярлахаас өөр аргагүй. Хараахан бүрдээгүй бол хойшдоо бүрдэх нөхцөл бий болгохын тулд шавийн үндсэн шинж чанаруудыг мэддэг байх





ёстай. Мэдэхгүй аваас өөрийгөө шинжиж чадалгүй агуу сайхан боломжоо алдахад хүрнэ.

### **в. Шавь нь багшийг шүтэх ёс**

Шавьд байх чанаруудыг шингээсэн нэгэн дээр дурьдсан ёсоор тухайн хүнд багшийн шинж чанар буй эсэхийг сайтар шинж. Тоочсон шинж чанарыг өөртөө шингээсэн бол түүнээс номлол сургаал сонсож болно. Гэвш Долбова, Санпұва хоёр багшийг шүтсэн өөр өөр намартай байдаг. Санпұва олон багштай, тэр хэрээр янз бүрийн сургаал сонсодог байж. Нэг удаа Хам нутгаас буцах замдаа жирийн сүсэгтэн номлол зааж байхтай таараад сонсоод байж гэнэ. Тэгэхэд нөхөд нь авчихаар юм алга гэцгээн ундууцахад Санпұва “Та нар юу ярина вэ? Би хэрэгтэй хоёр зүйл мэдэж авлаа” гэсэн гэдэг.


Харин гэвш Долбова таваас хэтрэхээргүй цөөхөн багштай байсан юм. Бодова, Гомборинчэн нар энэ хоёрын алин нь сайн болохыг хэлэлцээд “Ухаан тэлээгүй нөхцөлд багшаасаа зовхөн дутагдал олж хараад сүсэг төрөхгүй. Сүсэг төртлөө их удна, тэгэхээр гэвш Долбовагийн багшийг шүтэх ёс нь илүү зохимжтой тул түүний ёсыг баримталъя” гэж шийджээ. Энэ тун зөв шийдвэр, уг ёсыг дагаарай.


Багшаас номлол, сургаал хуртэнэ гэдэг бол ерөнхий ойлголт. Харин бүрэн гарын авлагаар сэтгэл оюуныг жолоодох багшийг шүтнэ гэдэг онцгой зүйл билээ.

#### **1) Багшийг шүтэх санаа бодол**

Үүнийг гурван хэсгээр тайлбарлана:

1. Багшийг шүтэх ерөнхий хандлага





- 
2. Гол үндэс болох сүсгийг бататгах
  3. Багшийн ачийг дурсан санаж бишрэх

**a) Багшийг шүтэх өрөнхий хандлага**

*Гол модон байгуулах судар-т багшид хүндэтгэлтэй хандах есөн хандлага бий хэмээн заажээ. Тэдгээр нь багшийг шүтэх гол санааг агуулах бөгөөд хураангуйлбал дөрвөн зүйл болдог.*

*1) Дуулгавартай хүү тэт хандлага.* Өөрийн зоргоор явахаа болж, багшийн удирдлагад бүрэн орно. Дуулгавартай хүүхэд аливааг өөрийн зоргоор хийдэггүй. Эцгээсээ зөвлөгөө хүсэж, хэлсэн үгийг нь дагадаг. Үүнтэй адил багшаас зөвлөгөө хүсэж бай. Энэ цагийн гэээрэгсдийн бясалгал судар-т:


Шавь өөрийн буруу дадал бүхнээ орхиж, багшийн зөвлөгөөг дагадаг.  
гэсэн байдаг.


Гэхдээ багшийн шинж чанар бүрдсэн нэгнийг л дага, барагтайхан нэгэнд дөрлүүлж болохгүй гэж сануулжээ.

*2) Эөдрэшигүй алмааз тэт хандлага.* Шулам болон буруу санаатан багшаас нь салгаж чадахааргүй ижилсэж, номын нөхөр болно. Дээрх сударт энэ тухай ингэж өгүүлжээ:

Улааныг үзээд урваж, шарыг хараад шарвалзахыг цээрлэ.

*3) Хөдлөшигүй газар тэт хандлага.* Багшийн оноосон ажил, үүрэгт хариуцлагатай хандана. Ямар ч үүрэг өгсөн халширч, шантарч болохгүй. Бодова бээр Жанавагийн шавь нарт хандан:





Та нар миний багш шиг бодисадватаай учирч хэлснийг нь дагаж яваа чинь хувь заяа шүү. Өгсөн үүргийг нь дарамт биш шагнал гэж бодоцгоо. Хэмээсэн юм шүү.


4) *Үүрэгтээ хариуцлагатай хандах*. Энд зургаан төрлийн хандлага бий.


(а) Ямар ч зовлон тохиолдсон ажрахгүй байхыг хүрээлсэн уулс мэт хандлага гэнэ. Жанаваг Рүгвад очиход бясалгагч Гомбо Ёндонбар хүйтэнд зутарчихсан байжээ. Тэгээд Шоннуудагва эрхэм дээр очдог юм билүү гэж асууж гэнэ. Тэгэхэд нь Жанава “Үлэмж тансаг ордонд өдий болтол налайж суусан. Одоо шиг Их хөлгөний багшийг шүтэн, номлол сонсож байгаа ийм боломж дахин гарагчгүй, хаашаа ч битгий яв” гэжээ. Уг хандлагыг дээрх маягаар ойлгох нь зүйтэй.

(б) Өөрийн муу үйлийн үрийг эдлэвч огт гутрахгүй байхыг зарц мэт хандлага гэнэ. Адиша орчуулагч нарын хамт Занд ирээд шавар шавхайтай газар буужээ. Тэгэхэд Донбова хамаг хувцсаа урж шавхайг цэвэрлээд хaa нэгтэйгээс хуурай цагаан широо авчран дэвсэж суудал зассан аж. Мөн Адишагийн өмнө мандал хийж тавьжээ. Тэгэхэд Адиша “Хөөх, чам шиг шавь Энэтхэгт л байдаг юм” хэмээн уулга алдсан гэдэг.

(в) Аливаа ихэрхэл, бардам зангаа сайн дарж, өөрийгөө багшаас доогуур тавихыг бараа бологч мэт хандлага гэнэ. Гэвш Донбова “Бардам зангийн сайраас эрхэм чанарын булаг ундрахгүй” гэсэн юм. Мөн Жанава “Урин цаг ирэхээр эхлээд уулын орой ногоорох нь уу, бэл нь ногоорох нь уу хараарай” гэж хэлсэн байдаг.

(г) Багшийн өгсөн халширмаар хүнд, хэцүү ажил





Үүргийг баяр хөөртэй гүйцэлдүүлэхийг хөлөг мэт хандлага гэнэ.

(д) Багш загнаж, зэмлэсэн ч уурлахгүй байхыг нохой мэт хандлага гэнэ. Багш Долүнба бурханч гэвши Лхасог таарах болгондоо загнадаг байжээ. Нэг удаа Лхасогийн шавь Нягмова Долүнба багшид нь уурлаж байхыг хараад “Таныг загнаж байгааг ойлгож байна уу?” гэж асуухад “Би ингэж загнуулах тоолондоо Хэрүга бурханы хүчийг олж авдаг” хэмээн Лхасо хариулсан гэдэг. Мөн *Билэг оюуныг төгөлдөржүүлэх найман тянган бадагт сударт*-т:

Багш нь шавиа загнаж, тоомжиргүй хандсан ч тэrsэлдэж болохгүй. Харин улам бүр номлол руу тэмүүлж, сүсэглэн араас нь уйгагүй яв, хэмээсэн байдаг.

(е) Багш ямар ч ажил үүрэг өгсөн нааш, цааш явахаас залхахгүй байхыг сал мэт хандлага гэнэ.


## 6) Гол үндэс болох сүсгийг бататгах


*Гурван эрдэнийн зулын зарф* сударт:

Сүсэглэх сэтгэл нь гэгээрлийн ээж тул  
Сүүгээр тэжээх мэт ухаарлаар амлуулж  
Үрээ харамлах мэт зовлонгоос гэтэлгэж  
Үүрдийн цэнгэлд гарцаас хөтөлнө.

Элэг зүрхэнд сүсэг оршиход  
Эрхшээх омог бишрэлээр солигдоно  
Эд баялагт хөл болж хүргэнэ  
Эрхэм буяныг гар болж хураана.

Түүнчлэн *Арван чанарын сударт* ийн өгүүлсэн байдаг:





Сүсэг бишрэл нь гэгээрэлд хургэх  
Сүйх тэрэг, унаа хүлэг мөн.  
Сүйхээтэй хүн л үүнийг таньж  
Сүсгээ хүлэглэн дээшээ дэвжинэ.

Өчүүхэн төдий ч сүсэггүй хүмүүнд  
Өөдлиөх гэгээрэх хүсэл ч төрдөггүй нь  
Үнс болж тулэгдсэн буурцагнаас  
Үр соёолох ерөөлгүйн адил аа.


Энд сүсэгтэй, сүсэггүй хоёр байдлыг харьцуулан эрхэм  
chanar бүхний үндэс нь сүсэг болохыг харуулжээ.


Гэвшил Донбова Адишад “Төвдөд олон бясалгагч  
байдаг. Харин онцгой чадвартай болсон хүн ганц ч  
алга” гэжээ. Тэгэхэд Адиша “Их хөлгөний их, бага  
эрхэм chanaryn аль нь ч багшийг хэрхэн шүтсэнээс  
хамаарч хөгждөг. Төвдүүд та нар багшдаа жирийн  
хүнээс дээргүй хандаж байна. Тэгэхээр яаж ч сайн  
chanar хөгжих билээ” гэжээ. Мөн хэн нэгэн chanга  
дуугаар “Адиша, гарын авлага хайрлаач” гэхэд “Ха, ха,  
би сонсгол сайтай шүү!” хэмээн хөхрөөд “Сүсэг бол  
миний гарын авлага. Сүсэглэ, сүсэглэ!” хэмээсэн гэдэг.  
Тиймээс сүсэг хамгаас чухал шүү.

Ер нь Гурван эрдэнэ, үйлийн үр, дөрвөн үнэнд  
сүсэглэх зэрэг олон сүсэг бий. Харин энд бид багшдаа  
сүсэглэх тухай ярьж байгаа билээ. Шавь нь багшдаа  
хэрхэн хандах тухай *Vajrapaniin avshig avah tarnid*:

Нууцын эзэн минь! Шавь нь багшдаа хэрхэн хандах вэ  
гэвэл Ялж төгс гэгээрсэн Буддатай адилхан хандана.

Сэтгэл зөвдөхөд зам зөвдөж  
Сэвтээх садаа өөрөө ховхроно





Алдаагүй зөв дадал эзэмшиж  
Амьтанд туслах бурхан болно.  
гэж өгүүлсэн байдаг.


Их хөлгөний судар, номуудад багшийгаа Ялгуулсан Будда хэмээн сэтгэх хэрэгтэй гэж өгүүлдэг. *Ёс зүйн судар*-т ч мөн ингэж заасан билээ. Багшийгаа амьд Будда хэмээн ухамсарлахын хэрээр түүнээс дутагдал эрэхээ болж, эрхэм чанарыг нь олж харах ухаан төрдөг учиртай. Тиймээс багшийг буруу талаас нь ажиглахын оронд сайн чанарыг нь олж харах ухаан хөгжүүл. *Важрапанийн авшиг авах тарфни*-д мөн ийн өгүүлжээ:


Сайн сайхнаар нь багшийг үнэл  
Саар алдааг нь байхгүй юм шиг март  
Сайшаасны хэрээр л сайнаас нь хүртэнэ  
Саараар нь дуудвал саарлыг нь л авна.

Үүнийг баримтал. Багш маш олон эрхэм чанартай байтал өчүүхэн алдаа, дутагдлыг нь анзаараад байвал оюун ухааны шидийг олоход саад болно. Багшид алдаа, дутагдал нэлээд байлаа ч бүү ойшоо. Харин эрхэм чанарт нь сүсэглэвэл оюун ухааны шидийг эзэмших үндэс болно.

Тиймээс өөрийн багшид их бага ямар нэг дутагдалтай ч түүнийг нь өөчилдөг буруу бодлоо дар. Ахин дахин дадуулбал тийм зан үгүй болно. Хэрвээ ингэж чадахгүй, эсвэл буруу санаандaa автан дутагдал дээр нь анхаарал төвлөрөөд байвал гэмээ наминчилж, дахин давтахгүй гэж андгайл. Тэгвэл аажимдаа ийм зан дарагдана.

Мөн багшийн ёс суртахуун, эрдэм мэдлэг, сүсэг







зэрэг аль байгаа эрхэм чанарт нь анхаарал хандуулж тэр сайн талыг нь үргэлж санаж, бодож бай. Ингэж сурвал зарим нэг дутагдал байсан ч сайн чанарт нь сэтгэл төвлөрч сүсэглэхэд саадгүй болно. Жишээ авьял даа. Чиний дургүй хүн олон сайхан чанартай ч зөвхөн алдаа дутагдлыг нь хайх сэтгэл түүний сайн талыг олж харах нүд хаадаг. Нөгөө талаар өөрөө олон дутагдалтай ч ганц нэг сайн чанараа дөвийлгөн бодсоор өөрийнхөө алдааг олж хардаггүй.

Адиша гүн ухааны хувьд мадхъямика үзэл баримталааг, багш Серлинба нь читтаматра сакаравадийн үзэлтэй байсан юм. Үзэл онолын үүднээс үзвэл багш шавь хоёрын хооронд их бага ялгаа бий. Гэхдээ Адиша Их холгөнд суралцах үндсэн шат болсон гэгээрэх тэмүүллийг Серлинбагийн гарын авлагаар хөгжүүлсэн билээ. Тийм ч учраас түүнийг бусад багш нараасаа дээгүүр тавьдаг байсан.

Багшийг зөвхөн сайн талаас нь харж, дутагдлыг нь анзаарахгүй байх нь зүй бус ч гэлээ сурах л хэрэгтэй. Ганц шад сургаал хэлж өгсөн байсан ч ингэж хандвал зохино. Энэ талаар *Нандин эрдэнийн үүл судар*-т ийн өгүүлжээ:

Багшийг дагавал зөв дадал нэмэгдэж, алдаа дутагдал цөөрнө. Багш чинь их бага судалсан, мэдлэгтэй мэдлэггүй, ёс зүйгээ сахидаг, сахидаггүй ямар ч байсан Ялгуулсан Будда хэмээн бодож сур. Буддатай учирвал баярлаж, сүсэглэх тэр л хэмжээгээр багшидаа баярлаж, сүсэглэ. Багшийгаа хүндэлж, тахихын хэрээр гэгээрэлд хүрэхэд дутуу байсан буян бүхэн гүйцнэ. Салахгүй зууралдсаар байгаа сэтгэлийн гэм





бүхнээс сална гэж бодвол баяр баясгалантай болно.  
Түүний сайн чанарыг нь дууриалал болгон, муугаас нь  
цээрлэж яваарай.

Мөн *Xar хүн Уграгийн асуултанд хашиулсан судар-т*:

Хар хүн гуай! Бодисадва нар аман айлдвэр сонсох  
болон унших хийгээд өгөөмөр чанар, ёс суртахуун,  
тэвчээр, зүтгэл, бясалгаль, билэг оюуныг эзэмших,  
тэрчлэн бодисадвагийн зам мөрийн төвшинд хүрэх  
чуулбарыг хуримтлуулахдаа ганцхан шад гарын  
авлага өгсөн багшийг ч зүй ёсоор хүндэлдэг. Хэлсэн  
сургаалд нь хэдэн нэр томъёо, уг үсэг байна төдий  
тооны галавт тэр багшийг үргэлж хүндлэн тахиж,  
өргөл барьц өргөн дээдэлдэг. Хар хүн гуай, энэ  
бол багшид үзүүлбэл зохих зүй ёсны хүндэтгэлийн  
нэгээхэн хэсэг. Тэгэхээр бусад өргөл хүндэтгэлийн  
тухай ярих нь илүүц биз ээ!


### **в) Багшийн ачийг дурсан санаж бишрэх**


*Арван чанар судар-т*:

Төөрч явахад олоод дуудагчаар бод  
Түнэр шөнийн зүүднээс сээрээгчээр бод  
Үйлэндээ живэхэд гарaa сунгагчаар бод  
Үнэнээс зорөхөд дуудаж залагчаар бод!

Орчлонгийн гавыг тайлсан чөлөөлөгчөөр бод  
Ороосон өвчнийг эдгээсэн анаагчаар бод  
Атгаг шунал, хүслийн түймрийг  
Адарын үүл болж унтраагчаар бод!  
гэсэн байна.

Мөн *Гол модон байгуулах судар-т* идэрхэн Судхана





эрхэм гэгээрлийн багш минь намайг бүх муу заяанаас аварсан хэмээн өгүүлсэн байдаг:

Үзэхийн далайд бол усан хөлөг  
Үнэнд хүрэхэд унаа хүлэг  
Хүсэх диваажинд зам заах овоо  
Хүй орчлонгийн чанарыг таниулагч аа.

Байсан, байгаа, байх цагуудын  
Барим тавим үнэнийг заасан  
Бишрэхээс бус учирч чадаагүй  
Билэгтэн мэргэдэд ч хөтөлж хургэсэн.


Зөв болгоны минь үрийг соёолуулж  
Зөв мөрт нь ургуулж ачилсан  
Багшийнхаа ачийг баходах Судхана  
Баярын нулимс мэлмэруулж байсан.


Үүнтэй адил багшийн ачийг санаж яваарай. Багшийн ачийг санах бүртээ "... багш нар минь" хэмээн бүгдийнх нь нэрийг тоочин, дүрийг нь сэтгэлдээ ургуулан бодож бай. Багшийнхаа дүр төрхийг төсөөлөн бодож, хэлж буй үгнийхээ утга учирт нь хамаг анхаарлаа төвлөрүүлэн дээрх мөрүүдийг чангаар уншаарай.

Түүнчлэн *Гол модон байгуулах судар*-т ингэж өгүүлжээ:

Багш минь Буддагийн сургаалыг номлооч  
Барагдашгүй сургаалынх нь сайхныг үзүүлэгч  
Бодисадвагийн явдлыг ашид таниулагч  
Бодолхийлж эргэлзэхгүй итгэл минь энэ.

Ариун чанаруудыг төрүүлэгч эх  
Амлуулж сургаалаар тэжээгч эжий  
Гэгээрч дээшлэхийн үүд болгонд  
Гэрэлт бамбар шиг гийгүүлэн зогсоод  
Гэтэлгэж бас муугийн хорлол  
Гэм нутглээс ангижруулагч билээ.





Өвдөхөөс төдийгүй өтлөхөөс гэтэлгэгч оточ мөөн  
Өвчноөс төдийгүй үхлээс аврагч хувилгаан мөөн  
Рашаанаар сурчигч ариун дээд хурмаст мөөн  
Ариудсан саран, амирлахуй зүгийн наран мөөн.

Дайсныг ч гэсэн нөхөр шигээ л номорлөх  
Далай ертөнцөд хэнийг ч залуурдах  
Даамай амгалан багшдаа үргэлж  
Дандаа ингэж Судхана биширнэ.

Бодисадва наадад ухаанаасаа хүртээж  
Бурхны хүүхдүүдийн гэгээрэлд хүргэнэ  
Бурсан хуврагууд ч шагших багшдаа  
Буцалтгүй итгэлээр залбирч ирлээ.

Нарт ертөнцийг аврагч мэтээр  
Намайг та хөтлонө ч, номорлонө ч  
Найрсал, зохирлыг нүд болж харуулна ч  
Найдаж итгэх минь энэ л байна.

Энэ маягаар Судханагийн оронд өөрийгөө тавьж,  
багшийн ачийг санан дээрх шүлгийг уншиж бай.


## 2) Багшийг шүтэх үйл ажил


Ашвагхоса *Багшийн тавин шүлэгт* бүтээлдээ:

Багштай хүний үүрэг цомхон  
Баярладаг юмыг нь үйлсээ болго  
Барайлгадаг юмнаас байнга зайлсхий  
Баримтлах, дагах юм ердөө л энэ.

Орчлонгийн үймээнээс багшийгаа ол  
Оройдоо дээдлэн заасныг нь баримтал  
Оюуны шид багшаас л ундарна  
Онцгойлж үүнийг Будда захисан

Товчондоо      бол      багшийг      баярлуулах      бүхнийг





хичээнгүйлэн гүйцэлдүүлж, баярлуулахгүй бүхнээс хянамгайлан цээрлэ.

Багшийг өргөл барьц өгөх, бие болон үг хэлээр өргөмжлөн хүндлэх, хэлснийг нь гүйцэлдүүлэх гурван арга замаар баярлуулдаг. Энэ тухай хутагт Майдар *Судар айтгийн чилэг*-тээ ингэж өгүүлсэн байдаг:

Өргөл барьц нь хүндлэл мөн ч  
Заасныг нь дагавал шүтлэг мөн.

ТҮҮНЧЛЭН:

Өнөд багшийгаа хазайхгүй дагавал  
Өргөмжөөс илүү дээдлэл мөн.  
Гэж өгүүлдэг билээ.

### 1) Өргөл, барьц өгөх. Багшийн тавин шүлэгт:

Андгайлж шавилсан номын багшдаа  
Авгай хүүхдээ ч, тэр ч бүү хэл  
Амиа хүртэл өргөх нь бий тул  
Агуурс хөрөнгө бол юу ч биш шүү.


ТҮҮНЧЛЭН:


Багшдаа өргөх нь Буддац өөрт нь  
Барьж өргөсөнтэй адил тэнцүү  
Өглөг чинь эргээд буян болж  
Өөрийн чинь чанарыг төгөлдөр болгоно.

Үүнээс гадна Лагсорва ингэж хэлжээ:

Сайн юм байсаар атал мууг нь өргөвөл тангараг доройтно. Багшийг баярлуулах сайн юм үнэхээр байхгүй бол харин гэм болохгүй.

Энэ санааг *Багшийн тавин шүлэгт*-д доорх байдлаар илэрхийлжээ:





Барьц өргөл өчүүхэн ч байсан  
Бага гэж голохоосоо өмнө<sup>1</sup>  
Барагдашгүй үржихийн ерөөл бодож  
Багшдаа өргөх нь буян билээ.

Өргөл өгөх нь шавийн хувьд эрхэм буян учир өгөхдөө ийм бодолтой байх нь зүйтэй. Харин багш нь өргөл, барьцаанд шунах ёсгүй юм. Шарава “Өргөл барьцаанд биш, сайн суралцаж буйд нь баясдаг хүнийг л багш гэнэ. Үүнээс эсрэг зан суртахуунтай бол гэгээрэлд хүргэх багш биш” гэсэн билээ.


2) *Бие болон уг хэлээр өргөмжлон хүндлэх.* Багшийгаа угааж арчих, биед нь иллэг хийх, хир буртагийг нь цэвэрлэх, дэргэд нь бараа болох нь биеэр үйлдэх өргөл хүндлэл. Харин багшийн эрхэм чанарыг нь магтан огүүлэх нь уг хэлний өргөл хүндлэл юм.


3) *Хэлснийг нь гүйцэлдүүлэх.* Өгсөн заавар сургаалыг нь зөрчилгүй гүйцэлдүүлэх явдал юм. Энэ хамгаас чухал. *Төрөл туулсан цадиг-т* энэ тухай өгүүлэхдээ:

Тусалсаных нь ачийг хариулна гэдэг  
Хэлснийг дагаж биелүүлэх явдал мөн.

*Асуулт:* Багшийн өгсөн зааврыг дагах учиртай юм байна. Гэтэл шүтэж буй багш нь буруу зам мөрөөр хөтлөх юм уу, гурван сахил зөрчих зүйл хийлгэх гэвэл яах вэ?

*Хариулт:* Энэ тохиолдолд Ёс зүйн судар-т заасныг баримталбал зохино. Уг номонд “Номлогоос гажуу зүйл шаардвал татгалз” гэсэн байдаг. Мөн Нандин эрдэнийн үүл судар-т “Багшийн сургаал зөв аваас түүнийг нь дага,





харин буруу бол бүү дагагтун” гэжээ. Тиймээс буруу гарын авлагыг нь дагаж болохгүй. Энэ тухай *Төрөл туулсан цадиг*-ийн арван хоёрдугаар хэсэгт тодорхой огүүлсэн байdag.

Гэхдээ үүгээр шалтаглан багшдаа сүсэггүй, хүндэтгэлгүй хандаж, муулж болохгүй. Харин чухам ямар шалтгаанаар багшийн зааврыг зохих ёсоор нь дагахгүй болсон өөрийн байр сууриа тайлбарлах хэрэгтэй. Энэ тухай *Багшийн тавин шүлэг*-т:

Үндэс, зохирлыг хангаагүй учраа  
Үгээр илэрхийлж тайлбар хийж бай  
гэдэг.


Ингээд эв зүйгээ олсон цагтаа номлолд хөтлөх багшийн зааврыг хичээнгүйлэн дагаж, биелүүлэх нь чухал. Энэ тухай хутагт Майдарын *Сударф айлгийн чимэг*-т огүүлэхдээ:

Багшийг дээдэлж шүтнэ гэдэг  
Барьц бэлэг зөөхийн нэр биш  
Баримтал хэмээсэн ном журмыг нь  
Баттай сахихыг л хэлсэн хэрэг ээ.

Бодова нэгэнтээ:

Ананда Буддад бараа болон явж байхдаа түүний зөвшөөрөөгүй хувцсыг өмсдөггүй, Буддагийн үлдээсэн хоолыг иддэггүй байсан. Гэнэт Буддатай уулзах болвол “Багшийгаа хүндэтгэе” хэмээн зөвшөөрөл авдаг байсан. Энэ бүхэн нь хойч үеийнхэнд үлгэр дууриал болох ёстой. Бид нар ямар номлол





сурснаа тооцохын оронд багшийн өгсөн хоолны их багыг бодож сууна гэдэг яваандаа ялзрахын шинж хэмээсэн билээ.

Хэдий хугацаанд багшийг шүтэх талаар Бодова ингэж хэлжээ:


Миний дэргэд буй шавь нарын үүрэг нэмэгддэг.  
Харин надаас холдохоор үүрэг нь хөнгөрдөг. Багшаас хэт холдох та нарт зохихгүй. Тиймээс хол ойроос хамаарахгүй үүргээ ухамсарладаг болтлоо суралцах хэрэгтэй.


### г. Багшийг шүтэхийн ач тус

Багшийг шүтсэнээр төгс гэгээрлийн төвшинд ойртоно, агуу гэгээрэгсдийг баярлуулна. Дараа дараагийн амьдралдаа багшаас хагацахгүй, муу төрөлд төрөхгүй. Муу үйлийн үр болон сэтгэлийн гэмд хялбар дийлдэхгүй. Бодисадвагийн сургаал зааврыг зөрчихгүй, тэр бүхнийг мартахгүй учир эрхэм чанарын чуулбар бүрдэж улам бүр нэмэгдсээр хэтийн ба ойрын бүх зорилго биелнэ. Багшийг санаа бодол болон үйл ажлаар асарч, хүндлэх зөв дадал хэвшиүүлбэл өөрийн болон бусдын зорилгыг биелүүлж, билэг оюун болон буяны чуулбарыг төгс догцлуулна.

Энэ тухай *Гол модон байгуулах судар*-т ингэж өгүүлдэг:

Хувьтай хөвгүүн минь, багшийг зүй зохисoor нь шүтсэн бодисадва нар муу төрөлд төрөхгүй. Багшийг санаж явдаг бодисадва нар бодисадвагийн заавар журмыг зөрчихгүй. Багшийн ивээлд орсон бодисадва нар энэ ертөнцөд бусдаас үлэмж илүү. Багшийг хүндлэн асардаг бодисадва нар бүх сургаалаа





марталгүй хэрэгжүүлдэг. Багшийг чин сэтгэлээр дагадаг бодисадва нар муу үйлийн үр ба сэтгэлийн гэм (нисванис)-д тэр бүр дийлдэхгүй.


Гээд цааш нь:


Хувьтай хөвгүүн минь, багшийн заасныг дагаж мөрддөг бодисадва нарт төгс гэгээрэгсэд баярладаг. Багшийн үгнээс гажилгүй амьдрягч бодисадва төгс гэгээрэлд ойртдог. Багшийн үгэнд эргэлзэхгүй бол багш улам дотносоно. Багшийг мартахгүй санаж яваа бодисадва бүхний хамаг зорилго гарцаагүй биелнэ.

Мөн үүнтэй адил *Tайллагдашигүй нууцын сударф*-т ингэж өгүүлжээ:

Хувьтай хөвгүүд, охид минь. Багшийг ихэд хүндэтгэн шүтэж, асран тойлж, тахиж зүй зохисоор нь шүт. Ингэж чадвал санаа сэтгэлд чинь зөв дадал шингэж, үйлдэл бүхэнд чинь зөв дадал хэвшинэ. Улмаар зөв үйл бүтээж, зөв дадал төлөвшиж, журмын нөхөд чинь хүндлэх болно. Буруу дадлаас салж, зөв дадалтай болсноор өөрийгөө болон бусдыг зовоохoo болино. Өөрийгөө, өрөөлийг буруу үйлээс сээрэмжлэн хамгаалснаар зүйрлэшгүй гэгээрлийн зам мөрийг төгс эзэмшиж, буруу зам мөр хөөсөн амьтанд тусалж чадна. Бодисадва багшийг ингэж шүтсэнээр эрхэм чанар бүхнийг өөртөө төгс цогцлуулдаг.

Түүнчлэн багшийг өргөмжлөн хүндэлснээр муу төрөлд амсах байсан үйлийн үр энэ насанд бие, сэтгэлийн өчүүхэн зовлон эдлэх эсвэл зүүдлэх төдийхнөөр шувтарч арилна. Мөн тоолшигүй олон гэгээрэгсдэд





өргөл тахил өргөсөн буянтай харьцуулшгүй их ач тустай. Энэ тухай *Кийитигарбха* сударт өгүүлэхдээ:

Багшийг шүтвэл тоолшгүй олон галавт муу төрөлд төөрөх байсан үйлийн үр энэ насанд халдварт өвчин тусах, өлсөж цангах зэрэг бие, сэтгэлийн зовлон төдийхөн болж арилна. Эсвэл зэмлэл хүлээх, зүүдлэх төдийхнөөр л муу үйл барагдана. Тэр ч бүү хэл ганц өглөө багшийг хүндэлсэн буян нь зөв дадал төлөвшүүлэх хүслээр хязгааргүй олон гэгээрэгсдэд тахил өргөх эсвэл заавар журам дагасан буянаас ч хол давуу. Багшийг өргөмжлөн хүндлэх нь санаанд багтамгүй сайн талтай.

Гээд цааш нь:

Гэгээрэгчийн цаглашгүй ид шид, хувилгаан чанар бүхэн үүнээс л урган гарна гэж үзэгтүн. Тиймээс багшийг Ялгуулсан Буддаг тахин шутэж байгаа мэт асран тойлж, хүндлэх ёстой.


Гэсэн байdag.


Бас *Төрөл туулсан цадиг*-т өгүүлэхдээ:

Эрдэмт багштайгаа шадар байж  
Эндэлгүй номыг нь дагаж гэмээнэ  
Эгнэшгүй гэгээрлийн эрхэм чанар  
Эрхбиш биед чинь наалдах учиртай.

Бодова хэлэхдээ:

Цоорхой тор усанд хаяхад загас орохын оронд замаг шүүрдэн төвог уддаг. Бид үүн шиг багшийн эрхэм чанарыг шингээхгүй атлаа зарим буруу зөрүүг нь





сурчихдаг. Тиймээс хааяа нэг багшид ирж очих төдийгөөр хязгаарлаж болохгүй.

#### д. Багшийг эс шүтэхийн гэм зэм

Багш, шавь барилдчихаад шүтэх ёсыг нь зорчвэл энэ насандаа олон төрлийн өвчин тусаж, элдэв хорлолд өртөнө. Хойд насандаа хэмжээлшгүй их, дуусашгүй урт муу төрлийн зовлон амсах болно. *Важрапанийн танграгийн тарни*-д энэ тухай ингэж өгүүлжээ:

Ялж төгс гэгээрсэн Будда! Багшийгаа басамжлан доорд үзсэн бүхний гарцаагүй эдлэх үйлийн үр юу вэ?

Будда: Важрапани минь, тэнгэр болоод бусад ертөнцийнхөн ч айн цочих бизээ. Асуугаагүй нь дээр байсан юм. Гэвч тэр тухай Нууцын эзэн чамд цухас дурьдья. Зүрх зоригтнууд анхааран сонсохтун.


Дагасан багшаа бүү гутаа  
Дараа нь чамайг там хулээнэ.  
Дайраад өнгөрөхгүй ээ, олон галваар  
Тасарч амсхийхгүй үргэлжлэх цагаар  
Даанч их тарчлах болноoo.


Гэсэн бол *Багшийн тавин бадаг* номд:

Ачит багшаа доромжлох аваас  
Аюулт шаналан, бузрын өвчин  
Адын хорлол, чөтгөрийн дайрлага  
Алгасалгүй дагасаар үхүүлэх болноoo.

Эрхтэн дархтны хавчлага дарамт  
Эрүү, хулгайн гэмтний халдлага  
Эндэл, осол, гал түймрийн  
Эргүүлгэнд үхэж там руу одноoo.

Ачит багшийн сэтгэлийг зовоож  
Амгалант царайг барайлгах аваас





Адаг доод халуун тамд  
Алгасал үгүй түлэгдэх нигууртай.

Аюус гэхчлэнгийн асар зовлонт  
Аймшиг төрүүлэм тамуудын ихэнхэд  
Алдас хийж ачит багшийнхаа  
Амирлангуйг цочоосон нүгэлтийд очдог.


Суут Шандэвагийн туурвисан “Хар дайсан”-ы хэцүү  
утгын тайлбар-т энэ талаар:


Хэлсэн сургаал нь бадагхан байлаа ч  
Хэзээд түүнийг багшаар дуудартун  
Хэрвээ тэгэхгүй бол нохой болж төрнө  
Хэтдээ бас яргачин төрөл ч олно.

Түүнээс гадна хөгжөөгүй байсан эрхэм чанарууд огт  
төлөвшихгүй, харин төлөвшсөн нь улам дордоно. Энэ  
цагийн гэгээрэгсдийн бясалгал судар-т:

Хэрвээ шавь нь багшдаа хар буруу санаж, догшин ширүүн хандаж уурлабал эрхэм чанар огт төлөвшихгүй. Багшийг Ялгуулсан Буддатай адилтгаж үзэхгүй бол мөн л адил. Гурван хөлгөнийг баримтлагч, номлол заасан хуврагийг хүндлэхгүй, Будда хэмээн сэтгэж чадахгүй аваас бүрдээгүй байсан эрхэм чанарууд хөгжихгүй, төлөвшсөн сайн чанарууд нь замхарна. Багшийг хүндлэхгүй бол сэтгэлийн эрхэм чанар мөхнө.

Буруу номлогч, муу хүнтэй нөхөрлөвөл сайн чанарууд аяндаа хорогдож, бүдгэрнэ. Улмаар алдаа дутагдал нэмэгдсээр хүсэмгүй үр дагавар авчирдаг. Тиймээс эгнэгт цээрлэж яв. *Гэгээн номлолыг үргэлж санаахуй судар-т:*





Хүсэл шунал, уур хорсол, мунхаглалын уг суурь нь муу нөхөр юм. Тэрээр хорт ургамалтай адил.  
ХЭМЭЭСЕН.

Мөн *Agyu nifvaan судар*-т бодисадва нар муу нөхрөөс эмээж яв, галзуу заан түүний дэргэд юу ч биш, галзуу заан амь бие төдийг л сүйтгэдэг бол муу нөхөр зөв бодол, ариун сэтгэлийг үгүй хийнэ. Галзуу заан махан биеийг хөнөөвч муу төрөлд аваачихгүй. Гэтэл муу нөхөр бүрдсэн буяныг сүйтгээд муу төрөлд төрүүлэх нь гарцаагүй гэсэн байдал.

Түүнчлэн *Үнэнийг өгүүлэгчийн бүлэг*-т:


Муу нөхөр могой мэтээр  
Мунхагийн хороор сэтгэлийг хатгахад  
Ачит багшийн сургаал ерөндөгөөр  
Аврах эмчилгээ хийхгүй болбоос  
Уулын оргилд гаран алдаад  
Унаж, нисэж үхэхтэй адил.


гэсэн байхад *Нөхдийн тухай цоморлиг*-т энэ тухай:

Итгэл бишрэлгүй, харамч хахир  
Элдэв хов руу шөвөлзөн гүйгч  
Эрдэмтэйн гэрээс цэрвэн тойрогч  
Ийм нүүгэлтэнтэй битгий нөхорлө өө.

Буруу санаатантай нийлэхийн цагт  
Буруугүй байлаа ч хүмүүс цэрвэнэ  
“Адилхан годилууд л нийлээ биз” хэмээн  
Амьтны ам чамд муруйна.

Гэмтэй амьтантай нөхөрлож ойртвол  
Гэм нүгэл нь чамд ч нялзана  
Хортой будаа ганицханыг үйхэд л  
Хоол чинь бүхлээрээ хор л болдог oo.





Буруу хүнтэй нөхөрлөвөл жам ёсны болоод тогтоосон хууль цаазаас гажих алдаа дутагдал багасахын оронд харин ч шинээр нэмэгдэнэ. Гэвш Донбова:

Муу хүн сайнтай нохорлөвч төдийлөн сайжирдаггүй.  
Гэтэл шилдэг сайн нь муутай нийлбэл дорхноо адгийн нэгэн болно.


ХЭМЭЭСЭН.


#### e. Дүгнэлт

Багшийн ёог хэмээх алдарт гарын авлагыг дээр өгүүлсэн ёсоор өөриймшүүлэх нь чухал. Гэхдээ ганц нэгхэн удаа бясалгаж, судаллаа гээд хэрэг болохгүй. Үнэн голоосоо номлол эзэмшие гэвэл алдаагүй хөтлөх сайн багшийг удаан дагах шаардлага гарна. Гэтэл явцын дунд “Нэгэнт багш шавь барилдах дээрээ тулхаараа бодлоосоо ухардаг” гэж Чадгавагийн хэлснийг санууштай. Өөрөөр хэлбэл багш шавь барилдах журмыг сахиагүйн улмаас өөдлөх бус бүр уруудах нь ч бий.

Багш шавь болох ёс журам нь бусдаасаа хамгийн чухал буюу хэтийн зорилго болох нирвааны үндэс болдог. Ерөнхий агуулгыг нь эрхэм зарлиг болон түүний утгын тайлбар зэргээс ишлэн авч ойлгоход дөхөмтэй болголоо. Мөн хэрэгжүүлэхэд хялбар болгох үүднээс эрхэм зарлигийн утгыг ухаарсан мэргэдийн хэлсэн үсийг нэмж шигтгэв. Өөрсдөө бусад эх бүтээлүүдийг нэмж судлаарай.


Бидний сэтгэлийн гэм хэрээс хэтэрсэн учир багш шавь барилдах ёсыг ойлгодоггүй, ойлголоо ч дагаж мөрддөггүй. Олонтаа номлол сонсдог боловч багш шавийн тогтсон журмыг зөрчих нь нэн их. Тэгсэн атлаа







буруугаа ухамсарлаж, дахин алдахгүйн төлөө чармайж нь даанч цөөхөн. Тиймээс дээр өгүүлсэн ач тус ба гэм зэмийн талаар ахин дахин бод. Бас урьд төрөлдөө багш шавийн барилдлагыг зөрчсөн гэмээ чин сэтгэлээсээ наминчил. Тэгээд дахин зөрчихгүй гэж олон удаа андгайл.

Номлолд суралцах шавьд байх ёстой чанаруудыг өөртөө хичээнгүйлэн бүрдүүл. Түүнээс гадна шинж чанар төгс бүрдсэн багшийн тухай байн байн бод. Гэгээрэлд хүргэх багштай учрах нөхцөл болсон билэг оюуны цогц буяныг нэмэгдүүлэхийн зэрэгцээ түүнийг үргэлж хүсэн залбирч бай. Тэгвэл тун удахгүй бодисадва нарын манлай болсон Садапрадите, гэгээрлийн багшийг уйгагүй эрэгч Судхана шиг болох нь дамжигтгүй.






V


## БЯСАЛГАХ ЖУРАМ

### 2. Бясалгалын тухай товч заавар

#### a. Бясалгах дараалал

- 1) Жинхэнэ бясалгалын үед хийх зүйлс
  - а) Бэлтгэл
  - б) Бясалгал
    - I) Бясалгальны ерөнхий зүйл
    - II) Бясалгах үе
  - в) Төгсгөлд нь юу хийх вэ?
- 2) Бясалгалын үе шатуудын хооронд хийх зүйлс
  - а) Мэдрэхүйгээ хянах
  - б) Ухамсартай үйлдэл
    - I) Үйл хөдлөлийн үндсэн хүрээ
    - II) Үндсэн үйл хөдлөлийг ухамсартай хослуулах
  - в) Зөв хооллох
  - г) Унтахгүй хичээх ба хэрхэн унтах тухай





## 2. Бясалгалын тухай товч заавар

Бясалгалын тухай товч заавар хоёр хэсэгтэй:

1. Бясалгах дараалал (5 дугаар бүлэг)
2. Бясалгальны тухай буруу ойлголтыг няцаах  
(6 дугаар бүлэг)

### a. Бясалгах дараалал

Бясалгалын зөв журам мөн хоёр хэсэгтэй:


1. Жинхэнэ бясалгалын үед хийх зүйлс
2. Бясалгальны үе шатуудын хооронд хийх зүйлс


#### 1) Жинхэнэ бясалгалын үед хийх зүйлс

Жинхэнэ бясалгал (1) бэлтгэл, (2) бясалгал, (3) төгсгөл гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

##### a) Бэлтгэл

Серлинбагийн үндэслэсэн бясалгайд бэлтгэх заавар журам зургаан хэсгээс бүрддэг. Тэдгээрийг тоочвол: (1) Орон байраа сайхан цэвэрлэж, Буддагийн лагшин, зарлиг, тааллын шүтээнүүдийг засна. (2) Сэтгэл харамгүй тахил бэлтгэж, сайхан байрлуулна. (3) Дараа нь олбог, дэвсгэр дээр хагас эсвэл бүтэн завилан сууж дотроо Гурван эрдэнээс аврал эрэн, гэгээрэх тэмүүллийг сэтгэлдээ нийцүүлэн баттай бясалгана. Хутагт Асанга *Шаравагагийн төвшин* номдоо нойрмоглож, нозоорсон сэтгэлээ сэргээхийн тулд бодлоо өөр зүйлд хандуулж болно. Харин сэтгэл сэргээд улмаар тогтвортгүй болохоос нь өмнө аль болох өөрийн биед амар байрлалаар нуруугаа цэхлэн сууна хэмээн өгүүлсэн байdag. (4) Агуу үйл хэрэг болон гүн үзлийн үе залгамжилсан багш нар мөн гэгээрэгсэд, бодисадва






болон шарвага, брадига, шашны сахиус зэргийг өөрийн өмнөх орон зайдаа тодорхой төсөөлж, ургуулан бодно. (5) Гэгээрлийн зам мөрийг өөриймшүүлэх: (а) эерэг нөхцөл бүрдүүлэх буюу төгс чанарын чуулбарыг хуримтлуулж, (б) сөрөг нөхцлөөс ангижрах буюу сэтгэлийн хир буртагийг арилгах ёстой. Энэ хоёрыг хослуулахгүй, аль нэгийг нь дагнан бясалгаж, суралцвал хичнээн хичээгээд ч маш их бэрхшээл туулна. Тиймээс бүрдүүлэх болон ангижрах нөхцлийг нэгтгэсэн долоон үет зан үйлийн зааврын дагуу бясалгах хэрэгтэй.


Уг зан үйлийн эхний үе болох мөргөлийг *Самандбадрын залбирын* залбирын дагуу хийнэ. Эхлээд бие, хэл, сэтгэл гурвыг хамтатган зэрэг мөргөх бөгөөд тус залбирын эхний шадыг уншина:

Бий орчлонг зүгтэй, цагтай нь  
Билгээр эзэгнэх будда бүхэнд  
Бие, хэл, сэтгэл гурваараа  
Биширч, магтаж, сөгдөж мөргөму.

Ийн мөргөхдөө орчлонгийн аль нэг хэсэг, эсвэл ямар нэг үеийн гэгээрэгчийг бус, харин хамаг ертөнц дахинд урд нь тодорсон, одоо оршин буй, ирээдүйд тодрох бух гэгээрэгсдийг сэтгэлдээ төсөөлнө. Тэгээд бусдыг дууриаж хэлбэрдэлгүй чин сэтгэлээсээ, гүн хүндэтгэлтэйгээр бие, хэл, сэтгэлээрээ мөргөх ёстой. “Ганцхан гэгээрэгчид мөргөсөн буян хэмжихийн аргагүй их билээ. Тэгэхээр олон гэгээрэгчийг төсөөлөн мөргөвөл яриангүй сайн” гэж Эшэдэ багш тайлбарлажээ.

Бие, хэл, сэтгэлээр тус тусад нь хэрхэн мөргөхийг





үзүүльье. Эхнийх буюу биеийн мөргөл нь дараах шадаар илэрхийлэгдэнэ:

Зөв мөртөө орохын мөрөодлөөр  
Зүг бүрийн буддаг дуудаж  
Тоос мэтээр биеэ олширсонд бодож  
Толгой мэхийн залбирч мөргөе.

Ингэхдээ цаг үе, зүг зовхис бүрийн бүх гэгээрэгсдийг сэтгэлдээ тодорхой төсөөлөн бодно. Тэгээд биеэ өртөнцийн тоосны тоогоор олширсон гэж сэтгэн мөргө. Хамаг сайн явдалд үнэн голоосоо сүсэглэж, тэрхүү сүсгээр сэтгэлээ бүхэлд нь ариусгана. “Ганц биеэр мөргөхийн буян их болохоор биеэ олон хувилган мөргөвөл агуу буянтай” хэмэн Эшэдэ багш хэлсэн билээ.


Сэтгэлийн мөргөлийг дараах шүлгээр илэрхийлнэ:


Тоос бүхэн дээр хумх шиг тоотой  
Тоо томшгүй будда байнам  
Тоо томшгүй будда нарын дунд  
Тогтоож харвал бодисадва нар байнам.

Бурхан номын чанарыг үзүүлэгч  
Буддаг дагуулж гэгээрүүлэгч бүхэн  
Бүхий хорвоог зай завсаргүй  
Бүчиж дүүргэхийн ерөл өргөнөм.

Мөргөхдөө энэ орчлонгийн хумхын тоос бүр дээр тэдгээр тоосны тоотой тэнцүү гэгээрэгсэд болон бодисадва нар хүрээлэн суусны голд нь өөрөө сууж байна гэж төсөөлнө. Тэгээд тэдний эрхэм сайн чанарыг санаж, өөртөө төлөвшүүлэхийг хүснэ.

Хэлний мөргөлийг дараах шадаар илэрхийлнэ:





Яруу магтаалаар далай бүтээлээ  
Ялдам эгшгээр давалгаа хийлээ  
Ялж төгс нөгцөгчийг бишрэн  
Ялгуулсан бурхдыг магтан дуулнам.


Ийн уншихдаа биеэ олон хувилсан, бие тус бүр тоолж баршгүй олон толгойтой, толгой бүхэн нь тоолохын эцэсгүй олон хэлтэй болж хувирсан хэмээн төсөөлне. Ингээд гэгээрэгсдийн эрхэм чанарыг яруу уянгалаг уншина. Энэ шүлгийн “ялдам эгшиг” гэдэг нь магтаж гэсэн санаа бөгөөд өгүүлэхүйн эрхтэн хэлээр мөргөж буй хэрэг юм. Харин “далай” нь маш олон тоог илэрхийлж байгаа юм.


Зан үйлийн энэ үед хоёр төрлийн тахил өргөдөг бөгөөд эхнийх буюу ердийн тахил нь дараах хоёр бадаг шүлэгт багтжээ:

Алаг цэцэгсээр сүлжсэн эрхин  
Аялгуут эгшиг, анхилуун үнэртэн  
Ямбаны шүхэр, арц утлага гэгээн зулыг  
Ягштал зохицуулж тахил өргөмү.

Гоёл чимэгтэй гангтан хувцас  
Гоц үнэртэн, янзын чимэгтэн  
Гойд тансаг молцог цацгаар  
Гоёсон тахилаа бурхандаа өргөмү.

“Алаг цэцэгс” гэдэг нь тэнгэр болон хүний ертөнцийн сайхан цэцэгсийн дэлбээ. “Эрхин” гэдэг нь олон төрлийн цэцгийн хэлхээ байна. Цэцгийн эрхи нь амьд болон хиймэл хоёр төрлийн цэцгэн эрхи байдаг. “Аялгуут эгшиг” гэдэг нь чавхдаст, үлээвэр, цохилуур, хангинуур хөгжим юм. “Анхилуун үнэртэн” гэдэг нь есөн анхилуун үнэртэн бүхий сүрчиг. “Ямбаны шүхэр”





гэдэг нь хамгийн шилдэг шүхэр. “Гэгээн зул” гэдэг нь анхилуун тосон зул болон бусад гэрэл цацруулсан эрдэнийн чулуу байж болно. “Арц утлага” гэдэг нь холимог болон дан хүж. “Хувцас гоёл” гэдэг нь хамгийн сайн хувцас гэсэн уг. “Тансаг үнэртэн” гэдэг нь тахилын угаалга хэмээх анхилуун ус бөгөөд гурван мянган ертөнцөд үнэр нь түгэх анхилуун шингэн юм. “Молцог цацааг” гэдэг нь тансаг үнэртнийг нунтаглан жинтуулсэн, эсвэл цэцгийн үйрмэгээр мандал дурслэн Сүмбэр уул мэт олон давхарлан унжуулсан байна. “Тоёсон тахил” гэдэг нь дээр дурьдсан бүхнийг тодорхойлохын сапуу тэр бүхнийг хараа булаахаар цогцлуулан байрлуулна гэсэн уг юм.


Харин ер бусын тахилыг дараагийн бадаг шүлэг илэрхийлийн:


Хорвоод төрөгсөд хэзээ ч хараагүй  
Хосгүй гайхам тахил өргөе  
Хоёргүй сэтгэлээр гэгээрнэ хэмээн  
Хотлыг гийгүүлэгч бурхандаа мөргөе.

Ердийн тахил бол энэ ертөнцөд байдаг жирийн тахил юм. Тэдгээрийг бодисадва зэрэг онцгой чадвартанггууд хувилгаан шидээр хувирган өөрчилдөг. Сүүлийн хоёр мөр нь дээрх хоёрын дутууг гүйцээж мөргөх, тахил өргөх үеийн сэтгэлийн төлөв, чин хандлагыг тодорхойлжээ.

Харин дараагийн бадаг шүлэгт гэмээ наминчлах тухай өгүүлсэн байна:

Хүсэл, хилэн, мунхагтаа автаад  
Хүрэлцэж, хэлэлцэж, бодож үйлдсэн  
Хүний хорвоогийн гэм нүглээ  
Хүлцэж гэмшихийг минь анзаарч өршөө.





Дээрх гурван хоронд автан бие, хэл, сэтгэлээр гэм хийдэг. Мөн чанарын хувьд өөрөө хийсэн буюу оролцсон, мөн бусдыг уруу татсан болон бусдыг гэмт үйлд хөөрөгдсөн байж болно. Тэр бүхнийг нийтэд нь “хүний хорвоогийн гэмүүд” гэж илэрхийлжээ. Тэдгээрийн ял зэмийг санаж, урьд гаргасандаа гэмшиж, цаашид давтахгүй хэмээн үнэн голоосоо андгай тавина. Тэгвэл урьд өмнөх гэм зэм нэмэгдэхгүй, хойшдоо ч дахин гарахгүй.

Дараагийн бадаг шүлэгт буяныг баходан баясах тухай өгүүлсэн байна:


Арван зүгийн будда, бодисадва нарт  
Анхлан, үргэлжлэн, замнан гэгээрэгч  
Амьтан бүгдийн хураасан буяныг  
Ашид даган, үнэнхүү баясму.


Эдгээр таван бодгалийн эрхэм сайн чанарыг дурсан санаж, эрдэнэсийн сан олсон гүйлгачинтай адилхан баярлах учиртай.

Дараагийн бадаг шүлэгт сургаал номлол айлдахыг хүсэн гүйх тухай өгүүлжээ:

Хүй орчлонг зул шиг гийгүүлэгч  
Хүслээс ангижирч гэгээрэгсдээс  
Хүршгүй боловсролд гэгээрсэн болгоноос  
Хүртээж эрдмээрээ гийгүүлэхийг гүйнам.

Арван зүгт буй төгс гэгээрэгсэд болон хүслээс ангижирч, бүхнийг ухаараад удаагүй байгаа гэгээрэгсдэд хандаж байгаа юм. Ингэхдээ тэднийг өөрсдийн биеэ оршин буй орчлон ертөнцийн тоогоор хувилган номлол сургаалаа заахыг хүснэ. Эшэдэ багш





“Ялж төгс гэгээрэгсэд” гэж хэлээрэй хэмээн сануулсан байdag.

Үүний дараагийн бадаг шүлэг залбирлын тухай өгүүлдэг:

Оройн нирваанд замчлагч болгоноос  
Олон амьтныг гэгээрүүлэн хөтөлж  
Орчлонгийн тоос шиг тоолшгүй галвуудад  
Оршин тогтонохыг залбиран гүйнам.


Ертөнцийн арван зүг бүхний нирваанд хүрэх жаяг сургаалыг үзүүлэгчдэд хандан амьтан бүхнийг ойрын болон алс хэтийн жаргалд хүртэл нь энэ ертөнцөд саатан үлдээч гэсэн гуйлит юм. Ингэхдээ төгс нирваанд одолгүй ертөнцийн тоосны тоотой тэнцүү галавт биеэ тоолшгүй олон хувилган залраач хэмээн хүсэн залбирна.


Доорх бадаг шүлгээр долоон үет зан үйл чухам юунд зориулагдаж буйг илэрхийлдэг:

Мөргөж, шүтэж, гэмүүдээ наминчилж  
Мөрөөдөж, залбирч, шүтэж хүрснээ  
Мөрдөх буян, итгэл зүтгэлээ  
Мөнхийн ариусал, гэгээрэлд зориулнаа.

Дээр өгүүлсэн зургаан зан үйлээр хуримтлуулсан зөв дадлаа, тэрхүү сайн чанарынхаа бүх үндсийг ерөнхийд нь амьтан бүхний тусыг бүтээх болон төгс гэгээрлийн үндэс бүрдүүлэхэд баттай зориулан залбирах ёстой. Ингэвэл зөв дадал огтхон ч дундрахгүй.

Дээрх зан үйлийг хийхдээ өөр зүйлд сатааралгүй, шүлгүүдийн утгыг нь ойлгохын сацуу алгуурхан уншиж, зааврын дагуу гүйцэтгэвэл хэмжих аргагүй их буян болно.





Мөргөх, тахих, залбирах, баходан баясах, гүйж хүсэх таван зан үйл нь сайн чанар бүрдүүлэх эерэг нөхцөл юм. Харин “нүглээ наминчлах” нь сөрөг нөхцөл болох гэм алдаанаас сэргийлдэг. “Баходан баясах” нь нэг талаар өөрийн зөв дадлаа баходан баясахын зэрэгцээ түүнийгээ улам нэмэгдүүлдэг. “Зориулах” нь буруугаас салах, зөвийг төлөвшүүлэх, улмаар нэмэгдүүлэх гурван буянаа гэгээрэлд зориулснаар очижүүхэн зөв дадлыг асар их болгон арвижуулдаг. Түүний зэрэгцээ зөвхөн энэ насанд хүртээд өнгөрөх байсан үр шим нь дуусашгүй болно. Товчоор хэлбэл дээрх долоон зан үйл бол зөвийг төлөвшүүлэх, буруугаас салах, улам бүр арвижуулах гурван зөв дадал юм.

(6) Дараа нь хүслээс ангижран гэгээрэгсдийг ургуулан бодож мандал өргөнө. Мандал өргөхдөө гүн мэдрэмжтэйгээр доорх үгсийг олон дахин уншиж залбирна:

Багшийг эс бишрэхээс эхлээд хоёр Би - д автагдах хүртэлх аливаа буруу үзэл санаа бүхнээс үтэр түргэн салах болтугай.


Багшийгаа өргөмжлөн хүндэтгэхээс аваад эзэн биегүй мөн чанартай бодит ахуйг ухаарах хүртэлх аливаа зөв үзэл бүхэн надад хялбархан төлөвших болтугай.


Дотоод болон гадаад саад бүгдийг арилган, сэтгэлийн их хүч хайрла.

## 6) Бясалгал

### I) Бясалгальн өрөнхий зүйл

“Бясалгах” гэдэг нь сэтгэлээ байнга зөв дадалд хандуулан, сэтгэлдээ түүнийг тогтоон барьж сурахын






нэр юм. Тэр гэхийн тэмдэггүй цаг хугацааны эхлэлээс бид сэтгэлийнхээ эрхээр явж ирсэн бөгөөд түүнийг хэзээ ч захирч байсангүй. Харин сэтгэл маань сэтгэлийн гэм мэтийн хирэнд баригдаж гэм буруу бүхнийг өдөөж, биднээр хийлгэсээр ирсэн. Иймээс сэтгэлээ захирч өөрийн хүссэнээр зөв дадалд хандуулж, улмаар гарын ясаар залах чадвартай болохын тулд бясалгадаг юм.


Гэхдээ санаанд орсноо бясалгаад байж болохгүй. Бас өөрийн хүссэн зөв дадалд чиглэсэн ч гэсэн хэмжээ, дэс дараалалгүй бясалгал хийвэл зөв дадал төлөвшихөд саад болохоос цаашгүй. Эхнээсээ ийм буруу хэвшил тогтчихвол насан туршийнхаа зөв дадал эзэмших боломжийг сүйтгэж орхино.

Тиймээс аливаа бясалгах зүйлийнхээ хэмжээ, дэс дарааллыг тодорхой тогтоох хэрэгтэй. Ингээд “тогтоосон хэмжээгээ эвдэхгүй” гэдэг хатуу шийдвэр гарга. Улмаар тогтоосон хэмжээ, дарааллаа хэтрүүлж, багадуулахгүйн тулд санамж, сэрэмж хоёрт тулгуурлах хэрэгтэй.

## II) Бясалгах үе

Эхлээд багшийг шүтэх ба үтэр түргэн төгс гэгээрлийн төвшинд хүрэхийн ач тус болон багшийг шүтэхгүй байхын гэм буруу, хойд насны зовлон зэргийг бodoх хэрэгтэй. Тэгээд “Би багшаас ямар нэг алдаа дутагдал огт эрэхгүй” гэж олон дахин андгайл. Тэгээд багшаас ёс зүй, сэтгэл төвлөрөл, билэг оюун, эрдэм мэдлэг болон бусад сайн чанарын алийг нь олж харсанаа бодож чин сүсэг төртөл бясалга. Дараа нь өөрт тус болсон мөн цаашдаа ч хэрэг болох сургаалынх нь ач тусыг өмнө өгүүлсэн судар номуудаас сэргээн санаж чин зүрхэндээ





хүндлэл төрөх хүртэл бясалгана.

### **в) Төгсгөлд нь юу хийх вэ?**

Бүрдүүлсэн зөв дадлаа *Саманбадрагийн залби* боладан *Далан өрөөл*-д өгүүлсэн ёсоор ойрын болоод хэтийн зорилгодоо хүрэх чин хүслээр зориулж байх хэрэгтэй. Нийтдээ өглөө, үдээс өмнө, үдээс хойш, үдэш дөрвөн удаа бясалгана.


Гэхдээ эхэндээ хэт удаан бясалгавал сэтгэл хөөрөл, нозооролд амархан ордог. Ийм байдал нэгэнт хэвшчихвэл сэтгэлээ захирахад хэцүү болдог учир эхлээд богино хугацаагаар олон удаа бясалгах хэрэгтэй. Бясалгальн амтанд ид автах үедээ завсарлавал дараа дахин үргэлжүүлэх хүсэл хадгалагдан үлддэг. Тэгэхгүй бол бясалгалаас жигшдэг гэсэн уг бий.


Харин бясалгал бага зэрэг тогтвортжсон хойно хугацаагаа сунгаж болно. Хэт хүчилсэн, хэт сулбагар бус бясалгаад сурчихвал хөөрөх, нозоорох саад бэрхшээл арилах болно.

### **2) Бясалгальн үе шатуудын хооронд хийх зүйлс**

Ерөнхийдөө бясалгальн завсарлагаар эргэл мөргөл хийх, уншилага унших гээд хийх зүйл олон бий. Гэхдээ завсарласан үедээ бясалгаж буй зүйлээ байнга санаж байх нь хамгаас чухал юм.

Бясалгал хооронд тухайн зүйлээ эргэн санаж, эргэцүүлэн бодохгүй сэтгэлээ зоргоор нь тавибал төдийлөн үр дунд хүрэхгүй. Тиймээс засварлах үедээ тухайн бясалгальнхаа талаар уншиж, сэргээн санаж байх хэрэгтэй. Мөн бясалгальн сайн талууд төлөвшихөд дэм болдог зөв дадал бүрдүүлэх, саад болдог алдаа дутагдлаас салах олон арга хэрэглэ. Энэ





сацуу бүхний үндэс болсон сахилаа ухамсартайгаар сахихыг хичээх нь зүй билээ. Тухайлсан нэг зүйлд оюунаа дадуулах, сахил сахих, зөв дадал хуримтлуулах гурвыг нийлүүлэн “турамсан бясалгал” гэж нэрлэх нь ч бий.

Мөн (а) мэдрэхүйгээ хянах, (б) ухамсартай үйлдэл, (в) зөв хооллох, (г) унтахгүйг хичээх болон хэрхэн унтах дөрвөн зөв дадал нийлж тайван төлөв ба үлэмж үзэлд хялбархан хүрэх үндэс болдог.

#### a) Мэдрэхүйгээ хянах


Мэдрэхүйгээ хянахад нэгдүгээрт үргэлж санаж сэрэх, хоёдугаарт байнгын чармайлт чухал. Эн түрүүнд мэдрэхүйгээ хянах сургаал болон дээр өгүүлсэн бясалгалын бусад зааврыг мартахгүй үргэлж санаж бай. Улмаар марталгүй санаж яваа заавруудаа байнгын чармайлтаар хэрэгжүүлж сурх хэрэгтэй. Энэ бүхний эцэст зургаан мэдрэхүйгээ хянаж, мэдрэхүйд өртдөг тааламжтай, тааламжгүй тус бүр зургаан объектоос сэрэмжилж чаддаг болно.


Мэдрэмжээ хянах хоёр арга бий:

1) *Мэдрэхүйгээ хамгаалах*: Ямар нэг объект нь мэдрэхүйн зургаан эрхтэнээр дамжин мэдрэмж бий болгодог. Ингээд сэтгэл өөрт тааламжтай объектод татагдах, тааламжгүй нь жигших зэрэг бусад сэтгэл хөдлөл үүснэ. Тиймээс тэдгээр сэтгэлийн хөдлөлд автахгүй байхыг хичээнэ.

2) *Зургаан мэдрэхүйгээ хянах*: Үүний тулд харах зэрэг хүртэхүйн үед сэтгэлийн гэм (нисуванис) төрүүлдэг объектоос мэдрэхүйгээ хамгаалж, сэрэмжилнэ.

Зургаан мэдрэхүйд өртдөг юмын шинж чанар болон





тэдгээрээс төрөх сэтгэгдлүүдэд хэт автагдахгүй мэдрэмжээ хамгаалахыг мэдрэхүйгээ хянах гэдэг. Сэргээж алдан сэтгэлийн гэм нэмэгдэж буруу сэтгэгдэл төрөхөөс сэргийлэх ёстой. Илт харагдахгүй байгаа дурс зэргийг бий болгон харах буюу тухайн үзэгдлээс үүдэн сэтгэлдээ түүнийг илэрхий урвуугаар төсөөлөхийг “хийсвэрлэлд автагдах” гэдэг. Зургаан мэдрэхүйгээр хүртэн уур, мунхаг, шунал гурвины аль нэг төрсон объектыг хожим сэтгэлийн мэдрэхүйгээр төсөөлөх буюу дараа нь бусдаас сонсон тэдгээрийн тухай хийсвэр төсөөлөл үүсэх нь “сэтгэгдэлд хүлэгдэж” буй хэрэг юм. Мөн өөрөө харж, хүртээгүй хэрнээ бусдаас дам сонсон бий болдог ойлголт ч үүнд хамаарна.

Сэтгэлийн гэмээс санаа сэтгэлээ хамгаалж зөв буюу тодорхой бус төлөв байдалд барихыг хянах гэнэ. Сэтгэлийн гэм илрээгүй тодорхой бус төлөв байдал гэдгийг сэтгэл зөв дадалд төвлөрөөгүй, жирийн үеийн үйл хөдлөл гэж ойлговол зохино.


## б) Ухамсартай үйлдэл


### I) Үйл хөдлөлийн үндсэн хүрээ

Бидний үйл хөдлөлийн үндсэн хүрээ өөрийн таван хөдөлгөөн болоод сүм хийд дэх таван хөдөлгөөн гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваагддаг.

Өөрийн таван хөдөлгөөн нь:

- (1) Биеийн хөдөлгөөн: Өөр газар орон, сүм хийд зэрэг өөр газар очих буюу эргэж ирэх.
- (2) Нудний хөдөлгөөн: Урьд нь огт мэддэггүй байсан юмыг харж анхны төсөөлөлтэй болох. Мөн өмнө нь мэддэг байсан зүйлээ харж тодорхой танин мэдэх.






- (3) Үе мөч, эд эрхтний хөдөлгөөн: Үе мөч, эд эрхтнуудээ тэнийлгэх болон хумих.
- (4) Хуврагийн хувцас хэрэглэлтэй холбоотой хөдөлгөөн: Хуврагийн гурван хэсэг хувцас ба бадараягаа хэрэглэж, хадгалах.
- (5) Бадар барихтай холбоотой хөдөлгөөн: Идэх, уух зэрэг үйлдлүүд.


Сүм хийд дэх таван хөдөлгөөн:

- (1) Биеийн үйлдэл: Хүрээ хийдэд суух. Үзэл бодол нэгтэй нөхөдтэй хамт байх, номлол, сургаалсонсохоор явах. Сургаал, номлол нь зохицох хийдийн номлогч, багшийн дэргэд завилан суух г.м.
- (2) Хэлний үйлдэл: Арван хоёр эрхэм зарлигаас үзээгүй хэсгээ судлах, цээжлэн тогтоох, судалсныг амны уншлага болгох, бусдад заах, идэвхээ нэмэгдүүлэх үүднээс бусадтай ярилцах г.м.
- (3) Оюуны үйлдэл: Шөнийн бясалгальн завсарт унтах. Нам гүмхэн орчинд очиж судалсан зүйлийнхээ утгыг эргэцуулэх. Сэтгэлийн есон төлөвт бясалгал хийх. Үлэмж үзэлд хүрэхийн тулд дуугаа хураах. Халууцсан эсвэл ядарсан үедээ цагаас эрт унталгүй сэргэг байх болон бусад үйлдэл.
- (4) Өдөр, (5) шөнийн үйлдэл: Өдөр, шөнийн эхний ба сүүлийн хэсэгт унтахгүй. Энэ үед бие, сэтгэлийн үйл хийнэ. Харин “шөнийн дунд хэсэгт унтах” нь зөвхөн шөнийн буюу сэтгэлийн үйлд хамаарна.

## II) Үндсэн үйл хөдлөлийг ухамсартай хослуулах

Энд дурьдсан арван үйл хөдөлгөөнийг хийхдээ тухайн зүйлдээ хамаг анхаарлаа төвлөрүүлж, хянамгай байх нь







зүйтэй. Дээрх үйлүүдийг ямар байдалтай хийж буйгаа шинжиж, ном ёсоор нь гүйцэтгэж байгаа эсэхээ хянаж бай.

Энэ нь дараах дөрвөн байдлаар тодорхойлогдоно:

- 1) Дээрх арван үйлийг хийхдээ тухайн үйлийг гүйцэтгэх ёс жаягтай зохицож байгаа эсэхийг шинжинэ. Жишээлбэл, ирж, очиходо тэр талаар ёс зүйд хэрхэн заасныг мэдээд “одоо би үүнийг ингэж хийх ёстoy” гэж бодно.
- 2) Явах зүг чиггээ шинжихдээ тэр зүг хаана, юунд хүргэдгийг ухамсарлах ёстoy. Жишээлбэл, хaa нэг тийшээ явахдаа архины мухлаг мэтийн таван буруу газрын аль нэг рүү явж болохгүй нь зүй. Харин түүнээс өөр тийшээ явна гэдгээ ухаарч, ухамсарлах ёстoy.
- 3) Цаг үеийн байдлыг шинжихдээ тухайн цаг юунд зохимжтойг мэдэж байх учиртай. Жишээлбэл, үдээс өмнө хот балгад руу явж болно, үдээс хойш явж болохгүй гэдгээ мэдэж, ухамсарлах хэрэгтэй.
- 4) Аливаа үйлдлийг хийхдээ хэрхэн хийх ёстoyг ухамсарлах хэрэгтэй. Жишээлбэл, гадагшаа гарах үедээ өөр айлд ямар байдалтай байх тухай заавар журамд заасныг санаж байх нь зүйтэй.

Товчоор хэлбэл өдөр, шөнийн үйлдэл бүхнээ эргэн санаж бай. Тэдгээрээс болох, болохгүйг нь ялга. Аливааг хийх болон татгалзахдаа “одоо үүнийг хийж байна, харин үүнээс татгалзаж байна” гэж байнга ухамсарлан хийж бай. Ингэж чадвал энэ насандаа алдаа эндэгдэл гаргахгүй. Бас хойд насандаа ч муу





заяанд төрөхгүй. Түүнчлэн бүрдүүлж амжаагүй сайн чанаруудаа хуримтлуулна гэж өгүүлсэн байdag юм.


Үүнийг хутагт Асангагийн мэдрэхүйгээ хянах болон түүний утгыг тайлбарласан бүтээлээс ишлэн авлаа. Энэ хоёр зүйлийг хичээнгүйлэн дагавал зөв дадал төлөвшүүлэхэд бусад ямар ч аргатай харьцуулшигүй ахицтай. Ялангуяа ёс суртахуун ариун болж, тайван төлөв ба үлэмж үзэлд хүрэхийн өмнөх сэтгэл төвлөрүүлэх бясалгалыг эзэмшидэг гэсэн байdag тул хичээх хэрэгтэй шүү.


### в) Зөв хооллох

Зөв хооллохын тулд дөрвөн дүрэм баримтална:

- 1) Хэт бага идэж болохгүй: Хэтэрхий бага хоолловол өлсөж, сульдана. Улмаар зөв үйл хийх хүчгүй болдог. Тиймээс маргаашийн хоол хүртэл өлсөхгүй байхаар бодож хоолло.
- 2) Хэт их идэж болохгүй: Хоолоо ихдүүлбэл ачаа үүрсэн мэт бие хүндэрдэг. Амьсгалахад ч бэрхтэй болж, нойрмоглон нозоорч юу ч хийж чадахгүй. Мөн сэтгэлийн гэмийг дараах чадвараа алдана.
- 3) Шингэц сайтай хоол идэх: Шингэцтэй хоол идвэл элдэв хууч хөдлөхгүй. Мөн шинэ зовлон үүсэхгүй.
- 4) Буруу санаагүй хооллох: Хооллохдоо ямар нэг ёс жаягийг зөрчихгүй бол таатай мэдрэмж төрдөг.

Эдгээр дүрэм нь хоолонд шунахын эсрэг чиглэж байгаа бөгөөд хэт ховдоглохын сөрөг талыг тунгаан бodoх бясалгалд тулгуурладаг. Ерөнхийдөө хоолонд гурван сөрөг тал бий. (1) Амтшин дурлахын сөрөг талыг бясалгахдаа: хичнээн сайхан үнэр, амттай хоол байлаа ч







шүдээрээ зажилж, шүлсээрээ дэвтээсэн хойно бөөлжис шиг болдгийг бодно. (2) Шингэсэн хоолны сөрөг талыг бясалгахдаа: идсэн хоолны нэгээхэн хэсэг нь шөнө дунд ба түүнээс хойш биеийн эд эс болон шингэдэг. Үлдсэн хэсэг нь баас, шээс болон биеийн доод хэсэгт хуримтлагдаж өдөр бүр гадагшилдаг. Мөн хоолноос олон өвчин үүсдгийг бодно. (3) Хоол эрж хайхын сөрөг талыг бясалгахдаа дараах таван зүйлийг бод:

- 1) Хойноос нь хөөцөлдөхийн гэм: хоол олох, хоолны мөнгөтэй болохын тулд бид халуунд халж, хүйтэнд хөрж зүтгэдэг. Харин түүнийгээ олж чадахгүй бол гуньж гутардаг. Хэрвээ олчихвол алдаж, үрэн таран хийчихвий гэж айна. Тэгээд хадгалж харамлах гэж зовдог.
- 2) Тангараг тасрах гэм: хоолны төлөө эцэг, хүү хоёр ч хоорондоо тэмцэлдэж тангараг тасардаг.
- 3) Ханахаа мэдэхгүйн гэм: хоолоо уlam нэмэхийн төлөө хаадаас эхлээд харц хүртэл хоорондоо тэмцэлдэн зовдог.
- 4) Бусдын эрхэнд ордог гэм: Бусдаар тэжээлгэгчид тэр хүнийхээ төлөө хэн нэгэнтэй байлдах ч хэрэг гарч зовлон эдэлнэ.
- 5) Буруу үйл хийх гэм: Хоол олохын тулд бие, хэл, сэтгэлээр гэм хийдэг. Ингээд хожим хийсэн гэм нүгэлдээ харамсан шаналсаар үхэж улмаар муу төрөлд төрне.

Гэхдээ хоолонд ганц нэг ашиг тус байлгүй яахав. Хоолоор биеийг тэжээн тэтгэдэг. Тиймээс “Зөвхөн амьд явахын төлөө хоолны хойноос хөөцөлдөхгүй.






Хүний энэ биеийг хоолоор тэжээн тэтгэж байгаад ариун журамт амьдралд хүрэх ёстой” хэмээн бодож сурах нь зүйтэй. Өглөг өгөгч, өглөгийн эзэд хуруу хумсаа хугалан байж олсныгоо маш их үр шим горьdon өглөгт өгдөг. Тиймээс тэдний хүсэл билээсэй гэсэн бодолтой өгснийг нь хэрэглэж бай. Мөн “Өглөг хайлласан нэгний тусыг бодож, өнөөдөр та миний эд эсийг хоолоор тэтгэлээ хожим би таныг номлогоор тэтгэнэ. Амьтан бүхэнд туслана гэдэг сэтгэлээр бусдаас авч бай” гэж Шантидэва *Хураангуй заавар журал* номдоо өгүүлсэн байдгийг санаж яв. Басхүү хутагт Нагаржуна *Анддаа илгээсэн захидал*-даа ийн өгүүлжээ:


Идээ умдаагаа эм гэж санаад  
Идэмхий уумхайнхаа ерөндөг болго.  
Ид бах, сайрхал, бардамнал бус  
Энэхэн бие л амьдруулан хүрт.

**г) Унтахгүйг хичээх ба хэрхэн унтах тухай**  
*Анддаа илгээсэн захидал-д:*

Мэргэд өдрийн туршид мөн шөнийн эхэн  
Адгийг хүртэл бясалгаад завсарт нь  
Унтах үедээ ч үр ашигтгүй өнгөрөөлгүй  
Өмнө хийснээ дурьдан санаж өнгөрөөдөг  
хэмээсэн байdag.

Энэ нь бүхэл өдрийн туршид бясалгал хий. Мөн шөнийн эхний болон сүүлийн хагас ч бясалгаль зориулагдана. Цаашилбал тэдгээрийн хооронд ч бясалгал үргэлжилнэ гэсэн санаа юм. Босоо, суугаагийн алинд ч сэтгэлээ таван хир буртагаас цэвэрлэж, цагаа үр ашигтай өнгөрөөх хэрэгтэй гэснийг дээр гаргажээ.







Унтахдаа санаж бодох болон мэдрэхүйгээ хянах, ухамсартай үйлдэх гурав нь жинхэнэ бясалгал ба бясалгалын завсарлагад хамаарна. Харин энд завсарлага буюу унтах журмыг өгүүлье. Унтахдаа бясалгах арга: Шөнийг гурав хуваасны эхний хэсэгт зөв дадал төлөвшүүлнэ. Харин шөнийн хоёрдугаар хагаст хэвтэж амарна. Бөх унтах, биеэ амраах хэрэгтэй. Тэгвэл бие сэргэж, зөв дадал төлөвшүүлэх хичээл зүтгэл улам нэмэгдэх ач тустай. Унтахын өмнө гарч гар, хөлөө угаана. Эргэж орж ирээд баруун талаараа хэвтэж, зүүн хөлөө баруун хөлөн дээрээ тавин арслан мэт унтана. Арслан мэт хэвтэхийн учир:

Араатан амьтдын дундаас хамгийн сур хүчтэй нь арслан билээ. Бас эрэмгий зоригтой, шантардаггүй учир зорьсныхоо туйлд хүрдэг. Тэгвэл бага унтан ёогоор хичээллэх нь асар их эрч хүч өгч, хүршгүй зүйлд ч хүргэнэ. Тиймээс унтахдаа арслан шиг хэвтэх учиртай. Залхуу, идэвх зүтгэлгүй, чадалгүй учир лус, бирд, тэнгэр мэтийн хүсэл тачаалдаа хөтлөгдөгчид ч зорьсныхоо эцэст хүрэх нь ховор юм.

Нөгөө талаар арслан шиг баруун талаараа хэвтвэл ердийнх шиг бие сулрахгүй. Нойрсож байлаа ч нам унтахгүй сонор соргог байдаг. Мөн элдвийн буруу зүйл зүүдлэхгүй гэсэн өөр тайлал ч бий. Ингэж унтах чадахгүй бол дөрвөн төрлийн алдаанд хүргэнэ.


Унтах үедээ дараах дөрвөн санаа бодолтой байна.  
(1) *Гэгээн бодол*. Хэвтэхийн өмнө сэтгэлдээ гэрэл төсөөлөн бодож, гэрлийн тухай бодолтойгоо унтана. Ингэвэл нойрон дунд ч сэтгэл харанхуйлдаггүй юм.






(2) *Нэхэн санах*. Унтахаасаа өмнө сонссон, бодсон, бясалгасан номлол, зөв дадал болон хэрэгтэй зүйлсээ эргэж сэргээн сана. Тэгвэл сэтгэл сэргүүн байгаа мэт зөв дадлыг ахин дахин хийдэг. Товчоор хэлбэл унтаж байхдаа ч зөв дадал төлөвшүүлнэ гэсэн үг. (3) *Сонор сээрэмж*. Сонор сээрэмжтэй байвал ямар нэг буруу бодол төрсөн ч зоргонд нь алдахгүй хянаж чаддаг. (4) *Сэргэхтэй холбогдох бодол*. Сэргэхдээ гурван бодолтой байна. Эхнийх нь, ямар ч тохиолдолд сэтгэлээ нойронд автуулахгүй хэмээн бодож гөрөөс шиг сэргэг унтах явдал. Тэгвэл нам унтахгүй, цагтаа сэргэг болно. Дараагийнх нь бодол, “Би Буддагийн тогтоосон сэргэг унтах журмыг дагана” гэж өөртөө үргэлж урам өгч, хичээж бай. Тэгвэл Буддагийн тогтоосон арслан мэт нойрсох аргыг очижүүлэн ч эвдэлгүй унтаж сурна. Гуравт нь, “Би сэргүүн үедээ зөв, сайн чанар төлөвшүүлэх гэж их хичээсэн. Маргааш ч мөн үргэлжүүлэх болно” гэж бод. Ингэвэл зөв дадлаас төрсөн урам зориг гээгдэхгүй. Түүгээр үл барам унтах үед мартсаныгаа сэргээн хөгжүүлэх урам улам бүр нэмэгддэг.

Хэрвээ идэж, унтах энэхүү дүрмийг зорчихгүй бол амьдралаа хий дэмий үрэх нь багасаж, зөв зүйлд зориулна. Энэ бүхнийг хутагт Асангагийн эх зохиолоос ишилэн авав. Бясалгальн бэлтгэл хэсэгт гарсан онцгой тохиолдлоос бусад үе буюу жинхэнэ бясалгал болон түүний төгсгөл, завсарлага үед гарсан журмуудыг хойшид гарах үлэмж үзэл хүртэлх бүлэг тухай бүр нь тохируулан хэрэглэнэ.







VI

БЯСАЛГАЛЫН ТУХАЙ БУРУУ ОЙЛГОЛТЫГ  
НЯЦААХ

---





Зарим нэг нь эрхэм зарлиг болон түүний тайлбарын гол утгыг өчүүхэн ч ухаараагүйн улмаас бясалгалын талаар эргэлзээтэй ойлголттой болдог.


**Эргэлзээ:** Бясалгал хийх үед бясалгалын объектыг ахин дахин задлан шинжлэх шаардлагагүй. Зөвхөн тухайн объект дээрээ л төвлөрөх хэрэгтэй. Объектыг билэг оюунаар задлан шинжлэх нь бясалгахад бус зөвхөн судалж, эргэцүүлэх үед л хамаатай. Аливаа ойлголт нь хийсвэр төсөөлөлд хэт баригдсан, жинхэнэ оршихуйгаас тасархай байдаг учир гэгээрэлд саад болно.


**Залруулга:** Энэ бол ерөөсөө бясалгал хийж үзээгүй хүний хоосон үг байна. Хутагт Майдарын *Сударф айлгийн читэгт*:

Эхлээд юмсыг судалж байж зөв ойлголттой болдог. Тэр зөв ойлголтоо өөриймшүүлбэл юмсын жинхэнэ оршихуйг ухаarah бэлгэ билгүүн төрдөг. хэмээсэн байдаг.

Эндээс харвал судалж бий болгосон ойлголтоо билэг оюунаар өөриймшүүлдэг. Улмаар жинхэнэ оршихуйг шууд танин мэддэг ажээ.

Ямар нэг бясалгалын үндсийг нь бусдаас мэдэж авдаг. Ингэж бусдын туслалцаатай тодорхой ойлголттой болно. Дараа нь сонссон зүйлээ эх судар болон учир шалтгааны үүднээс шүүн тунгааж, өөрийн чадвараар тодорхой ойлголттой болох юм. Сонсож, эргэцүүлж байвал эргэлзээ арилж итгэл үнэмшил төрдөг. Энэ бүхэн дадал зуршил болохыг “бясалгал” гээд байгаа юм. Иймээс уйгагүй задлан шинжлэх






бясалгал (аналитик шинжилгээ гэж ойлгож болно) ба задлан шинжлэлгүй төвлөрөх бясалгал хоёулаа хэрэгтэй. Судалж мэдсэнээ бататгахад задлан шинжлэлгүй төвлөрөн бясалгах, нэг бүрчлэн задлан шинжилж бясалгах аль аль нь чухал. Харин бясалгальг бүхэлд нь төвлөрөх бясалгал гэж үзэх нь ганц ширхэг тариан түрүү барьчихаад “Тариа гэдэг нь ероосоё л энэ юм” гэж зүтгэсэнтэй ижил шүү.


Түүнчлэн судалж бий болдог билэг оюунтай болохын тулд судалдаг. Эргэцүүлж бий болдог билэг оюунтай болохын тулд эхлээд эргэцүүлдэг. Үүнтэй адил бясалгалаас бий болох билэг оюунтай болохын тулд эхлээд бясалгах шаардлагатай. Учир нь тэрхүү билэг оюун нь бясалгалаас л үүсдэг юм.

Бясалгалин объектыг маш тодорхой эргэцүүлж бий болсон ойлголт нь бясалгалаар бий болдог билэг оюуны суурь болдог. Тиймээс эргэцүүллээс төрсэн билэг оюунаас бясалгалин билэг оюун төрнө гээд байгаа юм. Хэдий чинээ их судална, төдий чинээ ихийг мэднэ. Тэр хэрээрээ эргэцүүлэн бодно. Эргэцүүлэл их байх тусам түүнээс бий болдог билэг оюун нэмэгдэнэ. Тэр чинээгээр өөриймшүүлэн бясалгаж олон гэмээс салж, олон сайн чанар төлөвшүүлдэг. Тиймээс бясалгал хийхэд судлах, эргэцүүлэх хоёр хамгаас чухал гэж эрхэм зарлиг болон түүний тайлбарт өгүүлдэг биз ээ.

*Эсрэг байр суурь:* Судалж, эргэцүүлэх нь зөвхөн буруу ойлголтоос салах төдий үүрэгтэй болохоор бясалгаад байх хэрэгтүй, бясалгалтай ямар ч холбоогүй.

*Хариулт нь:* Энэ бол товлосон газраасаа өөр газар





морь уралдуулахтай л адил. Тэгэхгүй бол уялдаа холбоо алдагдана. Мөн гурван билэг оюун дараалан хөгждөг жамтай гэсэн эрхэм зарлигийн ерөнхий агуулгаас зөрнө. Улмаар “Сургаалыг алдалгүй дагахад олон юм судлах шаардлагагүй” гэдэг буруу яриаг зөв хэмээн үзэхэд ч хүрч болзошгүй.


Судар, тантрын ёсыг дагнан маш их судалсан эсвэл эх бүтээл огтхон ч судлаагүй хоёр хүн одоо л нэг хэрэгжүүлж эхэлье гэхээр бариад авах их, бага ямар ч юмгүй байдаг. Бас иймэрхүү буруу бодолтой хүнээс номлол сонсож, асууж шалгаахад гууль нь цухуйж, үхширмэл бодлоосоо ухардаг юм.


Судалж, эргэцүүлэх билэг оюунаар тогтоосныгоо өөриймшүүлэх нь бясалгал биш боловч түүнийг бясалгал гэхэд буруу нь юу байх вэ? Хэрвээ энэ буруу юм бол бясалгальн анхны босгыг алхаагүй жирийн хүн хэзээ ч бясалгал хийж чадахгүй гэсэн үг болно. Хүсэлт тэнгэрийн орноос дээд төвшинд ороход түүнд түшиглэн бясалгалаас гарсан ухаан төрнө, үүнээс өөрөөр эгэл хүнд бясалгальн билэг оюун шууд төрдөггүй гэж *Абхидхармакоша*-д олон удаа дурьдсан байдаг.

“Бясалгал”-ыг хутагт Дхармакиртигийн *Төгс чанараын тодорхой тайлбар*-т тодорхойлсноор ойлгох нь зүйтэй:

“Бясалгал” гэдэг бол сэтгэлээ өөрийн эрхээр болгох буюу бясалгаж буй зүйлээ бодитоор хэрэгжүүлэхийг хэлнэ.

Жишээлбэл, “сүсэг бясалгах”, “энэрэл бясалгах” гэдэг нь сэтгэл өөрөө тийм мөн чанартай болохыг хэлдэг.







Томоохон орчуулагчид энэ үгийг заримдаа “дадал болгох үе” гэж орчуулсан байдаг. Ер нь бол дадаж хэвших, бясалгах хоёр нэг л ойлголт. Тухайлбал, Майдарын *Илт ухааrahын чимэг*-ийн орчуулгад “танин мэдэх ба дадал болгох үе шат” хэмээн оноосон байдаг. Хутагт Майдар ингэж айлдажээ:

Сэтгэл шуудран өртөнцөөс уйдах нь  
Сэрж танихаас бясалгалд хүрэх нь  
Бодож, тунгааж, дадаж хэвшүүлж  
Боловсрол ахих шатууд билээ.

Майдар энд Их хөлгөний гэгээнтний бясалгын шат дараалал бол уйгагүй бодож, эргэцүүлж магадлан ойлгох үйл явц гэдгийг тодорхой хэлжээ.

Эндээс харвал задлан шинжлэл, төвлөрөх бясалгал хоёрыг харш гэж үзвэл ёстой хөгийн юм болох нь. Сүсгийг бясалгах, цаглашгүйн дөрвөн сайн чанар болон гэгээрэх тэмүүлэл бясалгах, мөнх бусыг бясалгах, зовлонг бясалгах гэх мэт ахин дахин задлан шинжлэх учиртай маш олон бясалгал байдаг. Мөн Шантидэва *Бодисадвагийн замнал* болон *Хураангуй заавар журам* -даа “Өөртөө дадал болгохийн тулд үүнийг би туурвилаа” хэмээн өгүүлсэн нь зам мөрийн үе шат бүхэн бясалгал болохыг тодорхой харуулж байна. Түүнчлэн Шантидэва хутагтын *Хураангуй заавар журам*-д “Тиймээс бие, эд эдлэл, хураасан буянаа үргэлж батжуулах, хамгаалах, ариусгах, арвижуулахад хэрэгтэй бүхнийг бясалгаарай” гэсэн байдаг. Энэ нь бие, эд эдлэл, сайн чанарын гурван үндсийг тус бүрд нь батжуулах, хамгаалах, ариусгах, арвижуулах







нь дөрвүүлээ л бясалгал гэсэн санаа юм. Тэгэхээр “бясалгал”-ыг хэт явцуу утгаар ойлгож болохгүй нээ.

Аливаа ойлголт нь төсөөллюс бий болдог учир гэгээрэлд саад болдог. Тиймээс тухай бүрт нь задлан шинжлэх бясалгал хэрэггүй гэдэг ташаа бодол бол чань буддизмын хятад багш Хуушааны үзэл баримтлал юм. Үүнийг хожим тайван төлөв ба үлэмж үзлийн бүлэгт няцаах болно. Энэ ташаарал эх сударт итгэхэд саад болохын салуу буруу үзэл бий болгодог. Олонх эх судрын агуулгыг тухай бүрт нь зайлшгүй задлан шинжлэх шаардлагатай. Гэтэл бясалгальн үед задлан шинжлэх хэрэггүй гэж үзэж байна. Иймэрхүү үзэл буддын шашин доройтохиin хэрээр улам дэлгэрдэг. Эсвэл эрхэм зарлиг ба түүний утга санааны томоохон тайлбаруудыг гарын авлага гэж ухаarahгүй. Үүнээс өөр өөдтэй юманд хүргэхгүй.

*Асуулт:* Задлан шинжлэх ба төвлөрөх хоёр төрлийн бясалгалаар зам мөрийг өөриймшүүлдэг аж. Харин задлан шинжлэх ба төвлөрөх бясалгалд юу юу хамаарах вэ?

*Хариулт:* Багшид сүсэглэх, олоход хэцүү сайн төрөл маш их утга учиртай мөн үхэл - мөнх бус, үйлийн үр, орчлонгийн гэм зэм болон гэгээрэх тэмүүлэл хөгжүүлэх нь задлан шинжлэх бясалгалд хамаарна. Эдгээрийг оюун санаагаа дайчлан, удаан хугацааны турш бясалгаж гүнзгий ухаарах ёстой. Тэгэхгүй бол үл итгэх зэрэг сөрөг талуудыг даван гарч чадахгүй. Харин гүнзгий ухаарах эсэх нь гагцхүү ахин дахин задлан шинжилж бясалгахаас шууд шалтгаална. Жишээлбэл, сэтгэл татсан зүйлийн сайн талыг хэт дөвийлгөвөл







түүнийг эзэмдэх асар их хүсэл төрдөг. Мөн дайсныхаа муу талыг үргэлж бодоод байвал маш их үзэн яддаг шүү дээ. Тиймээс энэ үед бясалгаж буй зүйлийн тухайн үеийн үзэгдэх байдал тийм ч чухал биш. Харин оюун санаагаа дайчилж, удаан хугацаагаар тухайн зүйлд зориулах хэрэгтэй байдаг учир задлан шинжлэх бясалгал хийдэг юм.

Тайван төлвийн үед сэтгэлээ өөрийн дураар захирч, төвлөрдөггүй байсан сэтгэлээ нэг зүйл дээр тогтоож сурдаг. Ахин дахин бясалгаад байвал сэтгэлийн тогтвржилт алдагдахгүй болно. Энэ үед нь төвлөрөх бясалгалд орох хэрэгтэй. Харин үүнийг тайван төлөв ба үлэмж үзлийн бүлэгт тодорхой тайлбарлай.

Энэ зүй тогтлыг ойлгохгүй байх нь бий. Мэдлэгтэй болохыг хүсвэл задлан шинжлэх бясалгал хэрэгтэй харин даяанчид төвлөрөх бясалгал хэрэгтэй гэдэг бол буруу ойлголт. Аль алинаар нь л бясалгах шаардлагатай. Мэдлэгтэй болохын тулд тайван төлөв болон бусдыг нь ч бясалгана. Даяанч нар ч багшид гүнзгий сүсэглэхийг бясалгах учиртай. Судар, тарни хоёрын бясалгальн ёсонд ч нэг бүрчлэн задлан шинжлэх аргаар бясалгах хэрэгтэй гэж өгүүлсэн байх нь олонтаа. Энэ зарчмаар бясалгахгүй эсвэл нэр төдий бясалгавал сургаалын амин сүнс болох саруул билэг оюун хөгжихгүй. Бага зэрэг хөгжлөө ч цаашдаа дэвжихгүй, дээд төвшинд хүртэл ахижгүй. Гэгээрэх сургаалын эцсийн зорилго нь юмс үзэгдэл хийгээд түүний мөн чанарыг тэр чигт нь алдаагүй ялгаж салгах билэг оюун юм. Тиймээс л “Билэг оюунаар бүхнийг ухаарна” гэж хутагт Майдар хэлжээ.






Бясалгасан сургаалаа мартах нь ихсэж, санах нь багасаж мөн авах гээх ухаан дордвол яах аргагүй төөрсний шинж. Харин эрхэм гурван эрдэнийн сайн чанаруудыг сайтар ойлговол итгэл бишрэл маш их нэмэгддэг. Түүнээс гадна орчлонгийн гэмийг эргэцүүлэн тунгаавал хүлээнээс ангижрах сэтгэл шулуудна. Орчлонд дур гутаж нирвааны сайн талыг олон өнцгөөс харж, туйлын зорилгоо болгодог. Гэгээрэх тэмүүлэл болон зургаан төгс чанарын гайхамшигийг олонтаа шүүн тунгааснаар эргэлт буцалтгүй итгэж биширдэг. Цаашилбал урам зориг орж, идэвх зүтгэл ч оргилно. Ер нь энэ бүхэн задлан шинжлэх билэг оюунаар эрхэм зарлигийн утгыг ухаарахтай нягт холбоотой. Тиймээс ухаан сэхээтэй хэн боловч энэ журмыг дагахаас өөр замгүй гэдгийг мэдэж авах нь чухал.


Бясалгальн арга барил сайн мэдэхгүйгээс зарим нь ингэж ярьдаг:

**Эргэлзээ:** Задлан шинжлэх бясалгал хэтэрхий их хийвэл сэтгэл нэг цэгт төвлөрөхөд саад болно. Тиймээс сэтгэлээ төвлөрүүлэх бясалгал тогтвортой хөгжихгүй.

**Залруулга:** Урьд нь сэтгэлээ нэг цэгт төвлөрүүлэх чадвар эзэмшээгүй, шинээр хөгжүүлэх гэж байж олон зүйл задлан шинжилбэл мэдээж бүтэхгүй. Тиймээс уг чадварыг эзэмшилээ тохиромжтойг нь буюу төвлөрөх бясалгал хийнэ гэвэл санал нэг байна.

Харин өмнө нь хэт их задлан шинжилвэл төвлөрөхөд саад болно гэж бодож байгаа бол бясалганд суралцах журмын талаар шинэ дэг ёсыг гаргасан хутагтуудын хийсэн тайлбарыг огт ойлгоогүй яваа







хэрэг. Үүнд тохирох жишээ авьяя. Уран дархан алт, мөнгийг ахин дахин галд хайлуулж, олон дахин усаар угаан элдэв хольц, хогноос нь салгадаг. Мөн уян зөөлөн ч болгодог. Ингээд ээмэг зэрэг хүссэн гоёлоо урладаг.

Яг үүнтэй зүйрлэж болно. Юун түрүүнд төрмөл болон олдмол сэтгэлийн гэм, буруу үйл ба түүний үр дагавар, орчлонгийн гэм мэтийн муу талыг задлан шинжлэх билэг оюунаар олон удаа бясалгана. Ингэснээр сэтгэл эмзэглэж, тэдгээрээс зугтаадаг. Энэ нь алтыг галд хайлуулах мэт сэтгэлийн буруу хандлагыг өөрчилж, хир буртагаас нь цэвэрлэдэг. Мөн багшийн эрдэм чадал, хүн заняны боломж бололцоо, эрхэм гурван эрдэнийн ач тус, зөв үйл болон түүний үр дагавар, гэгээрэх тэмүүлэл зэргийн ач холбогдлыг тухай тухайн бүлэгт зааснаар задлан шинжлэх билэг оюунаар ахин дахин бясалгана. Ингэвэл сэтгэл дэвтэж сүсэг соёлдог. Энэ нь алтыг усаар угаахтай адилхан. Улмаар сэтгэл зөв хандлагатай, баяр хөөртэй болж сайн чанарт сэтгэл дэвтдэг. Тэр цагт тайван төлөв, үлэмж үзлийн аль хүссэнээ бясалган эзэмшихэд итгэл үнэмшилтэй, амар хялбар болно. Иймээс задлан шинжлэх бясалгал нь төсөөлөлд автагдашгүй төвлөрөх бясалганд суралцах сайн арга юм.

Энэ талаар Хутагт Асанга:

Уран дархчууд бүгд л алт, мөнгийг хог хольцоос нь салгахын тулд цаг тухайд нь галд хайлуулж, усаар угаан элдэв зүүлт, чимэг хийж болохуйц уян хатан болгодог аргыг бид мэднэ. Дараа нь дарханы үр ухаанаар юу дуртайгаа урладаг. Бясалгагч ч мөн адил тухай бүрт нь шунал мэтийн хир буртагаас







жигшин зугтаж сэтгэлийн гэм бүхнээс холдоно. Улмаар зөв чиг хандлагатай болж, түүндээ баярлана. Ингээд сэтгэл хангалуун зөв зүг рүү тэмүүлдэг. Бясалгагч ийм сэтгэлээр тайван төлөв, үлэмж үзэл хоёрыг сүлэлдүүлэн хөдлөшгүй бат болгож, аль алинд нь хурдан хүрнэ. Мөн маш тайван, гүйвшгүй, шантрашгүй болж, санасандаа хүрэх зориг шулуудна. хэмээсэн байдаг.

Сэтгэлээ нэг цэгт төвлөрүүлэх бясалгальд хоёр гол саад бий. Тэдгээрийг хөөрөл, нозоорол гэдэг. Хэрвээ эрхэм гурван эрдэнийн төгс чанарыг хүчтэй, удаан мэдэрвэл нозоорлыг хялбархан давна. Түүнийг давж гаражын тулд бясалгаж буй зүйлийнхээ сайн талыг олж харах хэрэгтэй. Мөн өөртөө урам өгөх нь чухал гэж олон алдартнууд хэлсэн байдаг. Мөнх бус, зовлонгийн гэмийг хүчтэй, удаан бодох нь хөөрлөөс салахад дөхөмтэй. Хөөрөл нь хүсэл шуналд багтдаг сэтгэлийн сатаарал юм. Тиймээс түүний эсрэг жигшилийг хэрэглэх хэмээн олон эх сударт өгүүлжээ.

Түүнээс гадна багшид сүсэглэхээс эхлээд гэгээрэх тэмүүлэлд хөл тавих хүртэлх бүхнийг олон дахин бясалга. Тэр цагт ухаант мэргэдийг баясгасан төвлөрөх бясалгалыг баттай, хурдан төлөвшүүлнэ. Төвлөрөх бясалгал төдийгүй задлан шинжлэх бясалгалын үед ч хөөрөл, нозоорлоос ангид байх хэрэгтэй. Өөрийн багш нар болон түрүү үеийн мэргэдийн өгсөн бясалгалын тухай зааврыг дотроо эргэцүүлж, илүү ойлгомжтой болгох үүднээс судар, эх бүтээлүүдэд байдаг мэргэдийн хэлсэн оновчтой үтийг оруулан бүрэн дүүрэн болгохыг хичээллээ. Хэдий чадварлаг багш, авьяаслаг шавьтай












таарсан ч ягшмал арга барилаар сэтгэлд нь нэвтрэх хэцүү гэдэг ончтой сайхан үг бий. Тиймээс “Одоо бясалгах үе” гээд суулгаад байж болохгүй. Мөн “одоо сонсож, эргэцүүлдэг, хэрэгжүүлдэг үе” гээд байвал заасан номлол хэрэгжүүлэх үетэйгээ авцалдахгүй алдаа болно.

Бүх сургаалыг нэгэн зэрэг хэрэгжүүлнэ гэдэг маш ховор. Тиймээс бясалгах зүйлийг ангилж зааглах хэрэгтэй.

Эрхэм зарлигийг бүхэлд нь гарын авлага болгон мөрдөж чадах эсэх нь энэ бүлгийг ойлгосон үгүйгээс шууд хамаарна. Тэгэхээр буддын ном зохиол огтхон ч судалж үзээгүй бол санааны гарз биз ээ. Бас судар, тантрын хөлгөн судруудыг удаан судалсан хүмүүс ч бясалгалын үед урьд нь өөрийн судалсан зүйлдээ автчихдаг. Бясалгалын тухай илүү дэлгэрэнгүй тайлбарлах хүсэл байвч нуршуу болох вий хэмээн болгоомжилж байна. Бясалгалын тухай буруу ойлголтонд няцаалт хийсэн хэсэг үүгээр төгслөө.







## VII

# ЗАВШААН, БОЛОМЖ БҮХИЙ ХҮН ЗАЯА

Б. Багшийг ёсчлон шүтсэн шавь хэрхэн суралцах тухай  
1. Завшаан, боломж бүхий хүн заяаны тухай сануулах

а. Завшаан, боломж бүхий хүн заяаг тодорхойлох

1) Завшаан

2) Боломж

а) Өөрөө бүрдүүлэх боломж


б) Бусдын бүрдүүлэх боломж


б. Завшаан, боломж бүхий хүн заяаны ач холбогдол

в. Завшаан, боломж боломж бүрдсэн хүн заяаг

олоход бэрх

Одоо багшийг ёсчлон шүтэж буй шавийг багш хэрхэн





цааш хөтлөх тухай өгүүлэх болно.

## **Б. Багшийг ёсчлон шүтсэн шав хэрхэн суралцах тухай**

Энэ нь хоёр хэсэгтэй:

1. Завшаан, боломж бүхий хүн заяаны тухай сануулах  
(7 дугаар бүлэг )
2. Завшаан, боломж бүхий хүн заяаны хэргийг гаргах  
(8 дугаар бүлгээс хойш)

### **1. Завшаан, боломж бүхий хүн заяаны тухай сануулах**

Завшаан, боломж бүхий хүн заяаны тухай сануулах нь завшаан, боломж бүхий хүн заяаг тодорхойлох, утга учрыг нь эргэцүүлэх, олдоход бэрх болох тухай бodoх гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

#### **a. Завшаан, боломж бүхий хүн заяаг тодорхойлох**

##### **1) Завшаан**


*Эрхэм наандин чанафын хураангуй сударф-т:*


Сохор дүлий адгуусны  
Завшаангүй найман төрлийг  
Сургаалаар тэвчиж  
Найман завшааныг олно.

хэмээсэн байна.

Энд өгүүлснээр золгүй найман төрлөөс салбал завшаантай болох ажээ. Харин золгүй найман төрлийг Нагаржуна *Андаа илгээсэн захидал-даа* ингэж тодорхойлжээ:

Үзэл буруутны оронд төрөх,






Үзтэл мунхаг адгуус болох,  
Үнэнхүү гэсгээлт тамд унах,  
Үзэшгүй зовлонт бирд болох,


Шашин номоос хагацаж төрөх,  
Шал тэнэг, хэлгүй мэндлэх,  
Насан урттай тэнгэр эдгээрийн  
Найман золгүй төрлөөс ангид

Онцгой завшаан олсон дээрээ  
Орчлонгоос мултрах бүхнийг хийгтүн.

Түүнээс гадна дээрх найман муу заяанаас ангид боловч (1) буддын дөрвөн хувраггүй газар, (2) манггуу, хэлгүй, дүлий, тахир дутуу, (3) урьд ба хойд нас, үйлийн үр, эрхэм гурван эрдэнийг үгүйсгэгч буруу үзэлтэн, (4) Будда залраагүй түүний зарлиг сургаалгүй газар нутагт төрөх дөрвөн золгүй нөхцөл байдаг. Үүний эхний хоёр ба сүүлийнх нь авах гээх оюуны чадваргүй бол гурав дахь нь буддын шашинд итгэдэггүй юм. Гурван муу заяанд сайн чанар хөгжүүлье гэдэг санаа төрөх маш хэцүү, төрлөө ч зовлон нь дийлдэшгүй учир чадал дутна.

Махамати “Анданаа илгээсэн захидал”-д хийсэн тайлбар-таа урт наст тэнгэрийг ухамсаргүй, дүрсгүй хоёр зүйл бий гэжээ. Мөн Ашвагхоса Золгүй найман төрлийн тухай өгүүлэл-дээ Хүсэлт тэнгэрүүд үргэлж мэдрэхүйн ханамж таашаалд автдаг гэсэн байна. Харин Васубандху Абхидахармакоша номдоо ухамсаргүй тэнгэрийн орон тогтвортжсон бясалгальн дөрөвдүгээр үеийн Агуу шимт төвшинтэй нэг зиндаанд, гэхдээ маш хол оршдог. Тэнд төрөх, үхэх хоёроос бусад үед сэтгэхүй болон сэтгэл зүйн үйл явцууд унтарна.





Ингээд олон Их галвын турш сэтгэхүй ба сэтгэл зүйн үйл ажиллагаа нь бүрэн зогсдог. Дүргүй мандалд буй архадыг завшаангүй гэж хэлэх аргагүй. Харин тэнд төрсөн жирийн хүн нирвааны зам мөрийг эзэмших боломжгүй учир завшаангүй гэж байгаа юм. Байнга л ханамж таашалд мансуурсан хүсэлт мандлын тэнгэрүүд үүнтэй адилаан.

*“Анддаа илгээсэн захидал”-д хийсэн тайлбар-т чухам яагаад завшаангүй гэснийг ингэж тайлбарлажээ:*

Энэхүү найман төрөлд зөв дадал хөгжүүлэх чөлөө зав байхгүй учир завшаангүй юм.

гэж өгүүлсэн байдаг.


## 2) Боломж


### a) Өөрөө бүрдүүлэх боломж

Өөрөө бүрдүүлэх таван боломж байх бөгөөд *Шаравагагийн товшин судар-т*:

Бурхан шашинтай төв оронд  
Бүхий эрхтэн нь эрүүл, бүтнээр  
Түмэн завшаант хүн болж төрөөд  
Түйтгэрт хилэнцээс холуур тойроод  
Төгс гэгээрэлд үнэхүү сүсэглээд  
Төгөлдөр ёс зүйг баримтлан замнах  
хэмээсэн байдаг.

Үүний “бурхан шашинтай орон” гэдэг нь буддын дөрвөн зүйл сахилтай хуврагтай газар нутаг гэсэн үг юм. “Эрхтэн нь эрүүл” нь манггуу, хэлгүй биш, нүд, чих мэт үндсэн болон туслах эрхтнүүд бүрэн бүтэн байхыг хэлж байгаа юм. “Хилэнцээс холуур тойроод” гэдэг нь засашгүй алдаа гаргаагүй, түүнд бусдыг






өдөөн хатгаагүй гэсэн санаа. “Төгс гэгээрэлд үнэнхүү сүсэглээд” гэдэг нь ерийн болон ер бусын сайн чанар хөгжүүлэх ёс зүйд итгэхийг хэлнэ. Харин “төглдөр ёс зүй” нь буддын гурван аймаг савын эрдэм мэдлэгийг илрэхийлж байгаа юм. Энэ тав нь хувь хүн үйлийнхээ үрээр бүрдүүлдэг үлэмж чухал нөхцөл болно. Тиймээс өөрөө бүрдүүлэх боломж гэдэг.


## б) Бусдын бүрдүүлэх боломж

Бусдын бүрдүүлдэг таван боломж нь:

Будда заларсан эрин байх,  
Буянт номлол нь түгэж байх,  
Бурхны шашин оршин байх,  
Бултаараа түүнийг биширч байх,  
Бусдыг энэрэхүй үндэслэж байх.

“Будда заларсан эрин” нь тоолшгүй гурван галавт эрхэм чанар цогцлуулан гэгээрлийн зүрхэнд хүрсэн буюу төгс гэгээрсэн Будда оршин буйг хэлнэ. “Буянт номлол нь түгэж байх” гэдэг нь Будда болон түүний шавь нар номлол зааж буй гэсэн үг. “Бурханы шашин оршин байх” нь төгс гэгээрсэн Будда үлдэгдэлгүй нирваанд орох хүртлээ үнэмлэхүй үнэний гэгээн номлолоо таниулсаны үндсэн дээр буддын шашин доройтоогүй гэсэн санаа. “Бултаараа түүнийг биширч байх” гэдэг нь түүний номлолыг ойлгочихсон хүмүүс бусдад гэгээн номлолыг эзэмших чадвар байна гэж үзээд өөрийн мэдсэнээ тэдний хэр хэмжээнд нь нийцүүлэн зааж, дагуулахыг хэлнэ. “Бусдыг энэрэхүй нь үндэслэж байх” гэдэг бол өглөг хайлрагч болон өгөөмөр сэтгэлтийнүүд хуврагийн хувцас зэргийг өгөхийг хэлж байгаа юм. Энэ





тав нь бусдаас шалтгаалдаг гол нөхцөл болдог. Тиймээс бусдын бүрдүүлэх боломжуудын дөрөв нь өнөө үед бүрдэхгүй л болов уу. Харин гэгээн номлол ба гэгээн номлолыг заагчид байгаа болохоор номлол оршин байж түүнийг дагагчид гарч ирнэ. Тиймээс зохих нөхцлиүүд байна гэж үзэж болох юм.


#### **б. Завшаан, боломж бүхий хүн заяаны ач холбогдол**


Үүрдийн амгалан жаргаланголох сайн чанар эзэмшихийн оронд өнөө маргаашийн жаргал хайж, зовлонгоос зайлан зугтахыг адгуус чадна. Харин сайн заяанд төрчихөөд амьдралд ингэж хандвал адгууснаас юуны ялгаа. Чандрагомини *Шавьдаа илгээсэн захидал-д*:

Ангал жалганаас азаар гарчихаад  
Атга өвс үмхэх гэж шунаад  
Ахиад хавцал рүү нисэх туталтай  
Амьд явахын тулд амьдрах яг адилхаан  
хэмээсэн билээ.

Ерөөсөө хувь төөрөг бүхэн сайн чанар эзэмшихэд, ялангуяа Их хөлгөнд суралцахад тохироод байдаггүй. Гагцхүү өмнө дурьдсан бүх боломж бүрдсэн байх зайлшгүй шаардлага бий. *Шавьдаа илгээсэн захидал-д* энэ тухай:

Гэгээрэл ухаарлын оройд гараад  
Гэнэн ертөнцийг жолоодохын заяа  
Хатуужсан сэтгэлийн тэнхээтэй хүнд  
Хааяа нэгдэх ногдох ерөөлтэй.  
Тэр замаар араатан, жигүүртэн





Тэнгисийн загас, лусын савдаг  
Тэтгэгч сахиус, тэнгэр хүртэл  
Тэгж замнаж чадахгүй юм шүү

### Мөн Хэвлийд орохуй хэмээх сударт:


Хүн болж төрөөд зовлон эдэлдэг ч гэлээ сайн заяг  
юм хойно хэдэн сая галав хайгаад ч олно гэдэг хэцүү.  
Тэр бүү хэл тэнгэрүүд үхэж буй нэгэндээ сайн заяанд  
төрөх болтугай гэсэн ерөөл хэлдэг. Тэр сайн заяа нь  
хүний төрөл юм шүү дээ.  
гэх зэргээр өгүүлжээ.


Энд өгүүлснээр тэнгэрүүд ч хүн болж төрөхийг хүсэж  
мөрөөддөг ажээ.

Мөн урьд насандаа хүн явахдаа сургаал судалсан  
авьяастай Хүсэлт мандлын тэнгэрүүд хоосон чанарыг  
ухаарах боломжтой байдаг. Гэхдээ Хүсэлт тэнгэрийн  
биеэр ертөнцөөс хэтийдсэн мөрийг олохгүй. Өмнө  
нь Хүсэлт мандлын тэнгэр золгүй заяанд багтдаг  
гэдгийг хэлсэн. Тиймээс гэгээрлийн анхан шатны  
төвшинд хүрэхэд хүний төрөл хамгийн зохимжтой юм.  
Уттаракуру тивийнхэн хэдий хүн боловч ёс зүйн чанар  
төлөвшдөггүй, харин бусад гурван тивийнхэнд энэ  
чанар төлөвшдөг. Тэр дундаа Замбутивийн хүн үүнд  
илүү тохиромжтой.

Тиймээс энэ талаар олон талаас нь ахин дахин  
бясалга:

Ийм сайхан заяагаа би дэмий үрж болно гэж үү?  
Үүнийг утга учиргүй өнгөрөөвөл өөрийгөө хуурсантай  
адил, түүнээс илүү тэнэглэл гэж хaa байхав. Би муу  
заяаны аймшигтай урт замыг туулсаар сая л нэг





саллаа. Энэ боломжийг алдвал дахин муу заяанд төрнө. Тэгвэл ухаан санаагаа гээж, ховсдуулан эргүүтсэнтэй адилхан.

Мөн хутагт Арыашура хэлэхдээ:

Төрж ирээд үхэж буцах  
Төөрөг заяаны энэхэн завсарт  
Төөрч, дахиж хэзээ ч энддэггүй  
Төрөлд хүрэх боломж байдаг аа.

Оройгүй гэгээрлийн зам бий тул  
Очир эрдэнэтэй ч зүйрлэхгүй үнэтэй  
Орчлонд хосгүй хүний төрлийг  
Олсон завшааныг битгий алд аа.


гэсэн бол *Бодисаддаагийн замнал*-д:


Санааснаар олдохгүй энэ завшаанд  
Сайн суртлаар замаа засаад  
Зөв номыг мөрлөхгүй алдвал  
Зөнөг, тэнэгээс ч долоон дор oo.

Авралын номыг мэдсэн хэрнээ  
Алхайж залхуурч хойшоо суувал  
Амин наснаас хагацахын хэрдээ  
Амсах гаслан минь тоогүй болно oo.

Халуун тамд шатах цагт  
Хамаг бие шалзрах цагт  
Харамсаж, гаслах сэтгэлийн түймэр  
Хамтдаа бас дүрэлзэн шаналаана.

Олдоход бэрхтэй хүний төрлийг  
Олж мэндэлсэн азтай байлаа ч  
Алдаж, осолдон хилэнцэд ойчиж  
Аюус там руу унах нь энүүхэнд.  
Адын ховсонд эргүүтсэн ч юм шиг  
Алийгаа алдан самуурсан ч юм шиг





Алмайрч, манаан будилаад яваагаа  
Алинаас, хэнээс асуултай ч билээ.  
хэмээсэн билээ.

Донбо “Завшаан, боломж бүхий хүн болж төрснөө бодож явдаг уу?” гэж Жанавагаас асуужээ. Тэгэхэд Жанава “Ганц бодож явдаг юм минь шүү дээ” гээд:

Өөрөө гэгээрэх боломжтой дээрээ  
Өрсөж хэрвээ амжихгүй л юм бол  
Өмхий тамд ойчсон хойно  
Оргүүлж хэнээр татуулах билээ?


Хэмээн бясалгалынхаа өмнө байнга уншдаг “Төв үзэлд орох”-ын тайлбар номын дээрх хэсгээс хэлж өгчээ.


Сайн заяа нь алс хэтээ бодсон ч ач холбогдолтой юм. Мөн ойрын зорилгоо биелүүлж өндөр язгуурт төрөх, хөрөнгө хураах, найз нөхөдтэй явахын үндэс болсон өгөөмөр чанар, ёс суртахуун, тэсвэр тэвчээр болон бусад чанарыг хүн хялбархан эзэмшинэ. Энэ бүхнийг бодолцох хэрэгтэй. Бас доорх маягаар бодоод үз:

Хойд насандаа дээд язгуурт төрөх, нирваанд хүрэх хоёуланд нь тустай хүн заяаг алинд ч үгүй өдөр хоног аргацаан өнгөрөөвөл эрдэнэсийн арлаас гар хоосон буцахтай адил. Тэгвэл дараа төрөлдөө найман завшаан, арван боломж бүрдсэн хүн заяанд дахин төрөхгүй учир жаргал үзэхгүй, зовлон л үргэлжилнэ. Ингэж тэнэгтэж болно гэж үү?

Мөн хутагт Арьяшура:

Урьд төрлүүдийн буян нийлээд  
Ухаант хүний төрөлд авчравч





Улмаар буянаа нэмэхийн оронд  
Угаадас болгон асгаж дуусгаад

Дараа төрөлдөө нөгөө ертөнцөд  
Давшгүй зовлонгийн өрөөнд унах нь  
Эрдэнэсийн арлаас хувьгүй наймаач  
Эргэж хоосон буцахтай адил аа.

Арван буяныг тогтоогоогүй бол  
Ахиж чи хүн болж чадахгүй ээ  
Адгуус төрөлтөн цэнгэж болох ч  
Адгийн зовлонтой ч жишишгүй дор л доо.

Олдсон төрлөө дээшлүүлэхгүй л бол  
Онцгой завшааныг ашиглахгүй бол  
Ондоо төрөлдөө жаргана гэх нь  
Орой, үдшийн зэрэглээ адил аа.  
хэмээсэн байdag.


Ингэж эргэцүүлэн бодоод хүний амьдралыг утга  
учиртай өнгөрөөх чин хүслээ өдеөх хэрэгтэй. Энэ  
тухай *Бодисадвагийн замнал-д*:


Энэ биеийг тэжээсний хөлсөнд  
Эрхэм гэгээрлийн моринд хөллонө  
Энэ ажилд зүтгэхгүй гэвэл  
Эргээд хооллох хэрэг байна уу?

Гээд цааш нь:

Энэ насны төрлийн салаар  
Энэлэнгийн далайг хөвж гатална  
Энэ сал дахиад олдохгүй  
Эрхбиш байгаа дээр нь сэлүүрдээд бай.  
Гэхчлэн айлдажээ.

Бодовагийн *Сургаалт үлгэр* номд байдаг “Өт залбирав,





хулан унав, Замба нутгийн загас, Арвайн бантан” хэмээх сургаалт үлгэрүүдийг санан найман завшаан, арван боломж бүрдсэн хүн заяны тухай эргэцүүлээрэй.

### **в. Завшаан, боломж бүрдсэн хүн заяаг олоход бэрх**


Энэхүү завшааны тухай *Ёс зүйн судар*-т “Муу заяанаас төрөл арилжаад тэндээ төрдөг нь шороон түм. Харин муу заяанаас сайн заяаг олно гэдэг хурууны өндгөнд тогтох тоостой адил. Хоёр сайн заяанаас хагацан муу заяанд оддог нь түг түм. Тэндээсээ сайн заяанд төрнө гэдэг хумсны үзүүрт тогтох тоостой ижил” гэжээ. Тэгэхээр сайн, муу аль ч төрлийн дараа хүн заяаг олох хэцүү ажээ.


*Асуулт:* Яагаад хүн заяаг олох тийм хэцүү байдаг юм бэ?

*Хариулт:* Дээд төрөлтөн хүмүүсийн олонх нь буянт үйл хийхийн оронд ихэвчлэн буруу үйл хийж алдах нь элбэг. Тиймээс муу заяанд төрдөг. Энэ тухай Арыядэва *Дөрөөн* зуут-даа:

Гэнэн мунхагууд хавьгүй олоон  
Гэгээрлээс буруулах нь маш үнээн  
Гэсгээлт харанхуй тамын нүхэнд  
Гэмээ дагасан тэднээр дүүрдэг.  
гэсэн байдаг.

Түүнчлэн бодисадвад уурласан ганц хором төдийгөөр Амсхийх чөлөөгүй тамд нэг галав тарчлан зовно. Гэтэл бидэнд урьд төрөлдөө хуримтлуулсан засаж залруулаагүй, үр дагавар нь илрээгүй олон хилэнц бий. Тиймээс тэр бүхнийхээ төлөөсөнд муу заяанд төрөх нь гарцаагүй. Гэхдээ урьд нь хуримтлагдсан муу





заяаны үндсийг бүрэн арилгаж, нэмж хуримтлагдах үүдийг нь хааж болно. Ингэж чадвал сайн заяа тийм хол биш, гэтэл хэн нь ч хичээхгүй байгаа болохоор муу заяанд төрдөг юм. Нэгэнт муу заяанд төрчихвөл зөв дадал хөгжүүлж чадахгүй, үргэлж бурууг хийсээр олон галавт сайн заяаны барааг ч харахгүй. Тиймээс завшаан, боломж бүрдсэн хүн заяаг олох тун хэцүү байдаг. *Бодисадвагийн замнал-д:*

Иймэрхүү байдалтай байвал  
Эргээд хүн болж төрөхгүй ээ.  
Нэгэнт хүний төрлөөс хагацвал  
Нэмэгдэх юм хилэнц л үлдэнэ ээ.


Үнэн зөв дадал хэвишнийг  
Үзэж мэдсэн ч дагахгүй орхивол  
Муу заяанд унасан хойноо  
Мунхрахаас бус гэгээрч чадахгүй.

Зөв явдал, дадын оронд  
Зөрүү буруу алдаа хийвэл  
Сая живаа айсуй галавт  
Сайн алдар чамаас тойрно.

Даанч ховорхон хүний төөргийг  
Дагаж олдох гэгээн завшааныг  
Далайд хаясан буулга тоног  
Даяанч мэлхийг онож өмсөгдөх мэт  
Даанч ховорхон тохиол гэдгийг  
Даамай Будда зүйрлэж хэлсэн.

Ганцхан хормын алдаа хилэнцээр  
Гамшигт там руу шидэгдэх байтал  
Элэгдсэн цагуудын тоогүй алдаа  
Энхжинд яаж хүргэх билээ?  
Хэмээдэг билээ.  
*Эргэлзээ:* Урьдын алдааныхаа уршгаар муу заяаны





зовлон эдэлж хуримтлуулсан муу үйлийн үрээ бардаг.  
Тэгэхээр сайн заяанд төрнө гэдэг тийм ч хэцүү биш  
байлгүй.

*Залруулга:* Муу заяаны зовлон үйлийн үрээ  
эдлэхийн хэрээр барагдах нь үнэн боловч тухайн  
үедээ нэмж гэм хийсээр байдаг. Тиймээс үхсэн хойноо  
дахиад муу заяагаар тэнэн одох тул тэндээс мултарна  
гэдэг маш хэцүү. *Бодисадвагийн замнал-д* энэ тухай:


Үзтэл үйлдсэн хилэнцийн зовлонг  
Үйртэл эдлээд ч сална гэж үгүй  
Үүрэх зовлон чинь хажуу дэргэдээ  
Үр ач шигээ алдаанууд дагуулна.


Дээрх маягаар найман завшаан, арван боломж бүхий  
хүн заяаг олох тун хэцүү гэдгийг тунгаан бод. Энэ  
амьдралаа буруу зөрүү өнгөрөөвөл дэндүү хайран  
гэдгийг сана. Тэгээд хүн заяаны хэргийг нь гаргахын  
тулд “Гэгээн сайхан чанар хөгжүүлж наасаа үдье” гэдэг  
санаатай болоорой.

Нагаржуну *Анданаа илгээсэн захидал-даа:*

Уснаа хөвөх хоосон буулганд  
Уран мэлхий хөллөгдөх мэт  
Ухаант хүний төрлийг олох  
Учир, тохиол ховорхон тул  
Урьдын ерөолтэй энэ насандаа  
Улам гэгээрч, хэргээ бүтээ.  
Оюу номин эрдэнийн сан руу  
Огиж байгаа хүнээс илүү  
Оюун билэгт хүн болж төрчихөөд  
Осолдох гэмээс салаагүй нь гутмаар.

Мөн Чандракирти *Шавьдаа илгээсэн захидал-даа:*  
Хүссэнээр олддоггүй хүний төрөлд





Хүрсэн, төрсөн энэ чөлөөнөөр  
Зүрх сэтгэлээ ариусган байж  
Зүглэх гэгээрэлдээ шамдан зорь.  
хэмээсэн байdag билээ.


Агуу ёогч Бромдан “Байгаа цагаа ашигла” гэж Жанавад хэлэхэд “Завшаан, боломж ховорхон олдоно шүү” гэж хариулсан гэдэг. Бодова энэ тухай:


Пан хошуунд Маичахар хэмээх том хот бий. Тэр хот дайсанд эзлэгдээд ихэд сүйдсээр уджээ. Үүнд сэтгэл гундуу байdag нэгэн өвгөн байв. Тэрээр нэг өдөр хотыг чөлөөлсөн тухай дуулсан ажээ. Тэгээд явж чаддаггүй ч гэсэн барим modoор газар тулан мөлхөж “Маичахараг чөлөөлсөн гэдэг зүүд л биш байгаасай” хэмээн хөөрч байсан гэдэг. Яг л энэ өвгөн шиг найман завшаан, арван боломж бүрдсэн хүн заяаг олсондоо баярлаж гэгээрэлд шамдаарай.  
хэмээн сургасан байdag.

Завшаан, боломжийг нандигнах санаа бодол төртөл тэр тухай сайн бясалгаарай.

Завшаан, боломжоо бүрэн дүүрэн ашиглах чин хүсэлтэй болохын тулд дараах дөрвөн зүйлийг хэзээд санаж яв:

- 1) Сургаалыг хэрэгжүүлэх шаардлага. Амьтай бүхэн зөвхөн жаргахыг хүсдэг, хэн ч зовохыг бодлогтгүй. Харин жаргалд хүрч, зовлонгоос салах нь ганцхан Буддагийн номлооос хамаарна.
- 2) Хэрэгжүүлэх бололцоо. Гадаад нөхцөл болох багш байна. Мөн найман завшаан, арван боломжтой учир






дотоод нөхцөл ч бүрджээ.


- 3) Энэ насандаа хэрэгжүүлэх. Энэ насандаа хэрэгжүүлэхгүй бол дараа дараагийн төрөлдөө ийм завшаан, боломжтой таарна гэдэг ховор.
- 4) Одоо л хэрэгжүүлэх. Хэзээ ч ухэж магадгүй учир яг одооноос эхлэх хэрэгтэй.

Энэ дөрвийн гуравдугаарх нь “Дараагийн төрөлдөө номлолд суралцъя” гэж хойш тавьдаг залхуурлыг дарж байгаа юм. Дөрөвдүгээрх нь “Энэ амьдралдаа суралцана. Гэхдээ харин одоо биш хойтон, дараа сард, эсвэл маргааш эхэлье” гэдэг залхуурлыг дардаг. Ингээд энэ хоёрыг нэгтгэвэл “хурдхан суралц” гэсэн утгатай болно. Тэгэхээр ердөө гурван зүйл ч болгож болно. Ухнэ гэж бодох нь үүнд хамаатай боловч дараагийн бүлгүүдэд өгүүлэх тул нуршилгүй орхиё.

Энэ мэтээр завшаан, боломж бүрдсэн хүн заяаны тухай олон талаас эргэцүүлэх нь санаа бодолд маш сайн нөлөөтэй. Тиймээс дээр өгүүлсэн дагуу бодож бай. Харин бүхэлд нь бясалгахад хэцүү байж мэднэ. Тэгвэл завшаан, боломжийн утга учир, ойрын болон хэтийн зорилгоо гүйцэлдүүлэх, шалтгаан үр дагаврын хувьд олоход бэрх гэж хураангуйлаад тайлбарласан дагуу бясалгаарай.

Үүний зэрэгцээ завшаан, боломж бүрдсэн хүн заяаг олоход бэрх гэдгийг шалтгаан, үр дагавар талаас нь салган бодож сурах хэрэгтэй. (1) Ер нь аливаа сайн заяанд төрөхийн тулд ёс зүй болон бусад ариун зөв дадал зайлшгүй эзэмших шаардлагатай. Ялангуяа төгс завшаан, боломжтой болохын үндэс бол ариун ёс зүй юм. Түүнийг өгөөмөр чанар зэрэг бусад сайн чанараар








баяжуулдаг. Мөн ариун хүсэл эрмэлзэл ч чухал. Өөр олон сайн чанарын үрийг тарих хэрэгтэй. Гэтэл ийм шалтгаануудыг бүрдүүлсэн байх нь нэн ховор тохиолддог. Тиймээс сайн заяа, онцгой сайн заяанд төрнө гэдэг тэр чинээгээрээ ховорхон. Энэ маягаар завшаан, боломж бүхий хүн заяаг олоход бэрхийг шалтгаан талаас нь бясалгана.

(2) Завшаан, боломж бүхий хүн заяаг олоход бэрх гэдгийг дараах байдлаар үр дагавар талаас нь бодно. Муу заяаны амьтантай харьцуулахад сайн заяаны амьтан өдрийн од шиг цөөн. Харин өөртэй нь ижил сайн заяаны амьтан дотроо онцгой завшаантай нь бүр ч цөөхөн. Энэ дагуу бясалга.

Гэвц Долбова аз завшаан, боломж бүхий хүн заяаг олоход бэрх хэмээх энэ сургаалыг их чухалд тооцсон байдаг. Тэрээр бусад бүх сайн чанар зөвхөн эндээс ундарна гэж аминчлан захисан билээ. Тиймээс үүнийг ямагт санаж, хичээх хэрэгтэй.







VIII

## ХҮНИЙ ГУРВАН ХЭВ ШИНЖ

2. Завшаан, боломж бүхий хүн заняны хэргийг гаргах
  - a. Сургаалын ерөнхий журмыг тодорхой тайлбарлах
    - 1) Гурван хэв шинжийн хүн суралцах дараалалд эрхэм зарлиг бүхэлдээ багтдаг
    - 2) Шавийг гурван төвшинд хуваан үе шаттай сургахын учир
      - a) Шавийг гурван төвшинд хуваан сургах хэрэгцээ шаардлага
      - b) Шавийг үе шаттай сургах шалтгаан
        - I) Шалтгаан
        - II) Хэрэгцээ





## 2. Завшаан, боломж бүрдсэн хүн заяаны хэргийг гаргах

Үүнийг дараах хоёр хэсгээр тайлбарлана:

- Сургаалын ерөнхий журмыг тодорхой тайлбарлах
- Завшаан, боломж бүрдсэн хүн заяаны давуу талыг ашиглах


### a. Сургаалын ерөнхий журмыг тодорхой тайлбарлах


Энэ нь хоёр хэсэгтэй:

- Гурван хэв шинжийн хүн суралцах дараалалд эрхэм зарлиг бүхэлдээ багтдаг
- Шавийг гурван төвшинд хуваан үе шаттай сургахын учир

#### 1) Гурван хэв шинжийн хүн суралцах дараалалд эрхэм зарлиг бүхэлдээ багтдаг

Ялгуулсан Будда эхлээд гэгээрэх тэмүүлэл хөгжүүлж, улмаар буян болоод билэг оюуны чуулбарыг цогцлуулан, эцэст нь төгс гэгээрэлд хүрсэн юм. Энэ бүхнийг гагцхүү амьтан бүхэнд туслах гэж хийжээ. Ялгуулсан Буддагийн сургаал номлол нь амьтны зорилтыг хангахад чиглэсэн байдаг. Амьтанд ойрын зорилго буюу хойд насандaa хүн ба тэнгэрийн төрөл олох, хэтийн буюу үхэж, төрөх орчлоос ангижрах хоёр зорилго бий. Сайн төрөл олоход зориулагдсан номлол мөн түүнд хамаарах бусад сургаал нь бүхэлдээ эхлэн гэгээрэгчийн ерөнхий ба нийтлэг номын хүрээнд багтдаг. Энэ наасны амьжиргаа хөөцөлддөггүй, дараа төрөлдөө төгс сайн төрөл олохын төлөө бүхнээ





зориулан, хамаг үйл ажлаа түүнд чиглүүлж буй нэгнийг онцгой эхлэн гэгээрэгч гэнэ. *Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч* номд:

Ахуй энэ орчлонгийн жаргалд  
Аль бүхнээ зориулан байж  
Амия хичээн зүтгэж байвал  
Анхлан гэгээрэгч тэр болно.  
Хэмээсэн билээ.


Харин хэтийн зорилго нь үхэх, төрөх орчлоос ангижрах төдий нирваан болон төгс гэгээрэх нирваан гэсэн хоёр зүйл байдаг. Шарвага, брадига нарт зориулсан Буддагийн номлол болоод түүнд хамаарах бүх сургаал нь улам гэгээрэгчийн ерөнхий болон нийтлэг номын хүрээнд хамаарна. Оршихуйн бүх орчлоос залхан, энэ хүлээнээс ангижран зөвхөн өөрийн зорилгыг биелүүлэхээр тэмүүлж буй хүн улам гэгээрэгч мөн. Түүний баримтлах сургаал нь гурван заавар журам юм. *Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч* -д:


Амьдын цэнгэлээс нүүр буруулж  
Алдаа гэмийг засралаар гээж  
Ариун нирвааныг зорьсон бол  
Асуултгүй тэр улам гэгээрэгч.

Адишагийн *Хураангуй жууртын* зул номд ингэж өгүүлсэн байдал:

Төгс чанар ба тантрын сургаалд  
Төгөлдөр суралцаж гэгээрэлд хүрдгийг  
Түрүүлж бидэнд Будда сургасан  
Түүнийг нь би давтаж бичлээ.

Дээр өгүүлснээр төгс нирваанд хүрэх хоёр арга зам бий.





Тэдгээр нь Нууц тарнийн ба Төгс чанарын хөлгөн юм. Энэ хоёр төгс гэгээрэгчийн сургаал номлолын хүрээнд багтана. Агуу энэрэлдээ хөтлөгдөн бусдын толөө зүтгэж, амьтан бүхнийг зовлонгоос салгахын тулд төгс гэгээрлийн төвшинд хүрэх зорилготой. Улмаар зургаан төгс чанар, нууц тарнийн эхлэл, төгсгөлийн хоёр шатанд суралцаж байвал төгс гэгээрэгч болдог.  
*Гэгээрлийн замыг гэфэлтүүлэгч-д:*


Өөрийн зовлонгоор жишиг болгоод  
Өрөөл бусдыг зовлонгоос нь гэтэлгэх  
Үнэн гэгээн эрмэлзэл байвал  
Үнэхээр төгс гэгээрэгч тэр.  
хэмээн сургасан.


Төгс гэгээрэлд хүрэх арга нь төгс чанар болон тарнийн хөлгөн хоёр гэдгийг хэлсэн. Харин хэрхэн суралцах талаар хожим өгүүлнэ.

Дээр дурьдсан гурван хэв шинжийн хүний тодорхойлолт *Ашид буулган хураангуйлсан судар*-тай тохирдог. Тэнд:

Гурван төвшний гэгээрэлд зоригч байдаг. Арван буруу үйл хийхгүй гэж хуврагийн сахил аваагүй боловч ондөр ёс суртахуунтай хэсэг бий. Мөн шарвагагийн ёс зүйг чин үнэнчээр баримтлагч бий. Бас бодисадвагийн ёс зүйг сэвтээлгүй дагагч ч бий. Эдний нэгдэх нь эхлэн гэгээрэгч, удаах нь улам гэгээрэгч, сүүлийнх нь төгс гэгээрэгч юм гэж айлдсан байдаг.

Хүмүүсийг санаа зорилгоор нь гурван төвшинд хувааж болно. Васубандхугийн *Абхидахармакошагийн тайлбар*





ын тодорхойлолт *Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч*-тэй тохирдог. Эхлэн гэгээрэгчийг голчлон энэ насны амьжиргаа хөөсон ба хойд насаа эрхэмлэсэн гэж хоёр ангилдаг. Гэхдээ сайн төрөл олохыг эрхэмлэдэг учир энд хойд насаа эрхэмлэгчийг нь авч үзнэ.

## 2) Шавийг гурван төвшинд хуваан үе шаттай сургахын учир

Энэ нь хоёр хэсэгтэй:

- a. Шавийг гурван төвшинд хуваан сургах хэрэгцээ шаардлага
- b. Шавийг үе шаттай сургах шалтгаан


### a) Шавийг гурван төвшинд хуваан сургах хэрэгцээ шаардлага

Сургаалыг хүний санаа зорилгын гурван төвшинд зохицуулан номлодог. Гэхдээ дээд төвшний сургаалд нөгөө хоёр нь багтана. Эхлэн гэгээрэгч, улам гэгээрэгчийн сургаал бол Их хөлгөний зам мөрийн нэгээхэн хэсэг юм. Ашвагхошагийн *Гэгээрэх тэлүүлэл хөгжүүлэхүй* номд:

Амь тасалж, худлаа ярихгүй,  
Амьтны иомыг хулгайлж зөөхгүй,  
Өгөөмор зан, уужуу сэтгэл  
Өгсөх төрөлтний зан суртаал.

Орчлонг таньж зовлонгоос уйдаж,  
Онцгойрч гэгээрэх сургаалыг бясалгаж,  
Үйлийн үр, сэтгэлийн гэмээс салах нь  
Үнэнхүү нирваанд хүргэх сургаал.

Энэ бүхнийг өөрийн болгож,  
Энэ биенийхээ сургаал болговол



Эгнэгт ямагт хүлэг чинь болж  
Эрх чөлөө рүү хүргэх болно оо.  
  
Аливаа ертөнцийн хоосныг ухааруулж  
Амьтныг энэрэх сэтгэл үерлүүлэх  
Ариун Буддагийн арга замууд нь  
Агуу нирваанд хүргэх замнал аа.  
Хэмээсэн билээ.


Тиймээс орчлонгийн жаргал төдийхөнд тэмүүлсэн  
эхлэн гэгээрэгч эсвэл өөрөө л орчлонгийн хүлээнээс  
ангижрах гэсэн улам гэгээрэгчийн сургаалаар хөтлөнө  
гэсэн үг биш. Дээрх хоёртой зохицсон нийтлэг зарим  
сургаалыг төгс гэгээрэгчийн өмнөх шат болгон  
судалдаг. Энэ бол төгс гэгээрэгчийн сургаал судлах  
зам мөрийн нэгээхэн хэсэг болохыг одоо үзүүлнэ.


Өмнөх бүлэгт үзсэн завшаан, боломж бүрдсэн хүн  
заяаны хэргийг бүтээхийн тулд тийм хүсэл эрмэлзэл  
төрүүлэх хэрэгтэй. Энэ тухай *Төв үзлийн төн чанар*-т:

Үерийн хөөс, өвсний ус шиг  
Үзэгдээд алдагдах энэ биеийг  
Үлэмж тусаар бусдад зориулбал  
Үнэхээр дээдийн гавьяа болно оо.

Өндөр занят энэрэгч суутнууд  
Өвдөж хөгшрөх өөрийн биеийг  
Өнөр олныг өөд татах  
Өнийн их үйлсэд зольдог билээ.

Золгүй найман заяанаас холдсон  
Золтой гэгээрлийн зулыг харсан  
Энэ төрлөө суутнуудын жишгээр  
Эрх чөлөөний замнал болго оо.  
Хэмээн айлдсан юмаа.





Энэ дагуу “Миний амь усны хөөс, өвсний шүүдэр шиг хэврэг. Өвчний үүр болон өвдөж, өтөлж зовно. Тиймээс энэ наасаа өдөр шөнөгүй төгс гэгээрэгчийн сургаалыг судлан өнгөрөө. Тэгвэл сая утга учиртай болно” хэмээн бодож Их хөлгөнд суралцах хэрэгтэй.

*Асуулт:* Тэгвэл эхнээсээ л төгс гэгээрэгчийн сургаалыг судалж болох юм байна. Заавал эхлэн гэгээрэгч, улам гэгээрэгчийн зам мөрөөр явах ямар хэрэг байгаа юм бэ?

*Хариулт:* Эхлэн гэгээрэгч, улам гэгээрэгчийн буюу тэр хоёртой нийтлэг зам мөр бол төгс гэгээрэгчийн сургаал судлах бэлтгэл хэсэг юм. Харин одоо энэ тухай тодорхой тайлбарлана.

### б) Шавийг үе шаттай сургах шалтгаан


Нэг шавийг гурван төвшинд аажим ахиулан сургахын шалтгаан болон зайлшгүй шаардлагыг доор тайлбарлана.


#### I) Шалтгаан

Их хөлгөнтөн болох үүд нь төгс гэгээрэлд хүрэх тэмүүлэл (бодь сэтгэл) юм. Гэгээрэх тэмүүллийн тухай *Бодисадвагийн замнал*-д:

Гэгээрэх тэмүүлэл төрсөн мөчөөс  
Гэрэлд гарахаар тэмүүлсэн хормоос  
Амьдралын дөнгөнд хоригдсон болгон  
Аврагч Буддагийн хөвгүүн болдог оо.  
гэсэн байдаг билээ.

“Буддагийн хөвгүүн” эсвэл “Бодисадва” хэмээх нэрийг хүртсэн цагт Их хөлгөнтөн болно. Харин гэгээрэх тэмүүлэл нь сарнивал Их хөлгөнөөс хасагдана.







Тиймээс Их хөлгөнтөн бол्यё гэвэл гэгээрэх тэмүүлэл хөгжүүлэхийг зүйл бүрээр хичээ. Эхлээд ач холбогдлыг нь бясалга. Тэгвэл сэтгэлийн гүнд хүсэл эрмэлзлэл ундарна. Мөн долоон үет зан үйлийг аврал эрэхтэй хамтад нь хийх хэрэгтэй. Энэ бол гэгээрэх тэмүүлэл хөгжүүлэх дарааллыг тайлбарласан *Бодисадвагийн замнал*, *Хураангуй заавар журам* зэрэг гайхамшигт зохиолуудын заавар юм.

Дээр дурьдсан ач холбогдол нь ойрын ба хэтийн хоёр шинж чанартай байдаг. Ойрынх нь муу заяанаас салах, сайн заяанд төрөх хоёр зорилго агуулдаг. Гэгээрэх тэмүүлэл төрснөөр урьд төрөлд хуримтлагдсан муу заяаны шалтгаан арилахаас гадна цаашдаа нэмэгдэхгүй. Мөн өмнө нь хуримтлуулсан сайн заяаны шалтгаан улам арвиждаг. Шинээр үйлдэж буй үлтүүд гэгээрэх тэмүүллээр сүлэгдэх тул хэзээ ч дундаршгүй болдог. Ер нь зовлонгоос ангижирсан нирваан, төгс гэгээрэлд хүрэх хэтийн зорилго гэгээрэх тэмүүлэлд суурилсан цагт хялбархан бүтнэ.

Ойрын ба хэтийн зорилгод хүрэх гэсэн жинхэнэ хүсэл эрмэлзэл тэр бүр байдаггүй. “Би гэгээрэх тэмүүлэл хөгжүүлнэ” гэж ярьж байлаа ч хоосон уг байх нь элбэг. Тиймээс өөрийгөө үргэлж шинжиж бай. Эхлээд сайн төрөл, нирваан хоёрт хүрэх хүсэлтэй болох нь зүйтэй.

Сайн төрөл, нирвааны ач тусыг хүссэн эрмэлзэл бий болгохын тулд эхлэн гэгээрэгч, улам гэгээрэгчийн нийтлэг сургаалаас судлана. Дээрх хоёр зүйлийг зорилго болгож, тэр үр дүнд хүрэх хүслээ хөгжөөх нь чухал. Үүний тулд гэгээрэх тэмүүллийн үндэс болох






агуу хайр, энэрийг хөгжүүлэх учиртай.


Харин юуны түрүүнд өөрөө энэ орчлонд өчүүхэн ч жаргалгүй, зовж зүдэрч яваагаа бодно. Бүр биеийнхээ шар үс бостол энэ талаар бодох хэрэгтэй. Тэгвэл үхэх төрөхийн орчилд эргэлдэн өчүүхэн ч жаргалгүй, зовлонд дарагдан зүдэрч яваа бусад амьтныг өрөвдөн, шаналах сэтгэл төрдөг. Энэ тухай *Бодисадвагийн замнал-д*:

Өнөр ертөнцийн алив амьтанд  
Өөрийгөө ядаж аврахын хүсэл  
Төөрсөн зүүдэнд нь ч төрөөгүйсэн бол  
Төрөлхтөнийг аврах гэж хаанаас бодох вэ?  
хэмээн тэмдэглэсэн билээ.

Тиймээс эхлэн гэгээрэгчийн төвшинд өөрөө муу заяанд төрвөл зовно гэдгийг эргэцүүлэн боддог. Улам гэгээрэгчийн төвшинд сайн төрөл олсон ч амарлингуйн жаргал эдлэхгүй зовно гэдгийг эргэцуулна. Ингээд садан төрөл болсон бусад амьтдыг өөртэйгөө зүйрлэн бясалгаж агуу хайр, энэрэл соёолуулна. Эндээс л гэгээрэх тэмүүлэл боловсордог. Тиймээс анхан ба дунд төвшний нийтлэг санаа зорилгыг судлах нь хуурмаггүй гэгээрэх тэмүүлэл хөгжүүлэх арга болохоос огт өөр зам мөрөөр явна гэсэн үг биш.

Эдгээр шатанд аврал эрж, үйлийн үрийн тухай бодож санадаг. Улмаар зөв дадал төлөвшүүлж, буруугаас сална. Энэ бүхэн гэгээрэх тэмүүлэл хөгжих хөрс болдог. Мөн гэгээрэх тэмүүлэл төлөвшүүлэх арга болдог долоон үет зан үйлээр өөрийгөө ариусгадаг. Тиймээс дээр өгүүлсэн бүхнийг гэгээрэх тэмүүлэл хөгжүүлэх арга гэж ойлгох нь зүйтэй.







Анхан болон дунд шатны сургаал, номлолууд нь энгүй гэгээрэх тэмүүлэл төлөвшүүлэх нэг арга гэдгийг багш сайтар ойлгуулж, шавь ч баттай мэдэх хэрэгтэй. Тэгэхгүй бол дээд төвшний номлол ба бусад номлолын уялдаа алдагдана. Дээд төвшний зам мөрд орох хүртэл гэгээрэх тэмүүллийн талаар цэгцтэй, зөв ойлголттой болохгүй бол гэгээрэх тэмүүлэл эзэмшихэд саад болно. Ингээд их хэрэг бүтэхгүй гэдгийг байнга санаж яваарай.

Доод, дунд төвшинд суралцах сургаалыг дээд төвшний зам мөрд суралцах үед заасан дагуу сайтар эзэмшин хуурмаггүй гэгээрэх тэмүүлэл өөртөө бий болго. Тэрхүү гэгээрэх тэмүүллээ тууштай болгохын тулд урьдаар онцгой аврал эрэхийн сануу ерөөлийн зан үйлийг гүйцэтгэн гэгээрэх тэмүүллийн сургаалд хичээнгүйлэн суралцаарай. Дараа нь бодисадвагийн үйл хэрэг болох зургаан төгс чанар, дөрвөн хураангуй зэрэгт суралцан эзэмшихийг хичээ. Чин сэтгэлээсээ энэ зам мөрөөр замнах хүсэл төрвлөл гэгээрэх тэмүүлэл эзэмших ариун сахил авах хэрэгтэй. Тэгээд сахилаа зөрчиж үндсэн алдаа гаргахгүйн төлөө амиараа дэнчин тавь. Их, бага ямар ч алдаа гаргахгүйг хичээ. Хэрвээ алдаа гаргавал урд бүлэгт өгүүлсэн ёсоор тухай бүрт нь засаж залруулна.

Цаашдаа зургаан төгс чанарт суралцана. Ялангуяа сэтгэлээ хүссэн зөв дадалдаа төвлөрүүлэх тайван төлвийн мөн чанартай сэтгэл төвлөрүүлэх бясалганд сайтар суралц. Харин *Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч*-д “онцгой танин мэдэхүйтэй болохын тулд тайван төлөвт суралцдаг” гэсэн нь жишээ болгосон л хэрэг шүү. Бусад







зорилгоор, жишээ нь үлэмж үзэлд хүрэхэд мөн л тайван төлөвт суралцдаг гэж Адиша хэлсэн байдаг. Тиймээс үлэмж үзэлтэй болохын тулд тайван төлвийг эзэмших хэрэгтэй. Дараа нь Би - г баримтлах хоёр хэлбэрийн зэрэглээг арилгахын тулд гүн ухааны Би үгүй - хоосон чанарын үзлийг лавшруулан судална. Улмаар түүнийг зөв аргаар бясалган суралцаж оюун санааны хэмжээнд үлэмж үзлийг эзэмшидэг юм.

Тиймээс Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч-д гэгээрэх тэмүүллийн сахил сахих нь ёс зүйн заавар журам юм. Харин тайван төлөв ба үлэмж үзэл түүнд хамаарахгүй. Тайван төлөвт сэтгэлийн заавар журмаар хүрнэ. Үлэмж үзэлд билэг оюуны заавар журмаар хүрнэ гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл тайван төлвөөс өмнөх заавар журмууд арга барилд хамаарах бөгөөд зөв дадал цогцлуулах буюу харьцангуй үнэнд тулгуурласан сургаал юм. Энэ бол агуу их үйл хэргийн нэг шат. Харин билэг оюуны онцгой гурван заавар журам нь оюун санаанд хамаарна. Билэг оюун цогцлуулах буюу туйлын үнэнд тулгуурласан сургаал нь гүн үзэл санааны сургаалын нэгээхэн хэсэг билээ. Тиймээс энэ бүхний эрэмбэ дараалал, өвөрмөц онцлогийг нь мэддэг байх хэрэгтэй. Арга барилыг билэг оюунаар сүлэхгүй бол гэгээрэлд хүрэхгүй гэдгийг сайн тогтоож ав.

Энэ зарчмаар хүний сор болсон Буддагийн оюун санааны хөвгүүд эрхэм төгс чанарын далайгаар элин халин нисэж төгс гэгээрлийн төвшинд хүрдэг. Тэдний нэг жигүүр нь арга барилын хувийг агуулсан харьцангуй үнэн. Нөгөө нь бодит ахуйн мөн чанар буюу Би - г баримтлах хоёр хэлбэрийг үнэхээр ойлгосон






туйлын үнэн байдаг. Хэрвээ сургаалын ганцхан талыг нь баримталбал өрөөсөн далавч нь хугарсан шувуу шиг огт нисэж чадахгүй. Энэ тухай Чандракиртигийн *Төв үзэлд орохуй ном*-д:


Харьцангуй хийгээд туйлын үнэний  
Харыгүй жигүүр дэлгэж дэвсээр  
Хамаг амьтныг Будда дагуулаад  
Хамаг төгсийн чинадад хүргэнэ ээ  
гэж айлдсан байдаг.

Эхлээд судрын зам мөрөөр өөрийгөө хөгжүүлнэ. Дараа нь нууц тантрын зам мөрийг судлах нь гарцаагүй. Тантрын зам мөр төгс чанарын хоёр чуулбарыг хоромхон зуур цогцлуулдаг. Харин дээд төвшинд орох чадвар дутаж эсвэл дээд төвшний зам мөрөөр замнах сонирхол төрөхгүй байж болох юм. Тэгвэл тухайн судалж буй зам мөрөө гүнзгийрүүлэн үзээрэй.

Нууц тантрын хөлгөнд орохын тулд бүх хөлгөнд хичээн суралцах хэрэгтэй. Тэр дундаа нууц тантрын сургаал хамгаас чухал гэж үздэг. Тантрын ёсонд эхнээс нь багши шавийн барилдлагыг ёсчлон дагах болно. Мөн тухайн нэг зүйлд өгсөн амлалт, авсан сахилаа амь шигээ сахин хамгаалах ёстой. Үндсэн алдаа гаргавал дахин тангараг тавьж болдог ч сайн чанар хөгжүүлэхэд хэцүү болж өөрийгөө баллана. Тиймээс үндсэн алдаа гаргахгүйг хичээх нь зүйтэй. Мөн энгийн алдаа гаргахаас ч цээрлэнэ. Алдаа гаргавал гэмээ наминчлан, ахин давталгүй арилгах хэрэгтэй. Ер нь тангараг, сахил бол тантрын сургаалын суурь юм.

Дараа нь доод тантрын “тэмдэгт ёог” эсвэл “үүсгэх шат” хэмээх дээд тантрын аль нэгэнд сайн





заавар ашиглан суралц. Харин энэ бүхнийг эзэмшилэх хойноо доод тантрын “тэмдэггүй ёог” эсвэл дээд тантрын “төгсгөх шат”-ны аль тохиороход нь суралцах хэрэгтэй.

*Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч*-д сургаалд суралцах дэс дарааллыг ингэж тогтоосон байдаг. *Бодъя морийн зэрэг*-т ч энэ маягаар хөтлонө. Адиша өөрийн бусад зохиол бүтээлдээ мөн л ингэж туурвисан байдаг. Тэрээр *Их хөлгөний сургаалыг эзэтийх арга барилын хураангуй-даа:*

Сэтгэлд багтамгүй оройн дээд  
Сэхээрэл, гэгээрэлд хүрнэ гэвэл  
Санаа сэтгэлээ баттай өгсөн  
Сайн тэмүүлэл өөртөө үүсгэ.

Эртийн ерөөл, завшаан бүрэлдэж  
Энэ биенгийг эндээс оллоо  
Эргээд хүн болоход бэрх тул  
Эрхэм сургаалыг дагаснаар хожно.


Мөн:


Торонд суугаа хоригдол ялтан  
Торхийх чөлөөг анаж олвоос  
Толгой хандсан тэр л зүгтээ  
Тонилж зугтах нь мэдээж билээ.

Амилдаг, үхдэг энэ орчлоос  
Арилж мултрах чөлөө байхад  
Анаж түүнийг алавхийн олооч  
Алмайрч сааталгүй орчлонгоос сулраач.

Түүнчлэн:

Аврал үйлдэж, журмаа дээдэлж  
Аливаад гэгээрэх тэмүүлэл гүйж





Ариун бодисадын санваарыг сахиж  
Ашдын зургаан чанарыг мөрдөж  
Алгуур, буцалтгүй, аль чадлаараа  
Аажим дээшлэ, гэгээрлийн замаар.

Бас:

Арга барил, сэцэн ухааны үндэс нь болсон  
Тайван төлөв, үлэмж үзэлд таарах ёгийг бясалга.  
гэхчлэн сургадаг.

Мөн *Сэтгэл товлөрлийн бүлэг*-тээ Адиша ийн өгүүлсэн  
нь буй:


Асрал энэрлээс урган соёолсон  
Агуу гэгээрэх тэмүүлээ торд.  
Ахуйн цэнгэл, амьдын жаргалд  
Авталгүй орхиод “баяртай” гэчих.


Ачит багшаа бурхан Буддатай  
Адил зэрэгт дээдлэн шут ээ.  
Авралын хур, сүсгийн эрдмийг  
Адилхан чамд хүртээсэн шүү дээ.

Заасан номыг нь баттай мөрд  
Замнал болгож яштал дага аа.  
Замбуулингаас дээшилж бурханд нэвтрэх  
Зам мөр чинь тэр болноoo.

Оюун, махбодиороо давхар андгайлж  
Оюут багшийнхаа зааснаар гэгээрч  
Бие, хэл, сэтгэлээрээ ариудвал  
Билэгийн сав-оюунтан тэр шүү.

Бясалган гэгээрэх шат бүхэндээ  
Баримттай төрөх төгс чанаруудыг  
Эрдэмд цогцлоон төгөлдөр болго  
Энэ бол тарнийн журам ёс.






## II) Хэрэгцээ


*Асуулт:* Анхдагч, дунд төвшний сургаал номлол бол төгс гэгээрэгчийн бэлтгэл, дээд төвшний сургаалын нэг хэсэг юм байна. Тэгэхээр заавал эхлэн гэгээрэгч, улам гэгээрэгч буюу нийтлэг гэсэн тодорхойлолт юунд хэрэгтэй юм бэ?

*Хариулт:* Гурван төвшинд ялган сургах хоёр том хэрэгцээ бий. (1) Анхдагч, дунд төвшний хэмжээнд өөрийгөө хөгжүүлээгүй атлаа дээд төвшинд хүрсэн гэж боддог хийрхлийг дарна. Мөн төгс гэгээрэгч, улам гэгээрэгч, эхлэн гэгээрэгчийн оюуны чадал чансааны хувьд ч ихээхэн тустай байдаг. Тиймээс зааж буй багш дээд төвшний өндөр язгуур ба нирвааны үзэл санааг заалаа гээд буруудахгүй. Харин сайн чанарууд хөгжине.

Багахан санаа зорилготой нэгэн дээд төвшнөөс эхлэн судалсан ч дээд төвшний санаа зорилго төлөвшихгүй. Доод төвшинг алгассан учир алинд ч үгүй хоцорно. Дээд төвшний санаа бодолд ойр хүнд нийтлэг сургаал заахад өмнө байсан чанарууд нь сэргэдэг. Урьд нь хөгжөөгүй байсан зарим чанар хурдан төлөвшине. Ингэж осон нэмэгддэг. Улмаар бүр дээд төвшинд хөтлон оруулж болдог учир өөрийн төвшнөөсөө буурахгүй.

(2) Ухааных нь хэр хэмжээгээр шат дараатай хөгжүүлэх хэрэгцээний тухай *Дхаранийг эзэтишигчийн асуултанд* сударт тодорхой өгүүлдэг. Тэнд эрдэнэсийн чулууг, чулуу өнгөлөгч ямар дарааллаар өнгөлж засан гоёл чимэглэл болгодогтой жишин тодорхой тайлбарласан нь бий. Гэхдээ хэт нуршихгүйн үүднээс орхиё. Хутагт Нагаржуна сайн төрөл ба нирвааныг





эрхэмлэх үзлийг дэс дараатай судлах тухай ийн өгүүлжээ:

Эхлээд төрлөө ахиулахад суралц  
Эрх чөлөөнд дараа нь эрмэлз  
Энэ мэтийн эрэмбээр явбал  
Эрхбиш гэгээрэлд зөвөөр хүрнэ.


хутагт Асанга шат дараатай суралцах тухай өгүүлэхдээ:


Бодисадва нар сайн чанарыг эрэмбэ дараатай хөгжүүлэхийг чухалчилдаг. Тэд оюуныг чадвар багатай нэгэндээ эхэндээ хялбар номлол заадаг. Хялбархан заавар журмаар хөтөлдөг. Тэгээд оюуны чадвар нь дунд төвшинд хүрвэл тэр хэрийн номлол заана. Мөн дунд зэргийн заавар журмаар удирдан дунд төвшинд хүргэдэг. Хэрвээ оюуны чадвар нь нэмэгдсэн гэж үзвэл гүнзгий номлол зааж эхлэдэг. Мөн нарийн заавар журмаар удирдан чиглүүлж дээд төвшинд хүргэдэг юм. Ингэж аажмаар амьтанд тусладаг.

Мөн хутагт Арьяадэва *Хураангуй сургаалын* зул зохиолдоо эхлээд төгс чанарын сургаалыг өөрийн болгож байж тантрын сургаалыг судлах дараалалтайг нотлон өгүүлсэн байдаг. Түүнийгээ товчхон байдлаар ийн өгүүлжээ:

Эхэлж сүжиг төрөхөөс эхлээд  
Эрэмбэ дараагаар өөдөө өгсөж  
Гишгүүр дамжих мэт ахин ахисаар  
Гэгээрэлд хүрэхийг Будда айлдсан.

Мөн түүний *Дөрөөн* зуут-д зам мөрийн дарааллыг тодорхой тайлбарладаг:






Өөтэй буруу дадлууд эхлээд  
Өөрөөн чинь зайлж цэвэрших болно.  
Өөрийгөө хайрлахын хүлээс дараа нь  
Өвчдөө задран чөөтэй болно.




Хамгийн сүүлд буруу үзэл  
Хаягдаж чамаас гээгдэнэ гэдгийг  
Харж танивал ухаантан мөн  
Харьцуулж мэдвэл эрдэмтэн мөн.



Түүнчлэн хутагт Майдар:

Будах бөсийг эхлээд угаах шиг  
Будангуйгаас чөлөөлж өгөөмөр болгоод  
Хомголзох сэтгэлийг нь ариун болгоод  
Хоосон чанарыг сая бясалгуул  
гэх зэргээр айлдсан байдаг.

Энэ бадгийг ишлэл болгон Чандракирти зам мөрийн  
эрэмбэ дарааллыг гарцаагүй нотолсон юм. Дагаж  
мөрдөх үед зам мөрийн дараалал маш чухал тул энэ дэг  
жаягийг ягштал мэддэг байх хэрэгтэй.









## IX

# ҮХЛИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ


б. Завшаан, боломж бүрдсэн хүн заяны давуу талыг ашиглах


- 1) Эхлэн гэгээрэгчийн санаа зорилгыг судлах
- a) Эхлэн гэгээрэгчийн санаа зорилгыг судлах
  - I) Дараагийн төрлийг чухалчлах бодол төрүүлэх
    - а' Энэ ертөнцөд удаан амьдрахгүй гэж үхлийн тухай эргэцүүлэн бодох
      - 1' Үхлийн тухай бясалгахгүй байхын гэм буруу
      - 2' Үхлийн тухай бясалгахын ач тус
      - 3' Үхлийн тухай санаа бодол бий болгох
      - 4' Үхлийн тухай ойлголтын бясалгах арга
        - а" Зайлшгүй үхнэ гэдгээ эргэцүүлэх
          - 1" Эрлэгийн эзнээс зугтаж, зайлах арга үүй





- 2" Амьдралыг уртасгах арга үгүй, үргэлж хорогддог  
3" Үхэх нь гарцаагүй бөгөөд энэ амьдралд номлолд зориулах цаг байхгүй  
б" Үхлээ урьдчилан таах боломжгүй  
1" Энэ ертөнцөд амьдрах хугацаа тодорхойгүй  
2" Үхэх шалтгаан олон, амьдрах боломж бага  
3" Энэ бие маш хэврэг учир хэзээ үхэхийг нь тодорхойлох аргагүй  
в" Үхэх цагт хураасан буянаас өөр юу ч туслахгүй  
1" Хэн ч тусалж чадахгүй  
2" Хичнээн эд хөрөнгө байлаа ч хэрэг болохгүй  
3" Энэ бие хэрэг болохгүй





## б. Завшаан, боломж бүрдсэн хүн заяны давуу талыг ашиглах

Энэ нь гурван хэсэгтэй:

1. Эхлэн гэгээрэгчийн санаа зорилгыг судлах (9-16 дугаар бүлэг)
2. Улам гэгээрэгчийн санаа зорилгыг судлах (II боть)
3. Төгс гэгээрэгчийн санаа зорилгыг судлах (III боть)

### 1) Эхлэн гэгээрэгчийн санаа зорилгыг судлах

Энэ бүлэг гурван хэсгээс бүрдэнэ:

1. Эхлэн гэгээрэгчийн санаа зорилгыг судлах
2. Эхлэн гэгээрэгчийн санаа бодол хөгжсөнийг таних
3. Эхлэн гэгээрэгчийн тухай буруу ойлголтыг няцаах няцаах

#### a) Эхлэн гэгээрэгчийн санаа зорилгыг судлах


Энэ нь хоёр хэсэгтэй:


1. Дараагийн төрлийг чухалчлах бодол төрүүлэх
2. Хойд насандaa ёайн заяанд төрөх нөхцөл бүрдүүлэх

### I) Дараагийн төрлийг чухалчлах бодол төрүүлэх

Үүнийг хоёр хэсэгт хуваан тайлбарлана:

- а'. Энэ ертөнцөд удаан амьдрахгүй гэж үхлийн тухай эргэцүүлэн бодох
- б'. Хойд насны амьдралын тухай эргэцүүдэн бодох: дээд доод хоёр төрлийн жаргал ба зовлон





## а' Энэ ертөнцөд удаан амьдрахгүй гэж үхлийн тухай эргэцүүлэн бодох


Үхлийн тухай эргэцүүлэн бодох нь дөрвөн хэсэгтэй:


1. Үхлийн тухай бясалгахгүй байхын гэм буруу
2. Үхлийн тухай бясалгахын ач тус
3. Үхлийн тухай санаа бодол бий болгох
4. Үхлийн тухай ойлголтыг бясалгах арга

### 1' Үхлийн тухай бясалгахгүй байхын гэм буруу

Завшаан бүрдсэн энэ насын хэргийг гаргахад дөрвөн буруу бодол саад болдог. Мөнх бусын жам ёсыг мөнх мэтээр сэтгэх нь хамгийн эхний алдаа юм. Мөнх бус нь энгийн, нарийн хоёр төрөл байдаг. Энгийн мөнх бус буюу үхлийн тухай бясалгахгүй байх нь огт үхэхгүй гэдэг бодол төрүүлдэг гэмтэй. Бид огт үхэхгүй мэт сэтгэсээр явад бурууддаг. Бүгд насын эцэст үхнэ гэдгээ мэддэг боловч өдөр бүр “өнөөдөр лав үхэхгүй”, “өнөөдөр ч бас үхэхгүй” гэж бодож явсаар нэг л мэдэхэд үхэлтэй нүүр тулдаг билээ. Хэрвээ энэ бодлоосоо салахгүй бол түүнд бүрэн автагдаж, ингээд амьдрaad байх юм шиг сэтгэнэ.

Тэгээд энэ насын амьдралт төдийхнийг жаргалтай болгож, зовлонгоос салах гэж оролдон энэ ч хэрэгтэй, тэр ч чухал гэж гүйнэ. Тиймээс хойд нас, нирваан, төгс гэгээрэл зэрэг чухал ач холбогдолтой зүйлсийн тухай огтхон ч эргэцүүлэхгүй. Номлол дагая гэдэг бодол даанч төрөхгүй. Хааяа нэг номлол сонсож, судалж, бясалгах боловч зорилго нь энэ амьдралаар хязгаарлагдана. Тиймээс төлөвшүүлсэн сайн чанар нь дэндүү дорой байдаг. Дээрээс нь буруу зөрүү,






нүгэл хилэнцтэй хутгалдах нь элбэг. Иймээс муу заяаны шалтгаантай орооцолдохгүй байх гэж бараг угүй. Хэрвээ хойд насаа бодож зүтгэл гаргалаа гэхэд “яваандаа л хийе” хэмээн хойш тавьж, залхуудаа дийлддэг. Ингээд унтаж хэвтэх, ууж идэх, дэний чалчих зэрэгт сатаарсаар цаг нөгцөөнө. Тэгэхээр идэвх чармайлттай, ном ёсны зүтгэл гаргаж чаддаггүй.


Удаан амьдарна гэдэг мөрөөдөлдөө хууртагдана. Тэгээд хөрөнгө мөнгө, нэр хүнд мэтэд шунан дурладаг. Бүр түүнд хүрч чадахгүй нь хэмээн эмзэглэж, хэт уурлан бухимдаж эхэлдэг. Энэ бүхний хор хөнөөлд автан толгой нь эргэнэ. Ингэж уур уцаар, атаа жөтөөнд баригдан сэтгэлийн гэмүүд бий болно. Улмаар тэвчих аргагүй олдмол сэтгэлийн гэмүүд ундарсаар байх болно. Бие, хэл, сэтгэлийн арван хар нүгэл, засашгүй хүнд алдаа болон аар саар алдаа ч гарна. Улмаар гэгээн номлогоос гажих мэтийн буруу үйлдэл, муу заяаны дааж давшгүй зовлонд хүргэх гэм нүглийн хүч өдөр бүр өсөн нэмэгдэнэ. Энэ бүхнээс салах тухай тодорхой заасан гэгээн номлолын рашаанаас ч холдон оддог. Ингээд сайн төрөл болоод нирвааны амин сүнс тасарна. Төсөөлөхийн аргагүй хүнд хүчир, хатуу ширүүн муу заяанд төрнө. Үхэлд гүйцэгдэн, муу үйлийн үрдээ хөтлөгдөн муу заяа руу туугдан одох нь гарцаагүй тул үхэхгүй гэж бодохоос илүү тэнэглэл хаана байх вэ?

*Дөрвөн зуут-аас:*

Үхэхэд шүүгч Эрлэг хаан  
Үнэндээ чи бишээс хойш  
Үхэхгүй юм шиг алмайрч суувал  
Үнэнхүү тэнэгийн дээд буюу.

*Мөн Бодисадвагийн замнал-д:*






Алдаа, онооны үрээс бусдыг  
Авч чадахгүй, орхих байтал  
Авах төрлөө Эрлэгт даатгаад  
Алд биеэ ч гээх байтал  
  
Энийг тэрийг ч мэдэхгүйн балагаар  
Эргэцүүлж таниагүй харанхуйн гайгаар  
Эртээс гэгээрэлд зориогүйн лайгаар  
Эндсэн, алдсан олон нь хайраан.  
хэмээн анхааруулсан юмаа.


## 2' Үхлийн тухай бясалгахын ач тус

Үхлийн тухай үнэн зөв ойлголттой болох нь маш их ач тустай. Жишээлбэл, жам ёсны тухай бага сага ойлголттой, өнөө маргаашгүй үхнэ гэдэг нь тодорхой болчихсон хүн садан төрөл, эд хөрөнгөтэй удаан ханилахгүйгээ ухаарна. Ингээд тэдэнтэй зууралдаахаа болж өглөг өгөх зэргээр хүн болсныхоо хэргийг бага ч болов гаргах их хүсэл аяндаа төрдөг. Хөрөнгө хогшил, алдар нэр зэрэг энэ амьдралын юм бүхний толөө гаргасан зүтгэл нь усны хөөс шиг ямар ч хэрэггүй, хуурмаг гэдгийг ухаардаг. Ингэснээр гэм буруугаас сэргийлж, аврал эрэх, ёс зүй дагах зэргээр сайн үйл хийхдээ үргэлж сүсэглэх болно. Ийнхүү чармайн зүтгэж, амьдралаа гэгээн агуулгаар баяжуулдаг. Өөрөө гэгээн сайхан төвшин рүү тэмүүлэхийн зэрэгцээ бусдыг ч тэр зүгт хөтөлдөг. Тиймээс үхлийн тухай ойлголтоос өөр хэрэгтэй зүйл байна уу?

Энэ тухай олон ном сударт жишээ татан, магтаж сайшаан өгүүлсэн байдаг юм. *Гаслангаас салгах судар-т:*

Уриншийг дүгнэвээс намрынх нь ашигтай  
Ул мөрүүдээс зааных тодорхой





Ухаарлууд дотроос “мөнх бус”-ынх гэгээтэй  
Унах шалтгаануудыг заадгаараа ачлалтай.

Мөн бүх сэтгэлийн гэм, нүгэл хилэнцийг бяц цохидог алх, хамаг сайн чанарыг нэг дор эзэмших их үүд гэх зэргээр магтсан байдал билээ.

*Цоморлиг-т:*


Гангтар шаазан шиг хэврэгхэн биеийг  
Гандирс адил хуурмаг ертөнцийг  
Гарцаагүй чи танъж ухаарахад  
Гайтуулагч шулмын зэвсэг хугарна.  
Дэнс барьсан догшин эрлэг  
Дэргэдүүр зүгээр өнгөрч болно


гээд цааш нь:

Энэлж, өвдөж, үхэхээ санаж  
Энхрийлэх биеэ гээхээ ухаарваас  
Энэ орчлонд хоригдсоноо мэдээд  
Эгнэгт алдуурч гэгээрэхийг хүснэ.  
гэх зэргээр айлдсан байдал.

Товчхондоо бол хүн болж төрснийхөө хэргийг бүтээх цаг нь онцгой завшаан олсон яг энэ үе юм. Бид ихэнхдээ муу заяанд төрж байсан. Сайн заяанд хaa нэгтээ төрлөө ч ихэвчлэн боломжгүй төрөл олж байлаа. Тиймээс тэр үед номлолд суралцах зав зайд байсангүй. Бас бүх боломж бүрдсэн ч номлолыг зохих ёсоор нь судалдаггүй. Ингээд “Одоо лав үхэхгүй” гэдэг бодолд яваандаа хүрдэг. Үхэхгүй гэдэг бодол нь сүйрэл бүхний үүд. Харин үхлийн тухай санаа бодол нь үүний эсрэг буюу аливаа сайн бүхний хаалга билээ.

Тиймээс “энэ бол гүнзгий номлол бясалгах чадваргүй хүнд зориулсан заавар” гэж бодож болохгүй.






Эсвэл “Өөриймшүүлэх чанар мөн ч гэлээ эхэндээ жаахан бясалгана. Үргэлж бясалгах шаардлагагүй” гээд орхичихож бас болохгүй. Харин зам мөрийн эхлэл, төгсгөл, дунд үеийн алинд нь ч хэрэгтэй заавар журам хэмээн үнэн голоосоо итгэ. Тэгээд өөрийн болтол нь бясалгаарай.


### 3' Үхлийн тухай санаа бодол бий болгох

Ах дүү, амраг садандаа ээнэгшин дассаны улмаас тэднээс сална гэхээр төрдөг айdas бол гэгээрлийн зам мөр судлаагүй хүний айdas юм. Гэвч ийм айdas төрүүлэх гэсэн юм биш. Тэгвэл ямар санаа бодол төрүүлэх гээд байна вэ? Үйлийн үр, сэтгэлийн гэмийн эрхээр бие цогцостой болсон бүхэн үхэх нь гарцаагүй. Энэ айдсаас тийм хурдан салж чадахгүй. Гэхдээ үхээд муу заяанд төрөх шалтгаанаас салахгүй, сайн төрөл ба нирвааны үндсийг бүрдүүлэхгүй үхчих вий гэдгээс л эмээх хэрэгтэй. Ийм айdas байгаа цагт муу заяанд шалтгаанаас салж, сайн төрөл ба нирвааны үндсийг бүрдүүлдэг. Тэгвэл үхэх цагт айх аюулгүй болно. Харин эдгээр зорилгоо биелүүлээгүй бол үхсэн ч үхэх төрөхийн орчлоос салахгүй, ялангуяа муу заяанд төрнө гэхээс айн жихүүцэхэд хүрнэ. *Төрөл туулсан цадиг-т:*

Эргэж, хоргодовч үлдэж чадахгүй  
Эндэж алдсанаа баллах аргагүй  
Эргэлтгүй үхэлтэй учрах цагт  
Энэлж шаналахад хожимдсон байна.

Ертөнцийн жам ирдгээрээ ирэхэд  
Ерийн хүмүүс алдаандаа гэмшиж  
Алдас болгоныхоо араас гасалж  
Айсуй шийтгэлийн зовлонгоос сурдэнэ.





Үхэхийн цагтаа айна гэдэг нь  
Үйлдсэн алдаандaa халаглана гэдэг нь  
Сайн номлолыг дагаагүйнх билээ  
Сайтар гэгээрч, боловсроогүйнх билээ.

Мөн *Дөрөөн зуут-д*:

Амь наасаа буцааж өгөхөө  
Ашид хүн үнэнхүү санаваас  
Айдас хүйдсээс ангижирч чадна  
Айлгагч Эрлэгээс сүрдэхээ болино.  
гэхчлэн айлджээ.

“Амь бие, хөрөнгө мөнгөнөөс удахгүй хагацах болохоор утга учир алга” гэж ахин дахин мөнх бусын тухай бодох хэрэгтэй. Тэгвэл тэр бүхнээс салахгүй гэсэн адын горьдлого угүй болно. Тэр бүхнээс хагацан сална гэдгээс айн жихүүцэхээ больчихвол үхсэн ч эмээх зүйлгүй.

#### 4' Үхлийн тухай ойлголтыг бясалгах арга


Үхлийн талаарх ойлголтыг бясалгахдаа гурван үндэслэл, есөн шалтгаан, гурван шийдвэрийн дагуу бясалгадаг. Гурван үндэслэл нь:


- а” Зайлшгүй үхнэ гэдгээ эргэцүүлэх
- б” Үхлээ урьдчилан таах боломжгүй
- в” Үхэх цагт хуримтлуулсан буянаас өөр юу ч туслахгүй

#### а” Зайлшгүй үхнэ гэдгээ эргэцүүлэх

Гарцаагүй үхнэ гэдгийг бясалгахад дараах гурван шалтгаан хэрэгтэй:

- (1) Эрлэгийн эзнээс зутгаж, зайлах аргагүй





- (2) Амьдралыг уртасгах аргагүй, үргэлж хорогддог  
(3) Үхэх нь гарцаагүй бөгөөд энэ амьдралд номлолд зориулах цаг байхгүй

### 1” Эрлэгийн эзнээс зугтаж, зайлх арга үгүй

Ямар ч бие цогцос, хувь төөрөгтэй байсан үхэх нь гарцаагүй билээ. *Мөнх бусын цоморлиг*-т:

Төгс гэгээрсэн Будда өөрөө, түүнчлэн шарвага нар  
Түүний номлолыг сонсоод дамжуулагч брадига  
Эд нар бүгдээрээ энэ жам ёсноос гажаагүй болохоор  
Эгэл жирийн хүмүүс бид үхлээс зайлж даанч чадахгүй  
гэжээ.

Ямар ч газар оронд амьдарч байсан үхэл ирдэг жамтай.  
Энэ тухай мөн тэнд:


Үхэл гэж байдаггүй орон  
Үзэгдэх энэ орчлонд ч үгүй  
Хөлгүй далай, ууланд ч үгүй  
Хөх тэнгэр огторгуйд ч үгүй.


Мөн дээрх сударт ямар ч үед үхэж болох тухай:

Төрсөн үр нь, төрүүлсэн эх нь ч  
Биеийг элээж төрөл арилжина.  
Төөрсөн хорвоогийн ийм үнэнийг  
Сэхээрсэн мэргэд номлож айлдсан.  
Хэмээн сургасан.

Үхлээс хэн ч зугтаж чадахгүй. Маани, тарни уншаад ч нэмэргүй. *Хаанд өгсөн заавар*-т:

Жишээ авья. Mash том, гүн суурьтай, хэзээ ч эвдэрч цуурашгүй бөх бат, бас хоорондоо салшгүй барьцалдсан, тэнгэрт тулам өндөр оройтой дөрвөн уул





тал талаас зэрэг шахан нийлбэл хамаг өвс ургамал, мод бут, амьтан адгуусыг няц шахна. Энэ үед зугтан зайлж, хүчээр эсэргүүцэж, хөрөнгө мөнгөөр аргалж, маани мэгзэм уншиж бүрэн бүтэн үлдэх аргагүй. Яг үүнтэй адилхан, хаантан минь. Ийм дөрвөн их аюул тулгарахад зугтаах, хүч хэрэглэн буцаах, хөрөнгө мөнгөөр аргалах, маани мэгзэм уншаад ч мултрах аргагүй билээ. Энэ нь өтлөх, өвдөх, үхэх, доройтох дөрөв юм. Хаантан минь! Залуу насыг өтлөлт үгүй хийнэ. Эрүүл мэндийг өвчин үгүй хийнэ. Хамаг сайхан бүхнийг доройтол үгүй хийнэ. Амийг үхэл үгүй хийдэг. Энэ дөрвөөс зугтаах, хүч хэрэглэн буцаах, эд хөрөнгөөр аргалах, золиг шившилэг, эм тан, маани мэгзэмээр ч аргалах аргагүй.

Хэмээн өгүүлсэн.


Гамбава нэгэнтээ “Бид одоо л үхлээс айх ёстой. Нэгэнт үхэл ирэхэд айгаад нэмэргүй. Гэтэл бид яг эсрэгээр нь одоо айгаагүй хэрнээ үхэлтэй нэгэнт тулсан хойноо үсээ зулгаах юм даа” гэж хэлсэн байdag.


## 2” Амьдралыг уртасгах арга үгүй, үргэлж хорогддог

Хэвлийд орохуй хэмээх номд:

Одооноос эрүүл мэндээ ариглаж, хамгааллаа гээд их л бодоход зуун жил, түүнээс жаахан л илүү амьдарна. Хэмээн заасан.

Амьдрах хугацаа ердөө энэ. Сайндаа л энэ хэмжээнд хүрдэг ч тэр хугацаа маш хурдан өнгөрдөг. Жил нь сараар хорогдоно. Сар нь хоногоор багасна. Хоног





нь өдөр шөнөөр өнгөрнө. Тэр нь өглөө, үдэш гэсээр жирийнэ. Тиймээс амьдрал даанч богинохон. Гэтэл энэ хугацааны ихэнх нь нэгэнт өнгөрчихөж. Үлдсэн хугацаа нь өчүүхэн ч нэмэгдэхгүй харин зогсолтгүй, өдөр шөнөөр улам бүр хорогдоор байна. Энэ тухай *Бодисадвагийн замнал*-д:

Тоолох цаг цохилох тоолон  
Тоотой нас хорогдож урсана  
Тогтоох, сунгах арга байхгүй  
Тосох үхлээс зайллах замгүй.  
гэж айлдсан.


Иймэрхүү жишээ маш олон байдаг. Хэдий ганц ганц гогцоо сүвэлдэг боловч нэг л мэдэхэд бөс даавууг нэхэж дуусдаг. Хонь малыг нядалгааны газар руу тухад ч алхам алхмаар үхэл рүүгээ ойртдог. Оволзон урсах гол болоод хүрхрээнээс буух ус шиг амьдрал жирэлзэн өнгөрнө. Малчин шилбүүрээр ороолгон тухад хонь мал хар аяндаа хот руугаа дөхдөг шиг өвдөх, өтлөх зэргээр Эрлэгийн эзний өргөө рүү дөхдөг. Энэ мэтээр жам ёсыг олон талаас нь бясалгах хэрэгтэй.


#### *Цоморлиг*-т:

Урлах танхимд хоосон жаазанд  
Утас нэмэгдэж, учиг холбосоор  
Удалгүй нэхэгдэж дуусах бөстэй  
Урсах насны хэмжээг зүйрлэм.

Өнөө өвлийн идэшний үнээ  
Өдөр хоногоор нядалгаанд ойртоно  
Өөр төрөлтөн хүн ч бас  
Өнгөрсөн насаараа маргаашаа хорооно.

Энэ голын урссан ус  
Эргэж сөрөөд ирэхгүйн адил





Эдэлж амссан хоног өдрөө  
Эргүүлж яахин авчирч болно.

Уртгүй богино, уясалгүй ширүүн  
Улмаан бас зовлонт амьдрал  
Усан дээр бүтээсэн зураг аятай  
Удаах нь бүү хэл тогтооход бэрх.


Тасхийх ташуур, исгэрэх шилбүүр  
Дальдчих малыг хот руу нь тууна.  
Өтөлж, ядарч, өвдөхийн шилбүүр  
Өөрийн биенийг эрлэг рүү тууна.  
Хэмээн айлдсан юм.


Адиша гэгээнтэн голын хөвөөнд очоод мөнх  
бусыг бясалгаж байхдаа хувьсан өөрчлөгдөнө гэдэг  
чинь чухам мяралзан урсац энэ голын урсгалтай адил  
хэмээн хэлсэн гэдэг. *Tэнгэрлэг туульс судар*-т мөн олон  
зүйлтэй жишин:

Гурван ертөнц хаврын тэнгэр шиг  
Гүйвж, урвах нь агшны зуур аа  
Гудайж үхэх, өндийж төрөх  
Гунигт, инээдэмт жужигтэй адил аа  
Амьдрал гэдэг аянгын цахил шиг  
Ахархан агаад урсаж одноо оо.  
Гэхчлэн өгүүлсэн билээ.

Өчүүхэн ч болов дотроо нэгийг эргэцүүлдэг бол үүнийг  
ойлгоно. Мөнх бусын жамыг илэрхийлээгүй бодит юм  
нэг ч байхгүй гэдэг. Энэ үнэн. Тиймээс олон янзаар  
бодож үз.

Энэ маягаар дахин дахин эргэцүүлбэл ойлгох  
нь гарцаагүй. Өчүүхэн төдий бодох аваас огт нэмэр  
боловхгүй. Гамбава нэг удаа “Бодоод бодоод нэмэр





боловхгүй байна гэх юм. Гэхдээ та нар өдөр нь юухан хээхэнд сатаардаг. Шөнө нь унтаад өгдөг байж битгий худлаа ярь” гэсэн юм шүү.

Зөвхөн насны эцэст Эрлэгийн эзэнд туугдан нөгөө ертөнцүү явдаг юм биш. Тэр хооронд явж, сууж, унтаж байсан ч амьдрал хорогдоор байдаг. Ер нь эхийн хэвлүүд бүрдэхээс эхлээд ганц ч хором зогсолтгүй нөгөө ертөнцийг чиглэн явдаг. Амьдарна гэдэг өтлюх, өвдөх зэргээр Эрлэгийн элчид үхлийн зүг туугдахын нэр юм. Тиймээс амьд ахуйдаа нөгөө ертөнцүү явахгүй мэт баярлах хэрэг огт байхгүй. Жишээ нь, хадан хясаанаас үсэрч газар бяц унахын хооронд юундаа ч баярлах билээ. “Дөрвөн зуут”-ын тайлбар-т энэ тухай:


Эрхэм баатрууд эхийн хэвлүүд  
Эхэлж олдсон хормоосоо эхлээд  
Энэ ертөнцөд мэндлэхээсээ аваад  
Эрлэгийн зүг тасралтгүй довтолно.


Мөн Дөрвөн буруу үзлийг няцаасан хүүрнэл-д:

Уулын оройгоос хөл алдаад  
Унах зуураа амсхийж болох уу?  
Эхээс төрөөд л үхэл рүү довтолгох  
Энэхэн чөлөө жаргал мөн үү?  
Гэхчлэн сургасан юм.

Энэ бүх ишлэлүүд үхэл дэндуу хурдан ирнэ гэдгийг үзүүлжээ.

**3” Үхэх нь гарцаагүй бөгөөд энэ амьдралд номлолд зориулах цаг байхгүй**  
Дээр дурьдсан хугацаанд амьд явж магадгүй. Харин





цаг байна гэж найдах хэрэггүй. Бид олон жилийг ямар ч хэрэггүй өнгөрөөжээ. Үлдсэн хугацааг нь унтаж өнгөрөөнө. Дээр нь өөр олон дэмий зүйлтэй хөөцөлдөн хоног өдөр алдаж, залуу насаа үрэн таран хийдэг. Харин өтөлсөн хойноо номлол дагаж, эзэмшие гэвч бие, оюуны чалх нэгэнт доройтсон байдаг. Иймээс хүний нэг насанд номлолд зориулах цаг тун бага байдаг юм. *Хэвлийд орохуй-д:*

Амьдралын хагасыг унтаж бардаг. Арван жилд нь нялх балчир явна. Хорин жил өтөлж хөгширдөг. Мөн гаслан, зовлон, харуусал, хямрал, доройтлоор нэгээхэн хэсгийг нь нөгчөөнө. Бас зүсэн зүйлийн өвчин эмгэгт баригдан нөгөө хэсгийг нь барна.


*Мөн Дөрвөн буруу үзлийг няцаасан хүүрнэл-д:*


Хүн хамгийн уртдаа зуу насална. Гэвч насын эхэнд нялх, эцэст нь хөгшин байх учир хэрэг багатай. Улмаар нойр, өвчин мэтэд цаг алдсаар горьдлого тасардаг. Хүний амьдралд ер нь жаргалтай мөч гэж байна уу?

гэхчлэн өгүүлсэн байдаг.

Чадгава “Хэрвээ амьдралыг жаран жил гэж тооцвол нойр хоол, хөрөнгө хогшил, өвчин зовлонд үрсээр номлолд суралцахад таван жил ч үлдэхгүй” гэж хэлсэн байдаг.

Тиймээс “Үхэх үед энэ амьдралын жаргал цэнгэл бүхэн сайхан зүүдээ эргэн санахын дайтай байдаг. Үхэл хэмээх дайсан зогсолтгүй довтолж буй энэ хуурамч амьдралын юунд нь ч баясах билээ” гэж олон дахин бод.





Тэгээд номлол судлая гэдэг хатуу шийдвэр гарга. *Төрөл туулсан цадиг*-т:

Үйл заняндаа шаналах хүмүүс ээ!  
Үүрдийн юмгуй тул баясаад яана вэ?  
Үлэмж тансаг сарнай гол гэх ч  
Үзэхэд үлдсэн дурсамж шүү дээ.

Орчлонгийн үнэн энэ байхад  
Огтхон ч айдаггүй хүмүүс гайхмаар  
Отож, мөрдөх Эрлэг байхад  
Онхид тоохгүй нь бүр ч гайхмаар.

Өвдөх, өтлөх, үхэхийн дайсныг  
Өвдөглөж дарах хэн ч байхгүй  
Өөрийн эрхгүй төрөл арилжина  
Өвчтэй юм шиг баярлах юусан.

Бас *Каникад илгээсэн захидал*-д:


Залуу ч байсан, сайхан ч байсан  
Эрлэг чамайг оровдөхгүй авна.  
Угтах зам бүхэнд отож байгааг нь  
Ухаантай мэргэд сээрэмжилж мэднэ.


Авцаат эрлэг нумаа шүүрч  
Амь нэхсэн сумаа онилох  
Агшин зуурын тэрхэн чөлөөнд  
Амжиж гүйцээ, санасан хүслээ.

Энэ талаас нь ч бас бодоорой.

### 6” Үхлээ урьдчилан таах боломжгүй

Өнөөдрөөс хойш зуун жилийн дотор гарцаагүй үхнэ.  
Гэхдээ чухам хэзээ гэдэг нь тодорхойгүй. Өнөөдөр  
үхнэ эсвэл үхэхгүй гэж итгэлтэй хэлэх боломжгүй.







Харин үхэх нь гарцаагүй гэсэн санаагаар “Өнөөдөр үхнэ” гэж бодож сурах хэрэгтэй. “Өнөөдөр үхэхгүй” эсвэл “Өнөөдөр арай үхчихгүй байлгүй” гэж найдвал энэ амьдралаа төвхнүүлэх гэсээр хойд наасны талаар санаа зовохгүй. Энэ хооронд гэнэт Эрлэг ирж аваад явахад гаслан тарчилж үхдэг. Харин өдөр бүр үхэх бэлтгэлтэй байвал хойд насанд хэрэгтэй олон зүйл амжуулдаг. Үхэхгүй ч гэсэн түүнийг хийллээ гээд муу нь юу байхав. Харин үхлээ гэхэд гарцаагүй хэрэг болно. Жишээлбэл, өөрийг чинь хорлох дайсан удахгүй ирнэ гэдгийг мэдэж байгаа гэж бодьё. Гэхдээ чухам хэзээ гэдгийг нь тодорхой мэдэхгүй бол үргэлж сэрэмжтэй байхаас өөр аргагүй. Үүнтэй л адил.

Өдөр бүр “Өнөөдөр үхнэ” гэж, адаглаад “Өнөөдөр үхэж ч магадгүй” гэж бодоод сурчихвал хойд наасаа бодож, энэ амьдралын үймээн самуунд автдаггүй. Үхнэ гэдэг бодолгүй бол энэ ертөнцөд удаан амьдрах мэтээр сэтгэнэ. Тэгээд хоногийн хоолны хойноос гүйсээр хойд насыг мартааг. Жишээлбэл, нэг газар удаан суурышихаар болвол төвхнөж эхэлдэг. Харин суурин байхгүй бол нүүж суух бэлтгэлтэй байдаг. Тиймээс өдөр бүр өнөөдөр үхнэ гэдэг бодлыг доорх аргаар бий болгоорой.

### 1” Энэ ертөнцөд амьдрах хугацаа тодорхойгүй

Уттаракуру тивийнхний амьдрах хугацаа тодорхой байдаг. Бусад тивийнхэн чухам хэд насалдаг нь тодорхойгүй ч ихэнхдээ наасаа гүйцээдэг. Замбу тивийнхний нас харин огт тодорхойгүй. Эхэндээ тоолж баршгүй удаан амьдардаг байсан. Улмаар хорогдож бүр арваадхан жилийн настай болтлоо богиносох ажээ.





Тиймээс одоо хөгшин, залуу, дунд насны хэнийг ч үхэхгүй гэж хэлэх аргагүй. Энэ тухай *Авхидхафталиса* номд:

Энэ тивийн хувыд тодорхой юм үгүй  
Эхэндээ хязгааргүй, эцэстээ арав насална.

Мөн *Цоморлиг*-т:

Өглөө таараад мэндэлж зэрсон  
Өчнөөн хүнтэй орой нь уулзахгүй  
Үдэш салсан хүмүүсийн олон нь  
Үүрээр сэрэхэд хорвоод байхгүй.

Цааш нь:


Эрчүүл, хүүхнүүд олон байлаа ч  
Идэр залуудаа ч нас барж болно  
Насны галтайд үхэхгүй мэтээр  
Найдах юм хаана байна аа.


Эхэс байхдаа ч зулбаж л байдаг  
Эхээс төрмөгцөө ч эндэж л байдаг  
Мөлхөө насандaa ч алга болдог  
Мөрөө гаргаад л арилах нь ч байдаг.

Идэр залуудаа, дунд насандaa  
Эсвэл бүр зөнөсөн хойноо  
Ээлж дараалан нөхцөж одох нь  
Эрхгүй үйлийн үрийг дагах нь  
Болц нь гүйцээд самар жимс  
Бороо шиг асгаран унахын адил аа.

Хэмээн айлдсан.

Багш болон найз нөхөд чинь гэнэт л гадна, дотны ямар нэг шалтгаанаар насны эцэст хүрэлгүй, санаснаа гүйцээж чадалгүй үхсэн тухай үзсэн, сонссонoo нэхэн





сана. Тэгээд “Би ч гэсэн энэ жамыг тойрохгүй” гэж олон дахин бодож үхнэ гэдэгтэй эвлэр.

## 2” Үхэх шалтгаан олон, амьдрах боломж бага

Энэ амьдралыг бусниулах амьтай, амьгүй олон юм бий. Хүн ба хүн бус элдэв зүйлийн ад зэтгэр байдаг. Эдгээр нь янз бүрээр хор хөнөөл учруулна. Араатны аманд ч амь насаа алдаж болно. Үүнчлэн тэдгээр нь хэрхэн хор хөнөөл учруулдаг тухай бод. Мөн бидний бие хий, гал, ус, шороо хэмээх дөрвөн махбодоос бүтдэг. Тэд хоорондоо харшилснаас бодисын тэнцвэр алдагдана. Нэг нь ихсэж ногөө нь багасна. Ингээд амь авах өвчин үүсдэг. Ийм хор хөнөөл бидэнтэй хамт төрдөг учраас энэ биедээ найдах аргагүй. Тиймээс *Agyu их нирваан* сударт:

Энэ амь биенийг үргэлж дайсан хүрээлж байдаг.  
Тиймээс хором бүр амьдрал хорогдоно, огтхон ч нэмэгдэхгүй хэмээн бодохыг үхлийн тухай ойлголт гэднэ.  
гэж бичсэн байдаг.


Мөн Нагаржунагийн *Эрдэнийн эрхи*-д:


Эрлэгийн эрхэнд урваж хорвөх  
Энэ хорвоогийн амьдрал болбоос  
Элсэн шуурганд дальдчих зултай  
Эгээ адил, эмзэг, хэврэг.

*Андаа илгээсэн захидал*-д:

Хөөж, урсгах амьдралын үер дунд  
Хөөс, цэврүү шиг эмзэгхэн байтлаа  
Амсхийж, нойрсоод гэрэлт өглөө  
Амьсгал хураалгүй сэrsэн нь зол.

*Дөрвөн зуут*-д:







Нэг нэгээрээ оршиж чадахгүй махбодууд  
Нэгдэн нийлж бие цогцсыг бүтээсэн атал  
Хоорондоо огт харшлахгүй юм шигээр  
Хоссон төсөөлбөл том эндуурэл болно.  
гэхчлэн сургажээ.

Таван муу зүйл нүүрлэсэн энэ цаг үед урт наслах, сайн үйлийн үр хураасан нь маш ховор. Ууж хэрэглэх эмний үйлчилгээ муудан, өвчин дарах чадал нь суларчээ. Хэрэглэж буй хүнс шингэц муутай болсны дээр дөрвөн махбодыг тэтгэх чадвар нь ч буурсан байна. Шингэлээ гэхэд тусаар тун бага болж. Мөн хуримтлуулсан буян өчүүхэн атал алдаа эндэгдэл ихэсжээ. Тиймээс уншсан маани тарни ч хүч багатай болижээ. Энэ бүх шалтгаанаар урт наслах нь ховордсон юм.

Амьд явах олон нөхцлөөс үхлийн шалтгаан болж урвахгүй зүйл алга. Үхэхгүйн тулд бид хоол хүнс, гэр орон, найз нөхөд зэргийг эрж хайдаг. Гэтэл хоолоо ихдүүлэх, багадуулах мөн таарахгүй юм идэж уух бодлог. Бас гэр орноо сүйтгүүлж, нөхөртөө хууртана. Ийнхүү амьдрах гэж цуглуулсан зүйл маань эргээд үхлийн шалтгаан бодлог. Нөгөөтэйгүүр амьдарна гэдэг үхэхийн тулд оршиж буй хэрэг. Тиймээс амьд явах нөхцөл олон ч тэдгээрт найдах аргагүй. Энэ тухай *Эрдэнийн эрхи*-д:

Алагдаж, үхэх шалтаг олоон  
Арай гэж таарах амьдрах завшаан ч  
Алдаж, түүнээсээ салахын шалтгаан тул  
Аврал, гэгээрлийн мөрийг л хөө.  
Хэмээсэн байдаг.





### 3” Энэ бие маш хэврэг учир хэзээ үхэхийг нь тодорхойлох aргагүй

Бидний бие усны хөөс шиг хэврэг учир хор хөнөөл сүрхий байх албагүй. Өргөсөнд хаттуулаад ч үхэж мэдэх юм. Тиймээс ямар ч шалтгаанаар хялбархан үхэж болно. *Андаа илгээсэн захидал-д:*

Долоон нар шарах цагт  
Довцог байтугай Сүмбэр ч шатна  
Догшин далай ч ууршиж арилна  
Дорд хэврэгхэн хүмүүнийг яалтай.  
Гэж хэлсэн буй.


Дээр өгүүлснийг бодсныхоо дараа Эрлэгийн эзэн амь насыг хэзээ бүрэлгэх нь тодорхойгүй, тиймээс хойшлуулалгүй одоо л номлолд суралцъя гэдэг хатуу шийдвэр ахин дахин гаргах хэрэгтэй. *Каникад илгээсэн захидал-д:*


Эрлэг хаан хэнд ч анзаарагдахгүй  
Эгшин зуур л буугаад ирэх тул  
“Ирэх маргааш” гэж хойш тавилгүй  
Эрдэм, номлолд хүчээ зориул аа.

Үйл, ажлыг маргааш гэж  
Халширч битгий хойш нь тавь.  
Үнэнийг хэлэхэд өглөө нартай  
Золгох, золгохгүйг хэн мэднэ?

Агуу их ёогч Шри Жаган Митрананда:

Хосгүй заяагаар амьдралыг эзэгнэвч  
Хорвоогоос бие зээлснээ санаад  
Эрүүл, жавхлант, тэнхлүүн цагт нь  
Эрхэм үйлийг ханатлаа бүтээж





Эцэс хойт өтлохийн цаг дээр  
Инээж суухаар буяныг амжуул.  
Эгнэгт дордож ядарсан хойно бол  
Элдэв мөрөөдөл нэрмээс л болно.  
гэхчлэн бичсэн байдал.

Энэ гурван үндэслэлийн дотроос үхлийн тааварлашгүй байдал бол сэтгэл санааг эргүүлдэг хамгийн чухал үндэслэл юм. Тиймээс энэ хэсгийг хичээнгүйлэн судлаарай.

### **в” Үхэх цагт хураасан буянаас өөр юу ч туслахгүй**

#### **1” Хэн ч тусалж чадахгүй**

Хүн нөгөө ертөнц рүү гарцаагүй явна. Үхэх үед садан төрөл чинь яаж ч харамсан гашуудаж, хайрлан өрөвдөж, тойроод зогсож байсан ч нэг нь ч хамт явахгүй.

#### **2” Хичнээн эд хөрөнгө байлаа ч хэрэг болохгүй**

Сэтгэл хоргодом их эд хөрөнгөтэй байлаа гээд өчүүхэн хэлтэрхий өвөртлөөд, аваад явж чадахгүй.


#### **3” Энэ бие хэрэг болохгүй**


Цуг төрсөн яс махаа ч орхиод одох тул бусдыг нь ярих хэрэг байхгүй биз.

Тиймээс “Энэ амьдралын сайн сайхан бүхэн надаас хагацан одно. Би ч тэр бүхнээ орхин нөгөө ертөнц рүү явах нь зайлшгүй. Бүр өнөөдөр ч үхэж мэднэ” гэж бодож бай. Тэгвэл гагцхүү хийсэн буян, сайн үйл чинь л аврал, нөмөр нөөлөг юм гэдгийг ойлгодог.

*Каникагийн захидал-д энэ тухай:*

Цогц биетэйгээ төрсөн үйлийг  
Цугийг эдэлж барлаа ч гэсэн





Цоо шинэхэн хилэнц соёолж  
Цородож үхэлд хөтлөх аюултай.

Хар, цагаан үйлийн үрээс өөр  
Хань бараа болох юм чамд үгүй.  
Авсан, олсон, учирсан бүгд  
Арилж, чамайг орхих болно.

Харин Шри Жаган Митрананда:


Эрхэм дээдсийн сан арвин ч  
Эрлэгт ямар ч хамаа байхгүй  
Эгшин зуур бүхнээс нь салгаж  
Эзэрхэн чамайг шүүх болно.


Дайнд сөхрөх шиг хамгаа алдан  
Дайсандаа баригдах мэт хүчээ баран  
Даамай амрагаа, хөвүүнээ ч орхин  
Даанч хатуугаар хагацан сална.

Эгэлдрэх хувцасгүй, садан төрөлгүй  
Эзний ширээ, харш орд ч үгүй  
Эзэрхэг баатар, дайчид ч үгүй  
Эднийхээ барааг эгнэгт харахгүй.

Ган оосроор гавлаж холболоо ч  
Ганц ч амьтан чамайг дагахгүй  
Гарцаагүй үйлийн эзэн ирэхэд  
Гарах газаргүй, хаан дээдэс ч.  
гэх зэргээр дурьджээ.

Найман завшаан, арван боломж бүхий энэ насыг олоход  
бэрх атлаа маш хэврэг, оллоо ч хялбархан үхнэ гэдгийг  
эргэцүүлэн бод. Бид хойд нас, дараа төрлийн урвашгүй  
амгаланг бүрдүүлэхийн оронд өнөө маргаашийн  
жаргал эрж, зовлонгоос зугтах гэж оролддог. Үүнийг  
хүн битгий хэл ихэнх адгуус ч дөнгөнө. Тиймээс хүн





адгууснаас эрс ялгарах үйл хэргийг бүтээх хэрэгтэй. Эс тэгвэл дээд төрөл олсон ч завшаан, боломж бурдсэн энэ төрлийг олоогүй доод төрөлтэй адилхан шүү. Энэ тухай *Бодисадвагийн замнал*-д:

Гайхам завшаан, олдошгүй боломжийг  
Гавьяа болгож буян хураалгүй  
Гавихгүй адгуус ч чадчих зугаагаар  
Ганирч, мэнэрч барах нь хайран.  
хэмээн сануулжээ.


Үхлийн талаарх дээрх ойлголтуудыг бий болгоход хэцүү. Гэхдээ зам мөрийн үндэс нь болохоор хичээх л хэрэгтэй. Бодова үхлийн тухай хэлэхдээ:


Мөнх бусыг бясалгавал бидний төөрөгдөл арилна.  
Элгэн садан, хоронгө мөнгө зэрэг энэ насны эндуурэл  
бүхнээс салгана. Хэнийг ч дагуулахгүй орь ганцаар  
нөгөө өртөнц рүү шулуухан явна гэдгийг ухааруулна.  
Ном буянаас өөр юунд ч цаг зарцуулахгүй гэсэн бодол  
бий болж, энэ амьдралтай зууралдаахаа болино. Ийм  
бодол төрөөгүй цагт номлол сургаалын зам бүхэн  
хаалттай.

Мөн Долба:

Сайн бүхнийг өөртөө цогцлуулж, алдаагаа зас. Будда  
боловд багшид тэвчээр хатуужилтай, хичээнгүйлэн  
залбир. Зуун жилд хөгждөггүй ч гэсэн бүх зүйл  
нөхцөлдөн бүтдэг болохоор надад гэгээрэх тэмүүлэл  
төрж л таарна хэмээн бод  
хэмээн захисан байдаг.

Ганбава багшаас шавь нь “Бясалгалаа солих болсон














уу” гэж асуужээ. Тэгэхэд нь “Наадхаа л давт” хэмээн хариулж. Бас “Нэмэх үү” гэхэд “Нэмэх шаардлагагүй” гэж хариулсан гэдэг.

Тиймээс оюуны чадавх хүрвэл дээр өгүүлсэн дагуу бясалга. Харин чадвар хүрэхгүй бол гурван үндэслэл, есөн шалтгааны аль тохиромжтойг нь сонгож аваарай. Тэгээд энэ амьдралтай багласан шуналын цалмыг тасартал бясалга. Үхлийн тухай санаа бодлыг цаазын тавцан руу туугдагчдийн энгэрт зүүсэн ялын пайз шиг үхэн үхтлээ тээж яв.

Мөн багш шавийн барилдлага, завшаан - боломж болон мөнх бусын тухай өгүүлсэн эрхэм зарлиг, түүний тайлбаруудыг үзэж танилц. Тэр бүхнийг өөрийн дагах заавар журам болгон судал. Тэгвэл Буддагийн үзэл санааг хялбархан ойлгоно. Бусад бүлгүүдийг ч энэ зарчмаар судлах хэрэгтэй.







X

## ХОЙД НАСНЫ АМЬДРАЛЫГ ЭРГЭЦҮҮЛЭХ

б' Хойд насны амьдралын тухай эргэцүүлэн бодох: дээд, доод хоёр төрлийн жаргал ба зовлон

1' Тамын тарчилгааг санах

а" Амьтдын агуу их тамын тарчилгаа

б" Дагавар тамын тарчилгаа

в" Хүйтэн найман тамын тарчилгаа

г" Дайвар тамын тарчилгаа


2' Адгуусны тарчилгааг санах


3' Бирдийн тарчилгаа

а' Идэж уухад нь гадны саад учирдаг бирд

б' Идэж уухад нь дотоод саад учирдаг бирд

в' Идэж уух зүйл нь саад болдог бирд





## б' Хойд насны амьдралын тухай эргэцүүлэн бодох: дээд, доод хоёр төрлийн жаргал ба зовлон

Энэ амьдралд удаан тухлахгүй, мөд үхэх нь гарцаагүй. Үхсэн ч ор мөргүй алга болохгүй дахин төрөл авна. Гэхдээ дээд, доод хоёр төрлөөс өөр гарц бас байдаггүй. Тиймээс нэг бол сайн эсвэл муу заяанд төрнө. Гэхдээ өөрийн зоргоор сонгодог юм бас биш. Харин үйлийн үрийнхээ аясаар явж хийсэн сайн, муу үйлийнхээ хэмжээнд тохирсон заяанд төрнө. Тиймээс “Хэрвээ би муу заяанд төрчихвэл ямаршуухан байх бол?” гэж бодон муу заяаны тарчилгааг эргэцүүлэх хэрэгтэй. Хутагт Нагаржуна:


Халуун болоод хүйтэн тамын  
Халаах, хайрах зовлонг сана.  
Хармын зовлонт бирд төрлийн  
Хатах, өлсөхийн шаналанг сана.


Тэнэг төрсондое эдлэх үйл нь  
Тэгнэсэн ачаанаас нь хол давсан  
Адгуус амьтны төрлийн зовлонг  
Алхам тутамдаа бас сана.

Адгуус төрөлд унах шалтгааныг  
Алгасч бас болох замыг  
Алхам бүртээ санаж сэрэмжил  
Алс хэтийн мөрдлөг болго.

Замбутивд хүн болсны  
Зая золтой энэхэн чөлөөнд  
Адгуус төрөлд унах шалтгийг  
Арилгаж, цэвэрлэж замаа засаарай.  
хэмээсэн билээ.

Бүх орчлонгийн, ялангуяа муу заяаны зовлонг бясалгавал их тустай байдаг. Ингэж өөрөө зовлонгийн






далайд живж буйгаа бясалгавал жихүүдэс төрдөг. Мөн ихэрхэл, омогшил алга болж зовлон бол нүгэл хилэнцийн үр дагавар гэдгийг ухаарч алдаа эндэгдэл гаргахаас ихэд болгоомжилно. Хэн бүхэн зовлонг бус жаргалыг хүсдэг болохоор жаргал бол зөв дадлын үр шим гэдгийг ойлгож, зөв дадал төлөвшүүлэх урам зориг нэмэгддэг. Өөрийн зовлонг мэдрэхийн хэрээр бусдыг энэрэх сэтгэл бий болно. Мөн орчлонгоос залхан нирваанд хүрэх эрмэлзэл төрдөг. Зовлонгоос айн жихүүцэж, Буддагаас чин сэтгэлээсээ аврал эрдэг. Хойд насны тухай бясалгал нь энэ мэт олон талын ашиг тустай билээ. Энэ тухай *Бодисадвагийн замнал*-д:


Эрх биш зовлон байгаагүй бол  
Эрх чөлөөг юундаа хүсэх вэ?  
Эмгэг өвчин тусаагүй бол  
Эдгэх гэж яласандаа ч бодох вэ?  
Иймийн учир сэтгэл минь чи  
Эрх биш жаахан тогтох хайрла аа.

мөн цааш нь:

Барцад зовлон хортой, халтай ч  
Бардам дээрэнгүйн омгийг дардаг.  
Балмадаа жигшиж, энэрэхийг ухаарвал  
Баясгалант үйлийг урамтай хийдэг.  
Аиж балмагдаж зугтаахын эрхэнд  
Аврал ивээл хайхын эрхэнд  
Аврагч Самандбадра бурханы өмнө  
Алд биеэ өргөн тушаана.  
Хэмээн айлдсан юм.

*Бодисадвагийн замнал*-ын дээрх хэсэгт өөрөө мэдэрсэн зовлонгийн талаар өгүүлжээ. Гэхдээ хойд насны





зовлонтой зүйрлүүлэн бясалгахад болохгүй нь юу байхав. Амсах зовлон нь адилхан шүү дээ.


## 1' Тамын тарчилгааг санах


### а" Амьтдын агуу их тамын тарчилгаа

Эндээс гурван түм хоёр мянган багцадын дор Дахин амилах там бий. Түүнээс доошоо дөрөв дөрвөн мянган багцадын зйтай бусад долоон там байдаг. Тэдгээр найман тамын анхны, Дахин амилах тамын амьтад тал бүрээс цуглана. Тэгээд үйлийн үрээр бий болсон элдвийн мэсээр бие биенээ ээлжлэн сүлбэдэг. Ингээд бүгд муужран газар унацаана. Тэр үед огторгуйгаас “та нар дахин амилагтун” гэдэг дуу гарна. Тэгэхэд дахин амилж урьдын адил хатгалдана. Ийнхүү хэмжээлшгүй их зовлон эдэлдэг.

Хар шугамт тамын сахиулууд энд төрсөн амьтныг дөрвөлжин, найман өнцөгт зэрэг олон янзаар хуваахаар бие дээр нь хар шугам зурна. Тэгээд татсан шугамаа дагуулан мэсээр зүсэхэд амьтад зовдог.

Бөөгнүүлэн няцлах тамын сахиулууд амьтдыг нэг дор хураан бөөгнүүлнэ. Улмаар ямааны хошуу шиг төмөр уулын завсар шахан оруулна. Тэр даруй нөгөө хоёр уул шахан няцалдаг. Энэ үед амьтдын есөн сүвнээс нь цус гол мэт урсана. Мөн хонь, адуу, заан, арслан, барын хоншиор шиг хадаар шахаж няцална. дахиж амилуулан цуглуулаад том төмөр хурдэнд оруулан арвай шиг бяцална. Дараа дахин цуглуулж дээрээс нь төмөр бул унагана. Мөн төмөр дэвсгэр дээр таслах, хуваах, нүдэх, бяцлах зэргээр тарчилган зовоодог. Тэдний цус мөн л гол мэт урсана.






Гаслан ёолох тамын амьтад хоргодах газар эрж хайсаар төмөр байшинд орцгоноо. Оронгуут нь тал бүрээс нь улалзсан гал дүрэлзэн шатаадаг.


Ихэд гаслан ёолох там өмнөхтэй адил бөгөөд хоёр давхар байшинаараа ялгаатай.

Халуун тамын сахиулууд тэндхийн амьтдыг улайдан халсан олон багцад хэмжээтэй төмөр саванд хийж буцалгаад дараа нь загас шиг шардаг. Мөн улайссан төмөр ширхэгийн орчингоор нь сүлбэн, зулайгаар нь гаргана. Тэгэхэд ам, нүд, чих, ширхэгийн бүх сүвээр нь оч гардаг. Бас улайссан төмөр хавтан дээр дээш дооши нь харуулан хэвтүүлж гал дүрэлзсэн төмөр алхаар нүдэж балбан тарчилгана.

Маш халуун тамд гурван үзүүртэй сэрээ өтгөний сүв рүү нь сүлбэн оруулина. Сэрээний зүүн, баруун үзүүр нь хоёр мөрөөр, голынх нь зулайгаар гарч ирдэг. Тэгэхэд есөн сүв бүхнээс нь гал дүрэлзэнэ. Маш их халж улайссан төмөр хавтанд ороондо. Зэс буцлан үсчих том тогоонд толгойг нь уруу харуулан хийн чанаж дээш дооши, нааш цааш хөдөлгөн хутгана. Энэ үед арьс, мах, цус нь угүй болж зөвхөн араг яс л үлддэг. Тэгэхээр нь гаргаж улайдсан төмөр вандан дээр дэлгэнэ. Ингээд арьс, мах, цус нь дахин бүрэлдэж бий болонгуут эргүүлэн чанадаг. Бусад нь халуун тамтай адилхан.

Амсхийх чөлөөгүй аюус тамд эхлээд зуун багцадын цаадтайгаас их гал дүрэлзэн ассан газар дорно зүгээс ирдэг. Тэр их галд тамын амьтдын арьс, мах, судас, шөрмөс, яс бүгд ээлж дараалан чөмгөндөө тултал шатна. Бүх бие нь зулын гол шиг гал дүрэлзүүлэн асна. Бусад гурван зүгээс мөн л дээрхийн





адил гал дүрэлзсэн газар ирнэ. Тэгээд нэгэн дор нийлэн, амсхийх чөлөөгүй тарчлан зовдог. Энэлэн шаналах дугаар нь л амьтан байна гэдгийг мэдэж болно. Мөн хавтгай төмөр сараалжтай, галын улаан цогтой зууханд бужиглүүлнэ. Бас том төмөр уул өөд авируулж, буулгана. Үүний зэрэгцээ хэлийг нь гаргаж үхрийн ширшиг толийтол тэнийлгэн, төмөр гадсаар тэлэн хадна. Мөн төмөр дээр гэдрэг нь харуулан хэвтүүлээд төмөр бахиар амыг нь ангайлгаж улайссан төмөр бөмбөлөг хийнэ. Буцалмал зэс амаар нь цутгахад ам, хоолой, гэдэс дотрыг түлж, шатаагаад хошногоор нь гардаг. Бусад нь маш халуун тamtай адилхан.

Тарчилгааны нэгээхэн хэсгийг нь тоймлон узүүлбэл ийм юм. Өөр олон янзын зовлон бий. Байр байдал болон амсах тамлалыг *Төвшний тодорхой үндэслэл*-ийн дагуу дурьдлаа. Эдгээр тарчилгааг хэр удаан амсах тухай *Андаа илгээсэн захидал*-д:

Саяны өгүүлсэн тамын зовлонг


Сая живаа жилээр ч эдлэнэ.


Атгаг буруугийнхаа үрийг дуустал

Амь нь тасрахгүй тарчлах болно.

Гэж дурьдсан юм.

Энд өгүүлснээр үйлийн үр барагдаж дуустал тарчлан зовох ажээ. Хүний тавин нас нь Дөрвөн Махранз тнгэрийн хувьд нэг хоног юм. Ийм гучин хоног нь нэг сар болно. Арван хоёр сар нь нэг жилд тооцогдоно. Энэ тооллоор Дөрвөн Махранз таван зуун жил насалдаг. Харин үүнийг нэг өдөрт тооцоод гуч хоног нь нэг сар, арван хоёр сар нь нэг жил болж таван зуу хүрэхэд Дахин амилах тамын нэг өдортэй тэнцэнэ. Энэ





мэтчилэн хүний насаар тэнгэр зуу, хоёр зуу, дөрвөн зуу, найман зуу, мянга зургаан зуун жил дараалан Гучин гурван тэнгэрээс эхлээд Бусдад хувирагч тэнгэрүүд хүртэлх бусад тэнгэрийн нэг хоногтой тэнцдэг. Тэнгэрүүд өөрсдийн хэмжээгээр нэг мянга, хоёр мянга, дөрвөн мянга, найман мянга, нэг түм зургаан мянга хүртэл насална. Харин энэ хугацаа Хар шугамтаас Халуун тамыг хүртэлх тамын амьтан бүрийн нэг өдөртэй адил. Ингээд тамын өөрсдийнх нь тооллоор нэг мянгаас нэг түм зургаан зуун мянга хүртэл хугацаагаар үргэлжилж болно. *Аехидартаакошад* энэ тухай:


Хүний хорвоогийн хагас зуун  
Хүсэлт тэнгэрийн хоногтой тэнцэнэ  
Хүсэлт тэнгэрийн түвшин доогуур  
Хүнээс жаахан дээхнүүр төдий.


Дээд тэнгэрийн нэг хоног  
Дэлхийн бидний зуунтай тэнцүү  
Хүнд зургаан тамын хоног  
Хүслийн бурхадын настай тэнцүү.

Догшин, хатуу тамын хугацаа  
Доод тэнгэрийн нас шиг урт аа  
Маш халуун тамын нас  
Магад хагас галав болно.

Амсхийх чөлөөгүй там харин  
Дунд галвын настай болно  
Аяа хөөрхий нүтэл үйлдвээс  
Дуусахын эцэсгүй нажидаа эдлэнэ.  
гэж дүрсэлсэн байдаг.

## 6” Дагавар тамын тарчилгаа







Дээр өгүүлсэн найман там тус бүр дөрвөн талдаа нэжгээд хаалгатай. Гадуураа дөрвөн хаалга бүхий төмөр хашаагаар хүрээлэгдсэн байна. Хаалга бүр нь дөрөв дөрвөн дагавар тамтай холбогдоно. Тэдгээр там нь: Галт нурам, Өмхий хүүрэн балчиг ба баас шээсэн намаг, Хутга мэсэн зам, Хөлгүй нуур юм.

Эхний нь өвдгөнд тулсан галт нурам. Хоргodoх газар хайсан амьтад хөлөө дүрэхэд бүх арьс, мах, цус нь түлэгдээд татан авахад дахин ургаж төлждөг.

Түүнтэй зэргэлдээ хүүр шиг өмхий баас шээсэн намаг байдаг. Хоргodoх газар хайсан амьтад түүнийг гатлахаар ороод хоолойгоо тултал шигдэнэ. Энэ намагт шорон хошуут хэмээх хорхой амьдардаг. Тэд шигдсэн амьтдын арьс мах, гэдэс дотор, яс үсийг нүхлэн чөмгөнд нь тултал цоолдог.

Энэ намагтай зэргэлдээ хутганы ирийг дээш харуулсан зам байна. Хоргodoх газар хайсан амьтад түүн дээгүүр гүйхдээ бүх арьс, мах, шөрмөсөө хэрчүүлдэг. Дээш өргөхөд нь дахин эдгэрнэ. Түүний цаана илдэн навчтай мод бүхий ой бий. Нөмөр хайсан амьтад ойд орж, сүүдэрт суухад модноос илд унаж эд эрхтнүүдийг нь тасдан хаяна. Мөн газар унавал төмөр нохой ирж хойноос нь тасдан иддэг. Эндээс цааш Шалмали хэмээх төмрөн модтой цэцэрлэг бий. Хоргodoх газар эрсэн амьтад тэнд очиж өнөөх мод руу авирна. Дээшээ авиаах үед хурц өргөсний үзүүр нь доошоо харна. Харин буух гэхээр дээшээ харж бүх эд эрхтнийг нь эсгэн зүснэ. Мөн тэнд төмөр хошуут хэмээх хэрээ бий. Тэр хэрээнүүд мөр, толгой дээр сууж нүдний цөцгийг нь ухаж иддэг. Энэ гурван тамлал мэсээр тамлах адил боловч нэгэн зүйл тамд тооцогддог юм.






Шалмали цэцэрлэгийн цаахна буцламгай хорт шүлтээр дүүрсэн хөлгүй мөрөн байдаг. Хоргodoх газар хайсан амьтад тэнд орж дээш доош оволзон чанагдана. Зүйрлэбэл ширүүн гол дээр вандуй чанахтай л адил. Энэ мөрний хоёр эрэг дээрх гартаа гох дэгээ, тор, хаттуур барьсан сахиулууд эрэг рүү гаргахгүй буцаан түлхдэг. Гадагшаа гарвал дэгээ, тороор татан улайдсан том газар гэдрэг нь харуулан хэвтүүлнэ. Тэгээд “Хүсэх юм байна уу” гэж асуудаг. Амьтад “Бид юу ч мэдэхгүй, юу ч харахгүй байна. Харин их өлсөж цангаж байна” гэхээр нь улайдсан төмөр бөмбөлөг болон буцалмал зэс ам руу нь цутгана.


Энэ бүхнийг *Төвшингийн тодорхой тайлбар*-т заасан дагуу дурьдлаа. Уг номд дагавар, дайвар хоёр тамын үргэлжлэх хугацаа тодорхой бус гэжээ. Гэхдээ эдгээр зовлонг эдлэх үйл лайгаа барагдтал эдгээр тамд тарчлан зовох болно.

### **в” Хүйтэн найман тамын тарчилгаа**

Хүйтэн найман там Амьтны агуу их найман тамтай нэгэн төвшинд гэхдээ нэг түмэн багцадын цаана оршино. Замбутивээс гурван түм хоёр мянган багцадын доор Цэврүүт хэмээх там бий. Түүнээс доош хоёр, хоёр мянган багцадын зйтай бусад долоо нь байгаа.

Цэврүүт тамд маш хүйтэн жаварт хайрагдан бүх бие цэврүүтэж, агшдаг. Цэврүү хагарах тамд цэврүү нь хагарч, бие нь бүр илүү агшдгаараа ялгаатай. Шүд хавших, Аа тий тий, Аа чу тамуудыг тэндээс гардаг дуугаар нь нэрлэжээ. Удвал мэт задрах тамд тэсгэм хүйтэн жаварт хайрагдан арьс нь хохөрч, бие нь таваас зургаан дэлбээ болон зад хөлдөнө. Лянхуа мэт задрах





тамын ялгаа нь арьсны хөх өнгө нь улмаар улайж, арав буюу түүнээс ч олон дэлбээ маягтай задран хөлдөг. Улаан лянхуа мэт задрах тамын онцлог нь арьс маш их улайж, зуу юм уу түүнээс ч олон дэлбээ болон зад хөлдөнө. Эдгээр тамуудын шинж төрх, дараалал болон амсах тамлалыг мөн *Төвшигийн тодорхой тайлбар*-аас авсан болно. *Төрөл туулсан цадиг-т* хүйтэн тамд харанхуй байдаг тухай ийн өгүүлдэг:

Үйлийн үрийг үгүйсгэгчид хойд насандаа  
Үлэмж хүйтэн, түнэр харанхуй тамд төрнө.  
Өвдөж зовон, хөлдөж царцан зовлон руу  
Өөрөө гүйгээд очдог хэн байх билээ дээ?

#### Мөн *Шавьдаа илгээсэн захидал-д*:

Голдоо ортол ян хөлдөж  
Гон биеэрээ хүйдэс болно.  
Эсвэл бие цэврүүтэж, хагарч  
Идээ, чөмөг, пус савирна.


Эрүү, ам нь тас зуурч  
Эрүүл үс халзарч, мулзарна.  
Харах нүд, хамар, хоолой  
Хaa сайгүй хатгуулж өвдөнө.


Бие сэтгэл давхар тарчилж  
Бархирч гаслах аймшигт чимээ  
Хүний сэтгэлд багтамгүй энэлэнт  
Хүйтэн тамын дуу, чимээ.

Гэсэн байдаг юм.

Хийсэн муу үйлийн үр барагдаж дуустал ийм тарчилгаа амсах ёстой. *Төвшигийн тодорхой тайлбар*-т:

Амьтдын хүйтэн тамд байх хугацаа нь Их тамын





харгалзах амьтдаас хойш хойшдоо хагас хагасаар хасагдана.  
гэж дурьджээ.

Харин судруудад *Ахидхармакошагийн тайлбар*-ын доорх ишлэл элбэг таардаг:

Хуврагууд аа. Жишээ авьяя. Магадха нутгийн бүх үр тариаг наян хоёр нуруу болгон овоолжээ гэж төсөөл. Тэндээс зуун жилд ганц ширхэгийг нь авна гээд бодоод үз, хуврагууд минь. Харин Цэврүүтэд төрсөн амьтны насны тоо хэд хүрэхийг би хэлж мэдэхгүй. Магадхагийн наян хоёр нуруу тариаг ширхэг ширхэгээр нь зөөх нь хавьгүй хурдан. Хуврагууд аа, Цэврүүтийн ийм хорин жил Цэврүү хагарах тамын нэг жилтэй тэнцэнэ.

гээд цааш бүр тодруулж:


Хуврагууд аа. Лянхуа мэт задрах тамын хорин жил Лянхуа мэт их хагарах тамын ганц жилтэй дүйнэ. гэсэн байдаг билээ.


Ийм хугацаанд Хүйтэн тамд байх ажээ.

#### г” Дайвар тамын тарчилгаа

Энэ там Халуун, Хүйтэн тамын ойр хавьд байна. Мөн хүний ертөнцөд ч бий гэж Төвшингийн тодорхой тайлбар-т өгүүлдэг. Ёс зүйн судар-т их далайн эрэгт ойрхон байдаг гэжээ. Сангхафакшинаагийн тууж-д өгүүлсэн зүйл үүнтэй тохирдог юм. Абхидхармакошагийн тайлбар-т:

Энэ арван зургаан там нь тэдгээр амьтдын үйлийн





үрээр бий болсон. Харин Дайвар там нь олон буюу нэг, хоёр амьтны үйлээс үүсдэг юм. Түүний шинж төрх нь өвөрмөц, олон янз. Хаана ч байж болно. Гол мөрөн, уул нуруу, тал хээр болон өөр бусад газар, бүр газар доор ч байна.

Дээр өгүүлснээр тамд төрөх шалтгаан маш амархан үүсдэг ажээ. Бид өдөр тутам тамд төрөх олон шалтгаан хуримтлуулдаг. Бас урьд нь бий болгочихсон шалтгаан тоо томшгүй бий. Тэгэхээр сэтгэл амгалан сууж таараахгүй. Харин энэ бүхнийг эргэцүүлэн эмээж явах хэрэгтэй. Эдгээр тاماас бид зөвхөн амьсгалахын төдий зйтай амьдарч байна шүү дээ. Энэ тухай *Бодисадвагийн замнал-д:*


Аюус тамын болзол хангачихаад  
Амгалан, жаргалтай сууж болох уу?


*Андаа илгээсэн захидал-д:*

Амьд тулдаа арай ч очоогүй  
Аюус тамд унахад нүгэлтэн  
Аймшигт тарчилгааг нь дуулсан хэрнээ  
Айхгүй бол чулуун зүрхтэн үү?

Тамын тухай зураг харж, үнэнийг мэдэж  
Тамтаггүй энэлэл гэсгээлийг нь дуулахад  
Айдас жихүүдэс биеэр дүүрнэ  
Амсах эдлэхийг санаахын ч эцэсгүй.  
Гэхчлэн өгүүлсэн байдаг.

Энэ орчлонгийн зовлон дундаас муу заяаны зовлонг давахад бэрх. Харин тэр дотроос тамын зовлон тэсвэрлэшгүй хээцүү. Тамын шалихгүй зовлонтой харьцуулахад нэг өдөр хурц мэсээр гурван зуун





удаа сийчүүлэх юу ч биш. Амсхийх чөлөөгүй тамын тарчилгаа бусдаасаа ч аймшигтай байдаг. *Анддаа илгээсэн захидал-д:*


Жаргаж суугаа олны дундаас  
Жаргалангийн эзэнг асууж сурхад  
Шунах сэтгэлэсээ л салсан болгоныг  
Шуудхан зааж өгнөм билээ.  
Ай хөорхий зовлон дундаас  
Амсхийх төдий чөлөө ч гарахгүй  
Амьсгaa дарах агшин ч өгөхгүй  
Адаг доод там шиг нь үгүй.


Энэ яваа төрөлдөө бид  
Ирт мэсээр одор болгон  
Өдөрт гурвантаа зуун удаа  
Өвч сүлбүүлэх хажууд нь тоглоом.

Нэгэн өдрийн гурван зуун шарх  
Тамтай жишихэд юу ч биш  
Тэнд эдлэх нажид зовлонгийн  
Нэгээхэн хувьд ч хүрэх нь үгүй.  
Хэмээн өгүүлсэн байдаг.

Энэ бүх зовлонг эдлэх болсон шалтгаан нь зөвхөн бидний бие, хэл, сэтгэлийн алдаа эндэгдлээс өөр зүйлээс үүсээгүй гэдгийг ойлгож авагтун. Тиймээс очижүүхэн ч алдаа эндэгдэл гаргахгүйн төлөө бүх чадлаараа мэрийх хэрэгтэй. Дээрх номд ийн өгүүлдэг юм:

Аюус там руу чөтгөр гэхээсээ  
Амаар үйлдсэн нүгэл чинь хөтлөнө  
Бирдийн төрөл рүү шулам гэхээсээ  
Биеэр үйлдсэн нүгэл чинь чирнэ.





Доод төрөл рүү дайсан гэхээсээ  
Дотор сэтгэлийн нүгэл чинь зална  
Үүрдийн там руу эрлэг гэхээсээ  
Үйлдсэн хар үйлийн үр чинь тууна.

Муу үйл үртэйг сана,  
Мунхарсан сэтгэл хилэнцтэйг бод,  
Алд биеийн хилэнцээс булз,  
Амаар тарих нүглээс булт.

## 2' Адгуусны тарчилгааг санах


Хүчтэй нь хүчгүйгээ барьдаг нь адгуусны авир ёс.  
Мөн тэнгэр болон хүнд эдлүүлэх нь тэдний тавилан.  
Адгуус өөрийн гэсэн мэдэлгүй үргэлж л бусдын эрхэнд  
байдаг. Тиймээс зодуулж, алуулж, хорлогддог. Адгуус  
нь тэнгэр ба хүнтэй хамт байдаг бусад газар байхгүй  
гэж *Төвшигийн тодорхой тайлбар-т* өгүүлжээ.  
*Абхицхафракошагийн тайлбар-т:*


Адгуус бол хээр тал, гол ус, огторгуйд зорчигсад.  
Тэдгээрийн ихэнх нь том далайд орших бөгөөд  
тэндээс тархсан юм.  
Гэж тэмдэглэжээ.

Мөн *Садангийн захидал-д:*

Адгуус төрөлтний зовлон нэт  
Алуулах, эдлүүлэх, зодуулах мэт.  
Амгалант төрлөөсөө дутаасан тэд  
Аль алийгаа идэлцэхийн лайтай.

Эрдэнэ болдог сувдан яр  
Илбэхэд таатай сорлог үс  
Элдүүр даах арьс, хөрс  
Идэхэд сайхан гэх улаан мах.







Адгуус төрөлтэй хөөрхий тэдний  
Амиа алдах шалтгаан болно.  
Амьд үлдлээ ч ажлын мал болж  
Амгай, ташуур, буулганд сохөрнө.  
хэмээсэн байdag юм.

Энэ шүүлгийн эхний бадагт адгуусны зовлонг ерөнхийд нь илэрхийлжээ. Харин хоёр дахь хэсэг нь тухайн нэг зүйлийг дүрсэлсэн байна. “Эдлүүлэх, зодуулах” гэдэг нь уналга эдэлгээнд дөрлүүлнэ гэсэн санаа юм. Мөн хүн болон хүнээс бусад нь ч алж төхөөрдгийг давхар харуулжээ. “Аль алийгаа идэлцэх” гэдэг нь адгууснууд бие биедээ зовлон учруулдгийг үзүүлсэн байна. “амгалант төрөл” гэдэг бол нирваанд хүргэх зөв дадал юм. Харин тэнэг, мулгуу учир гэгээрлийн сургаал ойлгоогүй гэдэг санааг “дугаасан тэд” хэмээн илэрхийлжээ. Морь, шар, одос, илжиг, заан уналга ачлаганд хэрэглэгдэг гэсэн санааг “амгай, ташуур, буулганд сөхөрдөг“ гэсэн байна. Эдгээр тайлбарыг *Анданаа илгээсэн захидалын тайлбар*-аас авлаа.

Үүнээс гадна адгуус нь харанхуйд эсвэл усанд төрдөг. Тэгээд тэндээ өтөлж үхнэ. Хүнд ачаа зөөне, анжсанд хөллүүлж, үс ноосоо хяргуулна. Бас хөөгдөн мөшгүүлж, элдвээр тарчлуулан алуулдаг. Адгууснууд өлсөж цанган, халуун хүйтэнд зовно. Анчид зүйл бүрийн аргаар амийг нь хороодог. Тиймээс үргэлж айж түгшинэ. Адгуус ингэж зовдгийг эргэцүүлэн бодож жигшин, орчлонгоос ангижрах сэтгэл шулуудах хэрэгтэй.

“Адгуус хамгийн ихдээ ганц галав наслана” гэж *Абхидармакоша*-д дурьдсан байдаг. Энэ бол хамгийн





урт настай адгуус нэг галав амьдрна, харин хэр богинохон наслах нь тодорхой биш гэсэн үг юм.

### **3' Бирдийн тарчилгаа**

Хэтэрхий харамч хэн ч байсан бирд болж төрне. Бирдүүд өлсөж цанган зовдог. Бүх арьс, мах, цус нь хатчихсан байдаг. Шатсан хожуултай их төстэй бас нүүрэндээ үстэй. Ам нь үргэлж цангаж, хэлээрээ уруулаа байнга долоож явдаг. Бирд нийт гурван төрөл байна:

#### **а' Идэж, уухад нь гадны саад учирдаг бирд**

Энэ бирдүүд булаг шанд, нуур цөөрөм рүү тэмүүлнэ. Харин гартаа илд, жад, хутга барьсан амьтад булаг шанданд ойртуулахгүй хөөнө. Уяа гэсэн ч тэр ус өөрт нь цустай идээ бээр болон харагдаж уухаа болино.


#### **б' Идэж, уухад нь дотоод саад учирдаг бирд**


Энэ бирдүүдийн ам нь зүүний сувэгч шиг атал цурдийсэн том гэдэстэй бас амандаа уртай тул амаа ангайж явдаг. Идэж уухад нь гадны саад байхгүй ч олсон хоол ундаа идэж хэрэглэж чаддаггүй юм.

#### **в' Идэж, уух зүйл нь саад болдог бирд**

Энд идсэн, уусан бүхэн нь гал болон асаж, гэдэс дотор нь түлэгддэг Галан эрхит бирд багтана. Мөн Балчиг идэшил хэмээх баас шээсээр хооллодог бирд ч бий. Тэд зөвхөн илжирсэн, муудсан, хордсон хоол иддэг. Зарим нь бүр өөрийнхөө махнаас тасдан идиэ. Эд бүгд ариун сайхан хоол, унд хэрэглэх чадваргүй. Бирдийн орны тухай *Абхидахармакошагийн тайлбар*-т:

Бирдийн хааныг Яама гэнэ. Энэ орон Замбутийийн





доор, Ражагрихи хотоос гурван зуун багцадын доор  
оршдог. Бусад нь эндээс үүсэн бий болсон.  
гэсэн байдаг юм.

### Мөн *Анддаа илгээсэн захидал-д*:

Дуусахгүй шуналдаа хөтлүүлсэн бирд  
Дундрахгүй тэр зовлонгоосоо гадна  
Үүрдийн өлсгөлөн, ангах, айх, ядрах  
Үлэмж барагдашгүй шаналал эдэлнэ.

Тогоон чинээ гэдэстэй ч гэсэн  
Тоос ч орохгүй нарийн хоолойтой  
Идэш уushiны уртэс олсон ч  
Идэж, залгиж чадахгүй зовно.


Ясан хэдрэг шиг зарим бирд  
Яг зулбадас шиг улаан нүцгэн  
Хатсан борц шиг тэдний зарим нь  
Хамар амнаас нь гал гарна.


Амьсгааны оронд хэвэл цээжээс нь  
Ассан гал цоролзоод байтал  
Амандаа хоол хийх гэж зарим нь зүтгээд  
Амхруус, хомхруус болгож хаяна аа.

Бирд дотроо дорд заримд нь  
Бузар юмс, бээр ч олдохгүй ээ  
Бие биесээ урж шархлуулаад  
Бээр идээг сордог нь байнам.

Билгийн аргын хуанлийн улирал  
Бирдийн оронд огтоос хамаагүй  
Алиман саран дор ч ангаж хатна  
Алтан наранд ч хөлдөж осгоно.

Хамаг амьтныг тэжээн тэтгэгч  
Хатан дэлхийн шим ч хүртээлгүй





Хавьтсан газрынх нь жимс хувхайрч  
Харсан булгийнх нь ус ширгэнэ.  
Хэмээн дурьдсан байdag.

Энэ шүлгийн эхний бадагт бирдийн зовлонг ерөнхийд нь үзүүлсэн байна. Харин бусад хэсэгт зүйл бүрээр нь дурьджээ. Үргэлж хоол эрж хайдаг учир “ядарна”. Мөн усанд ойртуулахгүй илд, жад, цалам барьсан амьтдыг хараад “айдаг” юм. “Бузар юм” гэж хоолны хаягдлыг хэлжээ. “Шөнө” амнаас нь гал гарч гал дүрэлзсэн хоол иддэг. Нүдний харц нь хорт нөлөөтэй учир харахын төдийд л сэруүн сайхан гол горхийг ширгээчихдэг. Зарим нэгэнд нь гол горхи галт лав шиг харагдана. Нөгөөд нь зүсэн зүйлийн өт хорхой, идээ бээр урсаж байгаа мэт харагддаг ажээ.


*Шавьдаа илгээсэн захидал-д бирдийн тухай:*


Шазайтлаа цангасан нүгэлт бирд  
Шанд голын ус үзнэ ээ  
Шалавлан очоод залгилъя гэхээр  
Шал өмхий балчиг болно oo.

Зандан модот Малая хайрхан  
Зам хөндөлдөн ногоорон байлаа ч  
Ойртохын хэрд түймэрт идэгдэж  
Огтоос шимгүй нурам үлдэнэ.

Давалгаа элдэж, наранд мяралзах  
Далай нуур өмнө харагдавч  
Даруй түргэнээ цөлжин хувхайрч  
Далан элстэй.govь болчихно.

Үүл хуралдавч борооны оронд  
Үнс нурамтай чулуу орно





Аадрын оронд гал бууж  
Аянгын эзэн зэвээр харвана.

Халууцах үйлтэй зарим бирд  
Хахир өвлийн цасанд хатна  
Харин нөгөө даарах үйлтэй нь  
Халцгай, түлцгэй түймэрт осгоно.

Буяны оронд хилэнц үйлдэж  
Буруу үйлээр заняа эргэхэд  
Буй юмны сайхан нь хүртэл  
Буруугаар эргэдэг ийм учиртай.


Зүйргүй цүндгэр гэдэстэй ч гэлээ  
Зүүнээс нарийн хоолойтой бирд  
Ангахын цагт гадаад далайг ч  
Аливхийн залгимаар цангах билээ.


Хоолой нь цаанаа том байгаад  
Ховх сорлоо ч далайн усыг  
Ходоод гэдэс рүү нь юу ч орохгүй ээ  
Хортой ам нь усыг хатаачихна.  
гэж өгүүлсэн байdag.

Эдний хэрхэн тарчилдгийг сайн бодоод үзээрэй.  
Насны хэмжээг нь *Төвшингийн тодорхой тайлбар* ба  
*Абхицхарлакоша*-д хүний нэг сар бирдийн хувьд нэг  
хоног. Ийм өдрөөс бүтэх таван зуун жил насладаг гэсэн  
байdag. Мөн *Анддаа илгээсэн захидал*-д:

Алдаа энđлийн цалманд уяатай  
Адаг төрөлтний зовлон дусахгүй  
Арван таван мянган жилийг  
Ардаа орхисон ч хөгширч үхэхгүй.  
гэж айлдажээ.

*Анддаа илгээсэн захидалын тайлбар*-т зарим бирд таван







мянга, нөгөө нь нэг түм насладаг гэсэн байдаг. Мөн Төвийнгийн тодорхой тайлбар-т гурван муу заяаны биесийн хэмжээ нь янз бүр. Гагцхүү муу үйлийн үрээсээ хамааран том, жижиг байдаг тухай өгүүлжээ.

Муу заяаны зовлонг дараах байдлаар төсөөлөн бод. Галтай нурманд гарцаа шургуулж ганц нэг хоног суух, өвлийн хүйтэн жаварт мөсөн хонгилд хувцасгүй өнжих, хэдэн өдөр хоол ундгүй явах, зөгий хэдгэнэд байж ядтал хатгуулах энэ бүхэнтэй жиши. Гэтэл халуун, хүйтэн там, бирд болон нэгэн нэгнээ барьж иддэг адгуусны зовлонг би яаж тэсэх билээ гэж айdas жихүүдэс төртөл нь бясалгах хэрэгтэй. Муу заяаны зовлонг мэдэж байгаа хэдий ч сэтгэлдээ дасал болгохгүй эсвэл богино хугацаанд бясалгавал төдийлон хэрэг болохгүй. *Ёс зүйн судар-т:*

Анандагийн хоёр зээ дүү тойн болж номлол үзэх болжээ. Тэдэнд уншуулахаар ном өгч гэнэ. Гэтэл ганц хоёр өдөр уншаад залхууран орхижээ. Тэгэхээр нь Маудгальянд хүргэж өгсөн боловч мөн урьдын адил залхуудаа дийлдэв. Гэтэл Ананда “Наад хоёрыгоо хашраа” гэж Маудгальянд хэлж гэнэ. Тэгэхэд Маудгальян Амьтны тамыг ид шидээр бүтээж, нэг өдөр тэр хоёрыг түүгээр дагуулан явж, хэрчүүлэн, тасчуулан ёолох дууг сонсгож гэнэ. Огтчуулан тарчлахын зовлонг ч харуулав. Улайдан буцалж байгаа хоёр том ширмэн тогоог ч харуулжээ. Нөгөө хоёр “Энэ тогоонд хэнийг хийх вэ?” гэж асуужээ. Тэгэхэд нь “Анандагийн хоёр зээ тойн болчихоод залхуурч, цагаа дэмий үрж байгаа учир үхээд энд орно” гэж хариулав. Тэр хоёр маш балмагдан “Хэрвээ







биднийг таньчихвал одоо хийчихнэ” гэж бодоод Маудгальяны дэргэд гүйж очив. Тэгээд өөрсдийн бодлоо хэлж гэнэ. Тэгэхэд Маудгальян “Хоёр хувраг минь, энэ болон бусад зовлон залхуугийн гай тул хичээх хэрэгтэй” гэжээ.

Ингээд мань хоёр ч идэвх зүтгэлтэй болж гэнэ. Бүр хоол идэхээс нь өмнө там бодогдвол идэж чадахгүй, идсэнийх нь дараа бодогдвол огиж гаргадаг болов.

Дараагийн удаа тэнгэрийн орныг рид хувилгаанаар бий болгож тийш нь дагуулан явав. Тэнгэрийн уянгалаг ятга эгшиглэх ордон руу очигоолоо. Тэнд нь дүүрэн дагинас байх бөгөөд нэг ч тэнгэр байсангүй. Нөгөө хоёр яагаад тэнгэрүүд байхгүй байгааг асууж гэнэ. Тэгэхэд нь Маудгальян “Анандагийн хоёр зээ дүү хувраг болж хичээл зүтгэл гаргавал энд ирэх юм” гэж хариулижээ. Тэр хоёр маш баярлаж буйгаяа Маудгальянд хэлэхэд “Хоёр хувраг минь, энэ болон бусад сайн сайхан зүйлс хичээл зүтгэлийн үр шим. Тиймээс хичээх л хэрэгтэй” гэв. Нөгөө хоёр ч хичээх болж гэнэ.

Нэг удаа Маудгальян тэдэнд сургаал заахдаа хэдий сайн заяатай ч ухээд муюу заяанд төрж болно гэж эх зохиолд иш үзүүлсэн байдгийг тайлбарлаж өгчээ. Тэр хоёр “Тэгээнтэн минь, бид хүн эсвэл тэнгэр байсан ч гэсэн гурван муюу заяанд төрнө гэж үү?” хэмээн асуув. Харин Маудгальян “Хувь ерөөлтийнүүд минь, сэтгэлийн гэм оп мөргүй алга болтол таван төрлийн заяаны орчилд салхин тээрмийн сэнс адил эргэлдсээр байх болно” гэж хариулав. Тэгэхэд хоёр






хүүгийн ой гутаж “Сэтгэлийн гэмээс бүрмөсөн ангижруулах сургаал зааж хайрла” хэмээн хүсжээ. Ингээд Маудгальян хүссэн сургаалыг нь зааж, хоёр хүү ч архадын төвшинд хүрсэн юм. хэмээн айлдсан байдаг.


Зовлонг бясалгавал залхуугаа дийлж, нирваанд хүрэх хүсэл нэмэгддэг. Цаашилбал түүнд хүрэх үндсийг тавьдаг юм. Тэрхүү үндэс нь зовлонг бясалгах юм. Будда өөрөө байсан ч гэсэн Маудгальяны сургаалаас илүү зүйл хэлэхгүй байсан. Дээрх сургаалаар дотоод хөгжлийн анхан, дунд, дээд шатаар аажим өгсөх жамыг харуулжээ. Тиймээс өөрийнхөө чадлаар Анандагийн зээ нар шиг сэтгэдэг болтлоо энэ бүхнийг хичээнгүйлэн бясалгаарай.

Ниүсурва гэгээн:

Муу заяанд төрөх шалтгаан урьд нь гаргасан эсэх, одоо гаргаж байна уу, үгүй юу, цаашид гаргах уу, үгүй юу гэдгээ тунгаан бод. Хэрвээ урьд тийм зүйл хийсэн, одоо ч хийж байгаа, хойшдоо ч хийсээр байх юм бол гарцаагүй муу заяанд төрнө. Тэгээд “Би одоо юу хийх ёстой билээ” гэж бодож ч чадахгүй аагим цөлд тархиа гашилган сууна гэдгийг сана. Тэгвэл аяндаа айдас хүйдэс төрдөг. гэж айлдсан байдаг.

Энэ тун чухал болохоор одоо сайхан боломж байгаа дээр өгүүлснийг тунгаан бод. Тэгвэл урьд гаргасан нүгэл арилж, цаашид нүгэл үйлдэхгүй. Харин өмнө нь хураасан буянаа чин сэтгэлийн залбирлаар





хувилан улам нэмэгдүүл. Шинэ зөв дадал зүйл бүрээр төлөвшдөг сайн талтай. Улмаар боломж бүхий энэ амьдралаа өдөр өдрөөр утга учиртай зүйлд зориул.

Одоо л энэ тухай бодохгүй бол муу заяанд төрсөн хойноо аврал эрээд нэмэргүй. Тэр үед болох болохгүйг ялгах оюуны чадвар алдагдана.

#### *Бодисадеагийн замнал-д:*

Зөв зам, зөв дадалд  
Зөвхөн энэ төрөлдөө л хүрэх тул  
Муу заяанд нэг л ойчвол  
Мунхарсан хойноо гэгээрэх аргагүй.


Гээд цааш нь:





Нөмрөн айсуй аюулын өмнө<sup>1</sup>  
Нөмөрлөж хэндээ хоргodoх билээ  
Айсан нүд дөрвөн зүгтээ  
Аврал эрэн бүлтэлзэж байнам.



Аварч хэн ч туслахгүй гэдгийг  
Аваачиж дэргэдээ нуухгүй гэдгийг  
Андуутгүй ухаарч мэдэхийн цагт  
Аврал, өршөөлийг хаанаас хайх вэ?

Ахуй орчлонд нөмөр бологч  
Амьтан бүхнийг авран өргөгч  
Айдас, зовлонгоос гэтэлгэн туслагч  
Аврагч Буддад амжиж мөргөе.  
Хэмээн өгүүлсэн байдал.

Энэ бүлэгт муу заяаны зовлонг тоймлон үзүүллээ.  
Харин та бүхэн *Үргэлж санаж явах* номоос дэлгэрүүлэн  
харах хэрэгтэй. Дахин дахин уншихын сацуу уншсанаа  
эргэцүүлэн бодох нь чухал.









XI


## ГУРВАН ЭРДЭНЭЭС АВРАЛ ЭРЭХ


- β) Хойд насандаа сайн зананд төрөх нөхцөл бүрдүүлэх  
а' Буддын шашинтан болох гайхамшигт эхлэл болсон  
аврал эрхэд суралцах
- 1' Аврал эрэх шалтгаан  
2' Аврал эрэн хандах зүйл  
    а" Аврал эрэн хандах зүйлийн шинж чанар  
    б" Чухам түүнээс аврал эрэхийн учир  
3' Аврал эрэх арга  
    а" Эрхэм сайн чанарыг нь мэдсэний үндсэн дээр аврал  
    эрэх  
    1" Буддагийн төгөлдөр шинж  
        (а) Буддагийн бие цогцсын төгөлдөр шинж  
        (б) Буддагийн үг өгүүлэхүйн төгөлдөр шинж  
        (в) Буддагийн билэг оюуны төгөлдөр шинж





- (а) Бүхнийг танин мэдэхүйн төгөлдөр шинж  
(б) Энэрэн нигүүлсэхүйн төгөлдөр шинж  
(г) Гэгээрүүлэх үйлсийнх нь төгөлдөр шинж  
2" Номпол сургаалынх нь төгөлдөр шинж  
3" Хуврагийн хүрээний төгөлдөр шинж  
6" Гурван эрдэнэ тус бүрийн онцлогийг мэдсэнээр аврал  
эрэх  
1" Үндсэн шинж чанарынх нь онцлог  
2" Гэгээрүүлэх үйлсийнх нь онцлог  
3" Сүсэглэж бишрэх онцлог  
4" Зан үйлийн онцлог  
5" Нэхэн санаахын онцлог  
6" Буян нэмэгдүүлэх онцлог  
в" Андгай тавьж аврал эрэх  
г" Бусдаас бус зөвхөн Буддагаас аврал эрэх





## В) Хойд насандаа сайн заяанд төрөх нөхцөл бүрдүүлэх

Хойд насандаа сайн заяанд төрөх нөхцөл хэрхэн бүрдүүлэхийг дараах хоёр хэсгээр тайлбарлана:

1. Буддын шашинтан болох гайхамшигт эхлэл болсон аврал эрэхэд суралцах (11-12 дугаар бүлэг)
2. Сайн сайханд хүрэх үндэс болсон сүсэг бишрэлийг хөгжүүлэх (13-15 дугаар бүлэг)

### а' Буддын шашинтан болох гайхамшигт эхлэл болсон аврал эрэхэд суралцах

Хэрхэн аврал эрэх тухай дөрвөн хэсгээр тайлбарлана:


1. Аврал эрэх шалтгаан
2. Аврал эрэн хандах зүйл
3. Аврал эрэх арга
4. Аврал эрээд цаашдаа суралцах журам (12 дугаар бүлэг)


#### 1' Аврал эрэх шалтгаан

Ер нь аврал эрэх шалтгаан олон бий. Харин энэ төвшний аврал эрэх шалтгааныг өмнөх бүлэгт өгүүлсэн. Энэ амьдрал удаан үргэлжлэхгүй, удахгүй үхнэ. Үхсэн хойноо хаана төрөхөө өөрийн дураар шийдэж болдоггүй. Зөвхөн үйлийн үрээс шалтгаалдаг. Үйлийн тухай *Бодисадвагийн замнал-д*:

Гэгээн Буддагийн оюуны хүчээр  
Гэгээрэх хүсэл хааяахан төрдөг нь  
Гэв гэнэтхэн шөнийн аянга  
Гийгүүлж орхиод болих мэт ээ.

Учир иймээс зөв дадлын  
Уяа хүлээ хялбар алдуурч





Алдаа, эндлийн аргамжаа харин  
Аандыа чивчирч байдаг ажээ.  
хэмээн бичжээ.

Сайн үйлийн үр хүч муутай, муу үйлийн үр маш хүчтэй байдаг. Тиймээс ихэнхдээ муу заяанд төрдөг. Үүнийг бодохоос айдас, жихүүдэс хүрдэг. Тэгээд аврал эрэх бодол төрнө. Махатма Дигнага:

Хаяа оломгүй орчлонгийн далайд  
Хаашаа ч чиггүй хөвж явахад  
Хазах шунал, халдах тачаал  
Хар биеийн хүсэл, шунал


Мангас болж биеийг иднэ  
Матар болж махнаас зулгаана  
Энэ цагт хэндээ хандаж  
Энэрэл аврал хүсэхсэн билээ?  
хэмээн айлдажээ.


Нэг үгээр хэлэх юм бол муу заяанд төрөхөөс айх, түүнээс эрхэм Гурван эрдэнэ л аварч чадна гэдэг итгэл үнэмшил хоёр нь аврал эрэх шалтгаан юм. Хэрэв энэ хоёр шалтгааны тухай хоосон яриад өнгөрвөл аврал хоосон болно. Харин ийм хоёр бодол тууштай, хатуу итгэлтэй байвал аврал итгэл ч тууштай болно. Тиймээс хичээл зүтгэл чухал.

## 2' Аврал эрэн хандах зүйл

Дээрх хоёр бодолд үндэслээд хэнээс аврал эрэх вэ гэдэг асуулт урган гардаг. Ингээд чухам хэнээс, юунаас аврал эрэхийг тодруулъя.

**a" Аврал эрэн хандах зүйлийн шинж чанар**  
*Зуун тавин шүлэгт магтаал-д:*





Алд биеэс үүсэлтэй атлаа

Амь хорлох мангас болдог

Алдаа эндлийн учрыг таньж

Ангижирч чадсан нэгэн байвал

Хорвоод олдох сайхан чанаруудыг

Хослуулж өөртөө цогцлоож чадаад

Хоёргүй гэгээрлийн морийг олсон

Хувьтай нэгэн тэр байвал

Ухаан нь саруул хэн ч билээ

Урд нь мэхийж мөргөх билээ.

Улмаан түүнийг оройдоо залаад

Ухаарч гэгээрэлд суралцах билээ.

гэж өгүүлсэн.

Дээр өгүүлснээр хэнээс аврал эрэх, хэнээс эрэхгүйгээ ялгах ухаан хэрэгтэй. Тийм ухаантай бол үнэхээр аврал үзүүлэх Ялж төгс гэгээрсэн Буддад хандана. Түүний номлол болон хуврагийн хүрээ ч авралын эрхэм эрдэнэ болдог. Энэ тухай *Аврал эрэх далан бадаг шүлэгт*:

Эрхэм дээд шүтээн Будда

Эгэлгүй гэгээн номлол сургаал

Эгнэгт түүнийг түгээгч хувраг


Энэ гурав нийлээд авралын зам.


Хэмээн заасан юм.

## б” Чухам түүнээс аврал эрэхийн учир

Буддагаас аврал эрэх дараах дөрвөн шалтгаан бий.

- (1) Будда өөрөө сэтгэлийн гэмийг ялж, номхруулсан. Мөн аюулаас эмээхгүй төвшинд хүрсэн. Унасан нь унасныгаа босгож чадахгүйтэй адил тэрээр эдгээр чанарыг эзэмшээгүй бол бусдыг аварч чадахгүй.
- (2) Будда ямар ч тохиолдолд шавиа номхруулан,







хөгжүүлэх чадвартай. Ийм чадваргүй бол аврал эрээд ч тусалж чадахгүй. (3) Будда агуу их энэрэл нигүүсэлтэй. Хэрэв энэрэн нигүүлсэх сэтгэлгүй бол аврал эрсэн ч аварч чадахгүй. (4) Будда эд хөрөнгөөр тахил өргөхөд баярладаггүй. Харин түүний сургаалыг дагахад л баярладаг. Тиймгүйсэн бол зөвхөн өөрт хэрэг болоход нь туслаад бусдыг нь аврахгүй.

Товчхондоо бол Будда өөрөө аюул бүхнээс ангижирсан учир бусдыг аюулаас ангижруулах чадвартай бөгөөд хэнийг ч ялгалгүй энэрэн нигүүлсэх сэтгэлтэй. Өөрт нь хэрэг болсон болоогүй бүгдэд туслах нэгнээс аврал эрэн хандах нь зүй билээ. Энэ бүх чанар зөвхөн Буддад бий. Харин Вишну мэтийн бусад тэнгэрт ийм чанар байхгүй. Тэгэхээр гагцхүү Буддагаас аврал эрж болно. Тиймээс түүний айлдсан сургаал номлолыг дагачг шавь нар буюу хуврагуудаас ч аврал эрж болно гэсэн уг.

*Хураангуй заавар журам* номд дурьдсан гурван эрдэнийн эдгээр чанарт итгэж үнэмшин, нэгэн үзүүрт сэтгэлээр хандвал аврагдах нь гарцаагүй. Тиймээс үнэн голоосоо итгэх хэрэгтэй. Авралд хүрэх үндсэн хоёр нөхцөл бий. Гадаад нөхцөл болох багш Буддагийн хувьд бүх зүйл нь төгс бүрджээ. Харин дотоод нөхцөл буюу Буддагийн авралд хамаг сэтгэлээ даатгах итгэл байхгүй бол зовсоор байх болно.

Гэхдээ Будда түүнд итгэхгүй байсан ч агуу их энэрэл нигүүслээрээ бүхэнд тусалдаг. Туслахаас огт хойш суудаггүй, тэр бол бусадтай зүйрлэшгүй авран хамгаалагч миний хөтөч хэмээн ухамсарлаж түүнээс аврал эрэх хэрэгтэй. *Магтвал зохицчийн магтаал-д:*





Өмөг, нөмөргүй хөөрхийс биднийг  
Өвөртөө хаацайлах нөхөр чинь больё гээд  
Өндөр дээд Будда та минь  
Өршөөл энэрэлдээ хорвоог багтаалаа.

Үнэнхүү энэрэгч багши таны  
Үлэмж нигүүлсэх гэгээн хайр  
Үнэрхэлгүй туслах уужим сэтгэлийг  
Үнэлж, жиших хүн хорвоод угүй ээ.

Амьтай бүхнийг та минь л аварна  
Ард олныг та минь л нөмөрлөнө.  
Авралыг танаас эрэхгүй л юм бол  
Аяа хөөрхийс, живж далдарна.

Үнэн сэтгэлээсээ аврал эрвээс  
Үзэмжээр ялгалгүй нөхөрлөнө, та  
Өөр хэний ч санаанд төрөөгүй  
Өгөөмөр журмын суртаалтай, та


Аврал итгэлийн гадаад чанаруудыг  
Ашид та минь төгс бүрдүүлжээ  
Аврагдах дотоод чанараа бодоогүй  
Амирлангуй тэнэгүүд л зовно доо, хөөрхий.  
Хэмээн өгүүлсэн байдал.


### 3' Аврал эрэх арга

Буддагаас аврал эрэхийн тулд дөрвөн зүйл мэдэж байх  
хэрэгтэй:

1. Эрхэм сайн чанарыг нь мэдэх
2. Онцлогийг нь мэдэх
3. Авралыг нь хэрхэн хүртэх
4. Зөвхөн Буддагаас аврал эрэх

### а" Эрхэм сайн чанарыг нь мэдсэний үндсэн дээр аврал эрэх





Аврал эрэн хандаж буй зүйлийнхээ сайн талуудыг мэддэг байх ёстой.

1. Буддагийн төгөлдөр шинж
2. Номлолынх нь төгөлдөр шинж
3. Хуврагийн төгөлдөр шинж

### **1” Буддагийн төгөлдөр шинж**

Буддагийн төгөлдөр шинжийг дөрвөн зүйлээр тайлбарлана:

1. Буддагийн бие цогцсын төгөлдөр шинж
2. Буддагийн өгүүлэхүйн төгөлдөр шинж
3. Буддагийн билэг оюуны төгөлдөр шинж
4. Гэгээрүүлэх үйлсийнх нь төгөлдөр шинж


#### **(а) Буддагийн бие цогцсын төгөлдөр шинж**


Буддагийн бие цогцсын төгөлдөр шинж, төрхийг сэтгэлдээ ургуулан бодох хэрэгтэй. Тэдгээр шинж, төрхийг нь *Шинж, төрхийн тагтаал-д*:

Эрхэм таны цогцсын сайхан нь  
Эрхэс нь бүрдсэн тэнгэр мэт ээ  
Энэрэл хурсан төгөлдөр мэлмий нь  
Эрдэнийн тагштай рашаан мэт ээ.

Алтан хайрханы эрдэнийн оройг  
Ариун үүлээр бүчсэн мэт  
Анхилам таны бие юут  
Ариун номын нөмрөг чимжээ.

Аврагч таны, эрдэнийн гоёлгүй ч  
Асар гэгээн тунамал царай  
Ариун тунгалаг шөнийг чимэх  
Арван тавны саран мэт ээ.





Балч зөгий мэргэн гэлээ ч  
Баясгалант улаан уруулыг тань  
Сарнайн дэлбээнээс ялгахгүй болоод  
Салахгүй дагаж эргэнэм билээ.

Онцгой зохиц баруун мутар тань  
Орчлонгийн хүрдэн чимэгтэйн учир нь  
Орчлонгийн хүрдэнд эргэж зовсон  
Олон амьтныг аврах бэлгэтэй.

Будда таны гишгэсэн хөлийн  
Буурь ором лянхуа адил аа  
Буй олны харах нүдийг  
Буяны зам руу зааж хээлнэ ээ.


Өргөн дэлхийн олон газрын  
Өнгийн лянхуа нийлээд ч тэр  
Таван өнгөөр солонгороод ч тэр  
Таны мөр шиг хорвоог чимэхгүй ээ.  
Хэмээн магтсан байдал.


### (б) Буддагийн өгүүлэхүйн төгөлдөр шинж

Энэ ертөнцийн бүх амьтан нэгэн зэрэг, тус бүрдээ  
өөр өөр асуулт Буддад тавихад ганцхан агшны дотор  
бүгдийг нь оюун бодолдоо тунгаан нэг үгээр бүгдэд  
нь хариулж чадна. Тэгэхэд амьтан бүхэн өөр өөрийн  
хэлээр ойлгодог. Энэ гайхамшигт чадварыг нь *Үнэнийг  
өгүүлэгчийн бүлэгт* өгүүлсэнээр бodoх хэрэгтэй:

Амьтан бүхэн өөрийн асуултыг  
Ам амандаа ангид хэлэхэд  
Аврагч Будда нэг л үгээр  
Алинд нь ч таарах хариуг өгдөг өө.

Тиймээс энэ хөтөч ертөнцд  
Брахмагийн дуугаар дуугардаг.  
Тэнгэр болон хүний зовлонг арилгах  
Номлолын хүрдээ эргүүлдэг юм.





## гэсэн бол Зуун тавин шүлэгт магтаал-д:

Асар тунгалаг царай тань үзэсгэлэнтэй  
Аялга зохирсон дуу тань яруу сонсголонтой  
Амнаас дуурсах яриаг тань сонсохуйд  
Рашааны дээжис сарнаас сүрчих мэт.

Цэцэн үг тань аадар болоод  
Адаг шуналын тоосыг дарна.  
Цэнхэр хурмастын гарди болоод  
Атгаг хилэнгийн могойг тасчина.

Мунхаг сэтгэлийн мөсөн мөндрөөс  
Толгой халхлах шүхэр болно оо.  
Муу омог, бардамналын хадыг  
Хагачин зүсэх алмааз болно оо.


Ухаант мэргэн үг тань хуудуутгүй  
Учир нь тэр гэмээс ангид аа,  
Утга энгийн санаад хялбар аа  
Уужим яруу, санаа төгөлдөр өө.


Тухайлж үгийг тань сонсох бүрий  
Эмнэг зүрх номхорч уясна аа.  
Тунгааж дотроо бодохын хэрээр  
Элий мунхагаас салж амарна аа.

Туйлдсан нэгийг амсхийн амрааж  
Тун чиг сэрэмжгүйг авран хамгаалж  
Ташуурсан заримд тарыг нь таниулж  
Таны сургаал бүгдэд хурдэг ээ.

Авхаалжтай нэгний ухааныг нээж  
Арай дөнгүүрийн ухаарлыг нэмж  
Алмай нэгийн мунхагийг арилгаж  
Амьтан болгонд тусаа өгдөг өө.

Хэмээн айлдсан.





**(в) Буддагийн билэг оюуны төгөлдөр шинж**  
Буддагийн билэг оюуны төгөлдөр шинжийг танин мэдэх болон энэрэн нигүүлсэх гэсэн хоёр хэсгээр тайлбарлана.

**(а) Бүхнийг танин мэдэхүйн төгөлдөр шинж**

Будда харыцангуй ба үнэмлэхүй үнэн болон юмс үзэгдлийн мөн чанарыг алган дээрээ жур үр тавьсан мэт төвөггүй танин мэддэг. Тиймээс Будда мэдэгдэхүүн бүхнийг таньж мэдсэн байдаг юм. Харин Буддагаас бусад нь мэдэгдэхүүн ихдэж, танин мэддэг ухаан нь багадах учир бүхнийг танин мэдэж чаддаггүй билээ. *Магтвал зохицчийн тагтаал-д* энэ тухай:

Гагцхүү та л билгүүн оюундаа  
Бүх танин мэдэхүйг шингээсэн билээ.  
Харин танаас бусад бүгдээрээ  
Тэр бүхнийг ухаарна гэвэл хэт ихдэнэ.


гээд цааш нь:


Ялгуулсан минь, бүх үед бий болсон  
Аливаа юмс үзэгдэл бүгдийг нь  
Та алган дээрээ тавьсан жур үр мэт  
Алдаа эндэлгүй танин мэдсэн билээ.

Амьтай болоод амьгүй бүх юмсыг  
Бүхэлд нь болон тус бүрд нь  
Орон зайд чөлөөтэй тоглох салхи мэт  
Огт торолгүй танин мэдсэн билээ, та.  
гэхчлэн өгүүлжээ.

**(б) Энэрэн нигүүлсэхүйн төгөлдөр шинж**

Амьтад өөрийн мэдэлгүй сэтгэлийн гэмд хүлээтэй байдаг, харин Будда агуу энэрлээрээ аяндаа амьтадтай





холбогддог юм. Амьтны зовлонг ойлгохын хэрээр агуу энэрэл нь тасралтгүй ундарч байдаг. Энэ тухай Зуун тавин шүлэгт магтаал-д:

Амьтай бүхнийг хүлж торлосон  
Айdas шанланлын гав гинжийг  
Аврагч гэгээрийн ган өрөлбөөр  
Ачит Будда л тасчиж чөлөөлнө.

Анх түрүүнээ Будда танд  
Алга хавсран мөргөх нь зөв үү?  
Амьтан бүгдийг гаслангаас гэтэлгэгч  
Ариун сургаалд тань мөргөх нь ч зөв үү?

Мөн Үнэнийг өгүүлэгчийн бүлэг-т:

Харанхуй мунхагт төөрсөн олны  
Хамаг ухаан таг сохроод  
Хяслант орчлонгийн будангуйн гянданд  
Гаслан унахыг Та үзээд


Гаслант гянданы будангуйд орсон нь  
Хамаг ухаан сохорсных гэдгийг  
Хамаг ухаан сохорно гэдэг  
Харанхуй мунхаг явсных гэдгийг


Хэлж, засаж, өөд татаж  
Гэгээрүүлж, хөтөлж, төрөл дээшилүүлж  
Эгнэгт тэднийг аврахаар шлуудаж  
Эрхэм суртаалаа хөгжүүлсэн билээ.

Гээд цааш нь:

Хуял тачаалын эргүүлэгт автаад  
Хурьцах сэрлийнхээ ёроолд унагсад  
Тэр далайдаа живснийг хараад  
Тэсгэлгүй Буддад энэрэл соёолов oo.

Өдөр шөнөтэй нь зовлон нөхцсөн  
Өнөр өртөнцийг өрөвдөж нигүүлсээд





Өршөөж энэрэхийн арван шид нь  
Өөрөө аяндаа бүрдэн цогцлов оо.

Ачит Буддагийн энэрэл хайр  
Алгасарч дундрах нь хэзээ ч үгүй  
Ашид зөвдөн гэгээрэлд хөтөлж  
Амьтан бүхний сэтгэлд оршино.  
гэхчлэн өгүүлжээ.

### (г) Гэгээрүүлэх үйлсийнх нь төгөлдөр шинж

Буддагийн бие цогцос, өгүүлэхүй, билэг оюуны гэгээрүүлэх үйлс нь аяндаа, тасралтгүй үргэлжлэх хоёр чанартай. Тиймээс бүх амьтанд тусалдаг юм. Хэрвээ шавь дагаж мөрдвөөс Будда төгс цогцолсон бүхэнтэй үнэхээр золгуулна. Гай зовлонгоос салгаж, зөв зүйтэй бүхэнд хүргэдэг. Зуун тавин шүлэгт магтаал-д:

Зовлон шаналтлаа дараахад сургаж  
Золбин шулмын залийг илчилиж  
Зогсолтгүй эргэх орчлонгийн хүрднээс  
Зохистой мултрах зүгийг та заасан.


Амьтан бүгдийн эрж хайсан  
Ачлал хайр, гэгээрэл, энэрэл  
Алийг гүйсан ч бүхнийг нь та  
Алаг үзэлгүй өгч чадна.

Мөн *Магтвал зохицийн магтаал-д*:

Авралын гараа сунгалгүй орхиж  
Ангал руу хэнийг ч та түлхээгүй  
Ахуй ертөнцийн гайхамшиг болгон  
Аль нь ч танаас ангид үүдээгүй.

Энэ бол Буддаг бодож санаж явах хураангуй журам юм. Хэрвээ олон талаас нь бодвол сүсэг тал бүрээр хөгжинө. Дахин дахин бодвол итгэл өнө удаан, гүн бат





бодлог. Нөгөө хоёр эрхэм эрдэнэд ч уүнтэй адил хандах хэрэгтэй.


Эрхэм зарлиг түүний утга санааны тайлбарын ихэнхэд нь гурван эрдэнийн төгс чанарыг гаргасан байдаг. Дээрх бясалгалаар тэр бүхнийг лавтай мэдэж мөрдлөг болгодог. Үүнийг зарим нэг нь задлан шинжилж бясалгадаг ойлголт учраас хэрэгжүүлэх үед хэрэггүй гэдэг. Ингэвэл зөв дадал хуримтлуулж, хилэнцээ арилгах олон боломжоо үгүй хийнэ. Тиймээс эрдэнэт хүний хэргийг бүтээж утга учрыг гаргахад том саад болно гэдгийг мэдэж ав.


Сэтгэл санаанд дадуулж хэвшүүлсэн зүйлс тогтдог мөн чанартай. Тиймээс эхэндээ нэлээд хэцүү байдаг. Дараа нь аяндаа л сэтгэлд ороод ирдэг. Тэр үед “Төсөөлөн бодож буй Буддатайгаа адил төвшинд би хүрнэ” гэсэн гэгээрэх тэмүүлэл хөгжине. Ингээд өдөр ч, шөнө ч Буддатай учирна. Үхэх үедээ ямар ч зовлон эдэлсэн Будда санаа бодлоос салдаггүй юм. Энэ талаар *Бясалгалин хаан судар-т:*

Эргэцуулж хэлэх санаа минь гэвэл  
Эрмэлзэж чиний санасан зүйл чинь  
Эгнэгт санаанд хадагдаж явсаар  
Эрхбиш сэтгэлийг бүрнээ эзэмдэнэ.

Энэ мэтээр Буддагийн дурийг  
Энгүй билгүүн ном суртлыг  
Эгнэгт бясалгаж, үргэлж бодвоос  
Энэ биеийг тань эзэмдэж дүүргэнэ.

Алхам бүртээ өдөр болгон  
Амрах босох цаг бүртээ  
Ахуй ертөнцөд ижилгүй хаанчлагч  
Ашдын гэгээрлийг мөрөөдөн залбир.  
гэх буюу:





Бие, хэл, сэтгэлээрээ сүслээд  
Билэгт гэгээрэгсдийг магтан дуулж  
Өдөр, шөнийн хэвшил болговоос  
Өнөд өртөнцийн хаантай учирна.

Алс хэтдээ хорвоогийн жамаар  
Амия орхин нөгчихийн цагт ч  
Аврагч Будда орхихгүй тул  
Аймшиг, тарчлаан наждаар зовохгүй.  
Хэмээн өгүүлжээ.


Бодова нэгэнтээ:


Буддагийн төгөлдөр чанарыг байнга бодвол сүсэг нэмэгдэнэ. Сэтгэл ариусч, эрч хүч өгнө. Итгэл үнэмшил улам батжина, Аврал эрэх сургаалыг нь чадал чинээгээрээ ёсчлон биелүүлбэл хийсэн бүхэн чинь Буддагийн номлол болно.

Бид Буддагийн мэдлэг ухааныг мэрэгч төлөгчөөс ч доогуур үнэлдэг. Хэрвээ нэг мэрэгч “Энэ жил чамд ямар ч муу юм тохиолдохгүй. Би мэдэж байна” гэвэл сэтгэл амар буцдаг. Харин “Энэ жил өөдлөхгүй нь. Ийм юм хий, тийм юм хийж болохгүй” гэвэл хичээнгүйлэн дагадаг. Хийж чадаагүй бол “Хэлснийг нь хийсэнгүй дээ” гэж сэтгэл зовнино. Гэтэл Будда “Үүнийг, түүнийг цээрлээ”, “Үүнийг, түүнийг хэрэгжүүл” гэж захисан шүү дээ. Үүнд анхаарал хандуулдаг билүү? Хэрэгжүүлэгүй бол сэтгэл зовдог гэж үү? Харин ч “Номлолд л тэгж заадаг. Энэ цаг үед яаж тэгж чадах вэ, харин ингээ” гээд Буддагийн үгийг хэрэгсэлгүй өөрийн дураар явдаг.

Гэж сануулжээ.

Үүнийг нухацтай бodoхгүй, зугаа баяслын үг төдий





эндүүрэхийн оронд дотоод сэтгэлдээ эргэцүүлэн тунгаавал гарцаагүй үнэн билээ.

Тиймээс Буддагийн төгөлдөр чанарыг ахин дахин бодож үнэн голоосоо итгэл үнэмшилтэй болохыг хичээ. Ингэж чадвал Буддагийн айлдсан номлол хийгээд түүнийг дагагч хуврагт Будда мэт итгэж, аврал жинхэнэ утгаараа бий болно. Эс чадвал гэгээрэх шат дарааллын тухай ярих ч хэрэгтүй. Тэр бүхний үндэс болсон авралд барих сэтгэл ч баттай болохгүй.


## 2” Номлол сургаалынх нь төгөлдөр шинж


Буддагийн хязгааргүй эрхэм чанараас үүдэн бидэнд сүсэг төрдөг. Тэгэхээр “Тэр эрхэм чанар нь онолын ба хэрэгжүүлэх номлол, хориход болон зам мөрийн үнэн бөгөөд гэм нүглээс ангижран эрхэм чанар эзэмшишэн шинж чанартай. Энэ бүгдийг бясалган эзэмшишнээр л номлол нь бий болсон” гэж бод. *Номлолын жинхэнэ хураангуй-д:*

Аль ч ялгуулсан гэгээрэгч хэмжээлшгүй төгөлдөр чанартай. Тэд бүгд номлогоос төрсөн, номлолын л ач тус. Тэд нар бол номлолын биелэл, номлогоос л бий болсон. Тэд бүгдээрээ номлол эзэмшигч, түүнийг баримтлагч. Тэд бүгдээрээ номлогоор бүтээгдсэн. хэмээн бичжээ.

## 3” Хуврагийн хүрээний төгөлдөр шинж

Хуврагийн хүрээний цөм нь хоосон чанарыг шууд танин мэдэгчид юм. Номлолын төгөлдөр чанарыг нэхэн сана. Тэгээд хувраг бол тэр бүхнийг ёсчлон эзэмшишэн гэдэг үүднээс нь бодох хэрэгтэй. *Жинхэнэ номлолын хураангуй-д:*





Хувраг номлол заадаг. Хувраг номлолоо дагадаг. Хувраг номлогоор сэтгэдэг. Хувраг бол номлолын орон зай. Хувраг бол номлолыг баримтлагч. Хувраг бол номлолын үйлсийг цогцлоогч. Хувраг бол номлолын дээдлэгчид. Хувраг бол номлолын амьд цогцлол. Хувраг бол шударга зантай, ариун сэтгэлтэй. Хувраг бол энэрлийн номлолтон, энэрэнгүй сэтгэлтэн. Хувраг бол эгэл амьдралаас сэтгэл буруулан үргэлж номлогоор амьсгалагч. Хувраг бол үргэлж зөв сайныг хэрэгжүүлэгч билээ.

#### **б” Гурван эрдэнэ тус бүрийн онцлогийг мэдсэнээр аврал эрэх**

*Хураангуй заавар журам-д өгүүлсэн ёсоор эрхэм гурван эрдэнийн дотоод онцлогийг нь мэдсэний үндсэн дээр аврал эрдэг. Нийт зургаан онцлог ялгаа бий.*

##### **1” Үндсэн шинж чанарынх нь онцлог**


Буддагийн үндсэн шинж чанар бол төгс гэгээрэл юм. Номлол бол төгс гэгээрлээс боловсорсон жимс. Харин хувраг нь уламжлагдсан заавар журмаар бусдад номлол эзэмшигүүлэх үүрэгтэй.


##### **2” Гэгээрүүлэх үйлсийнх нь онцлог**

Будда гэгээрэлд хүрэх сургаал айлдсан. Номлол нь сэтгэлийн гэм болон зовлонг дараахад чиглэдэг. Харин хувраг гэгээрлийн замаар замнах урам хайрладаг.

##### **3” Сүсэглэж бишрэх онцлог**

Буддаг сүсэглэн биширч хүндэтгэнэ. Номлолыг дагаж





мөрдөн хүндэтгэнэ. Хувраг номлолыг даган биелүүлж байгаа учир түүнийг ч хүндэтгэнэ.

#### **4” Зан үйлийн онцлог**

Буддад тахил өргөж, залбирна. Номлолын хувьд бясалгал ёёгийг өөриймшүүлнэ. Харин хуврагт шашин ном болон эд зүйлийн энгийн өргөл, тусламж үзүүлнэ.

#### **5” Нэхэн санахын онцлог**

Гурван эрдэнийн төгөлдөр чанарыг *Гурван эрдэнийн төгөлдөр чанарыг санах судар-т өгүүлснээр бодож явна.*

#### **6” Буян нэмэгдүүлэх онцлог**


Хувь хүн болон номлолыг даган зөв дадал хөгжүүлбэл буян асар их нэмэгддэг. Будда, хувраг хоёр хувь хүн гэсэн үг. Нэг буюу олон хүнийг үлгэр дууриал болгон хөгжүүлсэн ч буян нэмэгдэнэ. Харин хувраг гэдэг нь дөрвөөс дээш тоотой байх учиртай.


#### **в” Андгай тавьж аврал эрэх**

*Ёс зүйн дэлгэрэнгүй тайлбар-т* Будда бол аврал номлогч. Номлол нь нирваанд хүрэх зам мөр буюу жинхэнэ аврал. Харин хувраг бол авралын биелэл болсон анд нөхөр. Энэ үүднээс аврал эрэх ёстой гэж өгүүлсэн байдаг.

#### **г” Бусдаас бус зөвхөн Буддагаас аврал эрэх**

Буддын болон бусад шашин, тэдгээрийн багш, шавь нарынх нь дээд, доод ялгааг сайн мэдэж ав. Тэгээд зөвхөн Гурван эрдэнээс л аврал эр. Буддын сургаал, номлолтой нийцэхгүй багшаас аврал эрж болохгүй. Буддын болон бусад шашинд ялгаа их бий.





*Багшийн ялгаа.* Будда алдаа дутагдлаас бүрэн салсан. Эрхэм төгс чанар бүрэн эзэмшишэн. Харин бусад шашны багш нар өөр байдаг. Энэ тухай *Үлэлж онцгойн тагтаал-д*:

Ямар ч замчин надад хэрэггүй  
Ялгуусан Будда таныгаа л дагана  
Яагаад гэвэл алдаа эндлээс  
Ямагт та минь ангид билээ.

Гээд цааш нь:


Алив сургаал, суртаал олоон  
Алийг нь ч сонирхож үзээд үзээд  
Ариун гэгээн Буддын сургаал л  
Аврагч гэдгийг баттай танилаа.


Сурталч, сургагч бусад олны  
Судалсан, оносон нь эндүү дүүрэн  
Суудал, явдал ташаагийн гайгаар  
Суут Буддаг танихын хувьгүй ээ.  
Хэмээн айлдсан билээ.

*Номлол сургаалын ялгаа.* Буддын шашин нь амгалангийн замаар явж амгаланд хүргэдэг. Орчлонгийн эргүүлэгнээс чөлөөлдөг. Сэтгэлийн гэнийг бүрмөсөн арилгадаг. Нирвааныг хүсэгчдийг төөрөгдүүлэлгүй зөв дадал эзэмшүүлж, гэмээс нь салгана. Бусад шашин үүнээс тэс өөр байдаг. *Үлэлж онцгойн тагтаал-д*:

Амьтан бүгдийг жаргалд хүргэх  
Ашдын ерөөлт энэ шашны  
Авралын арслан болсон таны  
Ариун сургаалыг дагадаг билээ

Мөн *Магтвал зохицчийн тагтаал-д*:





Цээж урсан шаналлаас салгаж  
Цэрвэж холдон цээрлэх бүхнийг,  
Чиглэж дагах авралын замыг,  
Чин сүжгээр гэгээрэх мөрийг,

Алдаагүй үнэнээр заасны учраа  
Ашдын замыг нээсний учраа  
Ариун Буддагийн гэгээн суртаал  
Аливаа сургаалаас төгс ялгарна.

Шашин хэмээн өөрийгөө цоллогч  
Шал хуурмаг цэцэрхэл олон ч  
Шагжамуни Буддагийн сургаалын хажууд  
Шалихгүй, дэмий, худлаа чалчаа

Илүү, дутуу, гоё муухай  
Ийм ялгаа дунд нь байхгүй  
Буддагийн сургаал оройгүй үнэн  
Бусад үлдсэн нь олхиогүй худал.



Буддаг дагавал зөв рүү хотолно  
Бусад нь харин төөрүүлж хорлоно  
Таны болоод бусдын сургаалыг  
Таних, ялгах шалгуур энэ ээ.

Ашид Будда диваажинд хотолно  
Аливаа бусад нь там руу чирнэ  
Аврагч Будда ба хуурмаг шашны  
Адилгүй ондоо ялгаа нь энэ ээ.

хэмээн сургажээ.

Энд өгүүлснээр хуврагуудын онцлог ялгааг мэдэж  
болно.







## XII



# АВРАЛ ЭРЭХ ЖУРАМ


- 4' Аврал эрээд цаашдаа суралцах журам  
а" Хураангуй заавар журам-д заасан дагуу суралцах
- 1" Эхний дөрвөн зүйл
    - (а) Төгс гэгээрэгчийг шүтэх
    - (б) Гэгээн номлол сонсох
    - (в) Номлол ёсоор сэтгэлээ засах
    - (г) Номлолыг дагаж мөрдөн хэрэгжүүлэх
  - 2" Удаах дөрвөн зүйл
    - (а) Мэдрэхүйгээ жолоодох
    - (б) Журам дүрэм дагах
    - (в) Амьтныг энзрэн хайрлах
    - (г) Гурван эрдэнийг тогтмол тахих
- б" Аман уламжлалын дагуу суралцах
- 1" Тусгай журам
    - (а) Цээрлэх журам
    - (б) Эзэмших журам
  - 2" Ерөнхий журам





- (а) Гурван эрдэнийн төгөлдөр чанар, онцлогийг санан, ахин дахин аврал эрэх
- (б) Гурван эрдэнийн их ивээлийг санан үргэлж тахих
- (в) Их энэрэнтгүй сэтгэлийг бодож амьтан бүхнээр аврал эрүүлэх
- (г) Аливаа тохиолдолд ямар ч хэрэг гарсан эгэл жирийн арга хэрэглэлгүй гурван эрдэнийг тахин залбирна
- (д) Аврал эрэхийн ач тусыг санан өдөр гурав, шөнө гурав аврал эрэх
- (ά) *Хураангуй заавар журалам*-д дурьдсан ач тус
- (а') Эхний дөрвөн зүйл
- (1') Агуу буян хураана
  - (2') Баяр баясгалан, дээд ханамж таашаал эдэлнэ
  - (3') Сэтгэлийн төвлөрөлд хүрнэ
  - (4') Сэтгэл ариусна
- (б') Дараагийн дөрвөн зүйл
- (1') Маш том өмгөөлөлтэй болно
  - (2') Бүх алдаатай буруу үзэл багасч улмаар арилна
  - (3') Оюунлаг суутнуудын эгнээнд багтана
  - (4') Буддын номлолыг таашаагч тэнгэр, хүмүүсийн талархал хүлээнэ
- (β) Бусад гарын авлагад дурьдсан ач тус
- (а') Буддын шашинтан болно
- (б') Сахил бүхний авах бололцоо нээгдэнэ
- (в') Урьд хуримтлагдсан хилэнц нимгэрч, барагдана
- (г') Агуу буян хураана
- (д') Муу заняанд торөхгүй
- (е') Хүн ба хүнээс бусдын хорлолд өртөхгүй
- (ё') Хүссэн бүхэн биелнэ
- (ж') Төгс гэгээрлийн төвшинд хурдан хүрнэ
- (е) Эрхэм гурван эрдэнийг тоглоом төдийд орхилгүй үнэнч байх мөн аминд тулсан ч үл татгалзах





#### 4' Аврал эрээд цаашдаа суралцах журам

Энэ бүлгийг хоёр хэсгээр тайлбарлана:

1. *Хураангуй заавар журам*-д заасан дагуу суралцах
2. Аман уламжлалын дагуу суралцах

#### а" *Хураангуй заавар журам*-д заасан дагуу суралцах

Үүнийг тус бүр дөрвөн зүйл бүхий хоёр хэсгээр тайлбарлана.

##### 1" Эхний дөрвөн зүйл

###### (а) Төгс гэгээрэгчийг шүтэх


Урьд нь өгүүлснээр сайн чанар бүхэн бүрдсэн, эрдэм бүхний ундарга болсон багшийг олж шүт. Буддагаас аврал эрнэ гэдэг түүний сургаалыг заагчаас аврал эрнэ гэсэн үг. Буддагийн сургаалыг ёс журмаар дагаж мөрдөх гэдэг нь гэгээрлийн зам заагчийг ёсчлон дагана гэсэн үг юм.


###### (б) Гэгээн номпол сонсох ба (в) Номпол ёсоор сэтгэлээ засах

Гэгээн Будда ба түүний дэргэдийн шавь шарвага нарын заасан судрын аймаг болон бусад сургаалыг зохих ёсоор нь сонс. Сонссон зүйлээ сэтгэлдээ тунгаа. Сэтгэлийн гэмээ дарах зорилго тавь. Номполоос аврал эрнэ гэдэг онолын болоод хэрэгжүүлэх номлолыг дагаж мөрдөхийг хэлдэг. Тиймээс номын ёс дагуу хэрэгжүүлэх шаардлагатай.

###### (г) Номлолыг дагаж мөрдөн хэрэгжүүлэх

Энэ нь нирваанд хүрэх номлолыг дагаж мөрдөн, хэрэгжүүлнэ гэсэн үг. Хуврагаас аврал эрсэн болохоор





нирвааныг зорьж буй нэгэнтэй нөхөрлөнө. Номлолыг дагаж мөрдөж, хэрэгжүүлэх гэж байгаа учир нирваанд тэмүүлэгчдийг даган суралцах хэрэгтэй.

## 2” Удаах дөрвөн зүйл

### (а) Мэдрэхүйгээ жолоодох

Юмс үзэгдлээс үүдээд сэтгэл догшрох гэмтэй тул сэтгэлээ хянаж суралцах хэрэгтэй.

### (б) Журам дүрэм дагах

Буддагийн бий болгосон тангараг, сахилыг хэр чадлаараа дага.

### (в) Амьтныг энэрэн хайрлах

Буддагийн сургаал номлол нь энэрэлт шинжээрээ бусдаас ялгардаг. Буддагаас аврал эрж буй учир бусад амьтныг энэрэн хайрла. Тэдэнд хор хөнөөл учруулахыг цээрлэ.

### (г) Гурван эрдэнийг тогтмол тахих

Өдөр бүр гурван эрдэнийг тахиж бай.

## 6” Аман уламжлалын дагуу суралцах


Аман уламжлал нь тусгай болон нийтлэг журам гэсэн хоёр хэсэгт хуваагдана.


## 1” Тусгай журам

Энэ хэсгийг цээрлэх ба эзэмших журам гэдэг хоёр зүйлээр тайлбарлана.

### (а) Цээрлэх журам

*Агуу нирваан судар-т:*





Гурван эрдэнээс аврал эрэгчид

Зөв дадлыг хөгжүүлэгч мөн

Гунигт, гэгээт цагуудын алинд ч

Завсрын шүтээнээс аврахыг горьдохгүй.

Хутагтын шашнаас аврал эрсэн бол

Хорлох сэтгэлээ хөсөр хая.

Хуврагт мөргөж, дагасан юм бол

Хуурмаг номтонтой тангарагаа тасла.

Хэмээн айлдсан юм.

Бусад тэнгэрээс аврал гүйхгүй, амьтан хорлож, хөнөөхгүй, өөр үзэл номполтой хүнтэй нийлэхгүй гэсэн гурван цээр бий.


*Эхнийх нь:* Бусад тэнгэрээс аврал гүйхгүй. Рудра, Вишну болон энэ ертонцийн бусад тэнгэрээс аврал эрэхгүй. Тэгэхээр уул усны лус, савдаг, онгон зэрэг бусад зүйлийн тухай дурсах хэрэггүй биз. Гурван эрдэнэд итгэхгүй тэдэнд сэтгэлээ жолоодуулж болохгүй. Гэхдээ эгэл жирийн амьдралын хүрээнд тэдэнд хандаж болох юм. Жишээлбэл, амьдрахын тулд өглөгийг нь авах эсвэл өвчинөө эмчлүүлэхийн тулд эмчид нь хандаж болно.


*Хоёр дахь нь:* Хүн болон адгуусыг санаа болон үйлдлээр хорлож болохгүй. Хүн, амьтан зодож, цохих, широнд хийх, дөрлөх, даашгүй хүнд ачаа ачих зэргээр хор хөнөөл учруулахыг цээрлэ.

*Гурав дахь нь:* Гурван эрдэнэд итгэдэггүй, түүнийг гутаан доромжлогчтой нийлж болохгүй.

## (б) Эзэмших журам

Буддагийн хөрөг дүр, баримал сайн, муу ямар ч байсан өөлж муулж болохгүй. Мөн зохимжгүй газар тавих,







барыцаанд өгөх зэргээр хүндэтгэлгүй, тоомжиргүй хандахыг цээрлэ. Түүнийг Будда мэт хүндэтгэ. *Анддаа илгээсэн захидал-д:*

Аврагч Буддагийн ялгуун дурийг  
Алтаар ширээсэн ч, modoор зорсон ч  
Ашигд дээдлэх оюунтан хүнд  
Ав адилхан шүтээн болно.  
гэсэн байдаг юм.

Ёс зүйн ангилал номд Манавакапила гэгч нэг этгээд сэтгэл нь боловсорсон, боловсроогүй олон хуврагийг “Үхэр толгойлсон та нар юуг буддын номлол мөн, юуг буддын номлол биш болохыг мэдэхгүй” гэж арван найман янзаар доромжилжээ. Тэгээд арван найман өөр толгойтой усны мангас болж төрсөн. Тэрээр Кашьяпа Буддагийн үеэс Шагжамуни Буддаг хүртэл адгуус явсан гэж өгүүлдэг. Мөн Ёс зүйн хэсэгт Кракуукчанда Буддаг төгс нирваан дүр үзүүлсний дараа Карумат хаан дурсгалд нь зориулж том суврага босгох зарлиг гаргажээ. Харин тэнд ажиллаж байсан нэгэн эр “Ямар ч том суврага вэ дээ, хэзээ дуусна даа” гэж хоёр ч удаа хэлж гэнэ. Хожим суврага баригдаж дуусахад мань эр урьдын хэлсэндээ их гэмшжээ. Тэгээд алтан хонх захиалан хийлгэж сувраганд зүүж гэнэ. Үүнийхээ үрээр тэр хойд насандаа царай муутай, атигар боловч цээлхэн эр хонгор дуутай болж төрсөн гэдэг. Тиймээс Буддагийн хөрөг, баримал зэргийг өөлж гоочилж болохгүй. Мөн хөрөг дүрийг томоор эсвэл эд зүйл хайрлалгүй урлаж байвал бүү хошуу дүр.

Агуу ёгч Жанчүв Ринчэн Адишад Манзуушрийн шуумал үзүүлж “Хэр урласан байна, сайн уу, муу юу?







Сайн болсон бол Ронгийн Гаргэвэгийн өгсөн дөрвөн цэн алтаар авъя” гэжээ. Тэгэхэд Адиша “Манзуширийн дурд өө байхгүй. Харин хийц нь дунд зэрэг юм” гээд магнайдаа хүргэсэн гэдэг. Адишаг хөрөг дүр бүхэнд хүндэтгэлтэй ханддаг байсан гэж ярьdag билээ.

*Дараагийн эзэмших зүйл.* Дөрвөөс дээш үгтэй ямар ч номлолд хүндэтгэлгүй хандаж болохгүй. Сургаал бүхий номыг барьцаанд тавих, арилжаа наймаа болгох, газар тавих, зохисгүй газар хадгалах, гуталтайгаа хамт хийх, дээгүүр нь алхах зэргийг цээрлээ. Эрхэм нандин номлол сургаал мэт бишрэн хүндэл. Жанава багш судар ном авч явaa хүнтэй таарах бүртээ босож алгаа хавсардаг байжээ. Босож чадахгүй болсон хойноо ч алгаа хавсардаг байсан гэлцдэг. Адиша өөрийнх нь сургаалыг сонсдоггүй нэгэн тарничтай Арид таарчээ. Харин тэдний дэргэд байсан нэг бичээч шүднийхээ хагийг номд нялж гэнэ. Үүнийг харсан Адиша ”Ээ, чааваас даа. Боль, боль” гэж уулга алджээ. Энэ үг нь өнөө тарничид сүсэг төрүүлж Адишагаар номлол заалгах болсон гэдэг. Бас Шарава: “Бид номлогоор тоглоом наадам хийх юм. Номлол болон багшид хүндэтгэлгүй хандах нь мулгуу болохын үндэс. Одоо тэнэглэж боллоо. Мунхагийн үндсийг дахин бүү усла. Үүнээс илүү тэнэглэвэл юунд хүрэх билээ” гэсэн байдаг.

*Гуравдугаарт,* тангараг сахил авсан аваагүй ялгаагүй буддын шашинтан хэн бүхнийг доромжилж болохгүй. Харааж, загнаж болохгүй. Хүний, өөрийн гэж ялгавартай хандахыг цээрлээ. Харин хувраг эрдэнэ хэмээн хүндэл. *Үзлийг өдөөх судар-т:*





Хээр даяанчилж бясалгал хийгчид  
Хийддээ үлдсэн нөхдөө бүү муул.  
Би бусдаас илүү гэж биеэ тоогчид  
Бодь сэтгэл төрдөггүй юм шүү.

Омголон зан муугийн үндэс тул  
Онгирч буурай гэлэнг бүү муул.  
Олон галавт нирваанд хүрэхгүй,  
Ойлгож ав, энэ жам ёсыг, сайтар.  
Хэмээн өгүүлжээ.


Донбова, Налжорва нар газар хэвтэх шар даавууны  
өөдөс дээгүүр ч алхалгүй, авч сэгсрээд дээш нь тавьдаг  
байсан. Тэднээс үлгэр ав. Бид гурван эрдэнийг хэдий  
чинээ хүндэтгэнэ бусад амьтан биднийг төдий чинээ  
хүндэлнэ. *Бясалгалаын хаан* сударт:


Үйлдсэн үйлийнхээ хэр таарсан  
Үр дагаврыг л амсах болно.  
Гэсэн юм.

## 2" Ерөнхий журам

Зургаан нийтлэг журам бий.

1. Гурван эрдэнийн төгөлдөр чанар, онцлогийг санан ахин дахин аврал эрэх
2. Гурван эрдэнийн их ивээлийг санан үргэлж тахих
3. Их энэрэнгүй сэтгэлийг бодож амьтан бүхнээр аврал эрүүллэх
4. Аливаа тохиолдолд ямар ч хэрэг гаргасан эгэл жирийн арга хэрэглэлгүй Гурван эрдэнийг тахин залбирах
5. Аврал эрэхийн ач тусыг санан өдөр гурав, шөнө гурав аврал эрэх
6. Эрхэм гурван эрдэнийг тоглоом төдийд орхилгүй үнэнч байх мөн аминд тулсан ч үл татгалзах





### (а) Гурван эрдэнийн төгөлдөр чанар, онцлогийг санан ахин дахин аврал эрэх

Дээр өгүүлсэн ёсоор буддын шашин ба бусад шашны авралын ялгааг бод. Мөн гурван эрдэнийн төгс төгөлдөр, онцлог чанарыг ахин дахин бод.


### (б) Гурван эрдэнийн их ивээлийг санан үргэлж тахих


Гурван эрдэнийн их ивээлийг байнга бодож хооллохынхoo өмнө үргэлж тахил өргө. *Бясалгалын хаан-д:*

Аяа хөөрхий, шалихгүй хүмүүс  
Аврагч Буддагийн буянаар  
Амны хишиг, буян олсноо  
Агшин зуурхан мартах юм даа.  
хэмээсэн байдаг юм.

Өөрийн аливаа сайн сайхан бүхнээ хоол унд олохтой зүйрлэн гурван эрдэнийн ивээл хэмээн бодож тахил өргөж бай. Гурван эрдэнэд өргөх тахил нь (1) тахил өргөх ба (2) сэтгэл гэсэн хоёр зүйлтэй. Эхнийх нь арван хэсэгтэй.

- 1) *Буддагийн бие цогцсыг тахих:* Буддагийн хөрөг дүрийг тахина.
- 2) *Суврага тахих:* Төгс гэгээрлийн төвшинд хүрэхийн тулд суврага зэргийг тахина.
- 3) *Бодитооф тахих:* Бодитой оршин буй Будда ба суврагыг тахина.
- 4) *Эчинэ тахих:* Будда болон суврага таараагүй тохиолдолд бүх гэгээрэгсэд, суврагыг төсөөлж тахина гэсэн үг. Аль нэгэн гэгээрэгчийг төгс нирваанд ороход







нь түүнд зориулан суврага босгон, дүрийг нь бүтээдэг. Энэ бол эчнээ тахил юм. Тэр хоёрын аль нэгийг тахисан ч болно, нэг нь ногөөгөө төлөөлдөг жамтай. Тиймээс эчнээ тахил өргөхдөө “Турван үеийн бүх гэгээрэгсэд болон арван зүгийн тоолшгүй олон сувраганд тахил өргөж байна” гэж бод. Ингэвэл бодит ба эчнээ тахил аль алийг нь өргөж буй хэрэг. Бодит тахилын буян маш их, эчнээ тахилын түүнээс ч илүү. Хослуулбал бүр агуу болно гэдэг. Ганц гэгээрэгч буюу ганц хөрөг дүр тахих нь олныг тахихтай мөн чанарын хувьд огт ялгаагүй гэдгийг сана. Тэгээд бүгдэд нь л тахил өргөж байна гэж бодвол илүү сайн.

5) *Өөрөө урлан тахих*: Чадахгүй гэж залхуурч, амар хялбарыг бодож бусдаар хийлгэлгүй өөрийн гараар урлана.

6) *Бусдыг уриалан тахих*: Өөрийн хөрөнгө арай хүрэхгүй бол “Энэ буян багатай, чадвар дорой зовсон амьтад тахил өргөвөл сайнсан” гэдэг энэрэнгүй сэтгэлээр бусадад хамт тахил өргөх санал тавина. Ингээд өөрийн сэнхрүүлсэн хүнтэй хоёулаа тахил өргөж болно. Үүнийг бусдыг уриалан тахил гэнэ. Ийм тахилын буян өмнөхтэй ижил.

7) *Эд хөфөнгө ба хүндэтгэлээр тахих*: Будда болон сувраганд хувцас, идээ, олбог, дэвсгэр, эм тан, зориулалтын эдлэл, арц хүж, шүхэр, цэцгэн эрхи, хөгжим мөн төрөл бүрийн зулаар тахил өргөнө. Бас бишрэн ярих, мөргөх, нүүр тулан уулзах, алгаа хавсрах, бүтэн биеэрээ мөргөх, нар зөв тойрох, алт мөнгөн ээмэг, бугуйч өргөнө. Наанадаж хонх, мөнгөн чимэг зүүж, хөшиг хөлтрөг хийж тахина.







8) *Агуу тахил*: Эд хөрөнгө, хүндлэлээр удаан тахихыг хэлнэ. Үүнд долоон зүйл багтана. Олон удаа, тансаг сайхан зүйлээр, бодитой ба эчнээгээр, өөрөө урлан эсвэл бусдыг уриалан, чин сэтгэлийнхээ гүнээс баясан, үнэнхүү сүсэгтэйгээр зөв сайн бүхнээ төгс гэгээрэлд зориулан тахина.

9) *Сэтгэлийн гэм халдаагүй тахил*: Энэ нь зургаан зүйл байна. (1) Тоомжиргүй хандаж цалгайралгүй, залхуурч бусдаар гүйцэтгүүлэлгүй өөрөө гардан хийнэ. (2) Бишрэн хүндэлж, (3) өөр зүйлд сатаarahгүй, (4) шунал хүсэлтэй хольж сэтгэлийн гэм болгохгүй. (5) Буддагийн сургаалд итгэдэг ихэс дээдсээс алдар, ашиг горьдохгүй байхаас гадна (6) тахилд таарах зүйлээр тахина. Харин бажүг мэт эмийн өвс тавих, тос нялах, гүгэл уугиулах мөн арка цэцэг зэрэг нь тахилд таарахгүй. Мөн эвдэрч хэмхэрсэн эд зүйл үүнд хамаарна.

Өөрөө бүтээсэн эсвэл бусад хүн өөрт чинь өгсөн тахилд өргөх зүйл байхгүй байж болох юм. Тэгвэл энэ ертөнцөд гэгээрэгсдийг тахиж буй бүх өргөлийг баходан баясаж хүндэтгэ. Энэ нь гэгээрэлд хүрэх буян хураадаг төвөг багатай, хязгааргүй том тахил юм. Тиймээс жаргал дүүрэн, хөөр баяраар ийм тахил хичээнгүйлэн өргөж бай. *Эрдэнийн тансаг үүл ба Гурван сахил сахих* зэрэг номд өгүүлснээр хэний ч биш хээрийн цэцэг навч, жимс жимсгэнэ, мод бут зэрэг гоё сайхан зүйлээр тахиж болно.

10) *Ёсилон дагах тахил*: Өдөр тутмын ажлаа хийж байхдаа Цаглашгүй дөрөв, Номлолын хураангуй дөрвөн утга, Гурван аврал, Төгс чанарын сургаалыг бодож сана. Гүн үзэл - хоосон чанарт сүсэглэн төсөөллөөс ангид





бай. Ёс зүйгээ чандлан сахихыг хичээ. Гэгээрэл, төгс чанар, дөрвөн хураангуйн зүйл бүрийг хичээнгүйлэн өөриймшүүл.

Энэхүү арван тахилаар эрхэм гурван эрдэнийг тахивал төгс төгөлдөр тахил болдог.


Эдгээр тахилыг өргөхөд санаа бодол нэн чухал. Гурван эрдэнийн алинд нь ч их, бага ямар ч тахил өргөсөн болно. Харин зургаан зүйлийг бодож бай. Тэгвэл үр дүн нь тоочихын аргагүй нэмэгдэнэ. Тахил өргөхдөө дараах зүйлийг бод:


- (1) Үүнээс илүү эрхэм сайн чанартай зүйл үтгүй
- (2) Үүнээс илүү түшиг тулгуур байхгүй
- (3) Тэр бол амьтан бүгдийн дээд нь
- (4) Удамбар цэцэг шиг ховор
- (5) Гурван мянган орчлон ертөнцөд ганц заларсан учир орь ганцхан
- (6) Ерийн ба ер бусын хамаг сайн сайхан бүхэн төгс цогцолсон

*Бодисадвагийн төвшин* номд бичсэн дагуу үүнийг дурьдлаа.

Эдгээр тахилыг байнга зохих ёсоор нь өргө. Шашны баяр, дүйцэн өдрүүдэд чадах чинээгээрээ сайн тахил өргө. Бид үргэлж идэж, ууж байдаг. Тиймээс байнга идээ, ундааныхаа дээжийг өргөж бай. Тэгвэл төвөг багатай их буян хуримтлуулдаг. Тиймээс уснаас өгсүүлээд идэж, ууж буй зүйлийнхээ дээжийг чин сэтгэлээсээ өргө.

Шарава ингэж сургасан байдаг:





Хоолны хөгцөрч муудсан хэсэг, цайны шарласан навчийг бус аль сайнаас нь өргө. Цай уух болгондоо сэргжимдэхийн төдий цацах нь тахил биш.

Гэсэн бол сударт:

Үржил шимтэй хөрсийг хагалаад цаг тухайд нь үр цацалгүй орхиж болохгүй. Үүн шиг энэ ба хойд насны амар амгалан бүхэн соёолох гэгээн талбайд эргэх дөрвөн улиралд амгалан жаргалангийн үр цацах хэрэгтэй. Сүсгийн анжисаар шан татаж, буяны үр суулга.


Энэ үрийг суулгахгүй бол үгээгүй ядуу хоцорно.


Түүнчлэн *Магтвал зохигчийн тагтаал*-д:

Будда тан шиг өгөөмөр хишигтэн  
Гурван ертөнцийн хaa ч байхгүй  
Бурхан бүгдийн оройн дээдэд  
Гагцхүү та л залардаг билээ.

Эцэс төгсгөлгүй хөх огторгуйн  
Эн хэмжээг жиших аргагүй шиг  
Танд тусалсан, хорлосон үйлийн  
Гарцаагүй гарах үрийг хэмжишгүй.  
хэмээн айлдажээ.

Эрхэм дээд энэ буяны орон зайд эгэл жирийн юм гэж очижүүхэн төдий ч байхгүй. Харин бидэнд тийм шинж чанар огт байдаггүй тул эрхэм гурван эрдэнийг үргэлж хичээнгүйлэн тахи!, Тэгвэл энэхүү гэгээн орон зайн нөлөөгөөр зөв дадал соёлон, зам мөрийн шат бүхэнд дотоод хөгжил улам нэмэгдэнэ. Сонссоноо тогтоохгүй,






бодоод ч ойлгохгүй, бясалгаад ч өөриймшүүлж чадахгүй, ерөөсөө оюуны чадвар хүрэхгүй байгаа нөхцөлд буян хуримтлуулах энэ аргыг хэрэглэ. Энэ бол дагавал зохих заавар журам шүү. Энэ тухай хутагт Майдар:


Яруу магтаалын дээдэд таацах  
Ялж төгс нөгцөгчийг дуулахад  
Яндашгүй их эрхэм чанарууд  
Яг л хаврын ногоо шиг ургана.  
Хэмээн өгүүлсэн билээ.

Энэ бол тахил гэдэг зөвхөн эд зүйл бус бидний сүсэг бишрэл гэсэн санаа юм. Тиймээс сүсэг байвал мандал, усаар ч тахил өргөж болно. Тэр бүү хэл санаанд оромгүй зүйлээр ч тахил өргөж болдог. Хэрвээ эд юм байхгүй бол тийм тахил өргөөрэй.

Харин юмтай хэрнээ харамлаж “Надад буян гэх юм юу байхав. Би ядуу хоосон хүн, тахил өргөх зүйл байхгүй” гэж халтар аяганд ганц нэг өвс хийчихээд “Энэ бол гавар, зандантай ус” гэж нэрлэдэг. Энэ бол сохор хүн хараатай хүнийг хуурах гэсэнтэй л адилхан шүү гэж Бодова сургаж байсан.

Пүчүнва “Би анхандаа хүрц эвгүй үнэртэй өвс өргөдөг байлаа. Дараа нь дөрвөн үнэртэн хольсон хүж өргөх боломжтой болсон. Одоо агар, дүрүга мэтийн тансаг үнэртэн өргөдөг” гэсэн байдал. Өөрөө өргөлөө чамлавал насан туршдаа тахил өргөж чадахгүй. Тиймээс өчүүхэн зүйлээр эхлэлээ ч хичээвэл улам бүр нэмэгдэх болно. Пүчүнвагаас үлгэр дууриал авах хэрэгтэй. Түүнийг хожим хорин хоёр алтан зоосоор хүж авч, тахил өргөж байсан гэлцдэг.





Хувилгаан шидийг олсон агуу бодисадва нар биеэ хэдэн түм хувилган, бие тус бүрээ зуун гартай болгон бясалгадаг. Ингээд орчлон өртөнцөд оршин буй гэгээрэгсдийг олон галваар тахидал, үүнтэй өөрийгөө харьцуулж “Би иймхэн тахил өргөөд гэгээрэлд хүрэхгүй юм байна” гэж өөрт буй жаахан ч болов сайн талаа чамладаг. Энэ бол номлолыг дутуу дулимаг ойлгосон хүний үг. *Эрдэнийн тансаг үүл* номд өгүүлснийг баримталбал зохино:

Судрын чиглэлийн ном зохиолоос агуу тахил болон өргөмжлөн хүндлэх тухай судла. Тэгээд чин сэтгэлээсээ, зүрхнийхээ угаас гэгээрэгсэд ба бодисадва нарт тахил өргө.


Хэмээн тэнд өгүүлдэг.


**(в) Их энэрэнгүй сэтгэлийг бодож амьтан бүхнээр аврал эрүүлэх**

Энэрэнгүй сэтгэлийн үүднээс бусад амьтныг аврал эрэх журамд чадах чинээгээрээ сургана.

**(г) Аливаа тохиолдолд ямар ч хэрэг гарсан эгэл жирийн арга хэрэглэлгүй гурван эрдэнийг тахин залбирна.**

Аливаа тохиолдолд, ямар ч ажил үйл хийсэн зөвхөн эрхэм Гурван эрдэнэд найдах хэрэгтэй. Гурван эрдэнийг зохих ёсоор нь тахи. Гурван эрдэнэтэй эс зохилдох бөө, удган мэтэд ямар ч тохиолдолд найдвар тавьж болохгүй. Сэтгэлээ тэр чигт нь зөвхөн эрхэм Гурван эрдэнэд тушаа.





**(д) Аврал эрэхийн ач тусыг санан өдөр гурав, шөнө гурав аврал эрэх**

Аврал эрэхийн ач тусыг *Хураангуй заавар журам* болон тусгай заавар журмын дагуу тайлбарлана.

**(а') Хураангуй заавар журам-д дурьдсан ач тус**  
Үүнийг хоёр хэсэг дөрвөн зүйлээр тайлбарлана.

**(а') Эхний дөрвөн зүйл**

**(1') Агуу буян хураана**  
*Үхэшгүй хэнгэрэгийн дхаани-д:*

Ялж төгс нөгчсон Буддаг  
Гэнэн нь ч, хэрсүү нь ч төсөөлж баршгүй.  
Ялгуун гэгээрлийн номлол сургаалыг нь  
Гэнэтдээ ч, аажимдаа ч төсөөлж баршгүй.


Ургэлж ямагт сайн мөртэй  
Бурсан хуврагуудын оюуныг ч төсөөлшигүй  
Үнэн сэтгэлээр тэдгээрт сүсэглэхийн  
Үр шим, хишигийг ч төсөөлшигүй.


Мөн *Төгс чанарын хураангуй-д:*

Агуу уужим далайн усыг  
Алгаараа хутган хэмжиж болохгүй.  
Аврал эрэх буяныг биежүүлбээс  
Ахуй гурван ертөнцөд багтахгүй.  
гэхчилэн сургадаг.

**(2') Баяр баясталан, дээд ханамж таашаал эдэлнэ**  
*Санаж бодохын цоморлиг-т:*

Өдөр шөнийн алинд ч болов  
Энэрэгч Буддаг бодох аваас





Өршөөл энэрлийг гүйх аваас  
Ирэх төрөлдөө хүн болно.  
гэсэн байдаг.

Буддагаас ийн аврал эрдэг шигээ нөгөө хоёр эрдэнээс ийм бодолтой аврал эрэх хэрэгтэй. “Авралын гурван шүтээнтэй болсон нь миний хувьд ховорхон олз” хэмээн бодож баярла.

**(3') Сэтгэлийн төвлөрөлд хүрнэ мөн (4') Сэтгэл ариусна**

Сэтгэл төвлөрүүлэх ба билэг оюуны заавар журам эзэмшин нирваанд хүрнэ.

**(б') Дараагийн дөрвөн зүйл**

**(1') Mash том өмгөөлөлтэй болно**

Үүнийг хожим өөр бүлэгт тайлбарлана.


**(2') Бүх алдаатай буруу үзэл багасч улмаар арилна**  
Гурван эрдэнээс аврал эрснээр буруу багш, буруу номлол, муу нөхөр зэрэгт итгэн, тэднээс аврал эрж хураасан муу үйлийн үр багасах буюу арилна.


**(3') Оюунлаг сүүтнуудын эгнээнд багтана**

Тэднээс аврал эрвэл оюунлаг сүүтнуудын нэг нь болно.

**(4') Буддын номлолыг таашаагч тэнгэр, хүмүүсийн талархал хулээнэ**

Төгс гэгээрэгсийн эгнээнд багтсанаар багш болон бусад нөхөд чинь баярлана. Харин тэнгэр баярладгийн учир гэвэл тэд “Бид хүн байхдаа аврал эрдэг байсан. Тэгээд төрөл арилжин энд төрсөн. Тиймээс ахин дахин





аврал эрж буй энэ хүн бидний нөхөр болох нь” хэмээн баярлаж, сайшаадаг.

**(β) Бусад гарын авлагад дурьдсан ач тус**

Гурван эрдэнээс аврал эрэхийн ач тусыг бусад гарын авлагад найман зүйлээр тоочсон байдаг.

**(а') Буддын шашинтан болно**

Буддын ба бусад шашин олон зүйлээр ялгаатай. Адиша, Шантипа нар аврал эрдгээрээ бусдаас ялгаатай гэж үзсэн байдаг. Анхлан аврал эрж цаашдаа ч түүнийг орхиогүй бол буддын шашинтан болно. Тиймээс буддын шашинтан болмогдоо эрхэм гурван эрдэнийг миний багш хэмээн үнэн голоосоо хүлээн зөвшөөр. Харин ингэж чадахгүй бол ямар ч зөв дадал төлөвшүүлээд буддын шашинтан болохгүй.

**(б') Сахил бүхнийг авах бололцоо нээгдэнэ**


*Абхидхарта кошагийн тайлбар-т:*


Аврал эрсэн хэн боловч жинхэнэ утгаар нь бүх сахил авах үүдээ нээдэг.

*Аврал эрэх далан шүлэг-т:*

Гурван эрдэнэд өөрийгөө даатгагч жирийн сүсэгтэн найман төрлийн сахилаас авч болно.

Энэ нь Гурван эрдэнээс аврал эрсэн хүний нирваанд хүрэх хүслийг сахил жинхэнэ утгаар нь хангана гэсэн үг юм.





### (в') Урьд хуримтлагдсан хилэнц нимгэрч, барагдана

*Хураангуй заавар журам-д аврал эрэн, гэмээ арилгахаар суралцаж байвал:*

Гахайны домгийг жишээ болгон дагах нь зүйтэй гэсэн байдаг.

Тэр домогт хойд насандаа гахай болж төрөх байсан тэнгэрийн хүү аврал эрсний хүчинд гахай болоогүй тухай өгүүлдэг. Тиймээс аврал эрвэл муу заяанд төрөх шалтгаан арилдаг. Энэ тухай:

Буддагаас аврал эрсэн хэн ч  
Муу заяанд төрөх учиргүй.  
Хүний энэхэн биеэ орхисон ч  
Тэнгэрийн төрлийг олно.

Мөн номлол болон хуврагаас аврал эрэх нь үүнтэй адил үр дүнтэй гэж тэнд өгүүлжээ. Тиймээс урьд хуримтлагдсан гэм нимгэрч арилдаг.

### (г') Агуу буян хураана

Энэ тухай өмнө нь тодорхой өгүүлсэн.


### (д') Муу заяанд төрөхгүй


Үүнийг өмнө өгүүлснээс сайн ойлгож ав.

### (е') Хүн ба хүнээс бусдын хорлолд өртөхгүй

Энэ тухай сударт:

Ухаангүй мэгдэж, балмагдах хүмүүс  
Уулын савдагаас аврал эрдэг ээ  
Удган мод, тахисан овооноос  
Учир эрж, аврал гүйдаг аа.





Авралын дээд нь тэнд байхгүй ээ  
Ачлалт гэгээрэл тэнд оршихгүй ээ  
Амь шигээ үнэнчээр шүтлээ ч гэсэн  
Ахуй орчлонгийн зовлонгоос салгахгүй ээ.

Харин та аврагч Буддад  
Хамгаас үнэн Номлол сургаалд  
Хайрлан энэрэгч бурсан Хуврагт  
Хандаж сүслэвээс зовлон арилна.  
Найман зөв дадлыг мөрдөх нь  
Үлэмжийн дөрвөн үнэнд хүргэнэ.  
Найдвар төрүүлж оюуныг чинь хөтөлж  
Үнэхээр чамайг нирваанд хүргэнэ.

Аврал бүгдийн дээд нь энэ  
Авралыг төрүүлэгч туйл нь энэ  
Ийм авралыг түшсэн хэн ч  
Энэ хорвоогийн зовлонгоос сална.  
гэсэн нь буй.

Үүнийг “Шидэт цалам” хэмээх буддын бус сургаалаас  
аврал эрсэн нэгний домогтой харьцуулан ойлгоорой.

### (ё') Хүссэн бүхэн биелнэ


Шашин номлолын аливаа үйл эхлэхийн өмнө эрхэм  
Гурван эрдэнээс аврал эрэн тухайн зүйлээ биелээсэй  
хэмээн залбирч бай. Тэгвэл хялбархан бүтнэ.


### (ж') Төгс гэгээрлийн төвшинд хурдан хүрнэ

*Арсланд өгсөн хашиулт:*

Сүсэгтэй бол золгүй заяанд төрдөггүй.

Бид онцгой завшаантай тавиланд төрчихөөд байна.  
Одоо Гурван эрдэнээс аврал эрж, гайхамшигт  
сургаалыг нь дагавал төгс гэгээрлийн төвшинд хурдан





хүрнэ. Ач тусыг нь энэ маягаар бод. Тэгээд хоногтоо едөр нь гурав, шөнө нь гурван удаа аврал эр.

**(e) Эрхэм гурван эрдэнийг тоглоом төдийд орхилгүй үнэнч байх мөн аминд тулсан ч үл татгалзах**

Амь нас, бие махбод, хөрөнгө хогшлын аль нь ч хорогдож дуусдаг. Харин ийм зүйлээс болж Гурван эрдэнээс татгалзвал төрөл тутамдаа тасралтгүй зовно. Тиймээс юу ч тохиолдсон эрсэн авралаасаа няцахгүй гэж олон дахин андгайл. Тоглоом наадмын төдийд ч Гурван эрдэнээс татгалзсан утгатай үг бүү хэл.


Хaa нэг тийшээ явахдаа Буддагаас аврал эр гэж багши нар маань сургадаг байсан. Гэхдээ би энэ талаар өгүүлсэн эх зохиол олж үзээгүй.


Харин Адишагийн Гэгээрлийн замыг гэрэлтүүлэгчийн тайлбар-т зургаан ерөнхий журам бий. Мөн бусад гурван журмыг судраас авч тайлбарлана. Үлдсэн гурвыг нь Аврал эрэх зургаан зан үйлийг баримтлан үзүүлнэ. Тэнд:

Шад номыг ч, лагшин дурсийг ч  
Шар орхимж номорсөн хэнийг ч  
Басамжилж огт болохгүй ээ  
Багши мэт дээдлэн хүндэл ээ.

Айлдсан сургаал номыг нь  
Адис аван оройдоо зал.  
Гэгээрсэн эсэхийг нь ялгахгүй тул  
Гэгээн дээдэс мэт хүндэлвэл зохино.  
Хэмээсэн байдаг.

*Нотлон буулгах хураангуй-д буй журмын талаар*  
Гамаба: “Энэ журмыг Ниүсүрва гаргаагүй. Бид хоёр







хамтдаа Гонбава багшаас сонссон” гэсэн байдаг. Харин энэ журам Гонбава багшийн Лүмбавад дамжуулсан тэгээрлийн сургаалд багтжээ.

Энэ журмыг зөрчвөл эрсэн аврал суларч, улмаар түүнийг алдах шалтгаан болно гэж үздэг. Зарим нэг нь тусгай журмын эхний гурав, дээр нь байнга аврал эрэх, аминд тулсан ч үл орхих, Гурван эрдэнэд тахил өргөх гурвыг нэмдэг. Ингээд энэ зургааг зөрчвөл аврал эрэх журам алдагдсан гэж үздэг. Зарим нь өөр өөрийн журмын сүүлийн гурвыг үүн дээр нэмдэг. Тэгээд нийт есөн зүйлийг зөрчвөл авралаа алдсан гэж тооцдог. Харин бусад журмыг зөрчвөл авралын хүч сулардаг хэмээн үздэг билээ.

Гэхдээ аминд тулсан ч орхихгүй гэдэг журмыг зөрчвөл гарцаагүй авралаа алдана. Тэрчлэн эрхэм Гурван эрдэнээс аврал эрдэг атлаа өөр шашныг хүлээн зөвшөөрч хоёрдмол хандлага гаргавал мөн л авралгүй хоцорно. Ингэвэл бусдаас аврал эрэхгүй гэдэг журмыг зөрчсөн хэрэг болно. Мөн гурван эрдэнийн авралд бүрэн итгээгүйн илрэл юм. Харин бусад тохиолдолд зөвхөн аврал эрэх журам зөрчигдөнө. Түүнээс биш авралаа алдахгүй гэж бодож байна.

Ерөөсөө Гурван эрдэнээс аврал эрэх нь буддын шашинд орох үүд билээ. Аврал эрэхдээ хоосон дур эсгэлгүй, үнэн голоосоо хандвал гайхамшигтай эрч хүч өгнө. Тэр цагт дотоод, гадаад ямар ч бэрхшээлд нугарахгүй. Онцгой сайн чанарыг ч хялбархан эзэмшинэ. Эзэмшсэн нь алдагдахгүй улам бүр нэмэгдэх болно. Тиймээс дээр дурьдсан тохиолдож болзошгүй аюулаас сэрэмжил. Мөн гурван эрдэнийн эрхэм





чанарыг санаж бод. Тэдгээр талуудыг нь онцлон аврал эр. Тэгээд аврал эрэх ёс журмаас гажихгүй хичээ.

*Асуулт:* Үхэх нь гарцаагүй гэдэг бодолтой боллоо. Үхээд муу заяанд төрөхөөс эмээдэг. Түүнээс эрхэм Гурван эрдэнэ л аварна. Тэгээд Гурван эрдэнээс аврал эрлээ. Аврал эрэх ёс журмыг огт зөрчсөнгүй. Харин яж аврах юм бэ?


*Хариулт: Цоморлиг-т ингэж өгүүлдэг юм:*





Ахуй орчлонгийн ёсыг таньсан  
Амьтны зовлонгоос салгах хөтөч би  
Ашдын зам мөрийг чинь заалаа  
Араас дагах нь та нарын хэрэг ээ.



Будда бол авралыг заагч багш. Хувраг нь авралд хүргэх анд. Харин эрхэм нандин номлол бол жинхэнэ аврал билээ. Түүнийг өөрийн болгосон цагт аюулаас ангижирна. Гэхдээ номлолыг нэг амьсгаагаар бүрэн эзэмшихдэггүй. Ганц нэг алдаа дутагдлаас салж, ганц нэг сайн чанар эзэмшин дээшлэх замаар суралцаж эхэлдэг. Ингээд улам ахисаар онцгой дээд төвшинд хүрнэ.

Тиймээс одоо зөв, буруу дадал тэдгээрийн үр дагаврын тухай сайн мэдэж авах хэрэгтэй. Улмаар авах, гээх журмыг ёсчлон биелүүлж номлолд суралцах нь зүйтэй. Зөв, буруу хоёр үйлийн үр дагаврыг алсуур бодож зөв алхам хийхгүй бол муу заяанд төрнө. Муу заяанаас айж эмээлгээ гээд аюулаас мултракхгүй.

Буруу дадлаас сэтгэлээ хөндийрүүлэх нь үр дагавар буюу муу заяанаас аврагдах нөхцөл юм. Харин энэ нь үйлийн үрд итгэж үнэмшихээс шууд шалтгаалдаг.







### XIII

## ҮЙЛИЙН ҮРИЙН ҮНДСЭН ШИНЖ

б' Сайн сайханд хүрэх үндэс болсон сүсэг бишрэлийг хөгжүүлэх

1' Үйлийн үрийг ерөнхийд нь эргэцүүлэх


а" Үйлийн үрийг ерөнхийд нь бодох журам


1" Үйлийн үрийг өөрчлөх аргагүй

2" Үйлийн үр үргэлж нэмэгддэг

3" Хийгээгүй үйлийн үрийг амсахгүй

4" Хийсэн үйлийнхээ үрийг амсана





## **б' Сайн сайханд хүрэх үндэс болсон сүсэг бишрэлийг хөгжүүлэх**

Энэ бүлэгт хойд насандаа сайн сайханд хүрэхийн тулд үйлийн үрд итгэж үнэмших сүсэг төрүүлэх мөн үйлийн үрийг ерөнхийд нь болон ширхэгчлэн бодох тухай өгүүлнэ.

### **1' Үйлийн үрийг ерөнхийд нь эргэцүүлэх**

Энэ тухай хоёр хэсгээр тайлбар хийнэ:

1. Үйлийн үрийг ерөнхийд нь бодох журам
2. Үйлийн үрийн төрөл зүйлийн ялгааг эргэцүүлэх

### **а" Үйлийн үрийг ерөнхийд нь бодох журам**


Үйлийн үрийг ерөнхийд нь бодох журам нь дөрвөн зүйлтэй:


1. Үйлийн үрийг өөрчлөх аргагүй
2. Үйлийн үр үргэлж нэмэгддэг
3. Хийгээгүй үйлийн үрийг амсахгүй
4. Хийсэн үйлийнхээ үрийг амсана

### **1" Үйлийн үрийг өөрчлөх аргагүй**

Амьтны агуу их тамд сэргүүн салхи сэвэлзээд өнгөрөх жаргал, гэгээн хутагтын сэтгэл хөндүүрлэх өчүүхэн зовлонгийн аль аль нь урьдын үйлийн үрээс үүдэлтэй байдаг. Жирийн хүн, гэгээнтэн хоёрын хувьд энд ялгаа байхгүй. Буруу үйлээс хэзээ ч сайн сайхан үүсдэггүй.

Урьд хийсэн буруу үйлээс бүх зовлон урган гардаг. Иймээс тамын амьтны амсах өчүүхэн жаргал, хутагтын мэдрэх ялихгүй зовлон ч үйлийн үр хуурмаггүйн гэрч юм. Эрдэнийн эрхи-д энэ тухай өгүүлэхдээ:





Буруу дадлаас зовлон бүхэн  
Бусармаг муу заяа ч эхтэй.  
Зөв дадлаас сайн бүхэн  
Зол жаргалант төрөл ч эхтэй.  
Хэмээсэн нь бий.

Жаргал, зовлон учир шалтгаангүй бий болдоггүй. Мөн Вишну, Ишвара тэнгэр мэтийн холбогдолгүй хөндлөнгийн шалтгаанаас ч үүсэхгүй. Их, бага аль ч үйлийн үр нь мөн тийм хэмжээний зөв, буруу үйлийн өгөгдөл байдаг. Энд ямар нэг алдаа эндэгдэл гараахгүй. Үүнийг танин мэдэж, итгэл үнэмшилтэй болох нь буддын шашинтан бүхний сүсэг бишрэлийн гэрч юм. Энэ бол сайн чанар бүхний үндэс нь билээ.


## 2” Үйлийн үр үргэлж нэмэгддэг


Зөв үйл хэдий өчүүхэн байлаа ч үр дүн нь жаргал байдаг. Мөн шалихгүй муу үйлийн үр дагавар маш их зовлон болж илэрдэг. Харин биет үйл хөдлөлийн үр дагавар сэтгэлийн үйлтэй харьцуулахад тэгтлээ их үрждэггүй. *Цоморилг-т:*

Багахан төдий ч муу үйл  
Хойд насанд аюул дуудна.  
Балга төдий ч хор долооход  
Хамаг биеийг үхүүлэхийн адил.

Ялихгүй ч гэсэн гавьяат үйл  
Хойд насны жаргал дуудна.  
Ялимгүй жижигхэн үр суулгаад  
Арвин ургац хураахтай адил.  
Хэмээсэн байдаг.

Өчүүхэн үйлийн үр дагавар маш их болж өсдөг тухай хуучны домгоос мэдэж авах хэрэгтэй. *Ёс зүйн үндэс-*






ээс малчин Нандагийн таяганд өртсөн мэлхий, мөн Таван зуун галуу, Загас, Яст мэлхий, Таван зуун бирд, Тариачин ба таван зуун шар зэрэг үлгэрийг унш. Түүнчлэн Цэцэн тэнэгийн үлгэр-ийн Суварнадэвата, Суварнавасу ба заан хариулагчийн тухай үлгэрийг үзээрэй. Бас *Ёс зүй, Цэцэн тэнэгийн үлгэр, Зуун үйл* зэрэг номыг уншвал итгэл үнэмшил нэмэгдэнэ.


Бас ёс зүй, зан үйл, амьдралын хэв маяг, үзэл баримтлал дөрвөөс сүүлийнхийг нь зөрчөөгүй боловч эхний гурвыг нь ямар нэг байдлаар зөрчиж сэвтүүлсэн бол лус болж төрнө гэж Будда хэлсэн байдаг. Энэ тухай *Сагарматийн асуултанд хариулсан судар-т:*

Шагжамуни Будда! Аль эрт, энэ галавын эхэнд би далайд амьдардаг байлаа. Кракукчханда Будда гэгээрэлд хүрэх цагт далайд лус, лусын хүү, лусын охин цөөхөн байсан. Надад олон бараа бологч байсангүй. Шагжамуни Будда! Харин одоо далай тоолж баршгүй олон лус, лусын хөвгүүд, лусын охидоор дүүрлээ. Үүний учир шалтгаан юу вэ? гэж асуухад,

Шагжамуни Будда: Лусын эзэн минь ээ. Тэд бүгд буддын ёсоор хувраг болоод номлолд тодорхой заасан ёс суртахуунаа сэвтээлгүй сахиж чадаагүй юм. Зан үйл, амьдрах хэв маяг, ёс зүйгээ төгс сахиагүй хэрэг. Харин үзэл баримтлалдаа тууштай байсан учир тамд төрөөгүй. Гэхдээ үхсэн хойноо лусын оронд төрсөн гэж хариулжээ.

Түүнчлэн Кракукчханда Буддаг номлол зааж байх үед ерэн найман сая, Канакамуни Буддагийн үед жаран дөрвөн сая, Кашьяпа Буддагийн эринд наян сая, бидний





багш Шагжамунийн үед ерэн есөн сая гэргийтэн болон хувраг лусын оронд төрсөн юм. Тэд бүгд зан үйл, амьдрах хэв маяг, ёс зүйгээ сэвтээхийн уршигийг амсчээ. Бидний багш Шагжамуни нирваан дүрийг үзүүлснээс хойш дөрвөн төрлийн сахилтан гэм хийж, ёс зүйгээ сэвтээвэл лусад төрнө гэж хэлсэн байdag.

Тэд алдаа эндэгдэл гаргасан боловч номлолд итгэх сүсгээ гээгээгүй учир үхсэн хойноо лус, тэнгэр, хүний биеийг олсон гэдэг. Сайн цагийн Будда залрах үед түүний гэгээрлийн сургаалыг дагаж, Их хөлгөнийхэн төдийгүй бусад бүх амьтан гаслангаас ангижирна гэжээ.

Тиймээс хэдий бага зөв, буруу зүйл хийлээ ч үр дагавар нь сүүдэр мэт дагаж зүйрлэшгүй жаргал, зовлон үүсгэнэ гэдэг хатуу итгэл үнэмшилтэй бол. Улмаар шалихгүй ч гэсэн сайн үйл бүтээе, ялихгүй ч гэсэн буруу зүйлээс цээрлээ гэж чармайх нь зүйтэй.


#### *Цоморлиг-т:*


Огторгуйд нисэгч шувуунд хүртэл  
Газар унах сүүдэр байдаг  
Олигтой, олиггүй үйл болгонд  
Араас нь боловсрох үр байдаг.

Аяганы хийцгүй гэрээс гарваас  
Аяны замд өлсөх нь лавтай  
Ариун үйлийг хийгээгүй болвоос  
Алсын төрөлдөө зовох нь лавтай.

Хээрийн хүнстэй аянд гарваас  
Хэцийн замдаа оөг цатгалан  
Хичээж буяныг хураасан аваас  
Хэтийн төрөлдөө зовлонгүй амгалан.

Гээд цааш нь:





Аар саархан гэмийн үрийг  
Алсдаа цайрах юм шиг битгий бод  
Ганц ганцхан дуслууд нэмсээр  
Ган торхноос хальдаг шүү дээ.

Бага багахан алдаа нийлсээр  
Баллаж мэдэх хилэнц овоорно.  
Бяцхан жоохон буяны соёолж ч  
Баясгалангийн цэцэрлэг үүсгэж болно.

Тов тов дуслууд нийлсээр  
Торх, хөнөгийг дүүргээд ирнэ.  
Тогтоосон жаахан зөв дадлууд  
Томорч бэхжин гэгээрэл болно.

*Төрөл түүлсан цадиг-т:*


Зөв, буруу үйлүүд аандaa  
Зөв, буруу зуршил болдог oo.  
Дадсан зуршилаа хаяхгүй аваас  
Дараа төрөлдөө ч давтаад явдаг aa.


Өгөөмөр сэтгэлгүй, ёсгүй аваас  
Өнгөлөг гоолиг, баян байлаа ч  
Өндөр дээд угсаатан байлаа ч  
Өнө хойтдоо жаргах нь үгүй ээ.

Өгөөмөр сэтгэл, ариун ёстон  
Өчүүхэн дорий нэгэн байлаа ч  
Өгөөмөр хураар баяжих нуур шиг  
Өнийн төрөлдөө жаргалаар бялхана.

Хүн болсон энэ төрлийн  
Зөв буруу үйлийн үрээр  
Хойд насанд эдэлж амсах  
Жаргал зовлонгийн үүд нээгдэнэ.

Зөвийг дагаж, буруугаас зайлж  
Зөвхөн сайнныг дадал болго.





Ондоогоор явбал дур л биз ээ  
Олиггүй төрөлд л унана биз ээ.  
гэхчилэн сургасан байдаг.

### 3” Хийгээгүй үйлийн үрийг амсахгүй

Жаргал, зовлон амсахын шалтгаан нь хийсэн үйл билээ.  
Хийгээгүй үйлийн үрийг эдэлнэ гэж огт үгүй. Бид одоо  
Буддагийн цогцлоосон барагдашгүй сайн үйлийн үрийг  
эдэлж байна. Энэ гайхамшигт учралын үндсийг бид  
бүрэн дүүрэн хурумтлуулаагүй. Гэвч тодорхой хувийг  
нь бүрдүүлсэн болохоор Буддагийн номлолд суралцах  
аз тохиожээ.

### 4” Хийсэн үйлийнхээ үрийг амсана

Зөв ба буруу үйл нь сэтгэлд таатай, таагүй үр дагавар  
бий болгодог.

*Үлэлж дээдэд зориулсан тагтаал-д:*


Бярманууд харин зөв бурууг  
Өөрөө боловсрох үртэй юутай нь  
Бяруу, тугалын наймаа адил  
Отгч авалцаж болдог гэдэг ээ.


Харин Будда үйлийн үрийг  
Хааш нь ч нуухын аргагүйг хэлсэн.  
Авалцаж өгөлцөх учиргүйг заасан  
Арилжиж солилцох боломжгүйг тайлсан.

*Бясалгалин хаан судар-т:*



Өөрийн тарьсан үйлийн үрээс  
Нуугдах юм шиг андуурахын хэрэггүй.  
Өөр бусдын үйлийн үрийг  
Үүрэх юм шиг айхын хэрэггүй.



*Ёс зүйн үндерс-т:*





Зуун галав өнгөрлөө гэхэд  
Үйлийн үр үрэгдэх нь угүй  
Цаг нь ирмэгц үр нь боловсроод  
Цаг наргүй амсах болно.  
Хэмээн өгүүлсэн байdag.







## XIV




# ҮЙЛИЙН ҮРИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ


- 6” Үйлийн үрийн төрөл зүйлийн ялгааг эргэцүүлэх  
1” Үйлийн арван хэлбэр гол зарчим болох нь  
2” Үйл ба түүний үр дагаврын уялдаа холбоо  
(а) Нүгэл ба түүний үр дагавар  
(а) Жинхэнэ нүгэл  
(β) Нүглийн хүнд, хөнгөний ялгаа  
(а') Үйлийн үр хураах замын ялгаа  
(б') Үйлийн үрийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг хүчин  
зүйл  
(1') Өгөгдлөөс хамааран үйлийн хүч  
нэмэгдэх  
(2') Тухайн хүнээс хамаарсан нөлөөлөл  
(3') Өглөгөөс үүдэлтэй нөлөө  
(4') Сэтгэлээс үүдэлтэй нөлөө  
(γ) Үр дагаврын тайлбар





- (а') Гүйцэд боловсрох үр дагавар  
(б') Шалтгаан болдог үр дагавар  
(в') Орчин тойронд гарах үр дагавар
- (б) Буян ба түүний үр шим  
(а) Арван цагаан буян  
(β) Буяны үр дагавар
- (в) Үйлийн үрийн бусад ангилал  
(а) Хүргэх ба гүйцэлдэх үйлийн үрийн ялгаа  
(β) Тодорхой ба бүрхэг үр дагавартай үйл
- 2' Үйлийн үр ба түүний үр дагаврыг нарийвчлан ялгаж бодох
- а" Гүйцэд боловсрох ашиг тус  
б" Гүйцэд боловсрох үйлийн үр дагавар  
в" Гүйцэд боловсрох үрийн нөхцөл





**б” Үйлийн үрийн төрөл зүйлийн ялгааг эргэцүүлэх**  
Үйлийн үрийн төрөл зүйлийн ялгааг хоёр хэсгээр  
тайлбарлана:

1. Үйлийн арван хэлбэр гол зарчим болох нь
2. Үйл ба түүний үр дагаврын уялдаа холбоо

### **1” Үйлийн арван хэлбэр гол зарчим болох нь**


*Асуулт:* Жаргал, зовлон бүхэн өөр өөрийн шалтгаантай. Хийсэн үйл өсч үрждэг. Хийгээгүй үйлийн үрийг амсахгүй. Мөн хийсэн үйл хорогдож багасдаггүй зэргийг мэдлээ. Харин үйлийн үрийн ямар хуулийг эхэлж судлах вэ? Хэрхэн зөв алхам хийх вэ?


*Хариулт:* Бие, хэл, сэтгэл гурваар хийсэн зөв, буруу бүх үйлийг арав болгон хураангуйлах аргагүй. Гэхдээ Будда гол гол зөв, буруу үйл болон засашгүй том нүглүүдийг тоймлон “арван хар нүтэл” гэж томъёолжээ. Мөн тэдгээр арван нүглээс цээрлэх гол зарчмыг хураангуйлан “арван цагаан буян” гэж номлосон юм. Түүнийг нь арван зөв үйл гэдэг. *Ахидхафтаакома-д:*

Алив үйлүүдийн голыг олоод  
Алмай нь хүртэл ялгахаар болгоод  
Аль нь зөв, буруугаар нь ялгаад  
“Арван үйл” хэмээн сургажээ.

### *Ёс зүйн тайлбар-т:*

Буруут хэлэлгүй үгээ цэнээд  
Бусармаг саналгүй сэтгэлээ цэвэрлээд  
Булхайг хийлгүй үйлээ ариусгаад  
Буддагийн заасан замыг олцгоо.  
гэх зэргээр заажээ.





Арван буруу үйлийн үрийг ухамсарлавал бүх сэдлийг нь ч дарж болдог. Тэгвэл бие, хэл, сэтгэлээрээ арван зөв үйл хийж, буруу бүхнээс сална. Энэ бол гурван хөлгөн, хүний хоёр зорилгыг биелүүлэхийн гол үндэс нь юм. Тиймээс ч Будда үүнийг ихэд сайшаажээ. *Далайн эзэн лусын хааны асуултанд хариулсан судар-т:*


Буян ном, буяны үйл гэдэг бол тэнгэр, хүн бүгдийн сайн сайхан бүхнийг цогцлоох үндэс гэж би хэлнэ. Бас шарвага, брадига нарын гэгээрэлд хүрэх үндэс мөн. Мөн төгс гэгээрлийн үндэс юм. Тэр үндэс нь чухам юу вэ? Тэр бол арван цагаан буян юм.


Гээд цааш нь:

Лусын эзэн минь, жишээ авъя. Бүх хот тосгон, гацаа суурин, улс гүрэн, хаадын харш газар дээр тогтдог. Мөн хамаг өвс ургамал, ой мод, навч цэцэг, эмийн ургамал ч газраас ургадаг. Бас бүх ахуй амьдрал, түүний эд баялаг, тариа ногоо энэ бүхний өгдөг тариан талбай ч бүгд газартай холбоотой. Энэ бүхний үндэс нь газар билээ. Лусын эзэн! Үүнтэй адил арван цагаан буян хийвэл тэнгэр ба хүн болж төрөх, зөв дадлын үр шимийг хүртэхэд суралцах, улмаар бүрэн төгс эзэмшигээний үрийг олно. Брадига нарын гэгээрэл, бодисадвагийн бүх үйл хэрэг, төгс гэгээрсэн буддагийн төвшинд хүрэх үндэс юм.

Хэмээн сургажээ.

Чандракирти *Төв үзлийн тайлбар* номдоо *Арван төвшиг-д* заасан арван буруу үйлийг цээрлэх, ёс зүйг хөхүүлэн магтаж, товчхон байдлаар:





Эгэл хүмүүн, шарвага, брадига, бодисадва нарын хүрсэн  
Эгэлгүй нирваан, дээд төрлийн үндэс нь ёс суртахуунаас өөр юу ч биш.  
хэмээн сургажээ.

Ядахдаа ёс зүйн ганц нэг журам сахиж мөрдье гэж бодлоггүй хэрнээ “Би бол их хөлгөнтөн” гэж ярих хүн бий. Энэ бол үнэхээр гутамшиг. *Кишитига бхигийн судар-т:*

Эдгээр арван буянд суралцах заавар журмыг дагаж гэгээрэлд хүрнэ. Амьд явах хугацаандаа арван буянаас ганцыг ч дагаагүй хэрнээ “Би их хөлгөнтөн. Би төгс гэгээрэлд тэмүүлж байна” гэж ярьдаг. Энэ бол бүх Ялгуулсан гэгээрэгч нарын нүдний өмнө ертөнцийг хуурагч худалч, ёс жудаггүй амьтан. Яах аргагүй бүхнийг үгүйсгэгч үзэлтэн мөн. Ингэж тэнэглэсээр үхэхийн цагт буруу тийшээ явдаг. гэсэн байдаг.

“Буруу тийшээ явах” нь муу заяа гэсэн утгатай байдгийг үргэлж бодож байгаарай.


## **2” Үйл ба түүний үр дагаврын уялдаа холбоо**


Үйл ба түүний үр дагаврын уялдаа холбоог гурван зүйлээр тайлбарлана:

1. Нүгэл ба түүний үр дагавар
2. Буян ба түүний үр шим
3. Үйлийн үрийн бусад ангилал

### **(a) Нүгэл ба түүний үр дагавар**

Үүнийг гурван хэсгээр тайлбарлана:





1. Жинхэнэ нүгэл
2. Нүглийн хүнд, хөнгөний ялгаа
3. Үр дагаврын тайлбар

## (а) Жихэнэ нүтэл

Арван хар нүгэл:

### *1. Амь таслах*


Амь таслах гэж юу вэ? *Хураангуй заавар журам*-д өгөгдөл, бодол, сэдэл, сэтгэлийн гэм, төгсгөл гэсэн таван зүйлээр тодорхойлсон байдаг. Гэхдээ дундах гурвыг нь санаанд багтааж үйлдлийг нь нэмбэл өгөгдөл, санаа, үйлдэл, төгсгөл гэсэн дөрөв зүйлээр томъёолж болно. Тэгвэл ойлгоход хялбар бөгөөд Асангагийн тодорхойлсноос ч зөрөхгүй.


Амь таслах өгөгдөл нь амьд амьтан юм. Асангагийн *Ёгд сурагцах дараалал*-д “өөрөөс нь бусад” буюу “өөр амьтан” гэж тодорхойлсон байдаг. Харин амиа хорлох нь үйлдлийн хувьд хилэнцтэй боловч төгсгөлд нь бий болдог санаа төрөхгүй гэж үздэг. Санаа нь бодол, сэдэл, сэтгэлийн гэм гэсэн гурван зүйл байна. Бодол нь доорх дөрвөн хэлбэртэй байна:

1. Өгөгдөл болох амьтныг амьтан гэж бодох
2. Эсвэл түүнийг амьтан биш гэж бодох
3. Амьгүй зүйлийг амьтан биш гэж бодох
4. Амьгүй зүйлийг амьтан гэж бодох

Эхний ба гурав дахь бодол нь эндуурээгүй, харин хоёр ба дөрөвдүгээр бодол нь эндуурэл болно.

Амь таслах тодорхой бодолтой байдаг. Жишээлбэл, зөвхөн Дэвадаттаг ална гэсэн тодорхой бодолтой байж. Гэтэл эндуурээд Яжнадаттаг албал





буруу өгөгдөлтэй аллага болно. Тодорхой чиглэсэн бодолтой үед эндүүрэх ёсгүй. Харин аль таарсныг нь ална гэдэг ерөнхий бодолтой бол эндүүрэлгүй бодол хэрэггүй. Энэ зарчмыг бусад есөн үйл тухай бүрд зохицуулан ойлгох хэрэгтэй.

Сэтгэлийн гэм нь гурван хорын аль нэгээс үүснэ. Харин сэдэл нь алах хүсэл юм. Энд үйлдэгч болон үйлдэх хэлбэр гэсэн хоёр зүйл байна. Өөрөө эсвэл бусдыг турхирсан аль нь ч ялгаагүй үйлдэгч болно. Үйлдэх хэрэгсэл нь мэс, хор, хараалын шившлэг гэх мэт янз бүр байж болно. Амь таслах үйлдлийн төгсгөлд цаад амьтан тэр дордоо эсвэл хожим үхнэ. *Аехидхафракоша:*


Алуурчин хохирогчоосоо өмнө эсвэл хамт үхвэл жинхэнэ аллага биш. Учир нь алуурчин өөр төрөл авсан байдаг.  
гэсэн байна.


Үүнтэй санал нэг байна.

## 2. Эс өгснийг авах

Бусдын эзэмшиж буй эд зүйл бол эс өгснийг авахын өгөгдөл юм.

Санаа нь гурван хэлбэртэй бөгөөд бодол ба сэтгэлийн гэм нь дээрхтэй адил. Сэдэл нь бусдын зүйлийг зөвшөөрөлгүй авах хүсэл юм. Үйлдлийг гүйцэтгэгч нь өмнөхтэй адил. Харин булаах ба мэдэгдэлгүй хулгайлахын аль аль нь эс өгснийг авсан хэрэг мөн. Мөн зээлснээ эргүүлж өгөхгүй байх, хадгалуулсан зүйлийг нь шамшигдуулах, луйвардах, хууран мэхлэх зэрэг аргаар өөрийн болгох ч үүнд хамаарна. Өөрөө ашиглах эсвэл бусдад ашиглуулах





мөн дайснаа хорлох үүднээс авсан байлаа ч хулгайд тооцогдоно.

*Хураангуй заавар журам*-д “Өөр газарт шилжүүлэх” гэж төгсгөлийг нь тодорхойлсон байдаг. Энэ тодорхойлолт тэр бүр таараад байдаггүй. Эд зүйлийг өөр газар шилжүүлийг гэдэг нь зөвхөн тодорхой нэг тохиолдлоор жишээ татсан хэрэг. Харин тариан талбай гэх мэтийг өөр тийш нь зөөх бололцоогүй. Тиймээс эцэст нь орхиход хүрдэг. Ер нь бол бусдын эд зүйлийг эзэмшинэ гэсэн уг. Бусдыг хулгай дээрэмд өдөөн хатгасан бол мөн эс өгснийг авсанд тооцогдоно. Жишээлбэл, бусдаар хэн нэгнийг алуулсан хүн хохирогч нь үхэнгүүт тэр тухай мэдээгүй байсан ч жинхэнэ амь тасалсан нугэлтэн болдогтой адил.


### 3. Буруу хурьцал


Буруу хурьцлын өгөгдөл нь зохисгүй хүн, зохисгүй эрхтэн, зохисгүй газар, зохисгүй цаг үе гэсэн дөрвөн зүйл байна. Хурьцаад зохимжгүй хүн гэдэгт хурьцах боломжгүй эмэгтэйчүүд, бүх эрчүүд мөн манингууд багтана. Үүнээс эмэгтэйчүүдийн талаар *Хураангуй заавар журам*-д:

Өөрийн эх болон эхийн халамжинд байгаа зэрэг сударт заасан хүнтэй хурьцаж болохгүй.

Ашвагхоша энэ талаар:

Бусдын эмтэй хурьцах зохисгүй  
Бурсан хуврагтай хурьцах зохисгүй  
Халамжийн хүнтэйгээ хурьцах зохимжгүй  
Хaanы цаазтай бол хурьцах зохимжгүй





Хэн нэгэн мөнгөө төлсөн  
Хэрэглэгч эмийг ашиглах зохисгүй  
Хэзээд өөрийн ураг төрөлтэй  
Хэрхэвч ойртон хурьцаж болохгүй.  
гэсэн байдал.

“Бусдын эм” гэдэг нь бусдын эхнэр. “Бурсан хувраг” бол эмэгтэй хувраг юм. “Халамжийн хүн” хэмээх нь хадамд гараагүй, өөрийн эцэг эх зэрэг хамаатан садан, хадам эх эцэг, бараа бологч нарын хараанд байгаа гэсэн уг. Эсвэл журам сахисан эмэгтэй юм. “Хааны цаазтай” гэдэг нь хавьтаж ойртохыг хорьсон хууль цааз. Мөн бусдын мөнгө толж авсан эмтэй хавьтвал буруу хурьцалд тооцогдоно. Харин өөрөө мөнгөө төлсөн бол буруу хурьцал биш гэж үздэг. Адиша ч мөн ингэж үзжээ.

“Хурьцаад зохисгүй эр хүнд” өөрөө болон бусад бүх эрэгтэй хүмүүс багтана.


Утрээнээс бусад эрхтэн нь хурьцаад зохисгүй эрхтэн юм. Энэ тухай Ашвагхоса:


Ам, хошного руу хурьцах нь зохисгүй  
Аарцаг, салтаа руу хурьцах зохисгүй  
Ар өгзөг рүү хурьцах нь зохисгүй  
Аль нэг эрхтнээр орлуулах нь зохисгүй  
хэмээн өгүүлжээ.

Энэ нь Адишагийн хэлсэнтэй ч таардаг юм:

Ам, хошного, жаахан охин, хөвгүүний урд хойд сүв,  
өөрийн гар нь хурьцаад зохимжгүй эрхтэн.

Багш болон сүм хийд, суврага шүтээний ойролцоо мөн олны нүдэн дээр хурьцах бас хавьтахад эвгүй





хазгай муруй, хайрга чулуутай бол хурьцахад зохисгүй газар болно. Энэ тухай Ашвагхоса:

Бурханы хийдэд хурьцалдах зохисгүй  
Буяны сувраг дор хурьцалдах зохисгүй  
Эрхэм багшийн нүднээ хурьцахгүй  
Эцэг эхээс нуулгүй хурьцахгүй.  
гэж заажээ.

Адиша ч мөн ингэж хэлсэн байdag.

Сарын тэмдэг ирсэн, жирэмсний сүүлийн сар,  
хөхүүл хүүхэдтэй байхад, нэг хоногийн сахилтай,  
хавьтах боломжгүй өвчтэй бол хурьцахад зохисгүй үе юм. Мөн тоог нь хэтрүүлж болохгүй. Нэг удаа хурьцах дээд хязгаар тав байна. Энэ тухай Ашвагхоса:


Сарын тэмдэг ирэхэд хурьцахгүй  
Саванд үр олдоход хурьцахгүй  
Үр нь нялх бол эхтэй нь хурьцахгүй  
Үнэхээр дургүй бол хэнтэй ч хурьцахгүй.


Энэлж шаналах өвчтонтэй хурьцахгүй  
Эгээрч гансран уймрагчтай хурьцахгүй  
Энд бас нэг хоногийн найман сахилыг  
Эрхбиш үйлдэгчтэй хурьцаж таarahгүй.  
гэж өгүүлсэн байdag.

Адиша ч мөн ингэж үзсэн бөгөөд ялгаа нь өдрийн цагийг хурьцахад зохисгүй гэсэн байdag.

Өөрийн эхнэртэй зохисгүй эрхтнээр, зохисгүй газар, зохисгүй үед хавьтвал мөн буруу хурьцал болно. Тиймээс бусад хүнтэй хурьцах тухай ярих хэрэгтүй бизээ.

Санааны хувьд бодол, сэтгэлийн гэм, сэдэл





гэсэн гурван зүйл бий. Бодлын тухай *Хураангуй заавар журагт*-д “Энэ бол тэр мөн” гэж эндүүрээгүй бол гэм буруутайд тооцно гэсэн байдаг. Харин *Ёс зүйд* эндүүрсэн, эндүүрээгүй бодлын аль нь ч адилхан завхайрал гэжээ.


Харин *Абхидафмакошагийн тайлбарт* бодлоос нь хамаарч нүгэл болох болохгүй хоёр тохиолдол байна гэсэн байдаг. Өөрийн эхнэр гэж андуураад бусдын эхнэртэй хавьтсан бол буруу хурыцал биш. Харин бусдын эхнэрийг андууралгүй хавьтвал буруу үйл болно гэж Васубандху тайлбарласан байна.


Сэтгэлийн гэм нь гурван хорын аль нэг юм. Сэдэл нь зүй бусаар хавьтах хүсэл. Үйлдлийн тухайд *Хураангуй заавар журагт* бусдыг завхайралд уруу татсан хүн буруу хурыцал хийсэн гэм буруутай болно гэжээ. Харин *Абхидафмакошагийн тайлбарт* үүнийг жинхэнэ буруу үйл биш гэсэн байдаг. Бусдын хатгалганд автсан бол алдаанд тооцохгүй гэж Асанга үзсэн эсэхийг нь шүүн тунгаагаарай. Төгсгөлд нь хоёр хүний хоёр бэлтгээрхтэн нийлнэ.

#### 4. Худлаа ярих

Худлаа ярихын өгөгдөл нь харсан, сонссон, хүртэж мэдэрсэн, сайн ойлгосон эсвэл хараагүй, сонсоогүй, хүртэж мэдрээгүй, огт ойлгоогүй юмс үзэгдэл юм. Мэхлэгдэгч нь хэлсэн зүйлийг ойлгох чадвартай амьтан.

Санаа нь харснаа хараагүй, хараагүй атлаа харсан гэх мэтээр бодит байдлыг өөрчлөх юм. Сэтгэлийн гэм нь гурван хор. Сэдэл нь байдлыг өөрөөр илэрхийлэх юм.





Үйлдэл нь уг дуугарах эсвэл дуугүй зөвшөөрөх мөн биеэр дохио зангаа хийсэн байж болно. Өөрийн болон бусдын тусын тулд худлаа хэлэх ч ялгаагүй гэсэн байдаг. Мөн бусдыг худал хэлүүлэх, хов зөөлгөх, ширүүн уг хэлүүлэх гурав нь тэр үйлдлийг хийсэнтэй адил үр дагавартай гэжээ. Васубандху *Абхидхафтаакшагийн тайлбар*-таа хэлний дөрвөн нүглийг дөрвүүлэнг нь бусдаар хийлгэсэн бол нүгэлт үйлд тооцно гэсэн байна. Харин *Ёс зүй-д зөвхөн өөрөө хэлсэн тохиолдолд жинхэнэ нүгэл болно гэж үздэг.*


Нөгөө этгээд хэлсэн угэнд итгэснээр худлаа хэлэх үйлийн төгсгөл бий болно. Ийм төгсгөл нь гараагүй бол чалчсанд тооцно гэж *Абхидхафтаакшагийн тайлбар*-т бичжээ. Мөн хов ярих, ширүүн уг нь тухайн төгсгөлдөө хүрээгүй бол чалчсан болдог.


### 5. Хов ярих

Хов ярих өгөгдөл нь хоорондоо эвтэй ба дайсагналцсан амьтан. Санааны гурван зүйлийн бодол, сэтгэлийн гэм хоёр нь өмнөхтэй ижил. Харин эв өвдрүүлэх ба эврэлцнийг уlam хүндрүүлэх нь хов ярих сэдэл юм. Үйлдэл нь худал, үнэн ярихын аль нь ч байж болно. Мөн сайн муугаар хэлж дайсагналцуулах, эвдрэлцүүлэх, бусдын болон өөрийн тусын тулд хов ярих ч үүнд хамаарна. *Хураангуй заавар журал*-д “Эвдрэлцүүлсэн гэдгээ ухамсарлавал” төгсгөл нь болно гэсэн бөгөөд салгах уг хэлсэн болохоо өөрөө ойлгож байх явдал юм.

### 6. Ширүүн уг хэлэх

Ширүүн уг хэлэх өгөгдөл нь хорсол занал төрүүлэх амьтан юм. Санааны бодол, сэтгэлийн гэм нь дээрхтэй





адил. Сэдэл нь ширүүн үг хэлэх хүсэл.

Гарал угсаа, бие махбод, ёс суртахуун, ааш зангийнх нь дутагдалтай холбоотой худал, үнэн таагүй зүйл яривал үйлдэл болно.


*Хураангуй заавар журам-д* “Хэн нэгэнд ширүүн хэлбэл төгсгөл нь бүрдэнэ” гэсэн байна. Харин ширүүн үгийг нь сонссон хүн ойлгосон байх ёстой гэж *Абхидахрлакошагийн тайлбар-т өгүүлжээ.*


### 7. Чалчих

Ямар нэг утгатай болон огт авцалдаагүй яриа нь чалчих өгөгдөл юм. Саная нь гурван янз. Асанга бодлыг нь “чалчиж буйгаа мэдэх” гэхээс илүү зүйл хэлээгүй байна. Энэ нь бодож буйгаа зүйлээ ярихын нэр мөн боловч цаад хүн нь заавал ойлгосон байх албагүй.

Сэтгэлийн гэм нь сэтгэлийн гурван хорын нэг байна. Сэдэл нь утга учиргүй, дэмий хоосон ярих хүсэл. Чалчиж эхэлснээр үйлдэл хийгдэнэ. Харин чалчаа яриа нь дуусвал төгсгөлдөө хүрнэ. Чалчих нь долоон төрлөөр илэрнэ:

- (1) Хэрүүл хийх, мууг нь дуудах, маргах, яс хаях
- (2) Буддын бус ном шастир, бярманы нууц тарнид баясах, мөн түүнд орох, түгээн дэлгэрүүлэх
- (3) Ядарсан дуугаар гаслах, хашгирах
- (4) Инээх, тоглоом шоглоом хийх, алиа марзан зүйл ярих
- (5) Хаад, түшмэд болон улс гурэн, хулгайч дээрэмчин мэтийн үймээн самууны тухай ярих
- (6) Согтуу галзуу мэт ярих
- (7) Буруу аргаар амьдардаг хэн нэгний тухай ярих





Утга авцалдаагүй, номлолд харш, учир холбогдолгүй ярианы эхлэл төгсгөл нь хоорондоо ямар ч холбоогүй байдаг. Сэтгэлийн гэм дэврээсэн тоглоом наадам, инээдэм нархиан, жүжгийн уг хэллэг ч үүнд багтана.

Үүний эхний гурвыг нь хэлний нүгэлд тооцно, тооцохгүй гэсэн хоёр байр суурь бий. Би энд эхнийхийг нь авлаа.

### 8. Шунаг зан


Шунаг зангийн өгөгдөл нь бусдын эд хөрөнгө. Санаа нь дээрх гурван зүйл болох бөгөөд бодол нь төөрөлдөөгүй байх ёстой. Сэтгэлийн гэм нь гурван хорын аль нэг байна. Сэдэл нь өөрийн болгох гэсэн хүсэл юм.


Үйлдэл нь хүссэн зүйлээ өөрийн болгох оролдлого. “Энэ минийх боллоо” гэж бодсоноор төгсгөлдөө хүрнэ. Харин Асанга “энэ юм минийх болох болтугай” гэдэг бодлыг төгсгөл гэсэн байна. Шунаг зан дараах таван шинжээр бүрэн илэрдэг:

- (1) Өөрийн эд хөрөнгөндөө маш их харам байх
- (2) Хөрөнгө хогшил цутгуулах хомхой зантай байх
- (3) Бусдын сайхан юмыг байнга бодон хорхойсох
- (4) Бусдын аливаа бүхэн минийх болоосой гэдэг атаархуу бодол
- (5) Шунагтаа хөтлөгдөн ичих нүүрээ гээж, гэм зэмийг нь ойлгохгүй бүрэн автах

Энэ тавын аль нэг нь төрөөгүй бол жинхэнэ шунаг зан гэж үзэхгүй. Энэ таван бодол арван хар нүгэлд шууд багтана гэж *Ёөгд суралцах дараалал-д өгүүлжээ*.

Харин дараах бодлууд нь жинхэнэ шунаг занд хамаарахгүй:






- (1) “Энэ айлын эзэн миний боол болж, хүссэнийг минь хийвэл юутай сайхан”
- (2) Бас эхнэр, хүүхэд болон хоол унд, эд хөрөнгөнийх нь тухай ингэж бодож
- (3) “Намайг шунал багатай, энэ орчлонгийн амьдралаас нүүр буруулсан, хичээл зүтгэлтэй, мэдлэгтэй, өгөөмөр чанартай гэж бусад хүн мэдвэл юутай сайхан”
- (4) “Намайг ихэс дээдэс, дөрвөн зүйлийн сахилтан хуврагууд хүндлэн хоол, хувцас мэтийг өгвөл юутай сайхан”
- (5) Мөн “Би хойд насандаа таван тансаг таашаалд умбасан тэнгэр болж төрөхсөн. Бас Раудра, Вишну тэнгэрийн орноос “Хувилгаан шидийг эрхшээгч”-ийн төвшинд төрөхсөн”
- (6) “Эцэг, эх, хүүхэд, эхнэр, боол болон хуврагуудын эд зүйлийг эзэмших хүсэл


## 9. Үзэн ядах

Үзэн ядах өгөгдөл, бодол, сэтгэлийн гэм гурав нь ширүүн үгийнхтэй адил. Сэдэл нь зодох, цохих зэрэг хүсэл. Мөн “Бусдыг алж, хүлэхэд яадаг юм, эд хөрөнгө, эрүүл мэнд нь доройтоосой” гэдэг бодол нь үзэн ядах нүгэл болно.

Тэрхүү санаагаа гүйцэлдүүлбэл үйлдэл болно. Зодож, нүдэх зэргээр төгсгөлдөө хүрнэ. Мөн доорх таван нөхцөл бүрдвэл жинхэнэ үзэн ядалт гэж үздэг. Харин аль нэг нь илрээгүй бол жинхэнэ үзэн ядалт биш:

- (1) Үзэн ядахаас аргагүй шалтгаан, байр байдалд уурлах
- (2) Хор хөнөөл учруулахад тэвчээр алдрах





- (3) Зүй бус зүйлд уурлах шалтгааныг сэтгэлдээ хадгалан ахин дахин бодож өс санах
- (4) “Яагаад зодож, алж болдоггүй юм бэ” гэж өсөрхөн бodoх
- (5) Ичгүүрээ алдан, гэм зэмийг нь ухамсарлахаа болж, хорлох сэтгэлээ барих чадваргүй болох

Мөн үзэн ядалт нь санаа төдий байж болно. “Энэ надад гай тарьсан” гэж нөгөө этгээдийг хорлох санаа хэдий хэмжээнд агуулна, төдий чинэ үзэн ядалтын хилэнц хураана. Бас бусдын одоогийн садан төрөл, эд хөрөнгө, сайн чанар зэрэг зүйлс нь дордоосой, түүнчлэн хойд насандаа муу заяанд төрөөсэй гэдэг хүсэл ч үзэн ядалтад багтана.


#### *10. Буруу үзэл*


Буруу үзлийн өгөгдөл нь оршин буй юмс. Санаа нь дээрхтэй адил гурван төрөл. Бодол нь үгүйсгэх үзэл санаандаа үнэмшсэн байна. Сэтгэлийн гэм нь гурван хорын аль нэг. Сэдэл нь үгүйсгэх хүсэл.

Үгүйсгэх тухай бодвол үйл болно. Энэ нь шалтгаан, үр дагавар, үйл хөдлөл болон бодит оршихуйг үгүйсгэсэн дөрвөн төрөл байна. Буян, нүгэл зэрэг зүйл байхгүй гэх нь шалтгааныг үгүйсгэж буй хэрэг. Харин энэ хоёрт хожмын нөлөө байхгүй гэдэг бодол бол үр дагаврыг үгүйсгэж буй явдал юм.

Үйл хөдлөлийг үгүйсгэх бодол нь гурван төрөл байна:

- (1) Үр тогтох бойжих үйл явцыг үгүйсгэх нь “эцэг, эх байхгүй” гэж бодохтой адил буруу
- (2) Ирэх, буцах үйл явцыг үгүйсгэх нь “хойд, урд төрөл байхгүй” гэж бодохтой адил буруу





(3) Эргэн төрөх үйл явцыг үгүйсгэх нь “хувилгаан шидээр төрдөггүй” гэж бодохтой адил буруу

Мөн оршин буйг үгүйсгэх нь архад байхгүй гэдэгтэй адил буруу үзэл юм.


Үгүйсгэсэн бодлоо илэрхийлснээр энэ үйлийн үр дүн гарна. Дараах таван хандлага ийм үр дүнд хүргэдэг:


- (1) Ухагдахууны бодит оршихуйг ойлгоогүй мунхаг сэтгэл
- (2) Хилэнц нүгэлд баясдаг хатуу сэтгэл
- (3) Алдаатай үзэл номлол баримтлан дагаж буруудсан сэтгэл
- (4) Өглөг өгөх, тахил өргөх, галаар ариусгах, сайн явдал зэргийг үгүйсгэдэг бүхнийг гутаах сэтгэл
- (5) Ичгүүр сонжуураа гээж, ямар гэм зэм учрахыг нь мэдэхгүй буруу үзэлдээ бүрэн автсан сэтгэл

Энэ таван хандлага бүрдвэл сая буруу үзэл болно.

Өөр буруу үзэл бий. Гэхдээ зөвхөн үүнийг буруу үзэл гэсэн нь бүх буяны үндсийг тасалж, ужид самуунд уруу татан муу бүхнийг хийлгэх гол үндэс болдог. Буруу үзэл нь бүхнээс хамгийн адгийнх нь учир энд багтаасан юм.

Амь таслах, ширүүн үг хэлэх болон үзэн ядах нь сэтгэлийн гурван хороор өдөөгдөөд уур хилэн тэдгээрийг дээд цэгт нь хүргэдэг. Хулгай, буруу хурьцаал, шунаг зан нь мөн сэтгэлийн гурван хороор өдөөгддөг боловч зөвхөн хүсэл тачаалаар төгсгөлдөө хүрнэ. Худлаа ярих, хов ярих, чалчих гурвын өдөөгч болон төгсгөлд хүргэгчийн аль алинд нь сэтгэлийн гурван хорын хувь оролцно. Бас буруу үзэл нь





сэтгэлийн гурван хороор өдөөгддөг. Гэхдээ зөвхөн мунхагаар төгсгөлдөө хүрдэг юм.

Эдгээр арван нүглээс сэтгэлийн гурав нь үйл болдог ч үйлийн илэрхийлэгч биш. Бие, хэлээр дамжин гаргах долоон үйлдэл үйлийг илэрхийлэгч болдог. Харин сэтгэлийн гурав нь үйл болохоос үйлийг илэрхийлэгч биш юм.

### (β) Нүглийн хүнд, хөнгөний ялгаа

Энэ нь хоёр хэсэгтэй:


1. Үйлийн үр хураах замын ялгаа
2. Үйлийн үрийг нэмэгдүүлэхэд нөлөөлдаг хүчин зүйл


#### (a') Үйлийн үр хураах замын ялгаа

Нүгэлт үйлийн уршгийг нэмэгдүүлдэг таван хүчин зүйл байдаг. Үүнийг амь таслахаар жишигээлэн үзүүль. Сэтгэлийн гурван хоронд хүчтэй автан санаатай амь тасалбал уршиг нь хүндэрдэг. Бусад буруу алхмыг үүнтэй жишин ойлгоорой.

Дараах үйлдлээр амь тасалбал уршиг нь улам нэмэгдэнэ:

- (1) Амь тасалсан, тасалж буй, таслах болсон зэрэгтээ баярлаж, баҳархах
- (2) Өөрөө амь тасалж эсвэл бусдыг үүнд өдөөн хатгаж, магтах
- (3) Амь таслахыг хараад сэтгэл хөөрөх, удаан санан дурсах
- (4) Амь таслахдаа үргэлж баярлан нэг дор олноор нь хороох
- (5) Маш ихээр тарчлаан зовоож хороох





(6) Айлган сурдуулж зүй бус зүйл хийлгээд амийг нь хороох

(7) Зовсон, дорой буурай амьтныг амь гүйн өршөөл эрж байхад нь алах

Амь тасалсан гэмээ цайруулахгүй бол уршиг нь улам нэмэгдэнэ:

(1) Өдөр тутам шашны сургаал дагахгүй бол

(2) Хагас сар эсвэл шинийн найман, арван дөрвөн, арван таван зэрэг өдрүүдэд нэг хоногийн сахил аваагүй. Мөн үе үе өглөг өгөх, буян хуримтлуулах, бясалгалд суух, гэмээ наминчлах, мөргөх, залбирах, сүсэглэх зэргийг хийгээгүй бол


(3) Өдрөөс өдөрт ичиж зовоон, гэмшихийг ухаараахгүй бол


(4) Эгэл амьдралын шунал хүслээс ангижрах номлолыг дагахгүй, ойлгоогүй бол

Цусан тахилга үйлдэх буруу үзэлд хөтлөгдөн буян хийж байна хэмээн амь таслах буюу энэ ертөнцийг бүтээсэн эзэн мал адгуусыг нэгэнт хэрэглэх зориулалтаар бий болгосон, тиймээс тэднийг алсан ч гэм болохгүй гэх мэт буруу сэдлээр амь тасалбал уршиг нь улам нэмэгдэнэ.

Үйлийн өгөгдлөөс хамаарч уршиг нь улам нэмэгдэнэ. Том амьтан, хүн, хүний үр удам, эх эцэг, ах дүүсээ хөнөөх, багш тэргүүтэн өөрийг нь хайрладаг нэгэн, номлол заагч, бодисадва, архад, брадигаг хөнөөх, гэгээрэгсдийг хороож болохгүйг мэдсээр байж түүнийг санаатайгаар шархдуулах зэрэг үүнд хамаарна.

Энэ таваас өөр хүчин зүйлээр амь тасалбал уршиг






нь арай хөнгөн байдаг. Бусад есөн буруу үйлийн уршигийг амь таслах нүглийн өгөгдлөөс бусад зүйлтэй нь жишин ойлгож болно. Эс өгснийг авахын хувьд их хэмжээний сайн юм авах, бусдын итгэлийг ашиглах, ядуус, гуйлгачин, хувраг, буддын шашинтны эд зүйлийг булаах, үүцэлж нөөцөлсөн зүйл авах, номлолд суралцагч, архад, брадига, хуврагийн хүрээ болон сувраганаас хулгай хийвэл өгөгдөл талаасаа уршиг нь нэмэгдэнэ.


Буруу хурыцах нь эх, ураг төрөл, дотно хүний эхнэр, гэлэнма, гэцүлма буюу эмэгтэй санваартан зэрэг хавьтахад зохисгүй хүнтэй хурыцах мөн ам мэтийн зохисгүй эрхтнээр хурыцах, нэг хоногийн сахилтай, жирэмсний сүүлийн сар, өвдсон мэт зохисгүй үед хавьтах, суврага болон хуврагийн орон байр хийд мэтийн зохисгүй газар хурыцвал өгөгдлөөсөө шалтгаалан уршиг нь хүндэрдэг.

Төөрөгдүүлэх зорилгоор янз бүрээр худлаа ярих, эцэг эх, бүр гэгээрэгч, анд найз, садан төрөлдөө худлаа ярих болон амь таслах зэрэг гурван ноцтой үйл өдөөн худлаа хэлбэл өгөгдөл талаасаа уршиг нь нэмэгдэнэ. Мөн хуврагийн хүрээний эвийг эвдэх санаархлаар худлаа ярих нь хамгийн хүнд уршигтай үйл болдог.

Эртний нөхөрлөл, багш шавь, эцэг эх, үр хүүхэд, хуврагуудын эв эсийг эвдэх хов ярьсан бол өгөгдөл талаасаа уршиг нь нэмэгдэнэ. Мөн биеийн гурван буруу үйлд өдөөн хатгасан хов яривал уршиг ихтэй.

Эцэг эх, багш зэрэг хүмүүст ширүүн үг хэлэх, зөв ариун зүйлийг ор үндэсгүй хараан зүхэх мөн гүтгэх, загнах, доромжлох нь өгөгдлийн хувьд уршиг ихтэй байдаг.





Чалчих нь өгөгдөл талаасаа хэлний гурван буруу үйлтэй ижил уршигтай. Түүнээс гадна хэрүүл өдөх, бусдын булагийн дэлгэх, маргалдуулан эвдрэлцүүлэх чалчaa уг их уршиг авчирна. Буддын бус номлолыг шохоорхон унших болон эх эцэг, төрөл садан, багшинаараа муулах, өөлөх, доог тохуу хийж зүй бусаар ярих нь өгөгдөл талаасаа уршиг ихтэй.


Хувраг ба суврага шүтээний эд зүйлд шунах болон сайн талаа дөвийилгэн хаад ноёд ба ариун явдалтан, ухаантан сэхээтнүүд энэ талыг минь анзааран магтаж, ергөл өгөөсэй гэж шунаглавал ихээхэн уршигтай.


Эцэг эх, ураг төрөл, багшдаа өс санах, гэмгүй, гүйлгачин дорой, өр нимгэн хүнийг хорлох сэтгэл агуулах, тэрчлэн үнэн голоосоо буруугаа хүлээсэн хүнд өс санах нь үзэн ядах өгөгдөл талаасаа их уршигтай.

Дээр өгүүлсэн бүхнийг үгүйсгэх нь буруу үзлийн өгөгдөл талаасаа ихээхэн уршиг дагуулна. Бусад буруу үзлээсээ илүү их уршигтай байдаг. Мөн энэ ертөнцөд төгс гэгээрсэн архад болон үнэний замаар замнагч, үнэний замд хүрсэн хүн байхгүй гэдэг үзэл ч уршиг ихтэй. Харин энэ бүхнээс бусад буруу үзлийн уршиг бага.

*Төвчиний тодорхой үндэслэл-д үйлийн уршигийг зургаан зүйлээр эрэмбэлэн жагсаасан байдаг:*

- (1) Хүчтэй сэдэл – Энэ бол сэтгэлийн гурван гэмээр өдөөгдсөн эсвэл өдөөгдөөгүй ч маш хүчтэй илрэх үйлдэл юм.
- (2) Дадал – гэдэг нь буян, нүглийг тухайллан удаан хугацаанд олон дахин давтаж зуршил болсон үйлдэл юм.





- (3) Шинж чанар – Бие, хэлний долоон үйлийн уршиг хойноосоо урагшлах тусам улам хүндэрнэ. Харин сэтгэлийн гурван үйлийн уршиг нь урдаасаа хойшлох тусам нэмэгдэнэ.
- (4) Суурь өгөгдөл – Будда, номлол, хувраг болон түүнтэй зүйрлэх нэгнийг хорлох эсвэл туслах буюу тийм үйлэнд хамжилцах.
- (5) Буруу хандлага тогтох - Үхэн үхтлээ зөвхөн нүгэл хийж, ганц ч буян хийхгүй байх явдал.
- (6) Тогтсон буруу хандлагаа өөрчлөх – Нүглийг цээрлэн хүсэл шунаалаас ангижран буян хийх.

*Анддаа илгээсэн захидал-д:*

Үргэлжид санаашран, сэтгэлийн жолоо алдаж  
Үзүүргүй хүслээр тэлүүлсэн ямар ч үйл адилах  
Үнэхээр гол таван чанар болж эгнэгт цогцлох тул  
Үзтэл буян болох зөвүүдийг нь сонгон дадал болго  
гэсэн байдал.


“Гол таван чанар” хөгжүүлэх дээрх гурван өгөгдөл дээр  
эрхэм Гурван эрдэнэ зэрэг эрхэм чанарт өгөгдөл ба  
эцэг эх зэрэг ач тус ихтэй хоёрыг нэмбэл нийт таван  
зүйл болно.


**(б') Үйлийн үрийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйл**

Үйлийн үрийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлийг  
дорвон хэсгээр тайлбарлана.

**(1') Өгөгдлөөс хамааран үйлийн хүч нэмэгдэх**

Эрхэм Гурван эрдэнэ, багш, багштай эн тэнциүү нэгэн,  
эцэг эхдээ хүчтэй сэдэлгүй боловч өчүүхэн төдий





тусалбал их буян хураадаг. Харин хор хөнөөл учруулбал маш их нүгэл хураана. *Гайхамшигт номлолыг үргэлж санах судар*-т энэ талаар өгүүлэхдээ:


Будда, номлол, хуврагийн очуухэн зүйлийг зөвшөөрөлгүй авбал нүгэл ихтэй. Тэднээс зөвшөөрөлгүй авсан зүйлээ тэр даруйд нь буцаан өгвөл Будда болон номлолын өмнө хийсэн гэм цагаадна. Хуврагаас хулгай хийсэн гэм үр дагавраа амсахаас нааш арилахгүй. Хувраг бол маш их хүчтэй өгөгдөл юм.


Хэрвээ хуврагийн бадар аяганаас хоолыг нь авсан бол Амьтны агуу их тамд унана. Хоолноос өөр зүйл авсан бол Амсхийх чөлөөгүй тамын ойролцоо Тас харанхуй там зэрэг газарт төрнө.

Ялангуяа ёс зүйн журмаа зөрчин хуврагийн хувийн эд зүйл, навч цэцэг, үр төдийхнийг нь хэрэглэсэн ч Амьтны агуу их тамд очно. Тухайн тохиолдлоос мултарсан ч хуурай цөлд гар хөлгүй, сохор амьтан болж төрдөг. Эсвэл гар, хөлгүй бирд болж удаан зовон тарчилна. Энэ мэт маш их зэмтэй гэж *Нарны шим судар*-т өгүүлдэг.

Мөн хуврагийн хүрээ - гэлэнгүүдэд зориулж өгсөн цэцэг ч байсан ганцаараа хэрэглэж, гэргийтэнд өгч эсвэл гэргийтэн хэрэглэж огт болохгүй гэж Будда хэлсэн байдаг. Тэгвэл маш хүнд нүгэл болно. *Нарны шим судар*-т:

Хуврагт зориулсан алив юмыг  
Хувьгүй бусдад тараасанд орвол  
Хутга мэсээр гар хөлөө  
Хугалуулж огтлуулах нь хамаагүй дээр.






Ариун хуврагуудад оногдох юмнаас  
Аминдаа хэрэглэж нүгэлд унаснаас  
Арвалзан буцлах гангийн хайлшийг  
Амандаа цутгуулах нь хамаагүй дээр ээ.


Эгэл хүн лам хуврагийн  
Эд өлгийг бүү хэрэглэ.  
Ингэсэнд орвол уул шиг галыг  
Идэх гэж оролдох нь хамаагүй дээр.

Хувраг ламын гэр оронд  
Хоног өнгөрөөж унтсанđ орвол  
Хуу шатах түймэртэй пинđ  
Хурхирч хэвтэх нь хамаагүй дээр.  
гэж өгүүлсэн байна.

Хуврагууд дундаас бодисадва хуврагтай холбоотой зөв үйл маш их буян хураадаг. Харин муу үйл бол асар том нүгэл хураана. *Сүсгийн хүч хөгжүүлэх тутрын тэмдэг судар*-т бодисадвад уурлан “ийм олигтүй хүн рүү харахгүй” гэж түүнээс нүүр буруулбал арван зүгийн хамаг амьтанд өширхөн харанхуй гянданđ хорьсноос хамаагүй их нүгэл хийж буй хэрэг. Мөн хэн нэг бодисадваг доромжлох нь Замбутивийн бүх амьтныг тонон дээрэмдэхээс ч их нүгэлтэй. Бас Ганга мөрний элсний тоотой тэнцүү суврага эвдлэн шатаах нь Их хөлгөнд сүсэглэгч бодисадвад өс санаж, уурласан алдаатай адил уршиг дагуулна.

Мөн *Тодорхой ба тодорхой бусад хүрэх бэлгэ тэмдэг судар*-т арван зүгийн амьтны нүдийг ухчихаад хожим өрөвдөж дахин нүд оруулах нь буян мөн. Урьд нь гянданđ хорьсон бүх амьтнаа суллаж Чакравартин, Бярман тэнгэрийн цэнгэл өдлүүлэх нь буян ихтэй.





Харин их хөлгөний бодисадваг бишрэн харах, бишрэн харахыг хичээх, магтан алдаршуулахын буян тэр бүхнээс үлэмж илүү гэжээ.

*Үлэмж амгаланд тагадтай хүргэгч шидээт судар-т* Замбутийн бүх амьтныг хороох эсвэл бүх хөрөнгийг нь дээрэмдэх уршигтай. Харин өчүүхэн өглөг амьтанд өгөх гэсэн бодисадвагийн сайн үйлд саад хийсэн гэм тэр бүхэнтэй харьцуулшгүй их. Тиймээс бодисадвад маш их анхааралтай хандах ёстой гэсэн байdag.


## (2') Тухайн хүнээс хамаарсан нөлөөлөл


Төмрийн хэлтэрхий хэдий жижигхэн ч усанд живдэг. Харин төмөр сав хичнээн том ч усанд хөвдөг. Учрыг нь мэдэх, мэдэхгүй хоёрын үйлдсэн нүглийн хүнд, хөнгөний ялгаа үүнтэй адил гэж Будда хэлжээ. *Их нирваан судар -т:*

Заваан залхагт барьцалдсан ялаа салж чаддаггүй шиг тэнэг хүн өчүүхэн гэм нүглээс салах чадваргүй байдаг. Алдаагаа ойлгодоггүй учир зөв замд орж чаддагтүй. Хэдий урьд насны буян байлаа ч нүгэл хийж буянаа доройтуулдаг. Тиймээс энэ амьдралдаа эдлэх байсан сайн сайхан бүхэн бүрэлдэхийн оронд тэсвэрлэшгүй там болон хувирдаг.

Энэ нь балга усанд атга давс хийвэл уухын аргагүй болдогтой адил. Хүнээс зээлсэн мөнгөө өгөөгүй бол нүүрийг нь харж чадахгүй зовдогтой ижил.

Амьдралын утга учрыг ойлгоогүй, төлөвшүүлсэн зөв дадал өчүүхэн, ноцтой алдаа гаргасан, алдаагаа наминчилж арилгаагүй, эхнээсээ буян хийгээгүй







таван нөхцөл нь энэ насанд эдлэх сайн сайхан үйлийн үрийг там болгон хувиргадаг.  
Хэмээн өгүүлжээ.

Гэмээ нуухын оронд урьдын алдаандаа гэмшиж, цаашдаа цээрлэж, түүнийг дарах зөв дадал хөгжүүлдэг ухаантан нүглээ нимгэлдэг гэж Будда хэлсэн юм. Харин мэдсээр байж үл тоомсорлон, учрыг нь мэднэ гэж онгиравол уршиг ихтэй.

*Нандин эрдэнийн цогцос сударф-т* гурван мянган ертөнцийн бүх амьтан орчлонгийн хүрдийг эргүүлэгч эзэн болж, Их хөлгөнд ороод дор бүрнээ далай шиг цөгцөнд Сүмбэр уул шиг голтой зул барин Буддагийн сувраганд өргөсөн ч амьдралын учрыг таньсан бодисадва ургамлын тосоор зул асааж суврага тахисан буяны зууны нэг хувьд нь хүрэхгүй гэсэн байдал. Энд санаа зорилго, гэгээрэх тэмүүлэл, тахил өргөсөн сувраганд нь ямар нэг ялгаа алга. Өргөсөн зул нь зорүүтэй ч өргөж буй хувь хүний ялгагдах онцлог асар их ажээ. Үүнээс сахил сахих болон сахил сахихгүй номлолд суралцах зарчмын ялгаа харагдаж байна. Нэг сахилтай, хоёр сахилтай, гурван сахилтай нөхцөлд ч төвшин дээш ахих нь ялгаатай. Жирийн хүн нэг хоногийн сахил аваад өглөг өгөх, сахилгүй үедээ өглөг өгөх хоёрын буяны хүч нь маш их зорүүтэй байдал.

*Ёс зүйн алдааг тас цогцог сударф-т* зуун жил тасралтгүй арван буруу үйл хийсэн хүн их гэм хураана. Харин гэлэн хүн ёс зүйгээ зөрчиж, багшийнхaa хувцсыг өмсөн сүсэгтнуудийн өгсөн хоолыг нэг удаа идсэний гэм түүнээс асар их гэсэн байдал. Будда үүнийг хувь





хүний онцлогоос хамааран алдаа дутагдлын уршиг ихэсдэг гэж тайлбарлажээ.

Мөн *Ёс зүйн тодорхой тайлбар*-т ёс зүй зөрчсөн ба заавар журмаа дагаагүй хэн бүхэнд:

Ёс алдаж, журмаа зөрчиж  
Сүсэгтний идээг хэрэглэсэнд орвол  
Үс хуйхlam дөл оволзсон  
Халуун ширэм залгих нь дээр  
хэлсэн байдал юм.


Гэгээнтэн Донба нэгэнтээ “Номлолд суралцахдаа дээрх гаргасан алдааны дэргэд арван хар нүгэл юу ч биш шүү” гэсэн юм. Энэ яах аргагүй үнэн үг.


### (3') Өглөгөөс үүдэлтэй нөлөө

Амьтанд өгөх өглөг дотроос номлолын өглөг илүү. Харин Буддад өргөх эдийн тахилууд дотроос номлол сургаалыг нь ёсчлон дагах буяны тахил илүү билээ. Бусдыг нь энэ маягаар ойлгох хэрэгтэй.

### (4') Сэтгэлээс үүдэлтэй нөлөө

Нандин эрдэнийн цогцос судар-т гурван мянган ертөнцийн амьтан бүхэн тус бүрдээ Сүмбэр уулын чинээ Буддагийн суврага бүтээв. Зуун сая галвын турш чадлынхаа хэрээр өнөө суврага тахин шүтжээ. Энэ бол их буян мөөн. Гэхдээ төгс гэгээрлийн төвшинд хүрэх тэмүүлэлтэй бодисадвагийн өлмийд ганц цэцэг дэвссэн буян түүнээс ч их гэжээ. Тавысан зорилгын хэр хэмжээ, зорилго нь өөрийн ба өрөөлийн жаргалын алинд чиглэсэн болон санаа бодол нь хүчтэй илэрсэн эсэх мөн тэрхүү санаа бодлоо хэдий хугацаанд хадгалсан зэргээс хамаарч үйлийн нөлөө нэмэгддэг. Энэ бүхнийг судрын





дээрх ишлэлтэй харьцуулан ойлгож ав.

Удаан, хүчтэй үргэлжилсэн сэтгэлийн гэмээс буруу үйл гарна. Сэтгэлийн гэмүүдээс уур хилэн хамгийн хүчтэй нөлөөтэй. *Бодисадвагийн замнал*-д энэ тухай:

Мянган галавт өглөг түгээж  
Мятрашгүй үнэнчээр Буддаг шүтсэн  
Гайхам буяны сайхан үр  
Ганцхан уурлахад хийсдэг нь хайран  
гэж сэрэмжлүүлсэн ажээ.

Өөрийн журмын нөхөд ялангуяа бодисадвад уурлах маш их уршигтай. *Бясалгалын хаан судар*-т энэ тухай:

Хуврагыг хорлох гэсэн  
Гэм нүгэлт сэтгэлийн үр  
Хожим хойтод ерөөсөө арилахгүй,  
Хостгүй ёс суртаалыг дагаад ч арилахгүй.  
  
Сүмд сууж бясалгаад ч арилахгүй  
Сүүлд баахан гэмшээд ч арилахгүй  
Буддаг тахиж мөргөөд ч арилахгүй  
Бусдад өглөг тараагаад ч арилахгүй.


Мөн *Бодисадвагийн замнал*-д:


“Өгөөмөр гэгээн бодисадва нарын тухайд  
Өөнтөгч муу санаалах төдийд  
Өчнөөн хичнээн бодсны тоогоор  
Өнө галавт тамд сууна” гэж Будда хэлсэн.  
Хэмээн айлдажээ.

### (γ) Үр дагаварын тайлбар

#### (a') Гүйцэд боловсрох үр дагавар

Арван хар нүгэл нь өөрсдийн гол үндэс болж буй





сэтгэлийн гурван хорын алинд суурилснаас хамааран их, дунд, бага хэмжээтэй болно. Үр дагавар нь мөн гурван өөр байна. *Төвшингийн тодорхой тайлбар*-т амь таслах зэрэг арван их үйлийн үрээр тамд төрнө. Дунд зэргийн арван үйлийн үрээр бирд болно. Харин бага үйлийн үрээр адгуус болдог гэжээ. *Арван төвшний судар*-т бага, дунд хоёрын үр дагаврыг дээрхээс эсрэгээр тодорхойлсон байдаг.


### (б') Шалтгаан болдог үр дагавар


Муу заяанаас хүн болж төрсөн ч өмнөх үйлийн үр нь дараах муу зүйлсийн шалтгаан болно:

(амь тасалсан учир) нас богино  
(эс өгснийг авсан учир) эд хөрөнгөгүй ядуу  
(буруу хурыцсан учир) эхнэр нь үнэнч бус  
(худлаа ярьсан учир) доромжлуулах  
(хов ярьсан учир) садан төрөлтэйгөө хэрэлдэж салах  
(ширүүн үг хэлсэн учир) сэтгэлд таагүй үг сонсох  
(чалчсан учир) бусад хүн үгийг нь тоохгүй бас тачаал,  
уур, мунхаг нь маш их байдаг.

Үнэнийг өгүүлэгчийн бүлэг ба *Арван төвшний судар*-т буруу үйл нь тус бүр хоёр үр дагавартай гэжээ. Хэдийгээр хүн болж төрсөн ч:

(амь тасалсан тул) богино настай ба өвчин ороомтгой  
(эс өгснийг авсан тул) ядуу ба бусад хөрөнгөө алдах  
(буруу хурыцсан тул) албат нь дуулгаваргүй, итгэлгүй  
ба хань ижил нь шалиг  
(худлаа ярьсан тул) ихэд доромжлуулах ба бусад  
хуурагдах






(хов ярьсан тул) муу найз нөхөртэй ба бусад хүн үргэлж эсэргүүцэн босох  
(ширүүн үг хэлсэн тул) муулуулах ба доромжуулах  
(чалчсан тул) үгийг нь тоохгүй байх ба итгэхгүй байх  
(шунаг тул) аливаад хүлэгдэх ба ханахаа болих  
(үзэн ядсан тул) бусад хүн туслахаас цааргалах ба бусад нь эсвэл өөрөө бусдад хор хөнөөл учруулах  
(буруу үзэлтэй тул) буруу үзэл бодолтой ба зусарч башир зантай болдог.


Хүн болж төрсөн ч амь таслахад дурладаг зан нь шалтгаан болдог үр дагавар буюу урьд хийж байсан үйлдээ таарсан үр дагавар юм гэж ахмад багш нар хэлсэн байдаг.

### **(в') Орчин тойронд гарах үр дагавар**

Амь тасалсан учир гаднаас олддог хоол унд, эм тан, үр тарианы шим муудна. Тэр бүхэн шим тэжээлгүй, шингэц муутай болж өвчин үүсгэх тул ихэнх амьтан цагаасаа эрт үхдэг. Хулгай хийвэл үр тариа муудаж, ургац гарахгүй, ган гачиг ихтэй, хүчтэй аадар орж, үр тариа хатаж үгүй болох үр дагавар гарна. Буруу хурыцвал хaa сайгүй баас шээс, балчиг шавар, намаг тогтох өмхий ханхалсан таагүй орчин бурдэнэ. Худлаа яривал газар тариалан ба арилжаа наймаа хөгжихгүй, эв түнжингүй, байнга хууртагдана. Мөн айдас хүйдсийн олон шалтгаан бий болдог. Хов яривал газар нутаг бартаа саад ихтэй хад чулуу, эрэг гангатай зэлүүд болно. Аюул осол тохиолдох шалтгаан нөхцөл бүрдэнэ.

Шиরүүн үг хэлбэл газар орон хожуул тайрдас, өргөст мод, хад асга, бул чулуугаар дүүрнэ. Мөн далай,






нуур, цөөрөм хатаж ширгэнэ. Эсвэл ус нь хужиртай шорвог, говь цөл, ээрэм эзгүй тал болж аймшигтай араатантай болно. Чалчвал жимсний модны үр боловсрохгүй, боловсорсон ч цаг бусаар үр тогтоно. Эсвэл боловсроогүй хэрнээ боловсорсон мэт харагдана. Ургамлын үндэс муудаж, удаан хугацаанд ч ургахгүй. Үзэсгэлэнт ой цэцэрлэг, цэцэгт хүрээлэн, нуур цөөрөм ховордохын зэрэгцээ айдсын шалтгаан болдог. Шунаг зан гаргавал жил, сар, бүр өдөр хоногийн хамаг сайн сайхан бүхэн дорийтон хомсдож, нэмэгдэхээ болино. Үзэн ядвал элдвийн өвчин тахал, халдварт өвчин, гамшиг зовлон учирна. Мөн гадаадын дайсантай байлдан, хямрал тэмцэл ихдэнэ. Бас арслан, бар зэрэг араатан, хорт могой, хилэнцэт хорхой, галт хорхой шавьж олширдог. Түүнээс гадна аюулт ягчис, хулгайч дээрэмчин олширдог. Буруу үзэл нь сав ертөнцийн ариун гэгээн, эрхэм бүхний эх ундаргыг таслана. Мөн ариун бус, зовлон таригч зүйлс ариун гэгээнд тооцогдох болно. Түүнээс гадна авралд хөтлөх багш, авран өмгөөлөгч нар үгүй болох үр дагавартай.


## (б) Буян ба түүний үр шим

### (а) Арван цагаан буян

*Төвийн тодорхой тайлбар-т амь таслах, хулгай хийх, буруу хурыцахын гэм зэмийг ойлгосон буянт сэтгэлээр тэднээс ангижрах бүхнийг хийн түүнийгээ эцэст нь хүргэх биеийн үйлийг буян гэнэ. Мөн хэлний дөрөв, сэтгэлийн гурван үйл ч үүнтэй адил. Ялгаа нь хэлний үйл, сэтгэлийн үйл гэдэг нэрэндээ байгаа юм гэжээ.*

Буяныг мөн өгөгдөл, сэдэл, үйлдэл, төгсгөл гэж






задалж болно. Амь таслахыг цээрлэх үйлээр жишээ авья. Өгөгдөл нь бусад амьтан. Нүглийн гэм зэмийг ухамсарлаад түүнээс цээрлэх эрмэлзэл нь сэдэл болно. Харин амь таслахаас бүрмөсөн цээрлэх санаа төрвэл үйлдэл болно. Төгсгөл нь огт амь таслахаа болих биеийн үйлдэл юм. Бусдыг нь энэ зарчмын дагуу ойлгож аваарай.


### (β) Буяны үр дагавар

Буян мөн л шалтгаан болдог, хүчтэй нөлөөлдөг, гүйцэд боловсрох гурван төрлийн үр дагавартай. Бага, дунд, их зөв үйлийн гүйцэд боловсрох үйлийн үрээр хүн болж төрнө. Мөн Хүсэлт тэнгэр болон дээд мандлын хоёр тэнгэр болж төрдөг. Шалтгаан болдог ба хүчтэй нөлөөлдөг үр дагаврыг нь нүглийн эсрэг гэж ойлговол зохино.

*Арван төвшний судар*-т эдгээр арван зөв үйлийг эзэмшвэл энэ өртөнцийн амьдралд татагдахаа болино. Бусдыг энэрэн хайрлахгүй байлаа ч бусдын заавраар бясалгавал шарвагагийн төвшинд хүрдэг. Мөн энэрлийн сэтгэлгүй ч бусдын туслалцаагүй өөрөө гэгээрэлд хүрэх эрмэлзэлтэй байж болно. Ингээд юмс үзэгдлийн уялдаа холбоог таньж мэдвэл брадигагийн төвшинд хүрдэг. Харин саруул ухаан, энэрэл хайр, гайхалтай арга барил, агуу зорилгоор нэг ч амьтныг орхилгүй Буддагийн бэлгэ билгүүнд хүрэх эрмэлзэлтэй суралцвал бодисадвагийн төвшинд хүрч, бүх төгс чанарыг эзэмшидэг юм. Энэ бүгдийг хичээнгүйлэн хөгжүүлбэл төгс гэгээрэгчийн бүх мөн чанарыг эзэмшинэ.

Арван цагаан буян ба түүний үр шимиийн тухай





бусад эх зохиолуудад тодорхой тайлбар байсангүй. Тиймээс энэ бүгдийг *Төвийн тодорхой тайлбар* ба *Хураангуй заавар журам* зэрэг зохиолуудаас ишлэн дурьдлаа.

### (в) Үйлийн үрийн бусад ангилал

Үйлийн үрийн бусад ангилын тайлбар хоёр хэсэгтэй:


1. Хүргэх ба гүйцэлдэх үйлийн үрийн ялгаа
2. Тодорхой ба бүрхэг үр дагавартай үйл


#### (а) Хүргэх ба гүйцэлдэх үйлийн үрийн ялгаа

Сайн заяанд хүргэх үйлийн үр нь буян, муу заяанд хүргэх үйлийн үр нь нүгэл байдаг бол гүйцэлдэх үйлийн үр тодорхой бус байдаг. Сайн заяанд төрсөн ч тахир дутуу, зүс царай муу, нас богино, өвчлөмтгий, ядуу тарчиг байдал нь нүглийн үрээс бий болдог. Мөн адгуус, бирд болсон ч аз завшаан, сайн сайхан бүхэн бүрдвэл буяны үр юм.

Ерөнхийдөө хүргэх ба гүйцэлдэх үйлийн үр боловсрох дөрвөн боломж бий. Тухайлбал хүргэх үйлийн үр нь буян байхад гүйцэлдэх үйлийн үр нь буян, нүгэл хоёрын аль нь ч байж болно. Мөн хүргэх үйлийн үр нь нүгэл байхад гүйцэлдэх үйлийн үр нь буян, нүглийн хоёр аль аль нь боломжтой. Асанга *Абхидхарлакоша* номдоо:

Буян, нүглүүд сайн болон муу заяан хүргэхийн сацуу бүрэн гүйцэлдүүлдэг болохыг ухаж ойлго. Хүргэх үйлийн үр нь чухам хаана төрөхийг заадаг бол гүйцэлдэх үйлийн үр нь тухайн олсон төрлийн зовлон, жаргалыг бүрдүүлдэг.





*Абхидхармакоша*-д хүргэх үйлээр тодорхой нэг төрөл авна, харин гүйцэлдэх үйл нь олон байж болно гэжээ. Энэ нь нэг хүргэх үйлийн үрээр ганц л төрөл авахаас олон төрөлд төрөхгүй, харин гүйцэлдэх үйлийн үр олон учир нэг хэвээрээ төгсөхгүй гэсэн уг юм. Мөн *Абхидхармакоша*-т энэ тухай заахдаа:

Ганц төрөлд хүргэдэг нэг үйл бий. Олон төрөлд хүргэдэг нэг үйл ч бий. Нэг төрөлд хүргэдэг олон үйл бас байдаг. Олон төрөлд хүргэдэг олон үйл ч байдаг.

Асанга үүнийг ганцхан хормын үйлээр нэг амьдралын үрийг суулгаж болно. Мөн тэрхүү үйл нь олон амьдралын үрийг суулгасан ч байж болно. Нэг үйлийн олон хором нь ганц л амьдралын үрийг ахин дахин суулгаж болдог. Эсвэл олон үйл өөр хоорондоо сүлжилдэн төрлийн олон хэлхээний үр хөврөлийг байн байн тэтгэдэг гэж тайлбарлажээ.


### **(Б) Тодорхой ба бүрхэг үр дагавартай үйл Төвшний тодорхой тайлбарыг:**


Санаатай хийж, хуримтлуулсан үйлийн үр дагавар тодорхой байдаг. Харин санамсаргүй үйлдсэн болон хуримтлуулаагүй үйлийн үр дагавар бүрхэг юм.

Хийсэн ба хуримтлуулсан үйлийн үрийн ялгааг уг номд тодорхойлохдоо:

Хийсэн үйлийн үр гэж юу вэ? Энэ бол санаж бодсон буюу санаа болон бие, хэлээр хийгдсэн үйл юм.

Гээд цааш нь:






Зүүдэндээ хийх, мэдэхгүй хийх, санамсаргүй хийх, хааяа хорхойсолгүй хийх, эндуурч хийх, мартаад хийх, бусдын эрхээр хийх, шинж чанарын хувьд тодорхой бус үйлдэл, гэмшиж зассан үйлдэл, эсрэг арга хэрэглэн дарсан арван үйлээс бусад нь хуриимтлуулах үйлийн үрд багтана.


Эдгээр арван үйлээс бусад нь хуриимтлагдах үйлийн үр юм. Харин энд дурьдснаас бусад нь хуриимтлуулсан үйл болно.

*Хураангуй заавар журат*-д хийсэн ба хуриимтлагдах үйлийг дараах байдлаар дөрвөн янз тайлбарласан байдаг. Амь тасалсан ч хуриимтлагдахгүй байх нөхцөл нь: үйлийн үрийн тухай мэдэхгүйн улмаас хийх, зүүдэндээ үйлдэх, зориуд үйлдээгүй, бусдын эрхээр хийх. Мөн ганц удаа үйлдээд түүндээ гэмшин, гэм зэмийг нь гүнзгий ухамсарлан дахин давтахгүй гэсэн хатуу тангараг тавиад хэлсэндээ хүрэх. Үр дагавар нь гарахаас өмнө амьдралтай зууралдсан шуналаа дарах. Мөн үйлийн үр нь боловсроогоос өмнө орчлонгоос ангижрах сургаалын үр сэтгэлдээ суулгах.

Хийгээгүй ч хуриимтлагдах нөхцөл: амь таслах гэж удаан бодож, хэрхэн алахаа төлөвлөсөн ч амийг нь хороолгүй орхих. Харин дээрх хоёр нөхцлөөс бусад тохиолдлоор амь тасалбал хийсэн ба хуриимтлагдах үйлийн үр болно. Хийгээгүй ба хуриимтлагдахгүй үйлийн үр нь дээрх гурваас бусад тохиолдол юм.

Эс өгснийг авахаас чалчих хүртэл бусад үйлүүдийг үүнтэй жишиж ойлгох нь зүйтэй. Сэтгэлийн турван үйлийн хувьд дээрх нөхцлүүдийн хоёр дахь нь байдаггүй. Бас эхний нөхцлийн санаатай хийх ба





бусдын эрхэнд автых гэдэг зүйл нь огт байдаггүй юм.


Тодорхой уршигтай үйлийн үр дагавар нь цаг хугацааны хувьд энэ *насандаа амсах, дараа төрөлдөө амсах*, өөр *төрөлдөө амсах* гурван төрөл байна. Энэ насандаа амсах үйлийн үр амьдарч буй тухайн цаг үед боловсордог. *Төвийн тодорхой тайлбар*-т доорх найман үйлийн үрийг энэ насандаа амсана гэжээ:


- (1) Амь бие, хөрөнгө хогшил, энэ амьдралд санаа тавих нь нүгэл учир энэ насандаа зовлон эдэлнэ.
- (2) Харин энэ бүхнийг огт хайхрахгүй бол буян.
- (3) Амьтанд илт хор хөнөөл учруулбал
- (4) Энэрлийг хөгжүүлж, бусдад тусалбал
- (5) Эрхэм Гурван эрдэнэ ба багш зэрэгт илт хайхрамжгүй хандвал
- (6) Тэдэнд ихэд итгэж, биширвэл
- (7) Тэтгэж тусалсан эх эцэг, багш зэрэг хүмүүстээ хор хөнөөл учруулж, ачийг нь хариулаагүй нүглийн үрийг энэ насандаа амсана.
- (8) Харин тэдэнд тусалж, ачийг нь хариулах санаа бодол бол буян бөгөөд үр шимийг нь энэ амьдралдаа эдэлнэ.

*Дараа төрөлдөө амсах* үйлийн үрийг хоёр дахь амьдралдаа эдэлнэ. *Өөр төрөлдөө амсах* үйлийн үрийг гурван төрлөөс хойш хүртэнэ.

Бидний мөн чанарт шингэсэн олон буян, нүглүүдийн үр дагавар дараах байдлаар илэрнэ:

- (1) Хамгийн хүнд үйл нь эхэлж боловсorno.
- (2) Чансаа нь ижил бол үхэх агшинд ой тойнд орсон нь эхлэн боловсorno.





(3) Ой тойнд зэрэг орж ирвэл аль илүү дадал зуршил болсон нь эхэлж боловсorno.

(4) Яг ижил хэмжээнд зуршил болсон байвал аль эхэлж хийсэн үйлийн үр нь түрүүлж боловсorno.

Энэ тухай *Абхидахтаакошагийн тайлбар*-т:

Аль илүү хүнд, эсвэл ой тойнд орсон,  
Аль зуршил болсон, эсвэл эхэлж хийсэн  
Үйлийн үрүүд л эн түрүүнд  
Энэ орчлонд боловсордог юм.


Хэмээн бичсэн байдаг.


## 2' Үйлийн үр ба түүний үр дагаврыг нарийвчлан ялгаж бодох

Арван хар нүглийг цээрлэвэл сайн төрөл олдог. Харин төгс гэгээрэлд хүрэх нөхцөл бүрдүүлэх нь зүйрлэшгүй дээд төрөл юм. Тиймээс ийм завшаан, боломж бүрдсэн заяаг л бүрдүүлэх хэрэгтэй.

### a" Гүйцэд боловсрох ашиг тус

Гүйцэд боловсрох үйлийн үр найман зүйлийн ашиг тустай. *Төгс сайхан амьдрал*: Өмнөх үйлийн үрээр урт наслах зяатай. Тэр ёсоор урт удаан амьдарна. *Төгс сайхан зүс царай*: Өнгөлөг, зөв төрхтэй, царайлаг. Ямар ч согоггүй учир нүдэнд дулаахан, биеийн харьцаа гоо сайхан байна. *Төгс сайхан угсаа*: Энэ амьдралд хүндтэй, нэр алдартай, дээд зиндааны гэр бүлд төрнө. *Төгс сайн хөрөнгө*: Баян чинэлэг, садан төрөл, наиз нөхөд олонтой. *Төгс сайхан яриа*: Бие, хэлээр хуураагүй учир бусад хүн итгэж найдна. Аливаа маргааны эцсийн шалгуур гэрч болдог тул хүмүүс үгэнд нь итгэнэ. *Төгс сайн нөлөө*: Өгөөмөр сэтгэл нь эрэлхэг зориг, хичээл






зүтгэлээр илрэх зэрэг сайн чанартай. Тиймээс алдар хүнд ихтэй, бусдад үргэлж хүндлэгдэнэ. *Эр хүйс*: Эр хүйстэй төрнө. *Хүч чадал*: Урьдах үйлийн үрээр энгийн хор уршиг бага тохиолдоно. Өвчингүй, эрч хүч ихтэй, энэ насандaa санаачлага, зүтгэл ихтэй амьдарна.


Түүнээс гадна эхнийх нь сайн төрөл, дараагийнх нь бие цогцос, гурав дахь нь угсаа гарал, дөрөв дэхь нь хөрөнгө болон нөхөд, тав дахь нь энэ амьдралын шударга үнэний шалгуур, зургаа дахь нь нэр хүнд, долоо дахь нь бүх сайн чанарын эзэн, найм дахь нь ажил хэргийн чадварыг тус тус илэрхийлж байгаа юм.

## б” Гүйцэд боловсрох үйлийн үр дагавар

Гүйцэд боловсрох үйлийн үр дагавар нь мөн найман зүйл байна:

- (1) Төгс сайхан амьдралтай учир өөрийн болоод өрөөлд хэрэг болох их буян хураана.
- (2) Төгс сайхан зүс царайтай учир шавь нар харсан даруйдаа баясан учирч, үгийг нь сонсож, дагах сэтгэл төрно.
- (3) Төгс сайн угсаатай учир хэлсэн үгийг нь дагаж мөрднө.
- (4) Төгс сайн хөрөнгötэй учир бусдыг өглөгөөр татан тэдний сэтгэлийг хөгжүүлнэ.
- (5) Төгс сайхан яриатай учир бусдын чадварт тохиуулан ухуулан сэнхруулж, сэтгэлийг нь хөгжүүлнэ.
- (6) Төгс сайн нөлөөтэй учир бусдын ажил үйлсэд дэм тус болно. Мөн бусдын ачийг мартахгүй. Бусад хүн үгийг нь дагана.





(7) Эр хүйтэй учир бүх сайн чанарын эзэн болно. Эрмэлзэл, хичээл зүтгэл шаардсан ид хав бүхний эзэн болж чадна. Саруул ухаанаар аливаа эрдэм мэдлэгийн эзэн болно. Мөн нөхөртөө түшигтэй, бусадтай хамт явах, ярьж хөөрөх, хөгжин баясах, аглаг газар даянчлахад тээр болж, ухарч няцахгүй.

(8) Хүч чадалтай учир өөрийн болон өрөөлийн хэрэг зоригоос ухрахгүй. Тууштай, маш оргилуун сэтгэлтэй. Аливааг ялгаж салган ойлгох чадвар эзэмшиж бүхнийг шууд танин мэдэх төвшинд хурдан хүрнэ.

## в” Гүйцэд боловсрох үрийн нөхцөл

Гүйцэд боловсрох үр нь найман үндсэн нөхцөлтэй:


1) Амьтанд хор хөнөөл болохгүй, хор хөнөөл учруулах санаа агуулахгүй байх нь төгс сайн амьдрал гарцаагүй боловсрох нөхцөл. Энэ нь:


Цаазын илднээс амьтныг аварч  
Цааз гэсгээлээс өршөөн хэлтрүүлж  
Амь таслахаас зайлж явбал  
Амь нас чинь аандаа уртасна.

Өвдсөн хөөрхийг асарч тэнхрүүлж  
Өвчин эмгэгийг эмнэж, анагааж  
Амьтныг бас хөнөөхгүй байвал  
Айх өвчингүй эрүүл явна.

2) Зул мэт гэгээлэг зүйлс болон шинэ хувцас өргөх нь төгс сайхан царай зүстэй болох нөхцөл. Мөн:

Уур уцаараас салахын цагт  
Уран голшиг чимэг нэмнэ.







Атаяа хорслуу хаяхын цагт  
Ашдын сайхан тавиланг олно.

- 3) Бардам зангаа дарж, багшаа бөхөлзөн дагаж, зарц барлаг мэт бусдыг хүндлэх нь төгс сайн угсаатай болох нөхцөл.
- 4) Гүйсан, гүйгаагүй хоол хүнс, хувцас зэргийг өгөх, зовсонд туслах, эрхэм сайн чанартай хүн болон ядууст өглөг өгөх нь төгс сайн хөрөнгөтэй болох нөхцөл.
- 5) Хэлний дөрвөн нүглээс цээрлэх нь төгс сайхан яриатай болох нөхцөл.
- 6) Дараагийн амьдралдаа олон сайн чанар цогцлуулан эзэмших өрөөл тавин залбирах, эрхэм гурван эрдэнийг тахих, эцэг эх, шарвага, брадига, сахил хүртээсэн багш болон бусад багшийг тахин шутэх нь төгс сайн нөлөөтэй болох нөхцөл.
- 7) Эр хүний давуу чанарт сэтгэл хангалиун байх, эм заяаны сул талыг ойлгон чамлах, бүсгүй тавиланд төрөх хүслийг дарах, эр эрхтэнээ засуулах гэж байгаа амьтныг сулаах нь эр хүйтэй болох нөхцөл.
- 8) Бусдын чадаагүйг бие даан хийх, бусадтай гар нийлэн ажиллах, бусдыг хооллож, ундлах нь хүч чадалтай болох нөхцөл юм.

Эдгээр найман нөхцөл дээр ариун зорилго, ариун ажил үйл, ариун орон зайд гэсэн гурван нөхцлийг нэмж бүрдүүлбэл үр шим нь илүү болно. Ариун зорилго нь өөрт хамаатай ба бусдад хамаатай хоёр зүйл байна. Өөрт хамаатай ариун зорилго:

- (1) Өөрийн эзэмшсэн бүх буянаа зүйрлэшгүй





гэгээрэлд зориулна. Үүнээс өөр гүйцэд боловсрох үйлийн үр горьдохгүй.

(2) Чин сэтгэлээсээ, маш хүчтэй үндэс болсон нөхцлүүдийг бурдуулнэ.


Бусдад хамаатай хоёр ариун зорилт:





(1) Хамт суралцаж буй нөхдийнхөө өөрөөс сайнд нь атаархаж, эн тэнцүүтэй нь өрсөлдөж, доогуурт нь дээрэлхэж болохгүй.


(2) Өөрөө нөхөд шигээ чадваргүй бол бахархан дууриаж, өдөр бүр тэдэнтэй адилхан болох талаар олон дахин бод.

Ариун үйл ажил нь өөрт болон бусдад хамаатай хоёр төрөл бий. Өөрөөс хамаарах ариун үйл ажил гэж өөрөө хүчтэй, тасралтгүй, удаан зөв дадал хөгжүүлэхийг хэлнэ. Бусдаас хамаарах ариун үйл ажил гэдэг бол бусдын эзэмшээгүйг эзэмших эрмэлзэл юм. Мөн буян хийсэн нэгэнд урам зориг өгч магтана. Ингэснээр үргэлж тасралтгүй суралцаж, шантралгүй зөв дадал эзэмшдэг. Ариун орон зай нь зорилт, үйл ажил хоёроос гарсан олон сайхан үр шимээс бүрддэг.

Энэ бүхнийг Асангагийн *Бодисадвагийн төвшинд* өгүүлсэн дээр нэмэлт хийн тайлбарлалаа.








XV


## БУЯНЫ ЗАМ МӨРД ОРОХ

---

---

- 3' Буян, нүглийн үйлийн үрийг бодож эргэцүүлсний эцэст хэрхэн буяны зам мөрд орох ерөнхий ба тусгай тайлбар  
а" Ерөнхий тайлбар  
б" Тусгай дөрвөн хүчээр нүглээс салах арга  
1" Гэмшилийн хүч  
2" Сөрөн дараах хүч  
3" Татгалзах хүч  
4" Тулгуур хүч





### 3' Буян, нүглийн үйлийн үрийг бодож эргэцүүлсний эцэст буяны зам мөрд орох ерөнхий ба тусгай тайлбар

#### а" Ерөнхий тайлбар

Хутагт Шантидэвагийн *Бодисадвагийн замнал*-д:

Бусармаг нүгэл нь зовлонгийн үүсэл тул  
Бушу түргэн бүрмөсөн салах гэж  
Бор хоногийг ч, гэгээн өдрийг ч  
Бодож тунгаасаар өнгөрөөж байна.

мөн:

Арван цагаан буян бүхний уг нь  
Ариун сүсэг гэж Будда сургасан  
Үнэн сүсгийн дээд нь харин  
Үйлийн үрийг бясалгах юм.


гэж өгүүлжээ.


Буян, нүглийн үр дагаврыг мэддэг болсондоо сэтгэл ханаж болохгүй. Дахин дахин бясалгах хэрэгтэй. Маш адarmaатай ойлголт болохоор түүнийг яв цав ойлгоход асар бэрх байдаг. *Бясалгалын хаан* сударт:

Од эрхис сартайгаа ойчиж  
Орон дэлхий хэмхрэн орчиж  
Огторгуй хүртэл зайгаа сэлгэдэг ч  
Онхид Таны үг л үнэнээрээ үлдэнэ.  
хэмээн айлдажээ.

Буддагийн хэлсэн үгэнд итгэж сурах хэрэгтэй. Буддад итгэхгүй бол гэгээрэгсдийг цэнгүүлэгч номлолын юунд ч итгэл үнэмшил төрөхгүй.

Зарим хүн үйлийн үрийг огт ойлгоогүй басхүү үл тоомсорлох хэрнээ би хоосон чанарыг ухаарчихлаа гэж





ярьдаг. Энэ бол хоосон чанарыг огт ойлгоогүйн гэрч шүү. Хоосон чанарыг ойлгоно гэдэг нь юмс үзэгдлийн уялдаа холбоог ухаарахын нэр юм. Энэ нь үйлийн үрийг зөв ухаарах гол тулгуур нь болдог билээ.

### Бясалгалин хаан судар-т:

Үзэгдэх орчлон илбэ зэрэглээ, усны хөөс мэт ээ  
Үзтэл гялбуулагч аянгын цахил, толинд харагдах сар  
шиг хуурмаг

Үхэж биеэ орхиод эрлэгт сүнс нь одох амьтан бүгдийг  
Үүрдийн хутаг олох ч юм уу, үгүй ч юм уу хэн мэдлээ.  
Ийм л хуурмаг хоосон гэтэл үйлийн үр хэтэрхийеэ  
оршиж


Эгнэгт эс арилан буян, нүглийн үр нь боловсорно  
Эгнэшгүй үнэнтэй ч, ухашгүй нарийн шалтгаан болоод  
учрыг


Эрхэм дээд бурхан Будда л тайлан хэлж чадах билээ.  
гэж өгүүлсэн билээ.

Тиймээс юмс үзэгдлийн уялдаа холбоо, үйл хоёрыг  
үйлийн үрийн зүй тогтол гэж ойлгох нь зүйтэй. Тэгээд  
бие, хэл сэтгэл гурваа өдөр, шөнийн алинд нь ч хянаж  
чадвал муу заяанаас зайлж чадна. Анхнаасаа үйлийн  
үрийн зааг ялгааг сайн ойлгохгүй эсвэл дулимагхан  
ойлгоод бие, хэл, сэтгэлээ зоргонд нь хаявал муу  
заяаны үүдийг татна гэсэн үг. *Сагарагатийн  
асуултанд хариулсан судар-т* энэ тухай:

Лусын эзээн! Бодисадвагийн ганц сайн чанар муу  
заяанд төрөх буруу үйлийг тасалдаг. Тэр ямар чанар  
вэ? “Би гэдэг юусан билээ? Өдөр шөнийг хэрхэн  
өнгөрөөнө вэ?” гэж буян мөн эсэхийг шинжих чанар  
юм.

ХЭМЭЭН ТЭМДЭГЛЭЖЭЭ.





Үүнтэй адил өөрийгөө шинжих тухай ахмад багш нар сургахдаа:

Үйлийн шалтгаан, үр дагаврыг судалж байхдаа өөрийгөө номлолтой харьцуулаад үз. Таарч тохиорх юм үнэндээ гарахгүй, бид ийм ухаан мөхөс болохоор гэгээрэлд хурдэггүй. Бие, хэл, сэтгэлийн алхам бүрээ үйлийн үрийн сургаалтай нийцэх эсэхийг нь ч үз. Өөрийгөө сургаал, номлолтой харьцуулж үзээд нийцэх зүйл байхгүй гэдгийг чин үнэнээр хүлээн зөвшөөрч чадваас ухаалаг хүн мөн. *Цоморлиг*-т ингэж айлдлжээ:

Тэнэг гэдгээ хэн мэднэ  
Тэр хүн ухаантан мөн.

Өөрийн үйлдлээ номлолтой харьцуулж үзэхэд хүүр үүрчихсэн мэт хоёр тийшээгээ харчихсан байвал өөрийгөө ариун, гэгээнд тооцдог ч адгийн тэнэг хүн шүү.


*Цоморлиг*-оос:


Ямар ч тэнэг ухаантай гэж бодовч  
Ямагт улс тэнэгээр нь л дуудна.

Адаглаад өөрийгөө номлогоос ямархан зайдай яваагаа мэдэж бай гэж зөвлөсөн байдал.

Мөн Бодова өөрийн сэтгэлээ байнга шинжихийг зөвлөдөг байсан билээ. Тэрээр *Төрөл туулсан цадиг*-аас доорх мөрийг иш татдаг байлаа:

Газар тэнгэрийн хооронд зайдуу  
Гадаад далайн эргүүд зайдуу





Ар, өврийн уулууд зайдуу  
Амьдрал болоод номлол зайдуу.

Энэ жишээ жирийн бид үйл номлогоос дэндуу тасархай байдгийг үзүүлжээ. Дээрх ганц бадаг номлолыг бодисадва Чандра сургаал хэлж амь зуудаг бярман Субхаситад мянган алтан зоос өгч сонссон юм гэдэг.  
Мөн Долүнба гэгээн:

Бодож тунгаах чадвартай нэгэн өөрийгөө шинжвэл уруу газар өнхрүүлсэн утасны дамар шиг номлогоос холдон одсоноо ойлгоно.  
Хэмээсэн аж.


Энэ мэтээр бодвол алдаа дутагдлаас зайлдаг жамтай.  
Энэ талаар *Үнэнийг өгүүлэгчийн бүлэгт*:


Амь бүү тасал, хүчирхэг хаантан минь!  
Амьтай бүхэнд ганц олдсон амьдрал нь үнэтэй.  
Урт насалж удаан жаргахыг мөрөөддөг болж гэм  
Уршиг тарьж амьтан хөнөөхийг бодохын ч учиргүй.  
Гэж хэлсэн байдал.

Энд өгүүлснээр арван хар нүгэл ба урьд өгүүлсэн засашгүй гэм нүгэл зэргийг санааны төдий ч бүү гарга.  
Түүнийг цээрлэн жигшиж хэвш, олон дахин давт.

Ингэж алдаа дутагдлаас салахгүй бол хүсээгүй ч зовлон эдлэх болно. Өөр зайлах газар байхгүй. Тиймээс огт хүсээгүй байтал үйлийн үр нь боловсроод нулимсаар нүүр угаадаг зуурдын жаргал амсах зүйл бүү хий. Харин үр шим нь баяр, жаргал эдлүүлэх аливаа бүхнийг хийх нь зүйтэй. Энэ тухай *Цоморлигт*:

Зовохоос хэрвээ айдаг бол  
Зовиур шаналаанаас халширдаг бол





Бор хоног, шар өдрийн алиинд ч  
Буруу үйлээс ямагт зайлсхий.

Буруу үйлийг нэгэнт үйлдвэл,  
Болихгүй тэгээд цааш нь хийвэл  
Зовлон чамайг салахгүй дагана,  
Зугтаж бултах газаргүй болно.

Үйлийн үрээс нуутдах газар  
Үнэнийг хэлэхэд хаа ч үгүй.  
Сансраас ч, далайгаас ч чамайг олно  
Сарьдаг хясаанд нуутдсан ч олно.

МӨН:

Өчүүхэн бодолтой дорой нялхас  
Өөрийгөө хөнөөх дайсан болдог  
Үйлийн үр нь эргээд түймэрдэх  
Үлэмж буруу үйлүүдийг хийдэг.


Голт зүрхийг эмтлэн шаналаах  
Гашуун нулимсаар нүүр угаах  
Үнэнхүү зовлонтой үр дагуулах  
Үйл бүхнээс зайлах нь чухаг аа.


Барцад гэм зовлонгийн оронд  
Баяр жаргал цогцлоож ирдэг,  
Сайхан үрийг ямагт дагуулагч  
Сайн үйлийг үйлдэх нь чухаг аа.

Аз жаргалын хүсэлд автаад  
Алдаа эндүүтэй үйлийг хийвээс  
Аймшигт үр нь дорхноо боловсорч  
Араас чинь гүйцэн тарчлаах болно оо.

МӨН:

Алдаа мартагдавч үйлийн үр нь  
Арилж ховхрон элэгдэх нь үгүй





Амьтан бүхний үйлийн үр  
Алсдаа боловсроод амдан тосно.

Аймшигт үр боловсорч гүйцээд  
Аюус тамд унахын мөчид  
Аль эргэд алдаж эндсэнээ  
Амьтад хөөрхийс сая л ухаардаг аа.


Гээд цааш нь:


Хөх төмрийг улаан зэв нь  
Хөнөөж өөрийг нь идэхийн адил  
Хүн амьтны сээрэмжгүй явдал  
Хүйтэн халуун там руу хөтөлнө.  
Гэхчилэн сургасан байна.

Хамлунба Пүчүнвад хандан “Миний багши Долба үйлийн үр л хамгаас чухал гэдэгсэн. Одоо ч үйлийн үрийг номлох, судлах, бясалгах нь ямар ч үнэ цэнэгүй болжээ. Ганц үүнийг өөрийн болгох тийм хэцүү гэж үү?” гэхэд Пүчүнва “Тэр үнэн шүү” гэж хариулсан гэдэг.

Долба гэгээн бээр “Адишагийн шавь нар минь. Өөртөө хэтэрхий эрдэх хэрэггүй. Үйлийн үр гэдэг нарийн шүү” гэдэг байлаа. Харин Пүчүнва “Өвгөн болсон хойноо ч би Цэцэн тэнэгийн үлгэр-ийг үзэж сууна” гэсэн юм. Мөн Шарава “Будда ямар ч зовлон гачлан тохиолдсон газар орон, байр сууцыг буруутгаж байгаагүй. Харин ийм үйлийн үрээр тэнд төрлөө гэж л ярьдаг байсан” гэдэг байлаа.

**б” Тусгай дөрвөн хүчээр нүүглээс салах арга**  
Алдаа гаргахгүйг хичээсэн ч болгоомжгүй байдал, сэтгэлийн олон гэмийн эрхээр алдаа гаргах нь бий. Харин үүнийгээ тоолгүй орхиж огт болохгүй.





Энэрэнгүй Буддагийн номлосон засаж залруулах аргыг хичээнгүйлэн дагах хэрэгтэй.

Гэм буруугаа засахдаа гурван төрлийн сахилд дурьдсан журмыг ашиглаж болно. Хилэнц нүглээ дөрвөн хүч ашиглан засдаг. *Дөрвөн чанар номлосон судар*-т энэ талаар:

Майдар минь, бодисадва, их бодисадва нар дөрвөн их хүч эзэмшивэл хийсэн болон хураасан алдаагаа арилгаж болно. Тэр нь ямар дөрвөн чанар вэ? Тэр бол ихэд гэмших, сөрөн дарах, татгалзах, тулгуур хүч дөрөв юм.

Нэгэнт хийгээд, хураачихсан үйлийн үрийг амсах нь тодорхой. Гэтэл энэ дөрвөн хүч түүнийг ч дардаг ажээ. Тэгэхээр үр дагавар нь тодорхой бус бусад үйлийн хувьд яриангүй сайн нөлөө үзүүлнэ.


## 1” Гэмшилийн хүч


Эхлэлийг нь тогтоох аргагүй цаг хугацааны эхнээс л нүгэлт үйл хийж байсандаа ахин дахин гэмш. Гүйцэд боловсрох үр дагавар зэрэг гурван үйлийн үр үүсдэг зарчмыг бясалгавал гэмшил төрөхөд тус болдог. *Алтан гэрэл судар*-ын Наминчлалын бүлэг болон *Гучин таван Буддагийн сургаал* хоёрыг гарын авлага болгон үүнд суралцаарай.

## 2” Сөрөн дарах хүч

Энэ нь зургаан хүчин зүйлээс бүрдэнэ:

- 1) *Гүн утгат сударт тулгуурах. Билгийн чандад хүрэхүй судар зэрэг бүтгэлүүдийн санааг ухаж, тогтоож, унших.*





- 2) *Хоосон чанаарт итгэх*. Би - үгүй ба гэгээн гэрлийн мөн чанарыг өөрийн болгох. Мөн сэтгэлийн язгуур чанар нь ариун гэдэг итгэл үнэмшилтэй болох.
- 3) *Тарни тоолох*. Зуун үсэгт зэрэг гайхамшигт тарнийг ёс журмаар нь тоолон унших. *Субахугийн асуултанд харцулсан судар-т өгүүлэхдээ:*

Тахиж баримтлах ёс зүйн салхин  
Тарнийн галыг хөгжөөн ноцоогоод  
Үнэн зүтгэлийн халуун дөлөөр  
Үзтэл гэмүүдийг шатааж хүйхлах нь


Хаврын цагийн хуурай модонд  
Хальтхан үсэрсэн ганцхан оч  
Хажуугийн салхинд хөгжин дүрэлзээд  
Хамаг ойг түймэрдэхийн адил.


Дагасан ёс зүйн гэгээн наранд  
Дагалдуулж униссан тарнийн ном  
Авралын илчээр эх мэтээр  
Алдаа эндлийн цасыг хайлцуулах нь

Мөнх сарьдгийн өвөр энгэрийг  
Мөнхүү гэрлээр эх нартан  
Цагийн хүйтэнд хунгарласан цасыг  
Цаглашгүй илчээрээ хайлцуулах мэт ээ.

Мянган төрлийн хилэнцийн харанхуйг  
Тарнийн зулаар хөөж гийгүүлэх нь  
Машид харанхуйд өргөсөн зул  
Тэр дорхноо гийгүүлэх мэт ээ.  
Хэмээсэн байдал юм.

Нүгэл арилсан шинж тэмдэг илэртэл тарниа унших






хэрэгтэй. *Урин даллах дхаарини*-д гэм арилсан шинж тэмдэг нь зүүдээр илэрдэг, зүүдэндээ муухай хоол, тараг сүү уун огиулна, мөн нар сар үзэгдэнэ, огторгуйгаар ниснэ, гол бадарна, том үхэр эсвэл хар хүнийг дийлийн, гэлэн, гэлэнма нарын хуврагийн хүрээг харна, сүү гардаг мод, заан, эцэг мал, уул, арслант ширээ, сайхан байшин өөд авирч эсвэл номлол сонсох зэрэгээр зүүдлэнэ гэжээ.


- 4) *Хөрөг дүр шүтэх*. Буддад сүсэглэн хөрөг дүрийг нь бүтээх.
- 5) *Taxil өргөх*. Будда болон түүнд зориулсан суврага зэргийг зүйл бүрээр тахих.
- 6) *Алдар хүндэд тулгуурах*. Будда болон их бодисадва нарын алдар нэрийг сонсож, тогтоох.

Энэ зургаа нь зөвхөн Шантидэвагийн *Хураангуй заавар журал*-д дурьдсан зүйлс бөгөөд өөр олон арга бий.

### 3” Татгалзах хүч

Энэ бол арван нүглээс бүрмөсөн татгалзах хүч юм. *Нафны шил судар*-т энэ хүч амь таслахаас эхлээд бие, хэл, сэтгэлээр хийсэн үйл, сэтгэлийн гэм бүхнийг дарна. Сэтгэлийн гэм, номлол зөрчсөн үйлдэл мөн өдөөн хатгасан ба хөхүүлэн дэмжсэн зэрэг өмнө нь хийсэн нүгэл бүхнийг дарна гэжээ. Дхармамитра *Ёс зүйн их тайлбар*-таа чин сэтгэлээсээ хандахын оронд “Наминчлах төдийгөөр буруу үйлийн үр дарагдах болов уу?” гэж бодох нь буруу гэдэг Буддагийн үгийг иш татсан байдаг. Мөн хожим дахин хийхгүй гэдэг хатуу шийдвэр маш чухал. Энэ бүхэн гэмшилийн хүчинээс шууд хамаардаг.





#### 4” Тулгуур хүч


Гурван эрдэнээс аврал эрэх болон гэгээрэх тэмүүлэл хөгжүүлэх нь тулгуур хүч юм. Будда эхлэн суралцагч нарт зориулан гэм буруугаа арилгах олон арга заасан. Гэхдээ энэ дөрвөн хүч бүгд нийлж нүглийг бүрэн арилгаж, төгс төгөлдөр болдог.

Гэм буруу дараах байдлаар арилна. Муу заяаны асар их зовлон үүсгэх үйлийн шалтгаан нь багахан зовлонгийн шалтгаан болж хувирна. Муу заяанд төрсөн ч түүний зовлонг амсахгүйгээр энэ амьдралд толгой өвдөх төдийгөөр өнгөрч болно. Мөн удаан эдлэх учиртай үйлийн хугацаа хорогдоно. Бүр огт амсахгүй өнгөрөх тохиолдол ч бий. Гэхдээ тухайн хүний сэтгэлийн хүч, гэмээ цагаатгах дөрвөн хүч бүрдсэн эсэхээс шалтгаална. Түүнээс гадна энэ аргыг хэр хүчтэй, удаан хэрэглэж буй зэрэг олон зүйлээс хамаардаг. Тиймээс тодорхой хэлэх аргагүй.

Судрын аймаг ба ёс зүйн судруудад “зуун галав болсон ч үйлийн үр барагдахгүй” гэсэн байдаг. Энэ бол гэмээ цагаатгах дөрвөн хүчийг бясалгаагүй тохиолдлыг хэлж буй хэрэг. Харин дээр заасан ёсоор гэм цагаатгах дөрвөн хүчинд суралцвал гүйцэд боловсрох үйлийн үр арилна гэсэн байдаг. Харибхадра *Билэг оюун төгөлдөржүүлэх найман тянган бадагт судрын их тайлбар*-т энэ тухай:

Гэм цагаатгах дөрвөн хүчийг бий болгох тусам гэм буруу хорогддог жамтай. Энэ дөрөв маш хүчтэй байвал бүр арилах нь дамжигтгүй. Алтыг тунгааж цэвэрлэхтэй адилтгаж болно. Гэгээн номлол зөрчсөн алдаа зэрэг бүх гэм мөн энэ жамаар арилна. Бардам





зангийн алдаа эндэгдлийг ч арилгана.


Харин “зуун галав болсон ч үйл үр барагдахгүй” гэснийг “гэм цагаатгах дөрвөн хүчинд суралцаагүй” нөхцөлд гэж ойлгох хэрэгтэй. Тэгэхгүй бол олон аман айлдвар, учир зүйн нотолгоо зэрэгтэй зөрчилдөнө.


Будда гэмээ арилгах дөрвөн хүчинд суралцахгүй бол “гүйцэд боловсрох үйлийн үрээ амсана” гэж хэлсэн. Харин энэ дөрвөн хүчинд суралцаагүй ч зарим үйлийн үрийг “амсахгүй өнгөрч болно”.

Гэмээ наминчлах, цээрлэх зэргээр гүйцэд боловсрох үйлийн үрийн уршгийг сулруулж болно. Тэгвэл нөхцөл нь бүрдлээ ч гүйцэд боловсрох уршиг нь илэрдэггүй, энэ буянаар буруу үзэл ба үзэн ядахын үндсийг ч устгаж болно гэсэн байдаг. Бхававивека *Учир шалтгааны дөл-дөө:*

Нэгэн цагт буян буруу үзэл, хорлох сэтгэлд дарагдаж болно. Үүнтэй адил нүгэл наминчлах, андгай тангараг, гэмшил зэрэг гэмээ цагаатгах хүчинд үйлийн үр суларч болно. Энэ бүхэн тухайн нөхцөл байдлаас шалтгаалдаг. Үр хөврөлийнх нь хүч суларсан буян, нүглийн үр дагавар гарахгүй. Нөхцөл нь бүрдэхгүй байгаа учраас үр дагавар нь илрэх цаг нь хойшлогдохоос биш ор мөргүй арилна гэж байхгүй. Үүнийг сударт “Тэгээн номлолыг дагагчийн гүйцэд боловсрох үйлийн үр нь энэ насандаа боловсордин” гээд “Гэмээ арилгах дөрвөн хүчээр муу заяанд төрөх үйлийн үр нь одоо толгой өвдөх төдийгөөр илэрдэг” гэсэн байдаг.

*Эргэлзээ:* Хэрвээ толгой өвдөх төдий болж





хувирдаг юм бол үр хөврөл бүрмөсөн устсан мэт үзэж болно гэж үү?

*Тайлал:* Бүх нүглийн үр дагавруудаас хамгийн аймшигтай нь болох тамын зовлонг амсаар ёстой байсан гэж бодьё. Гэтэл дөрвөн хүчний ачаар тэр зовлонг өчүүхэн ч эдлэхгүй өнгөрч болно. Энэ нь үр хөврөлийг устгаж байгаа хэрэг биш гэж үү? Толгой өвдөх мэтээр өнгөрөх нь үйлийн үр бүрмөсөн өөрчлөгдж байгаа явдал биш үү?!


Сэтгэлийн гэмийн үр хөврөлийг устгах арга сураагүй байлаа ч түүнийг сулруулах сөрөг нөхцлийг нь бүрдүүлбэл үйлийн үр илрэх боломжийг хаадаг. Гадна, дотны олон зүйлээс үйлийн үр дагавар хэрхэн бий болж буйг харж болно.


Их буян хуримтлуулахыг хичээх хэрэгтэй. Тэгээд буянаа уур хилэн мэтээр сэвтээхгүй бол дээрх үр дүнд хүрнэ. Тиймээс буянаа сэвтээлгүй нүглээ засаж залруулахыг хичээх нь зүй.

*Эргэлзээ:* Хэрвээ гэмээ цагаатгах дөрвөн хүчээр ноцтой үйлийн үрийг ч арилгадаг юм бол яагаад “гүйцэд боловсрох үйлийн үрээс бусад нь” гээд байгаа юм бэ?

*Тайлал:* Гүйцэд боловсрох үйлийн үр дагавраар нэгэнт сохор төрчихсөн бол түүнийг энэ дөрвөн хүчээр арилгаж болохгүй. Харин үйлийн үр нь бий болоогүй зөвхөн шалтгаан төдий байхад нь хялбархан арилгаж болно гэсэн утгаар Будда хэлсэн байдаг. Тиймээс эргэлзэх зүйл алга. Бхававивека энэ тухай *Учир шалтгааны дөл-дөө*:

*Эргэлзээ:* Үнэхээр гэмээ арилгаж болдог юм бол






яагаад “гүйцэд боловсрох үйлийн үрээс бусдыг” гэж Будда тодорхойлсон юм бэ?


**Тайлал:** Хараагүй, өрөөсөн нудтэй, тахир дутуу, хэлгүй дүлий болж үр дагавар нь нэгэнт гарчихсан, төрөлх шинж чанар болчихсон ямар ч үйлийн үрийг бүрмөсөн арилгах боломжгүй. Харин шалтгаан бүрэлдэх сэдэл байх үед нь түүний эсрэг сэдэл бүхий санаагаар нэг мөсөн устгаж болно. Ангулимала, Ажатасатру, Свака, Ашока зэрэг эцгийгээ хөнөөгчид үүний жишээ юм.

**Эргэлзээ:** Тэгвэл Ажатасатру болон эхийгээ алсан хүмүүс урьдынхаасаа тэс өөр, зөв санаа бодолтой болсон. Гэтэл яагаад үйлийн үр нь барагдахгүй Амсхийх чөлөөгүй тамд төрсөн юм бэ?

**Тайлал:** Түүнийг үйлийн үрд итгүүлэхийн тулд Амсхийх чөлөөгүй там мэтийн газарт төрүүлсэн хэрэг. Түүнээс буруу үйлийн үр нь арилалгүй тамд үлдсэн гэсэн үг биш. Бөмбөг газар ойх шиг тэнд төрөөд, эргээд гараад ирсэн юм. Тамын галыг мэдрээ ч үгүй гэдэг. Тиймээс гэм бурууг уг ёзоороор нь устгаж болно. Харин хийсэн үйл үр дагаваргүй байна гэж үгүй.

Гэхдээ хувь хүний гэмээ наминчилсан байдлаас шалтгаалдаг. Энэ тухай Будда *Бясалгалын хаан* сударт өгүүлсэн байдаг. Сурадатта хаан бодисадва Супуспачандаг алсандаа гэмшжээ. Тэгээд суврага бүтээж агуу их тахил өргөж өдөрт гурвантаа нүглээ наминчлах болж. Ингэж ерэн таван сая жил ёс журмыг үнэнчээр сахисан ч үхээд Амсхийх чөлөөгүй тамд төрөв. Мөн хорин жива галвын турш нүдээ тэс





цохиулах зэргээр өгүүлшгүй их зовлон амссан.


Гэхдээ нүглээ наминчлахгүй бол болохгүй. Гэмээ наминчлахгүй бол илүү их, бүр удаан зовно. Наминчилж, цээрлэвэл үйлийн үрээс юу ч үлдээлгүй салж болно. Гэхдээ эхнээсээ гэмээр буртаглахгүй ариун байх, наминчилж ариусгахын хооронд асар том зоруу бий. Энэ тухай *Бодисадвагийн төвшин*-д:


Үндсэн алдаа гаргавал дахин бодисадвагийн сахил хүртэн засаж болдог. Гэвч энэ яваа насандаа бодисадвагийн дээд төвшний эхний чанарыг ч эзэмшиж чадахгүй.  
хэмээсэн байdag.

Гэмээ наминчлан алдаагаа засаж болох ч бодисадвагийн Тэвчээрийн төвшинд хүрэхийн тулд арван галав шаардагдана. Энэ талаар *Алдаа эндэгдлийн хураангуй сударт*:

Идэрхэн Манзуши: “Будда минь, хэн нэгэн бусдад уруу татагдан номлол зөрчвөл яах вэ? Будда минь, энэ насандаа алдаагаа хэрхэн засах вэ?” гэж асуув. Будда хариуд нь: Манзуши минь, долоон жил өдөрт гурвантаа гэм буруугаа хүлээж наминчилсны дараа арилах болно. Тэгээд хамгийн түргэндээ арван галвын дараа Тэвчээрийн төвшинд хүрнэ. гэж өгүүлсэн байна.

Өөрийгөө ариусгана гэдэг гарах байсан зовлонт үр дагаврыг арилгаж байгаа хэрэг юм. Харин нүглээ арилгахгүй бол гэгээрлийн сургаалыг өөрийн болгоход маш их цаг ордог. Тиймээс анхнаас нь сэтгэлээ





сэвтээхгүйг хичээгээрэй. Оюунлаг хүмүүс аминд нь тулсан ч санаатай алдаа эндэгдэл өчүүхэн ч гаргадаггүй юм гэж Будда хэлсэн билээ. Наминчилж ариусгах, ариун явах хоёр ялгаагүй бол энэ үгийн хэрэг алга. Өдөр тутмын амьдралд ч ийм жишээ олон. Гар, холөө гэмтээвэл эдгээж болдог. Харин огт гэмтээхгүй байх нь түүнээс эрс ялгаатай. Тиймээс сэтгэлээ сэвтээхгүйг хичээх нь зүйтэй бөгөөд энэ тухай *Цоморлиг*-т:

Үнэний оронд хуурмагийг үйлдэж  
Үзтэл зөв номлолтой тэрслэгч  
Үхэхээс айж, үйлээс шантарч  
Үргэлж сэтгэлдээ дагжиж явах нь


Салах дөхсөн сал онгоцоор  
Салхи давалгаат далайд хөвөгчийн  
Санааны гүнд сүйрлийн айдас  
Салахгүй дагаж, мөрдөн хөөх мэт.


Аливаа гавьялаг хичээн үйлдэж  
Адаг муугаас дөлж, жигшигч  
Айсүй үхлийг юманд бодохгүй  
Амар түвшин аж торох нь

Сайн гараар зөв бүтсэн  
Сайхан бөгөөд бат онгоцоор  
Санаа амар далайд хөвж  
Сар хоногоор аялагчид мэт ээ.  
Хэмээн зүйрлэжээ.

Эхний хоёр бадагт дурьдсан шиг бүү яв, харин дараагийн хоёр бадагт өгүүлснийг л дага.

Ухаарагхгүй хүнд хэдий зөв зүйтэй үг хэллээ ч төдий л хэрэг нь гардаггүй. Харин номлолын талаар шалихгүй мэдлэгтэй ч мэдснийгээ дагаж мөрдөж чадвал маш их хэрэг болно. *Цоморлиг*-оос:





Амнаас унах үгс ухаантай ч  
Алмай хэнэггүй зантай аваас  
Ашигтай зөв дадал суртлыг  
Аминдаа шингээх хувь дутах нь

Аминыхаа толгойд бухалтай атлаа  
Амьтны толгой дахь бутыг шагшигч  
Ахиж дэвжихгүй шалихгүй цэцний  
Амны зугаа намтар мэт ээ.

Цэцэн ухаалаг үг яриагүй ч  
Чин үнэнээсээ номлолоо дагагчид  
Шунал мунхаг уураа дараад  
Шууд зөвдөхийн зам нээлттэй.


Сэрэмжтэй гэлэн айdasгүй баясгалантай ч  
Сэхээгүй хэнэггүйчүүдийн өмнөөс түгшинэ  
Сайн заяаг өөрөө олоод зогсохгүй  
Саар муугаас бусдыг гэтэлгэх нь


Шандас тэнхээт үлэмж заан  
Шавар намгийг гэтэлдэг бөгөөд  
Шаварт бас сорогдон живэгчийг  
Шалав татан аврахын адил аа.

Сэрэмжтэй гэлэн айdasгүй баясгалантай ч  
Сэрэмжгүй мунхагийн өмнөөс энэлзээд  
Сэтгэлд нь бугших гэм нүглүүдийг нь  
Сэгсэрч унагаад өөд татах нь

Намар оройн шаргал улиас  
Намуун салхины нэгэн үлээлтээр  
Хатсан навчсаа цөмийг гөвөөд  
Хамгаас цэвэршин нүцгэрэх мэт ээ.

Үйл, үр дагавар хоёр хоорондоо харилцан уялдаа  
холбоотой. Энэ жам ёсыг мэдэх нь амьтан бүхний  
тусыг бүтээх гэсэн хөлгөн бүхний ганц суурь мөн.








### Анддаа илгээсэн захидал-аас:

Төрлийн дээд чолоог эрмэлзвээс  
Төгс үнэн үзлийг хичээгтүн  
Төгөлдөр журамтай ч үзэл эндүү бол  
Төөрч будилаад үрийг нь эдэлнэ.

Эндээс жишээ авч *Үргэлж санаж сээрэх*, *Цэцэн тэнэгийн улгэр*, *Зуун үйл*, *Бодисадвагийн зуун домог*, *Ёс зүйн тухай өгүүлэл* болон Буддагийн бусад зарлигийг судла. Үйлийн үрийн сургаал амин чухал гэдгийг санаж тууштай, гүйвшгүй итгэл үнэмшилтэй бол.







XVI

## ЭХЛЭН ГЭГЭРЭГЧИЙН САНАА БОДОЛ

- 
- 
- б) Эхлэн гэгээрэгчийн санаа бодол хөгжсөнийг таних
  - в) Эхлэн гэгээрэгчийн тухай буруу ойлголтыг няцаах
- 





## б) Эхлэн гэгээрэгчийн санаа бодол хөгжсөнийг таних

Та урьд нь зөвхөн энэ амьдралдаа санаа тавьж, хойд наасны тухай үгнээс өөр ойлголтгүй явсан. Одоо эсрэгээр эргэж хойд насандaa санаа зовж, таны хувьд энэ амьдрал төдий л чухал биш болжээ. Энэ бол эхлэн гэгээрэгчийн санаа бодол хөгжиж буй хэрэг юм. Гэхдээ улам батжуулах шаардлагатай. Энэхүү санаа бодлоо улам хөгжүүлэхийг хичээ.


## в) Эхлэн гэгээрэгчийн тухай буруу ойлголтыг няцаах


**Төөрөгдөл:** Буддагийн аман айлдвартуудад орчлонгийн аливаа сайн сайхан бүхнийг сэтгэлээсээ таягдан хая гэсэн байдаг. Гэтэл зарим хүн дээд төрөл, эд баялаг зэрэг сайн сайхан бүхэн бол орчлон гэсэн үг тул түүнд санаа тавих нь илүүц гэж боддог.

**Залруулга:** Анхаарал хандуулбал зохих хоёр зүйл бий: хэтийн ба ойрын зорилго. Нирвааныг хүссэн хэн боловч одоогийн бие цогцос мэтийн сайн сайханд энэ цаг үеэс л санаа тавих хэрэгтэй. Энэ биеийг удаа дараалан олж байж л хэтийн зорилгоо биелүүлнэ.

Энэ бие, эд баялаг, найз нөхөд бүрдсэн дээд төрөл орчлонтой хүлдэггүй юм. Цаад угтаараа бие цогцос нь гэгээрлийн биежсэн төлөв, эд баялаг нь оршин тогтоно орон зай харин ойр дотны хүмүүс бол гэгээрүүлэх үйл хэрэг нь өрнөх хүрээ болдог. Майдарын *Сүдар айлгийн чимэг-т үүнийг*:

Хэрэглэхэд бүрэн эдийн баялаг  
Хээнцэр гол шиг бие цогцос





Хэзээд нийлэмжит ураг садан  
Хэн ч маргахгүй төрлийн дээд мөн.  
хэмээн тодорхойлсон байдаг.

Энэ нь дээд төрлөөр эхний дөрвөн төгс чанарыг эзэмшинэ гэсэн үг. Мөн тэр бүхнээр гэгээрлийн биежсэн төлвийг бүтээдэг гэж эх зохиолуудад олонтаа дурьджээ. Бүрэн төгс гэгээрхийн тулд ёс суртахуун, өгөөмөр чанар, тэсвэр зэрэг олон гайхамшигтай чанарт удаан суралцах шаардлага гарна. Тиймээс тэдгээрийн үндэс болсон бие цогцос мэтийн дээд төрөлд анхаарал тавих учиртай.


Тэр цагт хэтийн зорилгодоо хүрэх боломжтой.  
Энэ тухай *Бодисадвагийн замнал-д*:


Хуйлрах давалгаа, хуйсагнах салхитай  
Хур, аадар, аянгын цахилтай  
Хуурмаг орчлонгийн үнэн зовлонг  
Хүмүүн заяаныхаа хөлгөөр л гатална.  
гэж өгүүлжээ.

Шантидэва хүний биеийг олдог сайн заяанд тулгуурлаж нөхцөлдөн оршихуйн далайг гатлан, төгс гэгээрэлд хүрнэ гэжээ. Харин үүнд олон амьдрал шаардагдана. Тиймээс энэ биеийг бүрдүүлдэг нөхцөл болсон ариун ёс суртахуун бол гэгээрлийн сургаалын амин сүнс юм.

Сайн заяаны энэ биеийн шинж чанар хараахан төгс биш. Зарим нэг давуу талаа ашиглан сургаалд суралцаж болох ч ахиц муутай байдаг. Тиймээс шинж чанарыг нь төгөлдөржүүлэх хэрэгтэй. Үүний тулд гэцүл мэтийн сахил сахих нь хангалтгүй. Харин гэлэнгийн сахилыг төгс сахихыг л хичээ.

*Төөрөгдөл:* Зарим хүн ёс суртахуун дагаж сайн









төрөл олдог юм бол нэг өдрийн сахилаар ч олно, тэгэхээр төвөг ихтэй атлаа тус багатай гэлэнгийн сахилаар яах вэ гэдэг. Нөгөө нь аминчлан гэгээрэх сахилын зорилго нь архадын төвшинд хүрэх, тэгэхээр хорь хүртлээ гэлэн сахил авах хэрэггүй. Гэнэн сахилтай байсан ч архадын төвшинд хүрнэ, тиймээс хэцүү бөгөөд хэрэг багатай гэлэнгийн сахилаар яах вэ ч гэдэг.

*Залдуулга:* Ингэж ярьдаг хүнийг номлолын утга учрыг ойлгоогүй хоосон бурагч гэж үзэх хэрэгтэй. Доод сахилдаа тулгуурлан дээд сахилыг нь авч бүрэн төгс эзэмшсээрэй.

Эхлэн гэгээрэгчийн зам мөр буюу нийтлэг сургаалаар сэтгэлээ хөгжүүлэх бүлгийг өгүүлж дууслаа.





Printed and donated for free distribution by  
**The Corporate Body of the Buddha**  
**Educational Fundation**  
11F., 55 Hang Chow South Road Sec 1,  
Taipei, Taiwan, R.O.C.  
Tell: 886-2-23951198, Fax: 886-2-23913415  
Email: overseas@budaedu.org  
Website: <http://www.budaedu.org>  
**This book is strictly for free distribution,**  
**it is not for sale.**

Printed in Taiwan

